



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

I ХЭСЭГ

ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТ, ЗАРЧИМ

1.1 дүгээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино.

1.2 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмжээ хязгаар

- 1.Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан энэ хуулийн дагуу явагдана.
- 2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтална.
- 3.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэр, түүнд хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэрэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад нэгэн адил үйлчилнэ.
- 4.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэн, харьяалалгүй хүнд холбогдуулан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад энэ хуульд заасан журмыг баримтална.
- 5.Гадаад улсын, олон улсын байгууллагын дипломат эрх ямба, дархан эрх эдэлж байгаа хүнийг яллагдагчаар татаж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах зөвшөөрлийг Улсын ерөнхий прокурор Монгол Улсын гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар уламжлан тухайн улс, олон улсын байгууллагаас хүснэ.

1.3 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хэл, бичиг

- 1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг монгол хэлээр явуулж, төрийн албан ёсны хэл, бичгээр хөтөлж, баримтжуулна.
- 2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нь монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал бол өөрийн эх хэл, эсхүл сайн мэдэх хэл, бичиг, дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламж авах эрхээр хангагдана.

1.4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

- 1.1."анхан шатны шүүх" гэж эрүүгийн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлүүлэхээр хуулиар харьяалуулсан шүүхийг;
- 1.2."бусад газар" гэж хүн, хуулийн этгээдийн орон байрнаас бусад өмчлөл, эзэмшлийн байр, байгууламж, бусад объектыг;
- 1.3."бусад оролцогч" гэж гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагч, хэлмэрч, хөндлөнгийн гэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг;
- 1.4."гэр бүлийн гишүүн" гэж Гэр бүлийн тухай хуулийн 3.1.4-т заасныг;
- 1.5."томилогдсон өмгөөлөгч" гэж хуульд заасан тодорхой нөхцөлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох өмгөөлөгчийг;

- 1.6."давж заалдах шатны шүүх" гэж эрүүгийн хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлүүлэхээр хуулиар харьяалуулсан шүүхийг;
- 1.7."даруй" гэж боломжит богино хугацааг;
- 1.8."мөрдөгч" гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий албан тушаалтныг;
- 1.9."мөрдөн шалгах ажиллагаа" гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокурорын зөвшөөрлөөр, эсхүл мөрдөгч бие даан явуулах энэ хуульд заасан ажиллагааг;
- 1.10."мөрдөн шалгах нууц ажиллагаа" гэж прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулах энэ хуульд заасан ажиллагааг;
- 1.11."мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга" гэж мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах нэгжийн даргыг;
- 1.12."мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага" гэж энэ хуульд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахаар заасан байгууллагыг;
- 1.13."оролцогч" гэж сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, хуулийн этгээд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг;
- 1.14."орон байр" гэж Эрүүгийн хуулийн 13.6 дугаар зүйлийн Тайлбарт заасныг;
- 1.15."орчуулагч" гэж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, монгол хэл, бичиг мэдэхгүй хүнд түүний эх хэл, эсхүл сайн мэдэх хэл, бичгээс монгол хэл, бичиг рүү, эсхүл монгол хэл, бичгээс түүний эх хэл, эсхүл сайн мэдэх хэл, бичиг рүү бичгээр орчуулж байгаа хүнийг;
- 1.16."өмгөөлөх тал" гэж шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг;
- 1.17."өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч" гэж Эрүүгийн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүнийг;
- 1.18."прокурор" гэж Прокурорын тухай хуульд заасан дээд шатны прокурор, бусад прокурорыг;
- 1.19."саданийн хүн" гэж Гэр бүлийн тухай хуулийн 3.1.6-д заасныг;
- "1.20."талууд" гэж шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааны мэтгэлцээнд тэгш эрхтэй оролцож, санал, хүсэлтийнхээ үндэслэлийг тайлбарлах, танилцуулах оролцогч, эсхүл яллах, өмгөөлөх чиг үүргийг хэрэгжүүлэгчийг;
- [/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)
- 1.21."тусгай мэдлэг" гэж тухайн хүний эзэмшсэн шинжлэх ухаан, түүх, соёл, техник, технологи, урлаг, гар урлалын салбарын болон хэргийн бодит байдлыг тогтооход шаардагдах бусад мэдлэгийг;
- 1.22."төрлийн хүн" гэж Гэр бүлийн тухай хуулийн 3.1.5-д заасныг;
- 1.23."үндэслэл бүхий сэжиг" гэж энэ хуульд заасан тодорхой ажиллагаа явуулах нөхцөл үүссэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй гэмт хэргийн талаархи мэдээлэл, хэргийн нөхцөл байдалд тулгуурласан мөрдөгч, прокурор, шүүгчийн дотоод итгэлийг;
- 1.24."үр хүүхэд" гэж төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд, ач, зээ, гуч, жичийг;
- 1.25."хангалттай үндэслэл" гэж шүүх, прокурор, мөрдөгч энэ хуульд заасан шийдвэр гаргахад нөлөөлж байгаа бодит баримтад тулгуурласан нөхцөл үүссэнийг;
- 1.26."хойшуулшгүй тохиолдол" гэж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгааг;
- 1.27."хяналтын шатны шүүх" гэж Улсын дээд шүүхийг;
- 1.28."хэлмэрч" гэж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож, монгол хэл мэдэхгүй хүнд түүний эх хэл, эсхүл сайн мэдэх хэлээс монгол хэл рүү, монгол хэлээс түүний эх хэл, эсхүл сайн мэдэх хэл рүү, эсхүл сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг хэлмэрчилж байгаа хүнийг;
- 1.29."шинжээч" гэж Шүүх шинжилгээний тухай хуулийн 4.1.4-т заасныг;
- [/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)
- 1.30."шөнийн цаг" гэж тухайн өдрийн 22.00 цагаас дараа өдрийн 06.00 цаг хүртэлх хугацааг;
- 1.31."шүүгч" гэж бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчийг;
- 1.32."шүүхийн иргэдийн төлөөлөгч" гэж шүүх эрх мэдлийн байгууллагад ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих тогтолцоог бий болгох зорилгоор шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа иргэнийг;
- 1.33."шүүхийн шийдвэр" гэж Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 22.4, 22.5-д заасныг;
- [/Энэ заалтад 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 1.34."прокурорын шийдвэр" гэж Прокурорын тухай хуулийн 31.1-д заасныг;
- 1.35."мөрдөгчийн шийдвэр" гэж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгчийн гаргах тогтоолыг;

1.36."эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа" гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, түүнд прокурор хяналт тавих, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг;

1.37."яллах тал" гэж прокурорыг.

1.5 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдол

1. Дараахь тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй:

1.1. гэмт хэргийн шинжгүй;

1.2. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан;
[/Энэ заалт ад 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

1.3. яллагдагч, шүүгдэгч нас барсан /нас барсан хүнийг цагаатгах, эсхүл бусад хүнд холбогдох шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас уг хэргийг сэргээж хянан шийдвэрлэх ажиллагаа үүнд хамаарахгүй/;

1.4. тухайн хэргийг урьд нь хэрэгсэхгүй болгосон тогтоол, магадлал хүчинтэй байгаа;

1.5. тухайн үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон.

2. Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад энэ зүйлийн 1.1-д заасан нөхцөл байдал илэрвэл шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуустал нь явуулж, цагаатгах тогтоол гаргана.

3. Энэ зүйлийн 1.1, 1.2-т заасан үндэслэлээр эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосныг яллагдагч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, энэ зүйлийн 1.3-т заасан үндэслэлээр эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосныг яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн эс зөвшөөрвөл гомдлоо прокурор, шүүхэд гаргах ба шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулж, гэмт хэрэгт холбогдсон хүн, хуулийн этгээд гэм буруутай эсэхийг хянан шийдвэрлэнэ.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон бол энэ тухай хохирогч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэх ба уг шийдвэрийн талаар энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргах эрхтэй.

1.6 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байх

1. Шүүх, прокурор, мөрдөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулийн заалтыг чанд сахина.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа этгээд энэ зүйлийн 1 дэх хэсгийг зөрчвөл түүний гаргасан шийдвэрийг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүйд тооцож, хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

3. Шүүх хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улсын дээд шүүхэд энэ талаар санал гаргах ба Улсын дээд шүүх уг саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргана.

4. Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл Улсын ерөнхий прокурорт энэ талаар санал гаргах ба Улсын ерөнхий прокурор уг саналыг үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргана.

5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гаргах журам нь энэ хуулийн зарчим, агуулгад нийцсэн байна.

6. Энэ хуульд зааснаас өөрөөр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх хэм хэмжээ тогтоосон журам гаргахыг хориглоно.

1.7 дугаар зүйл. Хэргийн бодит байдлыг тогтоох

1. Мөрдөгч, прокурор нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох үүрэгтэй.

2. Хэргийн бодит байдлыг нотлохын тулд мөрдөгч, прокурор хуульд заасан бүх арга хэмжээг авч яллагдагч, шүүгдэгчийг яллах, цагаатгах, ял хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлыг эргэлзээгүй тогтооно.

3. Шүүх хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтооно.

4. Шүүх, прокурор, мөрдөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс гэм буруугүй болохыг өөрөөр нь нотлуулахаар шаардахыг хориглоно.

1.8 дугаар зүйл. Хүний халдашгүй байх эрхийг хангах

1. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, өмчлөх эрхэд нь халдах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хориглоно.

[/Энэ хэсэг т 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

2. Хуульд зааснаас бусад тохиолдолд хойшлуулшгүйгээр, эсхүл шүүхийн шийдвэрт зааснаас илүү хугацаагаар баривчлагдсан, цагдан хоригдож байгаа хүнийг прокурор даруй суллана.

[/Энэ хэсэг т 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

3.Хүнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгаан, үндэслэлийг мэдэгдэж, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг сануулна.

1.9 дүгээр зүйл.Эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг хориглоно.

2.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчээс мэдүүлэг авахдаа тэдэнтэй хүнлэг бусаар харьцаж, нэр төр, алдар хүнд, бие махбод, сэтгэл санаанд хохирол учруулах арга хэрэглэхийг хориглоно.

1.10 дугаар зүйл.Орон байрны халдашгүй байдлыг хангах

1.Орон байр халдашгүй байна.

2.Орон байранд хийх нэгжлэгийг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулна.

1.11 дүгээр зүйл.Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны мэдээллийг хамгаалах

[/Энэ зүйлийн гарчиг т 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

1.Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны мэдээллийг хуулиар хамгаалах ба энэхүү эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлаж болно.

[/Энэ хэсэг т 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

1.12 дугаар зүйл.Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх

1.Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

1.13 дугаар зүйл.Шүүхэд хандах

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүн, хуулийн этгээд хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн гэж үзвэл уг эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах эрхтэй.

1.14 дүгээр зүйл.Өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах

1.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн гэж үзэж байгаа хүн, хуулийн этгээд өөрийгөө өмгөөлөх, эсхүл өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй.

2.Хүн, хуулийн этгээд хуульд заасны дагуу хууль зүйн туслалцаа авах, өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх боломж, нөхцөл, цаг хугацаагаар хангагдана.

1.15 дугаар зүйл.Гэм буруугүйд тооцох

1.Шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хүн, хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй.

2.Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэнэ.

1.16 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах

[/Энэ зүйлийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

1.Шүүх, прокурор, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг үйлдэх, шийдвэр гаргах, хэргийн оролцогчтой харилцах, хэргийн материалыг оролцогчид танилцуулах, баримт бичиг хүлээн авах, хүргэх болон шүүх хуралдаан, шүүхийн хэлэлцүүлэг явуулах ажиллагааг цахим платформ ашиглан явуулж болно.

[/Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хавтаст хэрэг нь шүүхийн цахим платформын техникийн шаардлагад нийцсэн байна.

[/Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

3.Хэргийн оролцогчтой цахимаар харилцахад төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, мэдэгдэл хүргэх систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, мэдэгдэл хүргэх системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, тухайн этгээдийг таньж, баталгаажуулах боломжтой бусад цахим систем, өмгөөлөгчийн Монголын Өмгөөлөгчдийн Холбооны цахим системд бүртгүүлж холбогдсон цахим шууданг ашиглана.

[/Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

4.Өмгөөлөгч тайлбар, гомдол, хүсэлт зэрэг баримт бичгийг цахим баримт бичгээр хүргүүлж болно.

[/Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ХАРЬАЛАЛ

2.1 дүгээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны харьяалал тогтоох нийтлэг үндэслэл

1.Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь нутаг дэвсгэрийн болон хуульд заасан харьяаллын дагуу явагдана.

2.Монгол Улсын хилийн гадна үйлдэгдсэн, гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг тогтоох боломжгүй, Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын харьяаллыг Улсын ерөнхий прокурор, хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүний шийдвэрээр тогтооно.

3.Шүүх, прокурор хянан шийдвэрлэж байгаа хэрэг нь харьяаллын бус болохыг тогтоовол харьяалах хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, шүүхэд шилжүүлнэ.

4.Энэ хуульд зааснаар тогтоосон харьяаллын талаар шүүх, прокурор, мөрдөгч хоорондоо маргаж болохгүй ба шилжиж ирсэн хэргийг хүлээн авсан мөрдөгч, прокурор шалгаж, шүүх хянан шийдвэрлэнэ.

2.2 дугаар зүйл.Шүүхийн харьяалал

1.Энэ хуульд тусгайлан зааснаас бусад хэргийг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ.

[/Энэ хэсэг т 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

2.Анхан шатны шүүхэд ирсэн хэргийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон хэрэг хуваарилах журмын дагуу хуваарилна.

3.Хуульд тусгайлан зааснаас бусад эрүүгийн хэргийг сум буюу сум дундын, дүүргийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ.

4.Хэрэг тухайн шүүхэд харьяалагдахгүй байвал шүүгчийн шийдвэрээр харьяалах шүүхэд шилжүүлнэ.

5.Шүүх тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүнгүй болсон бол тухайн хэргийг өөр аймаг дахь сум буюу сум дундын, эсхүл сум буюу сум дундын шүүхээс дүүргийн шүүхэд Улсын дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхимын шийдвэрээр, нэг аймаг дахь өөр сум буюу сум дундын, эсхүл өөр дүүргийн шүүхэд тухайн аймаг, нийслэлийн шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний шийдвэрээр шүүхийн харьяалал тогтоон шилжүүлнэ.

[/Энэ хэсэг т 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

6.Гэмт хэрэг нь хэд хэдэн шүүхийн харьяалах нутаг дэвсгэрт үйлдэгдсэн бол сүүлчийн гэмт хэрэг үйлдэгдсэн газрын харьяалах шүүх хэргийг хянан шийдвэрлэнэ.

7.Гэмт хэрэг нэг шүүхийн харьяалах газар эхэлж, нөгөө шүүхийн харьяалах газарт төгссөн бол төгссөн газрын шүүх хэргийг хянан шийдвэрлэнэ.

8.Уг хэрэг адил эрх бүхий өөр шүүхэд харьяалагдах нь шүүх хуралдааны үед мэдэгдсэн бөгөөд хэргийн байдлыг бүрэн бодитойгоор тогтооход нөлөөлөхөөргүй байвал шүүх хуралдааныг үргэлжлүүлж, хэргийг эцэслэн шийдвэрлэнэ.

9.Эрүүгийн хэргийн оролцогч, гэрчийн олонхи байгаа газарт, эсхүл дагнасан чиг үүрэгтэй алба, нэгжийн мөрдөн шалгах ажиллагаа явуулсан эрүүгийн хэргийн шүүхийн харьяаллыг прокурорын саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын тэргүүн өөрчлөн тогтоож болно.

10.Энэ хуулийн 31.4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр сэжигтнийг баривчлах тухай прокурорын саналыг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

11.Энэ хуулийн 31.5 дугаар зүйлд заасны дагуу сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчилсан тухай мөрдөгчийн шийдвэрийг уг хэрэг гарсан газрын харьяалах шүүх, хэрэв баривчлагдсан сэжигтнийг 24 цагийн дотор уг хэрэг гарсан газрын харьяалах шүүхэд хүргэх боломжгүй бол баривчлах ажиллагаа явагдсан газрын шүүх хянан шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

12.Монгол Улсын хилийн гадна үйлдэгдсэн, гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг тогтоох боломжгүй, Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт гарсан гэмт хэргийн сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлтэй баривчлах, эсхүл яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын саналыг тухайн хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байгаа газрын харьяалах шүүх хянан шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.Энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ, энэ хуулийн 31.4, 31.5 дугаар зүйлд заасан баривчлах ажиллагаа, Арван долдугаар бүлэгт заасан хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэргийг нийслэлд Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх хянан шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

3.3 дугаар зүйл.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяалал

- 1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг энэ хуульд заасан нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу явуулна.
- 2.Энэ хуульд заасны дагуу тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газар нь прокурорын шийдвэрээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг хамтран явуулж болно.
- 3.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах хэд хэдэн байгууллагын эрх хэмжээнд харьяалагдах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг прокурор тогтооно.
- 4.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг шуурхай, бүрэн гүйцэд явуулахын тулд гэмт хэрэг илэрсэн болон оролцогч, гэрч, хохирогчийн олонхи байгаа газарт, эсхүл дагнасан чиг үүрэгтэй алба, нэгжид хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг прокурор тогтоож болно.
- 5.Мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байгаа хэрэг нь харьяаллын бус болох нь мэдэгдвэл харьяаллын дагуу шилжүүлэх саналаа прокурорт даруй хүргүүлнэ.
- 6.Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяалал тогтоолгох саналыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор энэ зүйлд заасан журмыг баримтлан шийдвэрлэнэ.

II ХЭСЭГ

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ, ОРОЛЦОГЧ

ГУРАВДУГААР БҮЛЭГ ШҮҮХ

3.1 дүгээр зүйл.Шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

- 1.Анхан шатны шүүх хуралдаанаар тухайн шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэх, гэм буруутай бол түүнд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хянан шийдвэрлэнэ.
- 2.Давж заалдах шатны шүүх хуралдаанаар анхан шатны шүүхийн ажиллагаа, шийдвэртэй холбогдуулан гаргасан талуудын гомдол, эсэргүүцэл үндэслэлтэй эсэхийг хянан шийдвэрлэнэ.
- 3.Хяналтын шатны шүүх хуралдаанаар гомдол, эсэргүүцлийн дагуу шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн эсэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэнэ.
- 4.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад энэ хуулиар харьяалуулсан асуудлыг шүүх хянан шийдвэрлэнэ.
- 5.Шүүх энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.5 дахь заалт, 31.4, 31.5 дугаар зүйлд заасан асуудлыг хянан шийдвэрлэх ажиллагааг хуанлийн өдөр бүр шөнийн цагаас бусад цагт тасралтгүй хэрэгжүүлнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ хэсэг т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

- 6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан асуудлыг хянан шийдвэрлэх шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмын дагуу томилно.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

3.2 дугаар зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй, хаалттай явуулах

[/Энэ зүйлийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

- 1.Төрийн нууцад хамаарах хэрэг хянан шийдвэрлэх, энэ хуульд тусгайлан зааснаас бусад шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

[/Энэ хэсэг т 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

- 2.Хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нээлттэй, эсхүл хаалттай явуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

- 3.Шүүх хуралдааныг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсгоно.

[/Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

3.3 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн

- 1.Эрүүгийн хуулийн тусгай ангид найман жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнээр, бусад гэмт хэргийг шүүгч дангаар хянан шийдвэрлэнэ.
- 2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүгч дангаар хянан шийдвэрлэх хэрэг ээдрээ төвөгтэй гэж шүүгч үзвэл энэ тухай саналаа Ерөнхий шүүгчид гаргаж, тухайн хэргийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнээр шийдвэрлэж болно.
- 3.Эрүүгийн хэргийг давж заалдах журмаар гурван шүүгчийн бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэнэ.
- 4.Эрүүгийн хэргийг хяналтын журмаар таван шүүгчийн бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэнэ.
- 5.Энэ зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэгт зааснаас бусад энэ хуулиар харьяалуулсан асуудлыг шүүгч дангаар хянан шийдвэрлэнэ.
- 6.Энэ зүйлд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмын дагуу томилно.
- 7.Сум буюу сум дундын, дүүргийн шүүх, түүнчлэн аймаг, нийслэлийн шүүх тодорхой эрүүгийн хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон бол сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн бүрэлдэхүүнд орох шүүгчийг харьяалах аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн, аймаг, нийслэлийн шүүхийн бүрэлдэхүүнд орох шүүгчийг Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын Тэргүүний шийдвэрээр шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмыг баримтлан томилно.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

3.4 дүгээр зүйл.Шүүхийн иргэдийн төлөөлөгч

- 1.Эрүүгийн хэргийг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэх хуралдаанд Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу иргэдийн төлөөлөгчийг оролцуулна.

[/Энэ хэсэг т 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

- 2.Шүүхийн иргэдийн төлөөлөгч дараахь эрхтэй:

- 2.1.шүүх хуралдааны явцад нотлох баримт шинжлэн судлахад оролцож, шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр асуулт тавих;
- 2.2.шүүгдэгчийн гэм буруугийн талаар санал бичих, уншиж сонсгох.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ПРОКУРОР

4.1 дүгээр зүйл.Прокурорын бүрэн эрх

- 1.Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцоно.

- 2.Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа дараахь эрхтэй:

- 2.1.гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалгах ажиллагаа хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг хянах;
- 2.2.гэмт хэргийн шинжийг өөрөө илрүүлсэн бол хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагад харьяаллын дагуу шилжүүлж шалгуулах;
- 2.3.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяалал тогтоох;
- 2.4.гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаар гаргасан санал, хүсэлтийг шийдвэрлэх;
- 2.5.эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох;
- 2.6.хэрэг бүртгэлтийн хэргийг хаах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татахаас татгалзах, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх, сэргээх, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, сэргээх, нэгтгэх, тусгаарлах;
- 2.7.хойшлуулшгүйгээс бусад тохиолдолд сэжигтнийг баривчлах саналыг шүүхэд хүргүүлэх, баривчлах ажиллагаа явуулахыг мөрдөгчид даалгах;
- 2.8.хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа явуулах хугацааг сунгах;
- 2.9.яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацааг сунгах саналыг шүүхэд хүргүүлэх;
- 2.10.энэ хуульд заасны дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулах зөвшөөрлийг мөрдөгчид олгох;
- 2.11.гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагчийг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлэх;
- 2.12.энэ хуульд заасны дагуу гаргасан оролцогчийн хүсэлт, гомдлыг хянан шийдвэрлэхийн тулд хавтаст хэргийг татаж хянах;
- 2.13.мөрдөгч, эсхүл хяналт тавьж байгаа прокурорыг татгалзан гаргах тухай хүсэлтийг шийдвэрлэх, хэргийг өөр мөрдөгч, прокурорт шилжүүлэх шийдвэр гаргах;
- 2.14.мөрдөгч, эсхүл хяналт тавьж байгаа прокурорын шийдвэр, ажиллагааны талаар прокурорт гаргасан гомдлыг хянан

шийдвэрлэх, тухайн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл хүчингүй болгох, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааг таслан зогсоох;

2.15.мөрдөн шалгах ажиллагаа явуулах даалгаврыг өгөх, түүний биелэлтийг хангуулах, шаардлагатай гэж үзвэл мөрдөн шалгах ажиллагаа явуулах даалгаврыг хэд хэдэн мөрдөгчид өгөх, мөрдөн шалгах ажиллагаанд биечлэн оролцож хяналт тавих, нэмэлт мөрдөн байцаалт явуулахаар хэргийг мөрдөгчид буцаах;

2.16.дээд шатны прокурор энэ хуульд заасан мөрдөгчийн саналыг үндэслэн тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурорын шийдвэр, ажиллагааг хянах;

2.17.эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх, эсхүл энэ хуульд заасны дагуу эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх тухай саналыг шүүхэд хүргүүлэх;

2.18.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцыг хянах, бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шалгах, шаардлагатай бол хавтаст хэргийг татаж хянах, уг ажиллагаанд илэрсэн зөрчлийг арилгуулах талаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын удирдлагад шаардлага тавих, зөрчлийг арилгуулах;

2.19.тухайн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа өмгөөлөгчийн ажиллагаанд хуульд заасны дагуу гомдол гаргах;

2.20.шаардлагатай мэдээ, судалгаа, баримт бичгийг байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах, газар дээр нь танилцах, мэргэжлийн дүгнэлт, магадлагаа гаргуулах, хавтаст хэргийг архивт хадгалах;

2.21.мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих;

2.22.прокурорын хянан шалгах ажиллагаа явуулах;

2.23.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад прокурор, мөрдөгч нь хууль зөрчиж оролцогчид хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

2.24.энэ хуульд заасан бусад эрх.

3.Прокурор шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцохдоо энэ хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

4.Прокурорын даалгаварт гаргасан мөрдөгчийн саналыг дээд шатны прокурор ажлын 3 өдрийн дотор шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

4.2 дугаар зүйл.Прокурорын үүрэг

1.Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан энэ хуулийг хэрэгжүүлж байгаад хяналт тавьж, хууль зөрчсөн шийдвэрийг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүй болгож, хариуцлага тооцуулна.

2.Прокурор нь шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг шүүхийн өмнө нотлох үүрэг хүлээнэ.

4.3 дугаар зүйл.Прокурорын хянан шалгах ажиллагаа

1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, мөрдөн шалгах ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаагүй гэж прокурор үзвэл оролцогчийн гаргасан гомдлоор, эсхүл өөрийн санаачилгаар гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчаас биечлэн мэдүүлэг авах, шинжээч дахин томилж дүгнэлт гаргуулах, үзлэг, нэгжлэг, туршилтыг давтан хийх, мөрдөн шалгах нууц ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдсан эсэхийг хянан шалгах ажиллагаа явуулж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ ӨМГӨӨЛӨГЧ

5.1 дүгээр зүйл.Өмгөөлөгчийн эрх, үүрэг

1.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, хохирогч, гэрч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хууль зүйн туслалцаа авах эрхээр хангах зорилгоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулна.

[/Энэ хэсэг т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

2.Өмгөөлөгч дараахь эрхтэй:

2.1.гэрч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй ганцаарчлан даруй уулзах, түүнээс мэдүүлэг авахад байлцах, асуулт тавих;

[/Энэ заалтад 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

2.2.хохирогч, гэрч, шинжээчээс мэдүүлэг авахуулахаар хүсэлт гаргах;

2.3.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад шинжээчийн дүгнэлттэй танилцах, өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах, нэмэлт ба дахин шинжилгээ хийлгэх хүсэлт гаргах;

[/Энэ заалтад 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

2.4.хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг энэ хуульд заасан журмын дагуу мөрдөгч, прокурор, шүүхэд гаргаж өгөх, түүнийг хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах, хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах, энэ хуульд заасан журмын дагуу оролцох;

[/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.5.өмгөөлж байгаа сэжигтэн, хохирогч, яллагдагч, шүүгдэгч, ялтны, эсхүл өөрийнхөө хүсэлтээр хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд байлцаж, аль ч үед асуулт тавих, хүсэлт гаргах;

2.6.мөрдөн шалгах ажиллагаа дууссанаар мөрдөн шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны үед хийгдсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг болон тэмдэглэлтэй хэргийн материалтай танилцах үед төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг хуулбарлан авах, тэмдэглэлд засвар оруулах тухай хүсэлт гаргах;

[/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.7.энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хуулбарлан авах зорилгоор зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн болон бусад техник хэрэгсэл ашиглах;

[/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

2.8.өөрсдийнх нь зөвшөөрснөөр хүн, хуулийн этгээдээс хэрэгт ач холбогдол бүхий тайлбар, баримт бичиг, лавлагаа, тодорхойлолт гаргуулж авах;

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтад 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

2.9.мөрдөгч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах хүсэлт гаргах;

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

2.10.хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хэргийн бүх материалтай танилцаж, төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах;

[/Энэ заалтад 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

2.11.шүүхийн хэлэлцүүлэгт оролцох;

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

2.12.мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүхийн ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах;

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

2.13.сэжигтнийг баривчлах, яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих, бусад таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд оролцох, таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл болсон мөрдөгч, прокурорын санал, шийдвэрийн үндэслэл, түүний нотлох баримттай танилцах;

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.14.анхан, давж заалдах, хяналтын шатны шүүх хуралдаанд оролцох;

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

2.15.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж оролцогчид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх санал гаргах;

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

2.16.энэ хуульд заасан бусад эрх.

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

3.Өмгөөлөгч нь шүүх, прокурор, мөрдөгчийн товлосон хугацаанд хүрэлцэн ирж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно. Хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцох боломжгүй бол энэ тухай урьдчилж мэдэгдэнэ.

4.Өмгөөлөгч тухайн хүн, хуулийн этгээдийн өмгөөлөгчөөр оролцох болсноо үйлчлүүлэгчийн бичгээр үйлдсэн хүсэлтээр баталгаажуулж, шүүх, прокурор, мөрдөгчид бичгээр мэдэгдэнэ.

[/Энэ хэсэгт 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

5.Өмгөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээгээр хүлээсэн өмгөөлөх, хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргээсээ татгалзаж болохгүй.

5.2 дугаар зүйл.Өмгөөлөгчийг сонгох

- 1.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч өмгөөлөгчөө өөрөө сонгоно.
- 2.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн зөвшөөрснөөр, эсхүл хүссэнээр тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн нь өмгөөлөгч сонгож болно.
- 3.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийг өмгөөлөгчөө сонгох боломжоор хангахдаа шүүгч, прокурор, мөрдөгч тодорхой хүний нэр зааж тулгаж болохгүй.
- 4.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч өмгөөлөгчөөсөө татгалзсан бол түүнд өөр өмгөөлөгч сонгох боломж олгоно.
- 5.Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлүүлэх эрхийг хангах журмыг хуулиар тогтооно.
- 6.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч тогтоосон хугацаанд өмгөөлөгч сонгож аваагүй бол тухайн ажиллагаанд томилогдсон өмгөөлөгчийг оролцуулна.
- 7.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн сонгосон өмгөөлөгч тухайн ажиллагаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцох боломжгүй байгаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахаар бол тухайн мөрдөн шалгах ажиллагаа, мөрдөн байцаалтын явцад хийгдэх шүүхийн хэлэлцүүлэгт шүүх, прокурор, мөрдөгч нь томилогдсон өмгөөлөгчийг оролцуулж болно.
- 8.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид өмгөөлөгч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах журмыг Монголын Өмгөөлөгчдийн Холбооны саналыг харгалзан хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.3 дугаар зүйл.Өмгөөлөгч оролцуулах

1.Дараахь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч оролцох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өмгөөлөгчгүйгээр явуулж болохгүй:

- 1.1.хөгжлийн бэрхшээл, сэтгэцийн, эсхүл хүнд өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй;
- 1.2.өсвөр насны;
- 1.3.монгол хэл, бичиг мэдэхгүй;
- 1.4.бүх насаар хорих ял оногдуулж болох;
- 1.5.хэргийн талаар харилцан эсрэг сонирхолтой сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн нэг нь өмгөөлөгчтэй байгаа бол бусад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч;
- 1.6.өмгөөлөгч оролцуулах хүсэлт гаргасан.

[/Энэ заалт ад 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан/](#)

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хүсэлтээр, эсхүл зөвшөөрснөөр энэ хуулийн 5.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу өмгөөлөгч сонгоогүй бол шүүх, прокурор нь томилогдсон өмгөөлөгч оролцуулна.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх хүсэлтийг бичгээр гаргасан бол өмгөөлөгч оролцуулахгүйгээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж болно.

5.4 дүгээр зүйл.Өмгөөлөгчийн үйл ажиллагаа явуулах баталгаа

- 1.Хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа эрүүгийн хэрэгтэй нь холбогдуулан өмгөөлөгчөөс мэдүүлэг авах, мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахыг хориглоно.
- 2.Хуульд өөрөөр заагаагүй бол шүүгч, прокурор, мөрдөгч нь өмгөөлөгчөөс үйлчлүүлэгчтэйгээ байгуулсан хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээг шаардахыг хориглоно.

[/Энэ хэсгийг 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ БАЙГУУЛЛАГА, АЛБАН

ТУШААЛТАН

6.1 дүгээр зүйл.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага

1.Тагнуулын байгууллага дараахь гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна:

- 1.1.Эрүүгийн хуулийн 14.9 /Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах/, 19.1/Эх орноосоо урвах/, 19.2/Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, саатуулах/, 19.3/Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах/, 19.4/Гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах/, 19.5/Зэвсэгт үймээн дэгдээх/,

19.6/Хорлон сүйтгэх/, 19.7/Хорлон сүйтгэх ажиллагаанд бэлтгэх/, 19.8/Экстремист үйл ажиллагаа явуулах/, 19.9/Үндэсний эв нэгдлийг бусниулах/, 19.10/Тагнуул хийх/, 19.11/Төрийн нууцыг хууль бусаар олж авах/, 19.12/Төрийн нууцыг задруулах/, 19.13/Төрийн нууцыг үрэгдүүлэх/, 19.14/Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх/, 20.1/Террорист үйлдлийн талаар зориуд худал мэдээлэх/, 20.2/Террорист үйл ажиллагаанд уриалах, түүнийг нийтийн өмнө зөвтгөх, хатгах/, 21.13/Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих/, 26.1 дүгээр зүйлийн 6.2 дахь заалт /Кибер орчинд хууль бусаар халдах/, 26.2 дугаар зүйлийн 2.2 дахь заалт /Кибер орчинд хууль бусаар халдах, программ хангамж, техник хэрэгсэл бүтээх, бэлтгэх, борлуулах, ашиглах, тараах/, 27.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг /Агаарын хөдөлгөөний аюулгүй байдалд халдах/, 29.1/ Түрэмгийлэл, эсхүл дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх/, 29.3/Үй олноор хөнөөх зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, борлуулах/, 29.5/Төрлөөр устгах/, 29.6/Хөлсний цэрэг ашиглах/, 29.7/Олон улсын хамгаалалтад байдаг хүнд халдах/, 29.8/Террорист үйлдэл хийх/, 29.9/Террорист үйлдэлд бэлтгэх/, 29.10/Терроризмыг санхүүжүүлэх/, 29.11/Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх/ дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт;

[/Энэ заалтад 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ заалтад 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтад 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтад 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ заалтад 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

1.2.тагнуулын байгууллага өөрсдөө илрүүлсэн Эрүүгийн хуулийн 13.1/Хүн худалдаалах/, 18.2/Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөх/, 18.5/Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх/, 18.6/Мөнгө угаах/ дугаар зүйл, 18.19/Виртуал хөрөнгийн үйлчилгээний дотоод мэдээллийг хууль бусаар ашиглах/ дүгээр зүйл, 18.20/Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд арилжааг урвуулан ашиглах/ дугаар зүйл, 20.7 дугаар зүйлийн 3.3-т, 26.1 дүгээр зүйлийн 6.1 дэх заалт /Кибер орчинд хууль бусаар халдах/, 26.2 дугаар зүйлийн 2.1 дэх заалт /Кибер орчинд хууль бусаар халдах, программ хангамж, техник хэрэгсэл бүтээх, бэлтгэх, борлуулах, ашиглах, тараах/-д заасан гэмт хэрэгт.

[/Энэ заалтад 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ заалтад 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан./](#)

2.Авлигатай тэмцэх байгууллага дараахь гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна:

2.1.Эрүүгийн хуулийн 22.1/Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/, 22.3/Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/, 22.4/Нийтийн албан тушаалтан хахууль авах/, 22.5/Хахууль өгөх/, 22.6/Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах/, 22.7/Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх/, 22.8/Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/, 22.9/Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/, 22.10/Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/, 22.11/Дураараа аашлах/, 22.12/Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/, 22.13/Хахууль авах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт;

[/Энэ заалтад 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтад 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

2.2.Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад илрүүлсэн Эрүүгийн хуулийн 18.6/Мөнгө угаах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт.

3.Цагдаагийн байгууллага энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаас бусад гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна.

4.Тагнуул, цагдаа, авлигатай тэмцэх байгууллагын албан хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах харьяаллыг прокурор тогтооно.

6.2 дугаар зүйл.Мөрдөгч

1.Мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хуульд заасан эрх, үүргийн дагуу, эсхүл прокурорын даалгавраар энэ хуулиар харьяалуулсан эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулна.

2.Мөрдөгч дараахь эрхтэй:

2.1.хэрэг бүртгэлтийн хэрэг нээх;

2.2.эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах санал прокурорт гаргах;

2.3.энэ хуульд заасны дагуу сэжигтнийг баривчлах;

2.4.хойшлуулшгүйгээс бусад тохиолдолд прокурорын зөвшөөрлөөр явуулах мөрдөн шалгах ажиллагааг явуулах саналыг прокурорт гаргах;

2.5.прокурорын зөвшөөрөл авахаар хуульд зааснаас бусад тохиолдолд гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, олж тогтоох мөрдөн шалгах ажиллагааг бие даан явуулах;

2.6.гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагчийг дуудан ирүүлэх;

2.7.шинжилгээ хийлгэхээр шинжээч томилох;

2.8.мөрдөгч авахаар хуульд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, хүчингүй болгох, шүүх, прокурор авахаар хуульд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, хүчингүй болгох, өөрчлөх тухай саналыг прокурорт гаргах;

2.9.сэжигтнийг баривчлах шүүхийн зөвшөөрөл авах тухай саналыг прокурорт гаргах;

2.10.оролцогчийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх;

2.11.прокурорын даалгавраар мөрдөн шалгах ажиллагаа явуулах, даалгаврыг эс зөвшөөрвөл хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор тухайн прокурорын газрын дээд шатны прокурорт саналаа бичгээр нэг удаа гаргах;

[/Энэ заалт ад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

2.12.хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгосон прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл 5 хоногийн дотор дээд шатны прокурорт бичгээр санал гаргах;

2.13.прокурорын зөвшөөрлөөр мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулахаар эрх бүхий байгууллагад даалгавар бичиж, гүйцэтгүүлэх;

2.14.өөр нутаг дэвсгэрт мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрэн сурвалжлах шаардлага гарвал энэ тухай даалгаврыг бичгээр хүргүүлэх ба түүнийг хүлээн авсан мөрдөн шалгах байгууллага даалгаврыг заасан хугацаанд биелүүлж, хариуг цугларсан нотлох баримтын хамтаар ирүүлэх;

[/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.15.энэ хуульд заасан бусад эрх.

3.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрэн сурвалжлах, мөрдөн шалгах ажиллагааг харьяаллын бус мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагаар хийлгэх шаардлага гарвал мөрдөгч энэ тухай саналаа прокурорт гаргана. Прокурорын даалгаврыг хүлээн авсан тухайн мөрдөн шалгах ажиллагааг явуулах байгууллага даалгаврыг заасан хугацаанд биелүүлж, хариуг цугларсан нотлох баримтын хамт прокурорт хүргүүлнэ.

4.Мөрдөгч гэмт хэргийн бодит байдлыг тогтоох, гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох талаар энэ хуульд заасан ажиллагаа явуулна.

5.Тусгай мэдлэг эзэмшсэн мөрдөгч энэ хуульд заасан шинжээчийн эрхийг хэрэгжүүлж, магадлагаа гаргаж болно.

6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан эрхийг хэрэгжүүлэх мөрдөгч нь шинжилгээ хийлгэхээр томилогдсон шинжээчтэй хамтран ажиллаж болно.

7.Мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадлага хэрэглэж болно.

8.Энэ зүйлийн 2.14 дэх заалт нь энэ хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэгт заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага хооронд өгөх даалгаварт хамаарахгүй.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

6.3 дугаар зүйл.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны даргын эрх хэмжээ

1.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад дараахь эрхтэй:

1.1.мөрдөн шалгах ажиллагааг зохион байгуулалтын болон мэргэжлийн удирдлагаар хангах замаар гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох талаар шуурхай зохицуулалт хийх;

1.2.мөрдөн шалгах ажиллагаа явуулах үүргийг нэг, эсхүл хэд хэдэн мөрдөгчид даалгах;

1.3.шаардлагатай гэж үзвэл тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурорт мэдэгдэж хэргийг нэг мөрдөгчөөс нөгөө мөрдөгчид шилжүүлэх;

1.4.хавтаст хэргийн материалтай биечлэн танилцах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцох, мөрдөгчид дэмжлэг үзүүлэх зорилгоор бичгээр зааварчилга өгч, биелэлтийг хангуулах;

1.5.шаардлагатай тохиолдолд мөрдөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

1.6.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч хууль зөрчиж оролцогчид хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

ДОЛДУГААР БҮЛЭГ ЯЛЛАГДАГЧ

7.1 дүгээр зүйл.Яллагдагч

1.Энэ хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг яллагдагч гэнэ.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа шүүгдэгчид энэ бүлэгт заасан эрх, үүрэг нэгэн адил хамаарна.

7.2 дугаар зүйл. Гэм буруутай эсэхийг урьдчилан тогтоохыг хориглох

1. Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, шинжээчид яллагдагчийн гэм буруугийн талаар хөдөлбөргүй үнэн гэж урьдчилан тогтоосон ямар ч нотлох баримт байж болохгүй.
2. Шүүх гаргах гэж байгаа шийдвэр, яллагдагчийн гэм буруутай эсэх асуудлаар байр суурь, саналаа урьдчилан илэрхийлэх, шүүх, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, шинжээч, мэргэжилтэн хуулийн хүчин төгөлдөр шийдвэр гарах хүртэл яллагдагчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж олон нийтэд мэдээлэхийг хориглоно.

7.3 дугаар зүйл. Ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх

1. Яллагдагч ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх эрхтэй.
2. Яллагдагчаар татсан, таслан сэргийлэх арга хэмжээ авсан шийдвэртэй танилцах, шийдвэрийн хувийг авах эрхтэй.

[/Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

3. Сонсгосон ялын талаар бичгээр болон амаар тайлбар гаргах эрхтэй.
4. Баримт сэлт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах эрхтэй.
5. Мөрдөн байцаалт дууссан бол хэргийн материалтай танилцаж, төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг хуулбарлан авах эрхтэй.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7.4 дүгээр зүйл. Мэдүүлэг өгөх, өгөхөөс татгалзах

1. Яллагдагч эх хэлээрээ болон өөрийн сайн мэдэх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах, мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй.
2. Яллагдагч өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруугүйгээ, эсхүл хэргийн байдлыг нотлох үүрэг хүлээхгүй.
3. Яллагдагчийг өөрийнх нь эсрэг мэдүүлэг авахаар албадахыг хориглоно.

7.5 дугаар зүйл. Мэдээлэл авах

1. Яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар шүүх, прокурор, мөрдөгчөөс энэ хуульд заасны дагуу өгөхийг зөвшөөрсөн мэдээллийг авах эрхтэй.
2. Яллагдагч монгол хэл, бичиг мэдэхгүй бол өөрийн эх хэл, эсхүл мэдэх хэл, бичгээр, хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй бол дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдээллийг авах эрхтэй.
3. Яллагдагч өөрийнх нь хүсэлтээр хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагаанд оролцох, уг ажиллагааны тэмдэглэлтэй танилцах, түүнд засвар оруулах хүсэлт гаргах эрхтэй.
4. Яллагдагч шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлттэй танилцах, мөрдөн байцаалт дууссаны дараа хавтаст хэргийн материалтай танилцаж, төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг дууны, дүрсний, дуу-дүрсний болон бусад техник хэрэгсэл ашиглан өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах эрхтэй.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

7.6 дугаар зүйл. Өмгөөлөгчтэй харилцах

1. Яллагдагч өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах, амаар, эсхүл бичгээр чөлөөтэй харилцах эрхтэй.
2. Өмгөөлөгч цагдан хоригдсон яллагдагчтай ганцаарчлан уулзах өрөө нь харилцааны нууцлалыг хангасан байна.
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгч нь яллагдагч өөрийгөө өмгөөлөх, эсхүл өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх боломжоор хангана.

7.7 дугаар зүйл. Гомдол, хүсэлт гаргах

1. Баривчлагдсан сэжигтэн, цагдан хоригдсон яллагдагч, шүүгдэгч нь түүнийг баривчилсан, цагдан хорьсон нь хууль ёсны эсэхийг шүүхээр хянуулах, хууль бусаар баривчилсан, цагдан хорьсон бол суллуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй.
2. Яллагдагч хэргээ шүүхэд шилжүүлж, хэлэлцүүлэхийг шаардах, энэ талаар гомдол гаргах эрхтэй.
3. Яллагдагч нь шүүх, прокурор, өмгөөлөгч, мөрдөгчийн ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах эрхтэй.
4. Бусад этгээдээс шүүхийн шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцэлтэй танилцах, түүнд тайлбар өгөх эрхтэй.
5. Мөрдөгч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах эрхтэй.

6.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх гомдол гаргах эрхтэй.

7.8 дугаар зүйл.Шүүх хуралдаанд оролцох

- 1.Яллагдагч анхан шатны шүүх хуралдаанд биечлэн оролцоно.
- 2.Яллагдагч шүүхийн хэлэлцүүлэгт оролцох хүсэлт гаргавал талуудын саналыг харгалзан шүүх шийдвэрлэнэ.
- 3.Яллагдагчийг энэ хуульд заасан үндэслэлээр дуу-дүрсний төхөөрөмж ашиглан өөр газраас шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд оролцуулж болно.

7.9 дүгээр зүйл.Яллагдагчийн үүрэг

- 1.Яллагдагч дараахь үүрэг хүлээнэ:
 - 1.1.шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудсан цагт хүрэлцэн ирэх;
 - 1.2.шүүх хуралдааны дэгийг сахих;
 - 1.3.шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэр, хууль ёсны шаардлагыг биелүүлэх;
 - 1.4.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад санаатай саад учруулахгүй байх;
 - 1.5.оролцогч, бусад оролцогчид нөлөөлөхгүй байх.
- 2.Яллагдагч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй нь хуульд заасны дагуу албадлага хэрэглэх, хариуцлага хүлээлгэх, түүнд авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх үндэслэл болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ХОХИРОГЧ, ИРГЭНИЙ НЭХЭМЖЛЭГЧ, ИРГЭНИЙ ХАРИУЦАГЧ

8.1 дүгээр зүйл.Хохирогч

- 1.Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ.
- 2.Шүүх, прокурор, мөрдөгч хохирогчоор тогтоох тухай шийдвэр гаргана.
- 3.Хохирогч энэ хуульд заасан эрхээ хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж болно.

8.2 дугаар зүйл.Хохирогчийн эрх

- 1.Хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дараахь эрхтэй:
 - 1.1.өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах;
 - 1.2.хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг гаргаж өгч хавтаст хэрэгт бэхжүүлж тусгуулах;
 - 1.3.мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;
 - 1.4.шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд оролцох;
 - 1.5.шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр шүүгдэгч, гэрч, шинжээчид асуулт тавих;
 - 1.6.шүүх, прокурор, мөрдөгчийн ажиллагаа, шийдвэрт энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргах;
 - 1.7.эх хэлээрээ, эсхүл сайн мэдэх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;
 - 1.8.хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол хавтаст хэргээс өөрт хамааралтай хэсэгтэй танилцаж, төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг хуулбарлаж, хувилж авах эрхтэй;

[/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

- 1.9.гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах;
- 1.10.шүүхийн цагаатгах, шийтгэх тогтоолын хувийг авах;
- 1.11.шүүгч, прокурор, мөрдөгч, орчуулагч, хэлмэрч, шинжээч, мэргэжилтэн, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;
- 1.12.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгчийн хууль зөрчиж учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх гомдол гаргах;
- 1.13.шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлтийн өөрт хамааралтай хэсэгтэй танилцах;

[/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

1.14.өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх;

[/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

1.15.энэ хуульд заасан бусад эрх.

[/Энэ заалтын дугаарт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

2.Хохирогч нас барсан, эрх зүйн чадамжгүй болсон, эсхүл өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах чадваргүй бол энэ зүйлд заасан эрхийг түүний хууль ёсны төлөөлөгч эдэлнэ.

3.Хохирогч дараахь үүрэгтэй:

3.1.шүүх, прокурорын дуудсанаар хүрэлцэн ирэх;

3.2.хэргийн талаар үнэн зөв мэдүүлэг өгөх;

3.3.өөрт илэрхий болсон хэргийн талаархи мэдээллийг задруулахгүй байх;

3.4.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам сахих.

4.Хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Зөрчлийн тухай хууль, эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

8.3 дугаар зүйл.Мэдээллээр хангуулах

1.Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу дараахь ажиллагааг явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө прокурор түүнд энэ тухай мэдэгдэнэ:

1.1.яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх эсэхийг шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлэг;

1.2.хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг харьяаллын дагуу шилжүүлэх;

1.3.ялсныг хорих ялаас хугацааны өмнө суллах асуудлыг шийдвэрлэх хуралдаан.

2.Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авсан, өөрчилсөн, хүчингүй болгосон, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, хаасан, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хэргийг прокурорт шилжүүлсэн талаар мөрдөгч түүнд мэдэгдэнэ.

3.Прокурор, мөрдөгч хуулиар хамгаалагдсан төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой асуудлаар хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдээлэл өгөхгүй.

[/Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

4.Прокурор, мөрдөгч нь гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчийн аюулгүй байдалд эрсдэл учруулж болох, эсхүл мөрдөн шалгах ажиллагаа явуулахад саад учруулж болох үндэслэл бүхий сэжиг байгаа бол энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна бусад мэдээллийг нууцалж болно.

8.4 дүгээр зүйл.Аюулгүй байдлаа хамгаалуулах

1.Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хохирогчийн хамаарал бүхий этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, энэ хуульд заасны дагуу хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалуулах тусалцаа авах хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргаж болно.

8.5 дугаар зүйл.Иргэний нэхэмжлэгч

1.Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээлгэхээр шаардлага тавьж байгаа хүн, хуулийн этгээдийг иргэний нэхэмжлэгч гэнэ.

2.Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ.

3.Мөрдөгч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргаж иргэний нэхэмжлэгчээр тогтооно.

4.Эрүүгийн хэрэгт гаргасан иргэний нэхэмжлэл нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөнө.

5.Иргэний нэхэмжлэгчид энэ хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.4, 1.5, 1.6, 1.8, 1.10, 1.11-т заасан эрх болон энэ бүлэгт заасан үүрэг нэгэн адил хамаарна.

6.Гэмт хэргийн улмаас учирсан хохиролтой холбогдолтой нэхэмжлэлийг тухайн эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй байхад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэхийг хориглоно.

7.Иргэний нэхэмжлэгч нь шүүхийн тогтоол, магадлалын зөвхөн иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргаж болно.

8.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэл байхгүй бол нэхэмжлэл гаргасан хүн, хуулийн этгээдийн нэхэмжлэлийг хүлээн авах, иргэний нэхэмжлэгчээр тогтоохоос үндэслэл бүхий шийдвэр гарган татгалзаж болох ба энэхүү шийдвэрт гомдол гаргах журмыг нэхэмжлэл гаргагчид тайлбарлана.

9.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нэхэмжлэгчээр тогтоохоос татгалзсан нь шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх шатанд тухайн асуудлаар дахин нэхэмжлэл гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

10.Иргэний нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзах эрхтэй.

11.Нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын болон шүүх хуралдааны тэмдэглэлд тусгах ба хэрэв бичгээр гаргасан бол хавтаст хэрэгт хавсаргана.

12.Нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг мөрдөгч, прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед хүлээн авах ба энэ тухай тогтоол гаргана.

13.Шүүхэд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх үед нэхэмжлэлээс татгалзах тухай хүсэлтийг шүүх зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө гаргаж болох ба хүсэлтийг шүүх хангана.

14.Нэхэмжлэлээс татгалзсан нь хууль зөрчсөн, эсхүл аль нэг этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон гэж үзвэл мөрдөгч, прокурор, шүүх нь түүний хүсэлтийг хүлээн авахгүй байж болох ба энэ тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.

8.6 дугаар зүйл.Иргэний хариуцагч

1.Өсвөр насны яллагдагчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнчлэн гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хууль ёсоор хариуцвал зохих хүн, хуулийн этгээдийг иргэний хариуцагчаар татан оролцуулж болно.

2.Иргэний хариуцагчаар татахдаа мөрдөгч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

3.Иргэний хариуцагч, түүний төлөөлөгч дараахь эрх эдэлнэ:

3.1.нэхэмжлэлийн талаар тайлбар гаргах;

3.2.баримт сэлт, хүсэлт гаргах;

3.3.энэ хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.10, 1.11, 1.12-т заасан эрх.

4.Иргэний хариуцагч, түүний төлөөлөгч нь энэ бүлэгт заасан үүргийг хүлээнэ.

5.Иргэний хариуцагчид энэ хуулийн 8.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан журам нэгэн адил хамаарна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ОРОЛЦОГЧ

9.1 дүгээр зүйл.Шинжээч

1.Прокурор, мөрдөгч нь өөрийн санаачилгаар, эсхүл оролцогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах асуудлыг тодруулахаар, эсхүл эд зүйл, хөрөнгийн үнэлгээ, хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоолгохоор шинжилгээ хийлгэх шийдвэр гаргаж, шинжээч томилно.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.Шинжээч хийсэн шинжилгээгээ үндэслэн тусгай мэдлэгийн хүрээнд өөрийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ.

3.Шинжилгээ хийлгэх шийдвэрт Шүүх шинжилгээний тухай хуулийн 7.3-т заасан зүйлийг тусгана.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

4.Шинжээч шинжилгээ хийж, дүгнэлт гаргахдаа энэ хууль, Шүүх шинжилгээний тухай хуульд заасан журмыг баримтална.

[/Энэ хэсэг т 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

5.Шинжээч гаргасан дүгнэлттэй холбоотой асуудлаар шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирж мэдүүлэг өгнө.

9.2 дугаар зүйл.Шинжээчийн эрх, үүрэг

1.Шинжээч нь Шүүх шинжилгээний тухай хуулийн 49.1-д заасан эрхээс гадна дараах эрхийг эдэлнэ:

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

1.1.хавтаст хэргийн материалаар шинжилгээ хийх тохиолдолд хавтаст хэргийн материалаас шинжилгээ хийх зүйлд холбогдох хэсэгтэй танилцах;

[/Энэ заал т-ыг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

1.2.прокурор, мөрдөгчийн зөвшөөрснөөр мөрдөн шалгах ажиллагаанд оролцох, түүнчлэн шинжилгээ хийхтэй холбоотой асуудлаар оролцогчид асуулт тавих, мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах;

[/Энэ заал т-ыг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

1.3.дүгнэлт гаргахад хэрэгцээтэй нэмэлт баримт ирүүлэх талаар шүүх, прокурор, мөрдөгчид хандаж хүсэлт гаргах;

[/Энэ заал т-ыг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

1.4.аюулгүй байдлаа хангуулах талаар хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргах.

[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ заалт 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулийн өөрчлөн найруулалтаар хасагдсан./](#)

[/Энэ заалт 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулийн өөрчлөн найруулалтаар хасагдсан./](#)

2.Шинжээч нь шүүх, прокурор, мөрдөгчийн тавьсан асуултын дагуу тусгай мэдлэг, мэргэжлийн хүрээнд шинжилгээг тал бүрээс нь бүрэн бодитой хийж, тогтоосон хугацаанд шинжлэх ухааны үндэслэл бүхий дүгнэлтийг бичгээр гаргана.

3.Дүгнэлт гаргасан шинжээч нь мэдүүлэг авахаар шүүх, прокуророос дуудсан цагт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг энэ хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан ирүүлнэ.

4.Шинжээч тавьсан асуултын заримыг санаатайгаар хариулахгүй орхисон, эсхүл тогтоосон хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн, эсхүл худал дүгнэлт гаргасан бол хуульд заасан хариуцлага хүлээнэ.

9.3 дугаар зүйл.Мэргэжилтэн

1.Шаардлагатай тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааны явцад, эсхүл шүүх хуралдаанд ул мөр, эд мөрийн баримт илрүүлэх, бэхжүүлэх, хамгаалах, техник хэрэгсэл, төхөөрөмж ашиглах, ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, хүний амь нас, эрүүл мэндэд аюул, эсхүл орчинд хөнөөл учруулж болзошгүй тэсэрч дэлбэрэх, химийн хортой бодис, бусад эд зүйл байвал тэдгээрийг аюулгүй болгох, зөвлөгөө авах зорилгоор тухайн хэрэгт хувийн сонирхолгүй тусгай мэдлэг, туршлага бүхий хүнийг шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэрээр мэргэжилтнээр оролцуулж болно.

2.Мэргэжилтэн дараахь эрхтэй:

- 2.1.өөрийн оролцож байгаа ажиллагаатай холбогдуулан асуулт тавих;
- 2.2.техник хэрэгсэл, төхөөрөмж ажиллуулах;
- 2.3.өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах хүсэлт гаргах;
- 2.4.гүйцэтгэсэн ажлын хөлс, зардлыг авах /албан үүргийнхээ хувиар оролцсон бол энэ заалт хамаарахгүй/;
- 2.5.өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангуулах хүсэлт гаргах.

3.Мэргэжилтэн дараахь үүрэгтэй:

- 3.1.шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирж, өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаатай холбогдуулан мэдүүлэг өгөх;
- 3.2.өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой асуудлаар оролцогчийн асуултад хариулах, тайлбарлах;
- 3.3.өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагааны нууцлалыг задруулахгүй байх.

9.4 дүгээр зүйл.Орчуулагч, хэлмэрч

1.Энэ хуулийн 1.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тохиолдолд шүүх, прокурор, мөрдөгч нь орчуулга хийх, хэлмэрчлэх мэдлэг, чадвартай хүнийг орчуулагч, хэлмэрчээр томилно.

2.Орчуулагч, хэлмэрч дараахь эрхтэй:

- 2.1.өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах хүсэлт гаргах;
- 2.2.орчуулах, хэлмэрчлэх мэдлэг, чадвар хүрэхгүй бол оролцохоос татгалзах;
- 2.3.гүйцэтгэсэн ажлын хөлс, зардлыг авах.

3.Орчуулагч, хэлмэрч дараахь үүрэгтэй:

- 3.1.шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсан цагт хүрэлцэн ирж орчуулах, хэлмэрчлэх;
- 3.2.үнэн зөв орчуулж, хэлмэрчлэх;
- 3.3.баримт бичиг, эсхүл түүний оролцоотой явагдсан мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлд үнэн зөв орчуулж, хэлмэрчилснийг баталж гарын үсэг зурах;
- 3.4.хэлмэрчлэх, орчуулах явцад мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэл, хэргийн талаархи баримт, мэдээллийг задруулахгүй байх;

[/Энэ заалтад 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

3.5.мөрдөн шалгах ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих.

4.Орчуулагч, хэлмэрч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үүргээ биелүүлээгүй, эсхүл санаатай зөрчсөн бол хуульд заасан хариуцлага хүлээнэ.

5.Энэ зүйлд заасан журам нь сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг мэдэх хэлмэрчид нэгэн адил хамаарна.

9.5 дугаар зүйл.Хууль ёсны төлөөлөгч

1.Мөрдөгч, прокурор дараахь хүнийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтооно:

1.1.өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг;

1.2.хохирогч, хуулийн этгээдийг төлөөлөх албан тушаалтан, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг;

1.3.хохирогч нас барсан, эсхүл сэтгэцийн, эрүүл мэндийн шалтгаанаар өөрийн хүсэл сонирхлоо илэрхийлж чадахгүй тохиолдолд түүний төрсөн, үрчилж авсан эцэг, эх, эхнэр, нөхөр, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг.

2.Энэ зүйлийн 1.1-д заасны дагуу арван найман насанд хүрээгүй хүний хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоож болно.

3.Хууль ёсны төлөөлөгчийг тогтоохтой холбоотой маргааныг шүүх, прокурор шийдвэрлэнэ.

4.Хууль ёсны төлөөлөгч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийн төлөөлөн оролцож байгаа оролцогчийн энэ хуульд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

9.6 дугаар зүйл.Гэрч

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ.

2.Гэрч шүүх, прокурорын дуудсанаар хүрэлцэн ирж, хэргийн талаар өөрийн мэдэх зүйлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.

3.Гэрч дуудсан цагт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол түүнийг шүүхийн шийдвэрээр албадан ирүүлнэ.

4.Гэрч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Зөрчлийн тухай хууль, эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

5.Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй.

6.Гэрч өөрийнх нь эсрэг, түүнийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай байдлаар мэдүүлэг авч байна гэж үзвэл энэ тухай тэмдэглэлд тусгуулан мэдүүлэг өгөхөөс татгалзаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхтэй.

7.Гэрч мэдүүлэг өгөхөөр дуудагдан ирсэн зардлаа төлүүлэх, энэ хуульд заасны дагуу аюулгүй байдлаа хамгаалуулах эрхтэй.

8.Шүүх, прокурор, мөрдөгч мэдүүлэг авахаас өмнө гэрчид энэ хуульд заасан гэрчийн эрх, үүргийг тайлбарлаж өгнө.

9.7 дугаар зүйл.Хөндлөнгийн гэрч

1.Прокурор, мөрдөгч нь хөндлөнгийн гэрч оролцуулахаар энэ хуульд заасан мөрдөн шалгах ажиллагааны явц, үр дүнг баталгаажуулахаар тухайн ажиллагаанд хоёроос доошгүй хөндлөнгийн гэрчийг оролцуулна.

2.Хөндлөнгийн гэрч тухайн хэрэгт хувийн сонирхолгүй хүн байна.

3.Хөндлөнгийн гэрч өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагааны талаар гомдол гаргах, мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлтэй танилцах, түүнд засвар оруулах хүсэлт гаргах эрхтэй.

4.Хөндлөнгийн гэрчээр оролцсон хүн гэрчийн мэдүүлэг өгөхөөр шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирэх, мөрдөн шалгах ажиллагааны журам сахих, нууцыг задруулахгүй байх үүрэгтэй.

5.Хөндлөнгийн гэрч оролцох боломжгүй бол тухайн ажиллагааны явц, үр дүнг дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ.

АРАВДУГААР БҮЛЭГ ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОЖ БОЛОХГҮЙ ҮНДЭСЛЭЛ

10.1 дүгээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч оролцож болохгүй үндэслэл

1.Шүүгч дараахь үндэслэл байвал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй:

1.1.оролцогчийн хувиар тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа, эсхүл оролцохоор бол;

1.2.тухайн хэргийн прокурор, мөрдөгч, өмгөөлөгч, оролцогчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн бол;

1.3.өмнө нь тухайн хэрэгт прокурор, мөрдөгч, оролцогч, бусад оролцогч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар оролцсон бол;

1.4.өөрөө шууд, эсхүл шууд бусаар энэ хэрэгт хувийн сонирхолтой байна гэж үзэх бусад үндэслэл байгаа бол.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүх бүрэлдэхүүнд хоорондоо гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн холбоотой шүүгч оролцож болохгүй.

3.Анхан шатны шүүх бүрэлдэхүүнд орсон шүүгчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн уг хэргийг давж заалдах, хяналтын

журмаар хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд орж болохгүй.

4.Шүүгч энэ зүйлийн 1.1, 1.2, 1.3-т заасан үндэслэлийг мэдмэгц эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзах үүрэгтэй ба уг үүргээ биелүүлээгүй бол гаргасан шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүй болгоно.

10.2 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч дахин оролцож болохгүй үндэслэл

1. Эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.

2. Энэ хуулийн 13.5 дугаар зүйлд заасны дагуу хамтран ажиллах этгээдээр тогтоосон шийдвэр гаргасан шүүгч уг хүний үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүгчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн холбоотой шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.

10.3 дугаар зүйл. Шүүгчийг татгалзан гаргах

1. Энэ хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр шүүгчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах тухай хүсэлтийг прокурор, оролцогч гаргаж болно.

2. Шүүгчийг татгалзан гаргах асуудлыг шүүх хуралдаан эхлэхээс өмнө шийдвэрлэнэ. Шүүх хуралдаан эхэлснээс хойш татгалзан гаргах үндэслэл мэдэгдвэл уг хүсэлтийг шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө гаргаж болно.

10.4 дүгээр зүйл. Шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хянан шийдвэрлэх

1. Хэргийг дангаар шийдвэрлэж байгаа шүүгчийг энэ хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр татгалзвал шүүгч шүүх хуралдааныг хойшлуулж, уг асуудлыг тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид танилцуулж шийдвэрлүүлнэ.

2. Ерөнхий шүүгчийг энэ хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр татгалзан гаргах хүсэлтийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд танилцуулж шийдвэрлүүлнэ.

3. Шүүх бүрэлдэхүүний аль нэг шүүгчийг энэ хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр татгалзан гаргах хүсэлтийг шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд шийдвэрлэж, санал тэнцвэл уг шүүгчийг татгалзсанд тооцно.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг тухайн шүүгчийг байлцуулахгүйгээр шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэх боловч татгалзагдаж байгаа шүүгч уг асуудлын талаар шүүх бүрэлдэхүүнд тайлбар гаргаж болно.

5. Шүүх бүрэлдэхүүний олонхийг энэ хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд заасан үндэслэлээр татгалзсан бол уг асуудлыг шүүх хуралдаан даргалагч тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид танилцуулж шийдвэрлүүлнэ.

6. Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу татгалзан гаргах шүүх бүрэлдэхүүнд Ерөнхий шүүгч багтаж байгаа, эсхүл нийт шүүгчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан тохиолдолд энэ тухай тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнд танилцуулж шийдвэрлүүлнэ.

7. Ерөнхий шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх шүүгчдийн зөвлөгөөнд Ерөнхий шүүгч уг асуудлын талаар тайлбар гаргаж болох боловч санал өгөх эрхгүй.

8. Энэ зүйлийн 1, 2, 3, 5, 6 дахь хэсэгт заасан үндэслэлээр гаргасан шийдвэр эцсийн байна.

9. Хяналтын шатны шүүхийн хувьд энэ зүйлийн 1, 2, 5, 6 дахь хэсэгт заасан асуудлыг Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

10.5 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгчийг татгалзан гаргах

1. Энэ хуулийн 10.1 дүгээр зүйлд заасан үндэслэлээр прокурор, оролцогч иргэдийн төлөөлөгчийг татгалзан гаргах хүсэлт гаргаж болно.

2. Иргэдийн төлөөлөгчийг татгалзан гаргах хүсэлтийг хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд шийдвэрлэнэ. Шүүх бүрэлдэхүүн шаардлагатай гэж үзвэл татгалзан гаргаж байгаа иргэдийн төлөөлөгчийн тайлбарыг сонсож болно.

10.6 дугаар зүйл. Шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах

1. Энэ хуулийн 10.1, 10.2, 10.3 дугаар зүйлд заасан журам шүүх хуралдааны нарийн бичгийн даргад нэгэн адил хамаарах боловч тухайн шүүх хуралдаанд урьд нь шүүх хуралдааны нарийн бичгийн даргаар оролцож байсан нь түүнийг татгалзан гаргах үндэслэл болохгүй.

2. Шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах хүсэлтийг эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгч, шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэх ба энэ шийдвэр эцсийн байна.

10.7 дугаар зүйл. Прокурорыг татгалзан гаргах

1. Прокурорыг татгалзан гаргахтай холбоотой асуудлыг энэ хуулийн 10.1, 10.3 дугаар зүйлд заасан журмаар зохицуулна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр прокурорыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гаргах хүсэлтийг оролцогч гаргаж болно.

3.Шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг, шүүх хуралдаанд оролцож байгаа прокурорыг татгалзан гаргах хүсэлтийг тухайн асуудлыг хянан шийдвэрлэж байгаа шүүх шийдвэрлэнэ.

[/Энэ хэсэг т 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

4.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хяналт тавих явцад гаргасан прокурорыг татгалзан гаргах хүсэлтийг дээд шатны прокурор шийдвэрлэнэ.

5.Прокурорыг татгалзан гаргах талаар энэ хуульд заасан үндэслэл байгаа, эсхүл энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу прокурорыг татгалзан гаргах шийдвэр шүүх гаргасан бол дээд шатны прокурор нь өөр прокурорыг томилно.

6.Энэ зүйлийн 3, 4, 5 дахь хэсэгт заасан үндэслэлээр гаргасан шийдвэр эцсийн байна.

10.8 дугаар зүйл.Өмгөөлөгчөөр оролцож болохгүй тохиолдол

1.Дараахь тохиолдолд өмгөөлөгч тухайн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй:

1.1.шүүхэд төлөөлөх эрхийг нь түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон шийдвэр хүчин төгөлдөр байгаа;

1.2.тухайн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгч, прокурор, мөрдөгч, гэрч, шинжээчээр оролцож байсан бол;

1.3.гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн нь тухайн хэрэгт хэргийн талаар харилцан эсрэг сонирхолтой оролцогчийн өмгөөлөгчөөр оролцож байгаа, эсхүл оролцож байсан бол.

2.Хэргийн талаар харилцан эсрэг сонирхолтой хэд хэдэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хуулийн этгээдийг нэг өмгөөлөгч өмгөөлж болохгүй.

3.Өмгөөлөгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр татгалзаагүй бол тухайн ажиллагаанд оролцож байгаа хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, бусад өмгөөлөгч, прокурорын хүсэлтээр өмгөөлөгчийг татгалзан гаргах асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

[/Энэ хэсэг т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

10.9 дүгээр зүйл.Мөрдөгчөөр оролцож болохгүй тохиолдол

1.Энэ хуулийн 10.1 дүгээр зүйлд заасан үндэслэл байвал мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад оролцож болохгүй.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр мөрдөгчийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад оролцож болохгүй тухай хүсэлтийг оролцогч тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурорт гаргаж болно.

3.Прокурор нь мөрдөгчөөр оролцож болохгүй тухай асуудлыг өөрийн санаачилгаар, эсхүл оролцогчийн хүсэлтээр шийдвэрлэх ба энэ шийдвэр эцсийн байна.

10.10 дугаар зүйл.Орчуулагч, хэлмэрчээр оролцуулж болохгүй тохиолдол

1.Энэ хуулийн 10.1 дүгээр зүйлд заасан үндэслэл, түүнчлэн орчуулга хийж, хэлмэрчилж болохгүй бусад байдал илэрвэл орчуулагч, хэлмэрчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж болохгүй.

2.Оролцогч энэ хуулийн 10.1 дүгээр зүйлд заасан үндэслэлээр орчуулагч, хэлмэрчийг татгалзан гаргах хүсэлтийг прокурорт гаргаж болно.

3.Тухайн хэрэгт урьд нь орчуулагч, хэлмэрчээр оролцож байсан нь түүнийг татгалзан гаргах үндэслэл болохгүй.

4.Оролцогч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад орчуулагч, хэлмэрчийг татгалзан гаргах тухай хүсэлтээ мөрдөгчид, мөрдөгч хүсэлтийг нь зөвшөөрөхгүй бол прокурорт гомдол гаргана.

5.Шүүх хуралдааны явцад орчуулагч, хэлмэрчийг татгалзан гаргах хүсэлт гаргасан бол шүүгч, шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэнэ.

6.Орчуулагч, хэлмэрчийг татгалзан гаргах үндэслэл байгаа боловч орчуулагч, хэлмэрч тухайн мөрдөн шалгах ажиллагаанд оролцож байгаа оролцогч, прокурор, мөрдөгч зөвшөөрвөл энэ зүйлийг баримтлахгүй байж болно. Энэ үндэслэлээр хэлмэрч, орчуулагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу орчуулагч, хэлмэрч оролцсон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцыг энэ хуульд заасан тэмдэглэлээс гадна дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ.

10.11 дүгээр зүйл.Шинжээчээр оролцож болохгүй тохиолдол

1.Шинжээч дараахь үндэслэл байвал шинжээчээр оролцож болохгүй:

1.1.тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, прокурор, шүүгч, иргэдийн төлөөлөгч, оролцогч, бусад оролцогчийн хувиар оролцсон бол;

1.2.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн бол;

1.3.шинжээч нь албан тушаалын болон бусад талаар оролцогчийн эрхшээлд байгаа бол;

1.4.оролцогчтой хувийн харилцаатай бол;

1.5. шинжилгээ хийлгэх тухай тогтоолд тавьсан асуулт шинжээчийн тусгай мэдлэгийн хүрээнээс хэтэрсэн, эсхүл тавьсан асуултад шинжлэх ухааны арга, хэрэгсэл ашиглан хариулах боломжгүй бол.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл байвал шинжээч шинжилгээ хийх, дүгнэлт гаргахаас татгалзаж, томилсон шүүх, прокурор, мөрдөгчид энэ тухай даруй мэдэгдэнэ.

3. Шинжээч шинжилгээ хийх, дүгнэлт гаргахаас татгалзсан нь үндэслэлтэй гэж үзвэл шүүх, прокурор, мөрдөгч өөр шинжээчийг томилно.

4. Оролцогч нь шинжээчийг татгалзан гаргах тухай хүсэлтээ мөрдөгчид, мөрдөгч хүсэлтийг нь зөвшөөрөхгүй бол прокурорт гомдол гаргана.

10.12 дугаар зүйл. Татгалзан гаргах асуудлыг шийдвэрлэх дараалал

1. Хэд хэдэн хүнийг татгалзан гаргах хүсэлт нэг зэрэг гарвал эхний ээлжид шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргахтай холбоотой асуудлыг шийдвэрлэнэ.

2. Шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргахтай холбоотой асуудлыг шийдвэрлэсний дараа прокурор, өмгөөлөгч, бусад оролцогчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэнэ.

III ХЭСЭГ

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ НИЙТЛЭГ НӨХЦӨЛ

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ХУГАЦАА, ЗАРДАЛ, БАРИМТ БИЧИГ

11.1 дүгээр зүйл. Хугацаа тоолох

1. Энэ хуульд заасан хугацааг минут, цаг, хоног, сар, жилээр тоолно.

2. Хугацааг тоолж эхэлсэн минут, цаг, хоногийг хугацаа тоолоход оруулахгүй.

3. Хугацааг цагаар тоолоход уг хугацаа нь сүүлийн цаг, минутад дуусна.

4. Хугацааг хоногоор тоолоход уг хугацаа нь сүүлийн хоногийн 24 цагт дуусна.

5. Хугацааг сараар тоолоход сүүлийн сарын мөн өдөр уг хугацаа дуусна. Хэрэв энэ сард тохирох өдөр байхгүй бол мөн сарын эцсийн өдөр хугацаа дуусна.

6. Хугацааг жилээр тоолоход дараа оны тухайн сарын тухайн өдөр уг хугацаа дуусна. Хэрэв хугацааны төгсгөл ажлын бус өдөр тохиолдвол хугацааны сүүлийн өдрийг түүний дараагийн ажлын эхний өдрөөр тоолно.

7. Гомдол, бусад баримт бичгийг хугацаа дуусахын өмнө шууданд өгсөн, баривчлагдсан, цагдан хоригдсон хүн цагдан хорих байрны захиргаанд өгсөн бол хугацаа хэтэрсэнд тооцохгүй.

11.2 дугаар зүйл. Хугацааг сунгах

1. Энэ хуулиар тогтоосон хугацааг энэ хуульд заасан журмаар сунгаж болно.

11.3 дугаар зүйл. Хэтэрсэн хугацааг сэргээх

1. Хугацаа хэтрүүлсэн нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх, прокурор хэтэрсэн хугацааг сэргээх тухай шийдвэр гаргана.

2. Давж заалдах гомдлыг тогтоосон хугацаанаас хэтрүүлж гаргасан бол сонирхогч этгээдийн хүсэлтээр хэтэрсэн хугацааг сэргээх тухай асуудлыг шийдвэрлэх хүртэл түүнтэй холбогдох шийдвэрийг биелүүлэхийг түдгэлзүүлж болно.

3. Хэтэрсэн хугацааг сэргээх, шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэхийг татгалзсан тухай шүүх, прокурорын шийдвэрт гомдол гаргаж болохгүй.

11.4 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал дараахь зардлаас бүрдэнэ:

1.1. хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, гэрч, хөндлөнгийн гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагч, хэлмэрч, өмгөөлөгчид төлөх зардал;

1.2. эд мөрийн баримтыг хадгалах, шилжүүлэх, шинжлүүлэхэд гарах зардал;

1.3. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурор, шүүхээс оргон зайлсан яллагдагч, шүүгдэгчийг эрэн сурвалжлахад гарах зардал;

1.4. гэрч, хохирогч, шинжээч, яллагдагч, шүүгдэгчийг албадан ирүүлэх, шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүйгээс шүүх хуралдааныг хойшлуулахтай холбогдон гарах зардал;

1.5. тухайн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай шууд холбогдон гарах бусад зардал.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох, санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.

11.5 дугаар зүйл. Гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагч, хэлмэрчид зардал төлөх

- 1.Шүүхэд гэрч, шинжээч, мэргэжилтэн, орчуулагч, хэлмэрчээр дуудагдсан хүн дуудагдаж ирсэнтэй холбогдож гарсан зардлаа нөхөн төлүүлж авах эрхтэй.
- 2.Шинжээч, мэргэжилтэн, орчуулагч, хэлмэрч урамшуулал авах эрхтэй.
- 3.Албан үүргийнхээ хувиар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон шинжээч, мэргэжилтэн, орчуулагч, хэлмэрчид энэ зүйлийн 2 дахь хэсэг хамаарахгүй.

11.6 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг гаргуулах

- 1.Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болохыг шүүх тогтоовол түүнээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг холбогдох баримтыг үндэслэн гаргуулна.
- 2.Хэд хэдэн шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдвол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зардлын хэмжээг хүн нэг бүрийн үйлдсэн гэмт хэрэг, гэм буруугийн хэр хэмжээг харгалзан шүүх хуваарилж тогтооно.
- 3.Шүүх шүүгдэгчийг гэм буруутайд тооцсон боловч Эрүүгийн хуульд заасны дагуу ялаас чөлөөлсөн тохиолдолд шүүх түүнээс зардлыг гаргуулна.
- 4.Эрүүгийн хэргийг энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1-д заасны дагуу хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгосон, шүүгдэгчийг цагаатгасан, эсхүл ял шийтгүүлсэн хүн, хуулийн этгээд төлбөрийн чадваргүй болох нь тогтоогдсон бол түүнийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлаас чөлөөлж, зардлыг төр хариуцна.

11.7 дугаар зүйл. Шүүх хуралдааны тэмдэглэл

- 1.Энэ хуульд заасан шүүх хуралдааны явцыг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга тэмдэглэл хөтөлж, дууны, эсхүл дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулна.
- 2.Шүүх хуралдааны тэмдэглэлд шүүх хуралдааныг хэзээ, хаана хийсэн, эхэлсэн, дууссан цаг, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хэлэлцэж байгаа хэргийн дугаар, шүүгдэгчийн биеийн байцаалт, шүүх хуралдаан эхлэхээс дуусах хүртэлх бүх үйл явцыг нэг бүрчлэн тусгана.
- 3.Шүүх хуралдаан даргалагч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зурах боломжгүй бол энэ тухай шүүхийн захиргааны ажилтан тайлбар бичиж тэмдэглэлд хавсаргана.
- 4.Шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн тэмдэглэл хөтлөхөд энэ зүйл нэгэн адил хамаарна.

11.8 дугаар зүйл. Шүүх хуралдааны тэмдэглэл танилцуулах

- 1.Шүүх хуралдааны тэмдэглэлийг шүүхийн шийдвэрийг уншиж сонсгосноос хойш 7 хоногийн дотор гаргаж, шүүх хуралдаан даргалагч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, прокурор, оролцогчид танилцуулна.
- 2.Шүүх хуралдаанд оролцогч, бусад оролцогч, прокурор шүүх хуралдааны тэмдэглэлийг танилцуулснаас хойш 5 хоногийн дотор засвар оруулах санал, хүсэлт гаргах, төрийн нууцад хамаарахаас бусад хэсгийг хуулбарлан авах эрхтэй.

[/Энэ хэсэг т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

- 3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан санал, хүсэлтийг хүлээн авсан шүүх 3 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.
- 4.Шүүх хуралдааны тэмдэглэлд засвар оруулах санал, хүсэлтийг хэлэлцэхэд шаардлагатай бол санал, хүсэлт гаргасан хүнийг байлцуулж болно.
- 5.Оролцогчийн хүсэлтээр шүүх хуралдааны явцыг баталгаажуулсан дууны, дуу-дүрсний бичлэгийг түүнд танилцуулна.
- 6.Шүүхийн хэлэлцүүлэг, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн тэмдэглэл танилцуулахад энэ зүйл нэгэн адил хамаарна.
- 7.Шүүх хуралдааны явцыг баталгаажуулсан дууны, дуу-дүрсний бичлэгийг прокурор, өмгөөлөгч хуулбарлан авах эрхтэй.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

11.9 дүгээр зүйл. Баримт бичиг хүргэх

- 1.Энэ хуульд заасны дагуу хүн, хуулийн этгээдэд хүргүүлэх шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэр, бусад баримт бичгийг шүүх, прокурор, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын захиргааны ажилтан хүлээн авах хүнд биечлэн гардуулж, эсхүл шуудангийн хаягаар, эсхүл цахимаар нь хүргүүлж, энэ тухай баталгаажуулна.

[/Энэ хэсэг т 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэл т оруулсан./](#)

- 2.Шүүх, прокурорын шийдвэр, бусад баримт бичгийг хүлээн авах хүн нь хүлээн авахаас зайлсхийсэн, татгалзсан бол энэ тухай баталгаажуулна. Шүүх, прокурорын шийдвэрийг тухайн байгууллагын цахим хуудсанд шийдвэр гарсан өдрөөс хойш 3 хоногийн дотор байршуулна.

3.Шүүх, прокурорын шийдвэр, бусад баримт бичгийг хүлээн авах хүн нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүлээн авснаа баталгаажуулж гарын үсэг зурах боломжгүй нөхцөлд хүлээлгэж өгсөн тухай боломжтой арга хэлбэрээр баталгаажуулна.

11.10 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг

1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналтын явцад үйлдэх тэмдэглэлийн болон шийдвэрийн маягыг Улсын ерөнхий прокурор батална.

2.Шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны явцад үйлдэх тэмдэглэлийн болон шийдвэрийн маягыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

11.11 дүгээр зүйл.Эрүүгийн хэргийн хавтаст хэрэг

1.Хавтаст хэрэг нь хэрэгт тусгасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр, баримт бичиг, хэрэгт хавсаргасан бусад баримт бичиг, зүйлээс бүрдэнэ.

2.Мөрдөгч, прокурор, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нь оролцогч, бусад оролцогчоос гаргасан хүсэлт, гомдол, мэдээлэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шийдвэр, бусад баримт бичиг, эд зүйлийг тэмдэглэл үйлдэж, эсхүл төрийн албан хэрэг хөтлөх журмын дагуу бүртгэж, хавтаст хэрэгт тусгаж, хавсаргана.

3.Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний баталсан болон бичсэн баримт бичгийг хавтаст хэрэгт шууд тусгана.

4.Овор хэмжээ, бусад шалтгааны улмаас хавтаст хэрэгт тусгах боломжгүй эд зүйл, баримт бичгийг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу тэмдэглэлд тусгана.

5.Хавтаст хэрэг нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад мөрдөгчид, энэ хуульд заасан үндэслэлээр шилжүүлсэн, эсхүл татаж хянаж байгаа бол прокурорт, шүүхийн шатанд тухайн шүүхэд байна.

6.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичиг, хэргийн материал нь цаасан болон цахим хэлбэртэй байж болно. Цаасан баримтыг шүүх, прокурор, мөрдөн шалгах эрх бүхий байгууллагын ажилтан хөрвүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулна.

[/Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ ДУУДАН ИРҮҮЛЭХ, АЛБАДАН ИРҮҮЛЭХ, ЭРЭН СУРВАЛЖЛАХ

12.1 дүгээр зүйл.Дуудан ирүүлэх

1.Мөрдөгч нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагчийг мэдүүлэг авах, шийдвэр танилцуулах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулахаар дуудан ирүүлж болно. Мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирээгүй нь албадлага хэрэглэх, хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.

2.Мөрдөгч нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авах, шийдвэр танилцуулах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулах зайлшгүй шаардлагатай бол прокурорын мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлнэ.

[/Энэ хэсэг т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

3.Шүүхийн шатанд оролцогч, бусад оролцогчийг шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлнэ.

4.Шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаан дуусмагч гэрч, хохирогч, дүгнэлт гаргасан шинжээч, яллагдагч, шүүгдэгчийг шаардлагатай тохиолдолд шүүхийн дуудсан цагт ирэхийг сануулж, тэмдэглэлд тусгана.

5.Цагдан хоригдсон яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих байранд нь, эсхүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах байгууллагад дуудан ирүүлж мэдүүлэг авна.

6.Өсвөр насны яллагдагч, шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан дуудан ирүүлнэ.

[/Энэ хэсэг т 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

7.Гэрч, хохирогч, яллагдагч, шүүгдэгч өөрөө сайн дураараа хүрэлцэн ирж мэдүүлэг өгөхөөр зөвшөөрсөн бол энэ зүйлд заасан журмыг баримтлахгүй байж болно.

8.Тухайн байгууллагын албан ёсны харилцаа, холбооны хэрэгсэл ашиглан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогчийг дуудаж болно.

9.Мөрдөгч нь хэргийн оролцогчийн хүсэлтээр төрийн байгууллага, албан тушаалтны албаны цахим шуудан, албан бичиг солилцооны дундын систем, төрийн үйлчилгээний нэгдсэн системд иргэний үүсгэсэн, бүртгүүлсэн цахим шуудан, хаяг, харилцаа холбооны утасны дугаарыг ашиглан дуудаж, прокурорын мэдэгдэх хуудсыг хүргүүлж болно.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

12.2 дугаар зүйл.Мэдэгдэх хуудас

1.Прокурор, шүүхийн мэдэгдэх хуудсанд дараахь зүйлийг тусгана:

1.1.мэдэгдэх хуудас хүргүүлж байгаа хүний нэр, албан тушаал;

- 1.2.дуудан ирүүлэх хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг;
- 1.3.ямар зорилгоор дуудаж байгаа;
- 1.4.хаана, хэзээ хүрэлцэн ирэх;
- 1.5.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирэхгүй бол үүсэх эрх зүйн үр дагавар;
- 1.6.гарын үсэг, баталгаажуулсан тэмдэг.

2.Цагдан хоригдсон яллагдагч, шүүгдэгчийг дуудан ирүүлэх тухай мэдэгдэх хуудсыг цагдан хорих байрны захиргаанд хүргүүлнэ.

3.Гэрч, хохирогч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас зайлсхийсэн бол түүний өмгөөлөгч, эсхүл гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүнд хүргүүлнэ.

[Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан.](#)

12.3 дугаар зүйл.Албадан ирүүлэх

1.Гэрч, хохирогч, иргэний хариуцагч, шинжээч, яллагдагч, шүүгдэгчийг прокурор, шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй бол шүүх өөрийн санаачилгаар, эсхүл прокурорын хүсэлтийн дагуу албадан ирүүлэх тухай шийдвэр гаргана.

2.Гэрч, хохирогч, иргэний хариуцагч, дүгнэлт гаргасан шинжээч, яллагдагч, шүүгдэгчийг албадан ирүүлэх тухай шийдвэрт дараахь зүйлийг тусгана:

- 2.1.албадан ирүүлэх шийдвэр гаргасан шүүх, шүүгчийн нэр;
- 2.2.гэрч, хохирогч, шинжээч, яллагдагч, шүүгдэгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг;
- 2.3.албадан ирүүлэх шийдвэрийн үндэслэл;
- 2.4.албадан ирүүлэх он, сар, өдөр;
- 2.5.албадан ирүүлэх ажиллагаа гүйцэтгэх байгууллагын нэр;
- 2.6.гарын үсэг, баталгаажуулсан тэмдэг.

3.Гэрч, хохирогч, иргэний хариуцагч, дүгнэлт гаргасан шинжээч, түүнчлэн яллагдагч, шүүгдэгч нь өөрөө хүрэлцэн ирвэл шүүхийн албадан ирүүлэх шийдвэрийг хэрэгжүүлэхгүй.

4.Шүүх хуралдаанд гэрч, хохирогч, иргэний хариуцагч, дүгнэлт гаргасан шинжээч, яллагдагч, шүүгдэгчийг албадан ирүүлэх ажиллагааг цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ.

5.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад тухайн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллага шүүхийн шийдвэрийн дагуу албадан ирүүлэх ажиллагааг гүйцэтгэнэ.

6.Төрийн тусгай хамгаалалтад байгаа албан тушаалтан, хүн энэ зүйлд заасан албадан ирүүлэх шүүхийн шийдвэрийг биелүүлнэ.

7.Арван зургаан насанд хүрээгүй, хүнд өвчний улмаас хүрэлцэн ирж чадахгүй гэрч, хохирогчийг албадан ирүүлэхийг хориглоно.

12.4 дүгээр зүйл.Эрэн сурвалжлах ажиллагаа

1.Мөрдөгч дараахь хүн, хуулийн этгээд, эд зүйл, хөрөнгийг олох зорилгоор эрэн сурвалжлах ажиллагааг өөрийн санаачилгаар, эсхүл шүүхийн шийдвэр, прокурорын даалгавраар явуулна:

- 1.1.байгаа газар нь мэдэгдэхгүй байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний хариуцагч, гэрч;
- 1.2.оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч;
- 1.3.хулгайлагдсан, барьцаалагдсан хохирогч;
- 1.4.хэн болох нь тодорхойгүй цогцсыг тогтоох;
- 1.5.эмнэлгээс оргосон сэтгэцийн өвчтэй хүн;
- 1.6.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий эд зүйл, мал, амьтан, баримт бичиг, тээврийн хэрэгсэл.

[/Энэ заалт ад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

2.Эрэн сурвалжлах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага шүүх, прокурорын шийдвэрийн дагуу яллагдагч, шүүгдэгчийг эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулж, үр дүнг шүүх, прокуророос тогтоосон хугацаанд танилцуулна.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан./](#)

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ

13.1 дүгээр зүйл.Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шүүхийн шийдвэр гаргах үндэслэл

1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд мөрдөгчийн санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн прокурор, шүүхийн шатанд прокурорын санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн шүүгч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан дараахь аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх шийдвэр гаргана:

- 1.1.тодорхой үйлдлийг хязгаарлах;
- 1.2.биечилсэн хамгаалалтад авах;
- 1.3.мэдээллийн нууцлалыг хангах;
- 1.4.нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, холбооны хэрэгслээр хангах.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аюулгүй байдлын хамгаалалтыг хэрэглэх хүрээнд прокурор, шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн дараахь арга хэмжээг авах тухай шийдвэр гаргаж болно:

- 2.1.нийтэд мэдээлэх мэдээллээс гэрч, хохирогчийг танихад ашиглагдаж болох нэр, хаяг, ажлын газар, мэргэжил, бусад баримт мэдээ, мэдээллийг нууцлах, өөрчлөх, арилгах;
- 2.2.нэрийг нь нууцалсан гэрч, хохирогчийн талаархи мэдээ, мэдээллийг хайх, задруулахыг хориглох;
- 2.3.шүүхээс тогтоосон хугацаанд мэдээллийг задруулахыг хориглох;
- 2.4.гэрч, хохирогчийн нэрийг ил болгон танилцуулах хүртэл гэрч, хохирогчид зохиомол нэр өгч хамгаалах.

3.Тухайн хэргийг гэрчлэхтэй холбоотойгоор гэрч, хохирогч, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд аюул учрах бодит үндэслэл байгаа тухай прокурорын санал, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл шүүх дараахь нэмэлт арга хэмжээ авч болно:

- 3.1.гэрч, хохирогчийг шүүх хуралдааны танхимд байлцуулахгүйгээр харилцаа холбооны хэрэгсэл ашиглан шүүхийн хэлэлцүүлэгт оролцуулах;
- 3.2.яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлөгчийг оролцуулж авсан гэрч, хохирогчийн мэдүүлгийн тэмдэглэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгтэй танилцах ажиллагааг гэрчийг байлцуулахгүйгээр хийх;
- 3.3.шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимд байгаа үед гэрч, хохирогч мэдүүлэг өгөхөөс татгалзсан, эсхүл түүнийг байлцуулах үед гэрч, хохирогч үнэнийг мэдүүлэхгүй байх нөхцөл байдал үүсч болохоор бол шүүх хуралдааны танхимаас шүүгдэгчийг түр гаргах.

4.Шүүх энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан арга хэмжээг авахад яллах талд давуу байдал олгохгүй, эсхүл шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дордуулахгүй, талуудад мэтгэлцэх боломжийг тэгш хангана.

5.Шүүх энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл хэсэгчилсэн байдлаар хаалттай явуулж болно.

6.Гэрч, хохирогчийг хамгаалах шийдвэрийг цуцлах тухай албан тушаалтны санал, гэрч, хохирогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл шүүх, прокурор гэрч, хохирогчийг хамгаалах тухай шийдвэрээ хүчингүй болгож, өөрчилж болно.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

7.Шүүхээс гэмт хэргийг илрүүлэх, бусад яллагдагч, шүүгдэгчийн гэм бурууг нотлох чиглэлээр мэдүүлэг өгч байгаа шүүгдэгч, эсхүл шинжээчийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр хамгаалах шийдвэр гаргаж болно.

8.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай прокурор, болон хамгаалалтыг цуцлах тухай шүүхийн шийдвэрт гомдол гаргаж болно.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

9.Гэрч, хохирогчийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зорилгоор мөрдөгч өөрийн санаачилгаар, эсхүл гэрч, хохирогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл гэрч, хохирогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээс бусад биеийн байцаалтыг мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгахгүйгээр тусад нь бичиж битүүмжлэн хавтаст хэрэгт хавсаргана.

10.Энэ зүйлийн 9 дэх хэсэгт заасан мэдээллийг шүүх хуралдааны явцад ил болгоно.

11.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын бусад арга хэмжээг энэ хуульд заасан журмын дагуу хэрэглэнэ.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.2 дугаар зүйл.Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шийдвэр гаргах

1.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээ авах тухай шийдвэрт дараахь зүйлийг тусгана:

- 1.1.аюулгүй байдлын хамгаалалтын ямар арга хэмжээ авах;
- 1.2.аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авах хугацаа;
- 1.3.аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага;
- 1.4.аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хэрэглэх хуульд заасан албадлага.

2.Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн, халдахаар завдсан, бэлтгэсэн, эсхүл халдлага бодитой эхэлсэн тохиолдолд

мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авч, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэр гаргуулахаар шүүхэд даруй хандана.

3.Шүүх нь прокурор, өмгөөлөгч, мөрдөгчийн аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасны дагуу авч болно.

13.3 дугаар зүйл.Хамтран ажиллах этгээдээр тогтоох

1.Шүүх дараахь тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн хүнийг хамтран ажиллах этгээдээр тогтоож болно:

1.1.зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүн гэмт хэргээ илчлэн ирсэн, зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлэх, мэдээлэл өгөх, эрх бүхий байгууллагатай хамтран ажиллахаа илэрхийлсэн бол;

1.2.Эрүүгийн хуулийн 19.4/Гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах/, 19.7/Хорлон сүйтгэх ажиллагаанд бэлтгэх/, 20.7/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/, 29.9/Террор үйлдэхэд бэлтгэх/ дүгээр зүйлийн Тайлбарт заасан ялаас чөлөөлөх үндэслэлтэй бол.

2.Яллагдагч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтийг прокурор яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлэхээс өмнө гаргана.

3.Дараахь хүнийг хамтран ажиллах этгээдээр тогтоож болохгүй:

3.1.Эрүүгийн хуулийн Хорин есдүгээр бүлэгт заасан гэмт хэргийн яллагдагч;

3.2.гэмт хэргийн зохион байгуулагч;

3.3.хүнийг алах, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэргийн гүйцэтгэгч.

13.4 дүгээр зүйл.Хамтран ажиллах этгээдээр тогтоолгох санал шүүхэд хүргүүлэх

1.Прокурор хамтран ажиллах тухай хүсэлт гаргасан хүний үйлдсэн гэмт хэрэг, илрүүлэхэд туслалцаа үзүүлэх гэж байгаа гэмт хэргийн нөхцөл байдал, гаргаж өгөх нотлох баримтын нотолгооны ач холбогдлыг шалгаж тогтоосон байна.

2.Прокурор хамтран ажиллах этгээдээр тогтоолгох саналаа шүүхэд хүргүүлэхээс өмнө тухайн хэргийн хохирогчийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авна.

3.Прокурор тухайн хүнийг хамтран ажиллах этгээдээр тогтоолгох саналыг битүүмжлэн шүүхэд хүргүүлнэ.

4.Шүүх энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан саналыг хүлээн аваад тусгайлан эрх олгогдсон шүүгчид даруй шилжүүлнэ.

5.Хамтран ажиллах этгээдээр тогтоолгох саналд дараахь зүйлийг тусгана:

5.1.саналыг хянан шийдвэрлэх шүүхийн нэр;

5.2.хамтран ажиллах хүний нэр;

5.3.тухайн хүн урьд нь ял шийтгүүлж байсан, яллагдагчаар татагдаж байсан гэмт хэргийн тухай;

5.4.эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татагдан шалгагдаж байгаа гэмт хэргийн тухай;

5.5.ямар гэмт хэрэгт хамтран ажиллах гэж байгаа тухай;

5.6.хамтран ажиллах гэж байгаа гэмт хэрэгт гэрчийн мэдүүлэг өгөх баталгаа;

5.7.хамтран ажиллах гэж байгаа гэмт хэрэгт нотлох баримт гаргаж өгөх баталгаа.

6.Хамтран ажиллах этгээдээр тогтоолгох хүн энэ зүйлийн 5.6, 5.7-д заасан баталгааг бичгээр гаргана.

7.Прокурор энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан санал болон энэ зүйлийн 5.6, 5.7-д заасан баталгааг өмгөөлөгчид мэдэгдэхгүй нууцлах хүсэлтийг шүүхэд гаргаж болно.

8.Шүүх энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл нууцлах тухай шийдвэр гаргаж болно.

9.Хамтран ажиллах этгээдэд болон түүний хамаарал бүхий хүмүүст энэ хуульд заасны дагуу хамгаалалтын арга хэмжээ авна.

13.5 дугаар зүйл.Хамтран ажиллах этгээдээр тогтоох тухай хэлэлцэх шүүхийн хэлэлцүүлэг

1.Энэ хуулийн 13.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан саналыг хүлээн авснаас хойш 72 цагийн дотор шүүгч шүүхийн хэлэлцүүлгийн товыг прокурор, хамтран ажиллах этгээдээр тогтоолгох хүн, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.

2.Хамтран ажиллах этгээдээр тогтоох тухай хэлэлцэх шүүхийн хэлэлцүүлгийг хаалттай явуулна.

3.Шүүхийн хэлэлцүүлэгт прокурор, хамтран ажиллах этгээдээр тогтоолгох хүн, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс гадна зайлшгүй шаардлагатай шүүхийн ажилтан болон шүүгч, шүүхийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий цагдаагийн албан хаагчаас бусад хүнийг оролцуулахгүй.

4.Шүүхийн хэлэлцүүлгийн явцад хамтран ажиллах этгээдээр тогтоолгох хүн, түүний хууль ёсны төлөөлөгчид өмгөөлөгч, прокурор асуулт тавьж болно.

5.Хамтран ажиллах этгээдээр тогтоолгох хүнд худал мэдүүлэг өгвөл хүлээлгэх хариуцлагыг сануулна.

6.Шүүхийн хэлэлцүүлгийн явцад хамтран ажиллах этгээдээр тогтоолгох хүний гаргасан мэдэгдэл, тайлбарыг түүний эсрэг баримт болгон ашиглахыг хориглоно.

7.Шүүхийн хэлэлцүүлгээс тухайн хүнийг хамтран ажиллах этгээдээр тогтоох эсэх тухай шийдвэр гаргана.

8.Шүүхийн шийдвэрт дараахь зүйлийг тусгана:

8.1.хамтран ажиллах этгээдээр тогтоосон хүний үйлдсэн гэмт хэрэгт нь оногдуулах Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хөнгөрүүлэх;

8.2.гэмт хэргийг илрүүлэхэд хамтран ажиллах этгээдтэй хамтран ажиллах нөхцөл;

8.3.хамтран ажиллах этгээдээр тогтоох шийдвэр хүчингүй болсноос үүсэх үр дагавар;

8.4.шүүхэд худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуулийн 21.2 дугаар зүйлд заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх, түүнчлэн бусад үр дагавар;

8.5.бусдаас санал болгож байгаа болзол, шаардлага, урамшуулал, төлбөрийг хүлээж авахгүй байж, энэ тухай болон тулгарсан бодит аюул заналхийллийг мөрдөгч, прокурорт тухай бүр мэдэгдэхийг хамтран ажиллах этгээдэд үүрэг болгох;

8.6.хамтран ажиллах этгээдээр тогтоох тухай шүүхийн шийдвэрт заагаагүй хамтран ажиллах этгээдийн үйлдсэн бусад гэмт хэрэг хамтран ажиллахад хамаарахгүй тухай;

8.7.шүүгчийн нэр, гарын үсэг.

9.Хамтран ажиллах этгээдээр тогтоох тухай шүүхийн шийдвэрийг прокурорт хүргүүлнэ.

13.6 дугаар зүйл.Хамтран ажиллах этгээдээр тогтоох шүүхийн хэлэлцүүлгийн тэмдэглэл

1.Хамтран ажиллах этгээдээр тогтоох шүүхийн хэлэлцүүлгийн явцыг энэ хуулийн 11.7 дугаар зүйлд заасны дагуу тэмдэглэлд тусгана.

2.Хаалттай явуулсан шүүхийн хэлэлцүүлгийн тэмдэглэл, бичлэг, тэдгээртэй холбоотой материалыг нууцалж, хавтаст хэргээс тусад нь битүүмжлэн хадгална.

3.Хадгалагдаж байгаа баримт, мэдээллийг зөвхөн шүүгч, прокурор, мөрдөгч энэ хуульд заасны дагуу тухайн хэрэгтэй холбоотой гомдлыг хянан шийдвэрлэхэд ашиглаж болно.

13.7 дугаар зүйл.Хамтран ажиллах этгээдээр тогтоосон шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох

1.Прокурор хамтран ажиллах этгээдээр тогтоосон шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох саналыг шүүхэд гаргаж болно.

2.Хамтран ажиллах этгээдээр тогтоосон шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох саналыг хянан шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлгийг хаалттай явуулна.

3.Дараахь нөхцөл байдал бий болсон нь хамтран ажиллах этгээдээр тогтоосон шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно:

3.1.хамтран ажиллах этгээдийн мэдүүлэг худал болох нь тогтоогдсон;

3.2.хамтран ажиллах этгээд мэдүүлэг өгөх үүргээ санаатай биелүүлээгүй;

3.3.гаргаж өгөхөөр тохиролцсон эд зүйл, баримт бичиг, бусад баримтыг гаргаж өгөөгүй;

3.4.хамтран ажиллах этгээд нас барсан, эсхүл эрх зүйн чадвар, чадамжгүй болсон.

4.Хамтран ажиллах этгээдээр тогтоосон шүүхийн шийдвэрийг энэ зүйлийн 3.1, 3.2, 3.3-т заасныг үндэслэн хүчингүй болгосон тохиолдолд үйлдсэн гэмт хэрэгт нь болон Эрүүгийн хуулийн 21.2 дугаар зүйлд зааснаар эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж шалгана.

5.Эрүүгийн хуулийн 21.2 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулж эхэлсэн бол яллагдагчид энэ хуулийн 13.5 дугаар зүйлийн 6 дахь хэсэг хамаарахгүй.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

14.1 дүгээр зүйл.Таслан сэргийлэх арга хэмжээ

1.Яллагдагч, шүүгдэгчид энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу дараахь таслан сэргийлэх арга хэмжээ авна:

1.1.хувийн баталгаа гаргах;

1.2.тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх;

1.3.хязгаарлалт тогтоох;

1.4.барьцаа авах;

1.5.цагдан хорих;

1.6.цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулах.

2.Мөрдөн байцаалтын явцад энэ зүйлийн 1.1, 1.4, 1.6-д заасан таслан сэргийлэх арга хэмжээг прокурор, энэ зүйлийн 1.1-д заасан таслан сэргийлэх арга хэмжээг мөрдөгч авна.

3.Мөрдөн байцаалтын явцад энэ зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээг шүүхийн зөвшөөрлөөр, эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх явцад энэ зүйлийн 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 1.6-д заасан таслан сэргийлэх арга хэмжээг шүүх авна.

4.Энэ зүйлийн 1.1, 1.2, 1.3-т заасан таслан сэргийлэх арга хэмжээг дангаар болон давхардуулан авч болно. Энэ зүйлийн 1.4, 1.5, 1.6-д заасан таслан сэргийлэх арга хэмжээг бусад таслан сэргийлэх арга хэмжээтэй давхардуулж авахгүй.

14.2 дугаар зүйл.Хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг хангах зорилгоор яллагдагчийн үйлдсэн гэмт хэргийн шинж, хувийн байдлыг харгалзан хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээг шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэрээр авна.

2.Яллагдагч шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудсан цагт хүрэлцэн ирэх, дахин гэмт хэрэг үйлдэхгүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх талаар хувийн баталгааг бичгээр гаргаж, гарын үсэг зурна.

14.3 дугаар зүйл.Хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

1.Энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.1-д заасан хувийн баталгаа гаргах яллагдагч нь байнга оршин суух газрын хаягтай, тодорхой ажил, хөдөлмөр эрхэлдэг байна.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

2.Хувийн баталгаа гаргасан яллагдагч ажил эрхлэлтийн байдал, байнга оршин суугаа газрын хаяг, холбоо барих утасны дугаар, шуудангийн хаяг өөрчлөгдсөн, эсхүл өөрчлөгдөх гэж байгаа талаар шүүх, прокурор, мөрдөгчид даруй мэдэгдэнэ.

3.Шүүх, прокурор, мөрдөгч яллагдагчид хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээг зөрчвөл таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх үндэслэл болохыг тайлбарлана.

14.4 дүгээр зүйл.Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллагдагч саад учруулахгүй байх нөхцөлийг хангах зорилгоор төрийн албанд ажиллах, тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, эсхүл тусгай зөвшөөрлөөр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, албан үүргээ биелүүлэхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээг прокурорын саналыг харгалзан шүүхийн зөвшөөрлөөр авч болно.

2.Прокурор, эсхүл мөрдөгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүхийн шийдвэрийг яллагдагч болон холбогдох байгууллага, хуулийн этгээдэд даруй хүргүүлнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүхийн шийдвэрийг хүлээн авсан байгууллага, хуулийн этгээд нь хэрхэн хэрэгжүүлсэн тухайгаа уг шийдвэрийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор прокурор, мөрдөгчид мэдэгдэнэ.

4.Хуулийн этгээдийн тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг энэ зүйлд заасны дагуу түдгэлзүүлж болно.

5.Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа дууссан, эсхүл уг арга хэмжээг хүчингүй болгосон, өөрчилсөн шүүхийн шийдвэр гарсан бол прокурор, эсхүл мөрдөгч уг шийдвэрийг яллагдагч болон холбогдох байгууллага, хуулийн этгээдэд даруй хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

14.5 дугаар зүйл.Хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээ

1.Яллагдагч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх, түүнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтоосон газар, нутаг дэвсгэрээс гарч явах, Монгол Улсын хилээр гарахыг хязгаарлах, тодорхой газар очих, тодорхой хүнтэй уулзахыг хориглох, тогтоосон замаар зорчихыг яллагдагчид даалгаж, хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг авах эсэхийг прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан таслан сэргийлэх арга хэмжээ авсан, хүчингүй болгосон тухай шүүхийн шийдвэрийг прокурор, мөрдөгч хяналт тавих байгууллагад даруй мэдэгдэнэ.

3.Шүүхийн шийдвэрт яллагдагчийн очих, оршин суух, ажиллах, зорчих газар, тодорхой хүнтэй уулзахгүй, харилцахгүй байхыг зааж, хяналт тавихыг эрх бүхий байгууллагад даалгана.

4.Шүүхийн шийдвэрт заасан бол хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих байгууллага нь яллагдагчид хяналтын төхөөрөмж ашиглан хяналт тавина.

5.Яллагдагчид энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу хяналтын төхөөрөмж ашиглан хяналт тавих бол түүнийг зөрчсөнөөс үүсэх үр дагаврыг урьдчилан танилцуулна.

6.Яллагдагч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргийг зөрчсөнийг мэдсэн хүн, хуулийн этгээд тухайн таслан сэргийлэх арга хэмжээнд хяналт тавьж байгаа байгууллагад мэдэгдэнэ.

14.6 дугаар зүйл.Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ

- 1.Прокурор, шүүх яллагдагчид мөнгөн хэлбэрээр барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.
- 2.Барьцааг яллагдагч өөрөө, эсхүл түүний өмнөөс бусад хүн, хуулийн этгээд гаргаж болно.
- 3.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд бусдын өмнөөс барьцаа гаргахыг хориглоно.
- 4.Барьцааны хэмжээг яллагдагчийн холбогдсон гэмт хэргийн шинж, хувийн байдлыг харгалзан тогтооно.
- 5.Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авахад шүүх, прокурорын дуудсан цагт ирэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх үүргийг яллагдагчид хүлээлгэнэ.
- 6.Барьцааны мөнгийг тусгай дансанд байршуулна.
- 7.Барьцаалуулагч нь өөрийн үүргээсээ татгалзаж барьцааны мөнгийг буцаан авах хүсэлт гаргасан нь яллагдагчид авсан барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж цагдан хорих үндэслэл болно.
- 8.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу барьцааны мөнгийг байршуулах, шилжүүлэх, шийдвэрлэх журмыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

14.7 дугаар зүйл.Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх

- 1.Яллагдагчаас барьцааны мөнгийг данс, цахим карт ашиглаж тусгай дансанд бэлэн бусаар шилжүүлсэн мөнгөн дүнгийн гүйлгээний баримтыг тэмдэглэлд хавсаргана.
- 2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баримтын хуулбарыг яллагдагчид болон барьцаа гаргагчид өгнө.
- 3.Барьцаа өгсөн яллагдагч нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас оршин суугаа газраасаа түр явах болсон, эсхүл дуудсан цагт хүрэлцэн ирэх боломжгүй болсон бол энэ тухай шүүхийн шатанд шүүхэд, мөрдөн байцаалтын явцад прокурорт, эсхүл мөрдөгчид урьдчилан мэдэгдэнэ.

14.8 дугаар зүйл.Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөнөөс үүсэх үр дагавар

- 1.Энэ хуулийн 14.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үүргийг зөрчвөл яллагдагчид авсан барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ болгон өөрчилж, барьцааг улсын орлого болгох үр дагавар үүсэх талаар барьцаа гаргагч, яллагдагчид танилцуулж, тэмдэглэлд тусгана.
- 2.Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгосон, эсхүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон бол барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, барьцааг буцаан олгоно.

14.9 дүгээр зүйл.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ

[/Энэ зүйлийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

- 1.Шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид дараах үндэслэлээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно:

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

- 1.1.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, эсхүл оргон зайлсан;

[/Энэ заал т-ыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

- 1.2.шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, эсхүл сүрдүүлсэн, эсхүл нөлөөлсөн, эсхүл тэдгээрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;

[/Энэ заал т-ыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

- 1.3 хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, эсхүл оргон зайлах, эсхүл хэргийн ул мөр, эд мөрийн баримт, нотлох баримтыг устгах, өөрчлөх, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдүүлэх, хуурамчаар үйлдэх, гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа;

[/Энэ заал т-ыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ заал т-ад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

- 1.4.урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй.

[/Энэ заал т-ыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

- 2.Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг найман жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид дараах үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно:

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

- 2.1.энэ хуулийн 31.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3-т заасан нөхцөл;

[/Энэ заал т-ыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

- 2.2.эд хөрөнгө, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа насанд хүрээгүй хүний эсрэг, эсхүл амь нас, эрүүл мэнд, бусад

шалтгааны улмаас өөрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чадваргүй хүний эсрэг гэмт хэрэг үйлдсэн;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.3.зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэгт хамтран оролцсон;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.4.Монгол Улсад оршин суух газрын хаяг тодорхойгүй, эрхэлсэн ажилгүйн улмаас түүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.5.Монгол Улсад байнга оршин суудаггүй.

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

3.Яллагдагч өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, эсхүл түүний амь нас, эрүүл мэндэд аюул учирч болох үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа бол прокурорын гаргасан саналыг үндэслэн шүүх яллагдагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

4.Хорих ял эдэлж байгаа ялтныг яллагдагчаар татаж мөрдөн шалгах ажиллагаа явуулахад прокурорын саналыг үндэслэн шүүх түүнийг мөрдөн шалгах ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн цагдан хорих байранд шилжүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авч болно.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

5.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан бол энэ хуулийн 14.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацааг баримттална.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

6.Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад прокурор, оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх энэ зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэгт заасан үндэслэлээр, эсхүл хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдсон шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

[/Энэ хэсгийг 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

14.10 дугаар зүйл.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах хугацаа

1.Яллагдагчийг цагдан хорих үндсэн хугацаа 1 сар хүртэл байна.

[/Энэ хэсэгт 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

2.Шүүх энэ хуулийн 14.9 дүгээр зүйлд заасан үндэслэл арилаагүй гэж үзвэл яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг тухай бүр 1 сар хүртэл хугацаагаар сунгах ба яллагдагчийг цагдан хорих нийт хугацаа Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг таван жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 6 сараас, Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг таван жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 12 сараас, Эрүүгийн хуульд хорих ялын доод хэмжээг найман жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 18 сараас хэтэрч болохгүй.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

3.Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/Хүнийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар санаатай алах/, 17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хулгайлах/, 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг/Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар залилах/, 19.6/Хорлон сүйтгэх/, 29.5/Төрлөөр устгах/ дугаар зүйлд заасан гэмт хэргийн яллагдагчийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас илүү хугацаагаар цагдан хорих шаардлагатай бол шүүх 6 сар хүртэл хугацаагаар нэмж сунгаж болно.

[/Энэ хэсэгт 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

4.Нэг хэрэгт дахин, эсхүл тусгаарласан, нэгтгэсэн хэрэгт шинээр цагдан хоригдсон бол өмнө нь цагдан хоригдсон хугацааг нийт цагдан хоригдсон хугацаанд оруулж тооцно.

5.Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэрэг үйлдэж, яллагдагчаар татагдан цагдан хоригдсон бол цагдан хорих хугацааг шинээр тоолно.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

6.Баривчлагдсан хугацааг цагдан хорих хугацаанд оруулан тооцох ба энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан цагдан хорих үндсэн хугацаанаас хасаж тооцно. Баривчлагдсан 24 цаг хүртэл хугацааг цагдан хоригдсон 1 хоногоор тооцно.

[/Энэ хэсгийн дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

7.Мөрдөгч яллагдагчийг цагдан хорих хугацааг сунгах тухай саналаа хугацаа дуусахаас 7-оос доошгүй хоногийн өмнө прокурорт хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

8.Прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл цагдан хорих хугацааг сунгах тухай саналаа даруй шүүхэд хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

9.Шүүх цагдан хорих хугацааг сунгах тухай прокурорын саналыг хугацаа дуусахаас 4-өөс доошгүй хоногийн өмнө хянан хэлэлцэж, цагдан хорих хугацааг сунгах, эсхүл сунгахыг татгалзах тухай шийдвэр гаргана.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

10.Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан яллагдагчийн цагдан хорих хугацааг баривчилсан өдрөөс, эсхүл яллагдагчийг цагдан хорьсон өдрөөс эхлэн прокурор хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл тоолно.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

11.Шүүгч баривчилсан, цагдан хорьсон цагийг захирамждаа заана.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

12.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор, оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч бөлно.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#) [/Энэ хэсгийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 07 дугаар дүгнэлтийн дагуу 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсэн. Улсын Их Хурлын 2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 92 дугаар тогтоолоор хүлээн зөвшөөрсөн./](#)

[/Энэ заалтын дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

13.Эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад шүүгдэгчийг цагдан хорьсон хугацаа нь энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хугацаанд хамаарахгүй.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ хэсгийн дугаарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

14.Хоригдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан үед хорих ялын хугацаа дуусахаар бол энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан журмын дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

15.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай шүүгчийн захирамжийн дагуу хоригдлыг цагдан хорих байранд хүлээн авсан өдрөөс эхлэн цагдан хорих хугацааг тоолно.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

14.11 дүгээр зүйл.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахыг хориглох

1.Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, суллагдсан яллагдагчид урьд нь цагдан хоригдсон үндэслэлээр дахин цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахыг хориглоно.

2.Өсвөр насны яллагдагч, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй яллагдагч, жирэмсэн яллагдагчид энэ хуулийн 14.9 дүгээр зүйлд заасан үндэслэлээр, эсхүл урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, дахин гэмт хэрэг үйлдсэн бол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

14.12 дугаар зүйл.Прокурор таслан сэргийлэх арга хэмжээ авах

1.Прокурор энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.1, 1.4, 1.6-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох асуудлыг өөрийн санаачилгаар, эсхүл энэ тухай мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл саналыг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор шийдвэр гаргана.

2.Яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгуулах хүсэлт прокурорт гаргаж болно.

14.13 дугаар зүйл.Яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлэг

1.Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5-д заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацааг сунгах санал, хүсэлтийг шүүхэд гаргаж болно.

2.Шүүх энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан санал, хүсэлтийг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор асуудлыг хэлэлцэх шүүхийн хэлэлцүүлгийн товыг прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.

[/Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

3.Шүүхийн хэлэлцүүлэгт прокурор, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулах ба хүсэлт гаргасан тохиолдолд яллагдагчийг оролцуулна.

4.Шүүхийн хэлэлцүүлэгт яллагдагчийн өмгөөлөгч хүрэлцэн ирээгүй бол томилогдсон өмгөөлөгч оролцуулж болно.

5.Прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан санал, хүсэлтийн үндэслэлд хамаарах баримт, мэдээллийг шүүх хэргийн оролцогчид танилцуулж, тэдгээрт тайлбар хийх, холбогдох баримт, мэдээллийг гаргаж өгөх боломжоор хангана. Талуудад танилцуулагдаагүй баримт, мэдээлэл нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.

[/Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

6.Шүүхийн хэлэлцүүлгийн явцыг энэ хуулийн 11.7, 11.8 дугаар зүйлд заасны дагуу тэмдэглэлд тусгаж, танилцуулна.

7.Яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгох шийдвэрийг даруй биелүүлнэ.

8.Шүүхийн шийдвэрт дараахь зүйлийг тусгана:

8.1.таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагчийн хувийн мэдээлэл;

8.2.санал, хүсэлт гаргасан хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал;

8.3.санал, хүсэлтэд дурдсан үндэслэл;

8.4.шүүх санал, хүсэлтийг хүлээн авсан, эсхүл хүлээн авахаас татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримт;

8.5.шүүгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, гарын үсэг;

8.6.он, сар, өдөр.

9.Шүүх таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацааг сунгах тухай шийдвэрт гомдол гаргах эрхтэйг яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, прокурорт танилцуулна.

10.Шүүх яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэр гаргасан тохиолдолд:

10.1.яллагдагчийг цагдан хорих шийдвэр гаргаснаас хойш 2 цагийн дотор яллагдагчийг цагдан хорьсон талаар түүний гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгч, гадаад улсын иргэн бол тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт, тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газар байхгүй бол гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ;

10.2.шүүхийн шийдвэрт тухайн шүүхийн харьяалах нутаг дэвсгэрт байрлах цагдан хорих байранд яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорихоор заана.

11.Шүүх дараахь тохиолдолд прокурорын саналыг үндэслэн яллагдагч, шүүгдэгчийн цагдан хоригдох байрыг өөрчилж, өөр цагдан хорих байранд шилжүүлэхээр шийдвэрлэж болно:

11.1.авлигын гэмт хэрэг, зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэргийг шалгах;

11.2.Эрүүгийн хуулийн 10.1/Хүнийг алах/, 19.4/Гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах/, 19.7/Хорлон сүйтгэх ажиллагаанд бэлтгэх/, 20.7/Мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/, 29.9/Террор үйлдэхэд бэлтгэх/ дүгээр зүйлд заасан гэмт хэргийг шалгах;

11.3.яллагдагчийн амь нас, эрүүл мэндэд аюул учрах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа бол;

11.4.яллагдагчийн мэдүүлгийг газар дээр нь шалгах ажиллагааг өөр нутаг дэвсгэрт явуулах бол.

12.Шилжүүлж цагдан хорих шүүхийн шийдвэр гарсныг энэ зүйлийн 10.1-д заасны дагуу мэдэгдэнэ.

13.Таслан сэргийлэх арга хэмжээний талаар талуудаас шүүхэд гаргасан санал, хүсэлт, тэдгээртэй холбоотой нотлох баримтыг эрүүгийн хэрэгт хавсаргана.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

14.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед энэ хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.2, 1.3, 1.5 дахь заалтад заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацаа сунгах санал, хүсэлт болон хугацаа сунгасан шүүхийн шийдвэрийг даруй мөрдөгч, прокурорт мэдэгдэж, эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

14.14 дүгээр зүйл.Цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулах таслан сэргийлэх арга хэмжээ

1.Яллагдагч, шүүгдэгчээр татагдсан цэргийн алба хаагчийг цэргийн ангийн удирдлагад прокурор, шүүхийн шийдвэрээр хянан харгалзуулна.

2.Цэргийн ангийн удирдлага цэргийн алба хаагчийг мөрдөгч, прокурор, шүүхээс дуудсан цагт ирүүлж байх үүрэг хүлээнэ.

14.15 дугаар зүйл.Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад яллагагч, шүүгдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ авах

/Энэ зүйлийг 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн./

1.Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх энэ хуульд заасны дагуу яллагагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааныг хойшлуулах, завсарлуулах, хэргийг түдгэлзүүлэх, тусгаарлах, буцаах, шүүгдэгчийг гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэх үед яллагагч, шүүгдэгчид авсан таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой прокурор, оролцогчийн гаргасан санал, хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэнэ.

/Энэ хэсгийг 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн./

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүхийн шийдвэрт яллагагч, шүүгдэгчид урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлсэн, өөрчилсөн, хүчингүй болгосон үндэслэлийг тусгана.

/Энэ хэсгийг 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн./

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ ХҮСЭЛТ, ГОМДОЛ ГАРГАХ

15.1 дүгээр зүйл.Хүсэлт, гомдол гаргах

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах тухай хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргах эрхтэй.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн уг ажиллагааны оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээд нь шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэр, ажиллагаанд гомдол гаргах эрхтэй.

15.2 дугаар зүйл.Хүсэлт, гомдол гаргах журам

1.Хүсэлт, гомдлыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед гаргаж болно.

2.Шүүх, прокурорын шийдвэрт энэ хуульд заасан хугацаанд гомдол гаргаж болно.

3.Хүсэлтэд тогтоолгох үйл явдал, гаргуулах шийдвэрийн талаар заана.

4.Хүсэлтийг тухайн ажиллагаа явуулж байгаа шүүх, прокурор, мөрдөгчид гаргах ба гомдлыг хуульд заасны дагуу хяналт тавих, шийдвэр гаргах эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана.

5.Хүсэлт, гомдлыг амаар, эсхүл бичгээр гаргах ба амаар гаргасан бол тэмдэглэлд тусгаж, хүлээн авсан албан тушаалтан, хүсэлт, гомдол гаргагч гарын үсэг зурна.

6.Хүсэлт, гомдлыг хангаагүй нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухайн ажиллагаа болон бусад ажиллагааны үед хүсэлт, гомдол дахин гаргах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

15.3 дугаар зүйл.Баривчлагдсан сэжигтэн, цагдан хоригдсон яллагагч, шүүгдэгчийн хүсэлт, гомдлыг шилжүүлэх

1.Баривчлагдсан сэжигтэн, эсхүл цагдан хоригдсон яллагагч, шүүгдэгч энэ хуульд заасан хүсэлт, гомдол гаргасан бол баривчлах байр, цагдан хорих байрны захиргаа 12 цагийн дотор хаягаар нь хүргүүлнэ.

2.Дуудан ирүүлсэн сэжигтэн дуудан ирүүлсэнтэй нь холбогдуулан энэ хуульд заасан хүсэлт, гомдол гаргах эрхтэй.

15.4 дүгээр зүйл.Хүсэлтийг шийдвэрлэх

/Энэ зүйлийн гарчиг-г 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

1.Хуульд заасан журмын дагуу гаргасан хүсэлт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад оролцогч, бусад оролцогч, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад ач холбогдолтой бол бүрэн, эсхүл хэсэгчлэн хангах, эсхүл хангахаас татгалзах тухай шүүх, прокурор, мөрдөгч шийдвэр гаргана.

2.Хүсэлтийг хангах үндэслэл нь тодорхой бол даруй, шалгах шаардлагатай тохиолдолд түүнийг гаргаснаас хойш ажлын 5 өдрийн дотор хангах эсэхийг шийдвэрлэнэ.

15.5 дугаар зүйл.Гомдол гаргасантай холбогдуулан шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх

1.Гомдлыг хянан шийдвэрлэх албан тушаалтан шаардлагатай гэж үзвэл шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэрийн биелэлтийг гомдлыг шийдвэрлэх хүртэл хугацаанд түр түдгэлзүүлж болно.

15.6 дугаар зүйл.Гомдлыг шалган шийдвэрлэх нийтлэг журам

1.Энэ хуулийн 15.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан албан тушаалтны талаар гаргасан гомдлыг тухайн албан тушаалтны шийдвэр, ажиллагаанд хяналт тавих албан тушаалтан хүлээн авч, гомдолд дурдсан үндэслэлийг тал бүрээс нь хянаж, шаардлагатай бол нэмэлт баримт гаргуулж, тайлбар авч болно.

2.Гомдлыг хянан шийдвэрлэх албан тушаалтан бүрэн эрхийнхээ хүрээнд гомдол гаргагчийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээг цаг алдалгүй авна.

3.Хууль бус шийдвэр, ажиллагааны улмаас гомдол гаргагчийн эд хөрөнгө, эрүүл мэндэд хохирол учирсан бол энэ хуульд заасан журмын дагуу хохирлоо арилгуулахаар хандах эрхтэй болохыг түүнд тайлбарлана.

15.7 дугаар зүйл.Мөрдөгч, прокурорын шийдвэр, ажиллагаанд гаргасан гомдлыг хянах

1.Оролцогч нь мөрдөгчийн шийдвэр, ажиллагаанд гаргах гомдлыг хяналт тавьж байгаа прокурорт, хяналт тавьж байгаа прокурорын шийдвэр, ажиллагааны талаархи гомдлыг тухайн нэгжийн дээд шатны прокурорт шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор гаргана.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

2.Гомдлыг хүлээн авсан прокурор 14 хоногийн дотор, нэмэлт материал шалгах, эсхүл бусад арга хэмжээ авах бол 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.

[/Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

3.Гомдлыг хянасан албан тушаалтан, прокурорын зүгээс мөрдөгч, прокурорын шийдвэр, ажиллагааг хүчингүй болгох, өөрчлөх, эсхүл гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай шийдвэр гаргана.

4.Гомдол гаргагчид гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн, түүний үндэслэл, уг шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шийдвэрийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор дээд шатны прокурорын газарт гомдол гаргаж болохыг тайлбарлана.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

5.Дээд шатны прокурорын газар нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан гомдлыг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд хянаж шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

15.8 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрт гомдол гаргах

1.Прокурор, оролцогч энэ хуулийн 12.3, 13.1, 13.2, 13.5, 13.7, 14.4, 14.5, 14.13, 19.2, 19.3 дугаар зүйл, 21.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл 3 хоногийн дотор гомдол гаргаж болно.

2.Анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүхийн шийдвэр нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт хамаарахгүй.

3.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад шүүгч дангаар гаргасан шийдвэрийн талаархи гомдлыг тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгч, түүний эзгүйд томилсон шүүгч даруй хянан шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэр эцсийн байна.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

4.Гомдол гаргагч гомдлыг хянан шийдвэрлэхэд оролцож, гомдлын үндэслэл, нотолгоо, шаардлагатай баримт бичгийг гаргаж танилцуулах эрхтэй.

5.Шүүх гомдлыг хянан шийдвэрлээд дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

5.1.гомдлыг хангаж, шүүхийн шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох;

[/Энэ заалтад 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

5.2.гомдлыг хангахгүй орхих.

6.Гомдол гаргагч шүүхэд хүрэлцэн ирээгүй нь шүүхийн хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.

15.9 дүгээр зүйл.Хүсэлт, гомдлыг хавтаст хэрэгт хавсаргах

1.Энэ хуульд заасны дагуу гаргасан хүсэлт, гомдол, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн баримт, тэмдэглэл, холбогдох бүх материалыг хавтаст хэрэгт хавсаргана.

АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ НОТЛОХ БАРИМТ

16.1 дүгээр зүйл.Нотлох баримт

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.

2.Баримтат мэдээлэл нь гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг, эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, мөрдөгчийн магадлагаа, энэ хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, эрх бүхий байгууллагын цахим мэдээллийн сангаас цахим гарын үсгээр

баталгаажуулж авсан лавлагаа, тодорхойлолт, ул мөрөөс авсан хэв, мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл, хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл болон энэ хуульд заасан бусад баримтаар тогтоогдоно.

[/Энэ заалт ад 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

3.Прокурор, мөрдөгч, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээлэл, өргөдлийг шалгах, эрүүгийн хэргээс бусад зөрчил, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын явцад хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн болон энэ хуулийн Дөчин хоёрдугаар бүлэгт заасан журмаар гадаад улсаас ирүүлсэн баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцож болно.

4.Мөрдөгч энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу нотлох баримт цуглуулж, шалгаж, бэхжүүлнэ.

5.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцох нь тэдгээрийг шалгах зорилгоор мөрдөн шалгах ажиллагаа явуулахыг хязгаарлах үндэслэл болохгүй.

6.Нотлох баримтыг хууль бус арга, хэрэгслээр цуглуулж, бэхжүүлэхийг хориглоно.

7.Энэ хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж авсан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцохгүй.

8.Шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаанаар шинжлэн судалсан нотлох баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болно.

9.Хавтаст хэрэгт авагдаагүй нотлох баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.

10.Хохирогч, яллагдагч тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс гаргаж өгсөн эд зүйл, баримт бичиг, гомдол, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч, прокурор авч хавтаст хэрэгт тусгаж хавсаргана.

11.Энэ хуульд заасны дагуу оролцогчоос прокурор, мөрдөгчид гаргаж өгсөн эд зүйл, баримт бичиг, гомдол, мэдээлэл, бусад баримтыг олж авсан эх сурвалжийг зааж хэлээгүй бол дангаараа нотлох баримт болохгүй.

12.Өмгөөлөгчийн хууль зүйн туслалцаа үзүүлэх, өмгөөлөх үйл ажиллагаатай холбоотой харилцааны баримтыг нотлох баримтаар тооцохгүй.

13.Шүүх, прокурор, мөрдөгч тухайн хэрэгт хамааралтай энэ хуульд заасны дагуу цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай эсэхийг бүхэлд нь үнэлнэ.

14.Нотлох баримтыг шинжлэн судлах явцад хэрэгт ач холбогдолтой, хамааралтай эсэхэд эргэлзэх үндэслэл байвал тухайн нотлох баримтыг шүүх, прокурорын шийдвэрийн үндэслэл болгохгүй.

15.Хавтаст хэрэгт тусгагдсан нотлох баримтыг шүүх хуралдаанаар шинжлэн судалж аль нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болохыг шүүх шийдвэрлэнэ.

16.2 дугаар зүйл.Нотолбол зохих байдал

1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны явцад дараахь байдлыг нотолно:

- 1.1.гэмт хэрэг гарсан байдал /гэмт хэргийг хэзээ, хаана, яаж үйлдсэн болон Эрүүгийн хуульд заасан бусад байдал/;
- 1.2.гэмт хэргийг хэн үйлдсэн;
- 1.3.гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр;
- 1.4.Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал;
- 1.5.гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ;
- 1.6.гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл.

16.3 дугаар зүйл.Мэдүүлэг

1.Мөрдөгч нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, бусад оролцогчоос эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар, шинжээчээс гаргасан дүгнэлтийнх нь талаар тайлбарлуулах, эсхүл тодруулах зорилгоор мэдүүлэг авч болно.

2.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлгийг нотлох баримтаар тооцох боловч уг мэдүүлэг дангаараа түүнийг яллах үндэслэл болохгүй.

3.Мэдүүлэг өгөгч мэдүүлгийнхээ эх сурвалжийг зааж чадаагүй бол тухайн мэдүүлэг нь дангаараа нотлох баримт болохгүй.

4.Дараахь хүнээс гэрчийн мэдүүлэг авч болохгүй:

- 4.1.тухайн хэргийг урьд нь хянан шийдвэрлэсэн шүүгч, прокурор;
- 4.2.өмгөөлөх, хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргээ гүйцэтгэж байх явцад тухайн хэргийн байдлыг мэдэх болсон өмгөөлөгч, хуульч;
- 4.3.хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэх замаар уг хэргийн байдлыг мэдэх болсон эвлэрүүлэн зуучлагч;
- 4.4.өвчний улмаас хэргийн нөхцөл байдлыг зөв ойлгож, зөв мэдүүлэх чадваргүй болсон нь тогтоогдсон хүн;

4.5.эмчилгээ хийж байх явцад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн холбогдсон хэргийн талаар мэдэх болсон сэтгэл зүйч;

4.6.өөрийн болон гэр бүлийн гишүүдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзсан гэрч, хохирогч.

5.Энэ зүйлийн 4.5-д заасан хүн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчтэй харилцах явцад хийгдсэн тэмдэглэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг нь хэргийн нотлох баримт болохгүй ба сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу нотлох баримтад тооцож болно.

6.Энэ зүйлийн 4.5-д заасан хүнээс сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн гэрчийн мэдүүлэг авч болно.

7.Энэ зүйлийн 4.5-д заасан хүнтэй харилцан ярьсан ярианы талаар сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч өөрөө задруулсныг сонссон гэрчийн мэдүүлгийг шүүхэд нотлох баримтаар тооцож болно.

8.Дараахь мэдүүлэг дангаараа яллагдагч, шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайг нотлох шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй:

8.1.нэрийг нь нууцалсан гэрчийн мэдүүлэг;

8.2.хамтран ажиллах этгээдийн мэдүүлэг;

8.3.яллагдагч, шүүгдэгчийн хэргээ хүлээсэн мэдүүлэг;

8.4.өвчний улмаас хэргийн нөхцөл байдлыг зөв ойлгож, зөв мэдүүлэх чадваргүй болсон гэрч, хохирогчийн мэдүүлэг.

9.Шүүх хавтаст хэргийн материалд тусгагдсан мэдүүлгийг шүүх хуралдаанд өгсөн мэдүүлэгтэй харьцуулан шүүхийн шийдвэрийн үндэслэл болгох эсэхийг шийдвэрлэнэ.

10.Гэрчээр мэдүүлэг авч байх үед гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрвэл мэдүүлэг авах ажиллагааг зогсоож, сэжигтнээр мэдүүлэг авах ажиллагааг энэ хуульд заасны дагуу явуулна.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

11.Дүрс харж ярих боломжтой технологи, мэдээллийн хэрэгсэл ашиглан мэдүүлгийг авч болно. Энэ тохиолдолд өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчийн оролцоог ханган дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж, хавтаст хэрэгт хавсаргана.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

12.Хүнийг гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл байгаа бол түүнийг гэрчээр дуудах, түүнээс гэрчийн мэдүүлэг авахыг хориглоно.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

16.4 дүгээр зүйл.Эд мөрийн баримт

1.Эд мөрийн баримтад гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн тээврийн хэрэгсэл, уналга, зэвсэг, хэрэгсэл, гэмт үйлдлийн замаар олсон мөнгө, үнэ бүхий зүйл, бусад эд зүйлс, гэмт хэргийн ул мөр үлдсэн, агуулсан түүнчлэн гэмт хэрэг, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг илрүүлэх, хэргийн бодит байдлыг тогтоох, эсхүл сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм бурууг үгүйсгэх, эсхүл хөнгөрүүлэхэд ач холбогдол бүхий бичмэл болон цахим баримт, бусад эд зүйлийг тооцно.

16.5 дугаар зүйл.Шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тусгай мэдлэг зайлшгүй шаардагдсан, эсхүл эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоохоор шинжилгээ хийлгэнэ.

2.Шинжилгээ хийлгэхээр хэд хэдэн шинжээчийг томилсон бол дүгнэлт гаргахаас өмнө хоорондоо зөвлөлдөж, санал нэгдвэл дүгнэлтэд бүгд гарын үсэг зурна.

3.Дүгнэлт гаргахад санал зөрсөн шинжээч саналаа бичиж, дүгнэлтэд хавсаргана.

4.Шинжээчийн дүгнэлтийг шүүх, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах үүрэггүй боловч дүгнэлтийг зөвшөөрөхгүй байгаа бол үндэслэлийг заана.

5.Шинжээчийн хэд хэдэн дүгнэлт, мөрдөгчийн магадлагаа гарсан тохиолдолд эдгээрийг шүүхээр хянан хэлэлцэж, алийг нь нотлох баримтаар тооцохыг шийдвэрлэнэ.

16.6 дугаар зүйл.Баримт бичиг

1.Хуулийн этгээд, албан тушаалтан, иргэний баталсан болон бичсэн баримт бичиг, эрүүгийн хэрэгт ач холбогдолтой баримтат мэдээллийг тухайн төрийн байгууллагаас үнэн зөвийг баталгаажуулж ирүүлсэн тохиолдолд нотлох баримт болно.

2.Бичмэл нотлох баримт энэ хуулийн 16.4 дүгээр зүйлд заасан шинжтэй байвал эд мөрийн баримт болно.

3.Бичмэл нотлох баримтыг эх хувиар нь, хэрэв эхийг авах боломжгүй бол прокурор, мөрдөгч тэмдэглэл үйлдэн хуулбарлан авна.

4.Энэ хуулийн 16.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан нотлох баримтыг тухайн төрийн байгууллагаас үнэн зөвийг баталгаажуулж ирүүлнэ.

16.7 дугаар зүйл.Мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэл

- 1.Мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэл, түүнд хавсаргасан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, авсан гэрэл зураг, үйлдсэн гар зураг, ул мөрөөс авсан хэв нотлох баримт болно.
- 2.Мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгагдсан нөхцөл байдал нь дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгээс зөрсөн тохиолдолд шүүх, прокурор дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг нотлох баримтаар тооцно.
- 3.Шүүх энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцөл байдлыг тогтоохоор прокурор, оролцогчийн хүсэлтээр мөрдөн шалгах ажиллагаанд оролцсон хүнийг гэрчээр дуудаж, нотлох баримтыг шинжлэн судалж болно.

16.8 дугаар зүйл.Мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох

- 1.Хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох ба нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны арга, хэрэгсэл, эх сурвалж нууц байна.
- 2.Прокурор, мөрдөгч нь мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах шийдвэр, түүний үр дүнг хавтаст хэрэгт хавсаргахад энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримтална.
- 3.Мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах байгууллага, ажилтны үйл ажиллагааны зарчим, эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон энэ хуульд заагаагүй асуудлыг Гүйцэтгэх ажлын тухай хуулиар зохицуулна.
- 4.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн болох баримт, мэдээллийн талаар мөрдөгч нууц ажиллагааны магадлагаа үйлдэж, прокуророор баталгаажуулж хавтаст хэрэгт тусгана.
- 5.Хавтаст хэрэгт тусгагдаагүй баримт сэлт, мэдээлэл, мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн, бусад баримт болон гүйцэтгэх ажилтай холбоотой ямар ч баримт мэдээллийг шүүхийн хэлэлцүүлэг, урьдчилсан хэлэлцүүлэг явуулах, хэрэг хянан шийдвэрлэх шүүхэд танилцуулахыг хориглоно.

16.9 дүгээр зүйл.Нотлох баримтыг шинжлэн судлахаас татгалзах

- 1.Шүүх дараахь тохиолдолд нотлох баримтыг дахин шинжлэн судлахгүй:
 - 1.1.танин мэдэхүйн хувьд нийтэд илэрхий, эсхүл шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон хэргийн нөхцөл байдал;
 - 1.2.тухайн хэрэгт хамааралгүй нөхцөл байдлыг тодруулсан;
 - 1.3.эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах зорилгоор гаргасан нөхцөл байдал, баримт.

16.10 дугаар зүйл.Нотлох баримт гаргаж өгөх, нотлох баримт шалгуулах, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлтийг шийдвэрлэх

- 1.Хохирогч, гэрч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, сэжигтэн, яллагдагч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргаж өгсөн эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг мөрдөгч хүлээн авч, тэмдэглэл үйлдэн хавтаст хэрэгт тусгаж хавсаргана.
[/Энэ заалт ад 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)
- 2.Хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, яллагдагч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг шалган тогтоолгохоор мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргах эрхтэй.
- 3.Хүсэлтэд тогтоолгох үйл явдал, явуулах мөрдөн шалгах ажиллагааны талаар заана.
- 4.Шүүх, прокурор, мөрдөгч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүсэлт нь хэргийг тал бүрээс нь бүрэн бодитой тогтооход ач холбогдолтой бол бүрэн, эсхүл хэсэгчлэн хангах, эсхүл хангахаас татгалзах тухай шийдвэр гаргана. Хүсэлтийг хэсэгчлэн хангасан, эсхүл хангахаас татгалзсан үндэслэлийг шийдвэртээ тодорхой тусгана.
[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)
- 5.Мөрдөгчийн энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, яллагдагч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь прокурорт, прокурорын шийдвэрт тухайн дээд шатны прокурорт хандан гомдол гаргаж болно.
- 6.Энэ зүйлд заасан хүсэлт, гомдол, тэдгээрийг хангасан, хангахаас татгалзсантай холбоотой баримт, шийдвэрийг эрүүгийн хавтаст хэрэгт тусгана.
- 7.Энэ зүйлд заасны дагуу гаргаж өгсөн эд зүйл, баримт бичиг, мэдээлэл, бусад баримтыг оролцогчийн хүсэлтээр шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр нотлох баримтаар тооцуулах, шүүх хуралдаанд шинжлэн судлуулах эрхтэй.

16.11 дүгээр зүйл.Нотлох баримтаар тооцохгүй байх

- 1.Дараахь тохиолдолд өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгсөн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлгийг нотлох баримтаар тооцохгүй байх тухай прокурорын санал, оролцогчийн хүсэлтийг шүүх хянан хэлэлцэж, тухайн нотлох баримтыг нотлох баримтад тооцохгүй байх эсэхийг шийдвэрлэнэ:
 - 1.1.энэ хуульд заасныг зөрчиж мэдүүлэг авсан;
 - 1.2.энэ хуулийн 5.3 дугаар зүйлд заасныг зөрчсөн;

1.3.өмгөөлөгчтэй мэдүүлэг өгөх эрхийг зөрчиж мэдүүлэг авсан.

2.Энэ хуульд заасан үндэслэл, журмыг зөрчин цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцэж байгаа эсэхийг харгалзан бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь, тодорхой мөрдөн шалгах ажиллагаагаар цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтын заримыг нотлох баримтаар тооцохгүй байх тухай прокурорын санал, оролцогчийн хүсэлтийг шүүх хянан хэлэлцэж, дараахь шийдвэр гаргана:

2.1.санал, хүсэлтийг хүлээн авахаас татгалзах;

2.2.бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нотлох баримтаар тооцохгүй байх;

2.3.тодорхой мөрдөн шалгах ажиллагаагаар цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтын заримыг нь нотлох баримтаар тооцохгүй байх.

3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан нотлох баримтад үндэслэн цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй байх тухай прокурорын санал, оролцогчийн хүсэлтийг үндэслэн шүүх хянан шийдвэрлэнэ.

16.12 дугаар зүйл.Эрүү шүүлт тулгаж авсан нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй байх

1.Эрүү шүүлт тулгаж, бусад хэлбэрээр хүнлэг бус, хэрцгий харьцаж мэдүүлэг авсан нь тогтоогдвол авсан мэдүүлгийг нотлох баримтаар тооцохгүй.

[Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.](#)

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдүүлгийг эрүү шүүлт тулгах гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд нотлох баримтаар тооцож болно.

16.13 дугаар зүйл.Шинжлэн судлахаас татгалзсан, хүчингүйд тооцсон нотлох баримт

1.Шүүх энэ хуулийн 16.9, 16.11 дүгээр зүйлд заасны дагуу шинжлэн судлахаас татгалзсан, хүчингүйд тооцсон нотлох баримтыг шүүхийн шийдвэр, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгана.

16.14 дүгээр зүйл.Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх

1.Энэ хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах замаар нотлох баримт цуглуулж, хэрэгт цугларсан эд мөрийн баримт, баримтат мэдээллийг мөрдөн шалгах ажиллагааны болон шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж бэхжүүлнэ.

2.Нотлох баримт бэхжүүлэхдээ тэмдэглэл үйлдэхийн зэрэгцээ мэдээллийг тусгасан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх, гэрэл зураг авах, гар зураг үйлдэх, ул мөрнөөс хэв, хээ буулгаж авах зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчимд нийцэх бусад аргыг хэрэглэнэ.

3.Мөрдөгч нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхдээ тэдгээрийг устах, гэмтэх, үрэгдэхээс хамгаалах арга хэмжээг авна.

4.Нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхдээ иргэний амь нас, эрүүл мэндэд аюултай, эсвэл тэдний нэр төрийг гутаан доромжлох, хүнлэг бус, хэрцгий харьцах, айлган сүрдүүлэх, мэдүүлэг, тайлбар, дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэхийг хориглоно.

5.Эд мөрийн баримтыг бэхжүүлэхдээ тэдгээрийг хэн, хэзээ, ямар эх сурвалжаас хэрхэн олж авсан талаар, түүний онцлог шинж, хэлбэр дүрс, тоо хэмжээ, хадгалсан, шилжүүлсэн, хүлээн авсан шилжилт хөдөлгөөний талаар мөрдөн шалгах ажиллагааны болон прокурорын хянан шалгах ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгана.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

6.Цахим баримтыг бэхжүүлэхдээ цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, зөөвөрлөх явцад мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар авсан арга хэмжээ, хэрэглэсэн техник хэрэгслийг бэхжүүлсэн тэмдэглэл үйлдэж, гэрэл зураг авах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгээр давхар баталгаажуулна.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан ажиллагаанд оролцсон тусгай мэдлэгтэй мөрдөгч, мэргэжилтний хийсэн үйлдэл, үйл ажиллагааны нөхцөл байдал, авсан арга хэмжээ, ажиллагааны үр дүнг тэмдэглэлд бүрэн тусгана.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

8.Цахим төхөөрөмжөөс өөрчлөгдсөн, устгасан мэдээллийг сэргээсэн тохиолдолд нотлох баримтад тооцож болно.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

9.Мөрдөн шалгах ажиллагааны явцад гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн хувийг хавтаст хэргийн хамт хадгална.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

16.15 дугаар зүйл.Нотлох баримтыг шалгаж үнэлэх

1.Мөрдөгч нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхдээ хуулийн дагуу явагдаж байгаа эсэх, цугларч байгаа нотлох баримт нь хэрэгт хамааралтай, ач холбогдолтой эсэхийг хянаж үнэлнэ.

2.Шүүх, прокурор, мөрдөгч нь хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгож нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ.

3.Хэрэгт авагдсан нотлох баримтыг харьцуулан шинжлэн судлах, бусад нотлох баримттай харьцуулах, шинэ нотлох баримтыг цуглуулах, нотлох баримтын эх сурвалжийг магадлах аргаар нотлох баримтыг шалгана.

IV ХЭСЭГ

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУСГАЙ ЖУРАМ

АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ

ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

17.1 дүгээр зүйл.Яллагдагч хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт гаргах

1.Яллагдагч гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрч, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлэхээ илэрхийлж, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн бол хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг мөрдөгч, эсхүл прокурорт гаргаж болно.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.Яллагдагч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтийг прокурор хэргийг шүүхэд шилжүүлэхээс өмнө гаргана.

[/Энэ хэсэг т 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

3.Яллагдагч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтэд хохирлоо нөхөн төлсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн баримтыг хавсаргана.

[/Энэ хэсэг т 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэл т оруулсан./](#)

[/Энэ хэсэг т 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

4.Яллагдагчид гэмт хэрэг үйлдсэн гэм бурууг нь хүлээн зөвшөөрүүлэхээр тулган шаардах, албадахыг хориглоно.

5.Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг найман жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй.

6.Яллагдагч хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэхээр гаргасан хүсэлтийг хүлээн авсан мөрдөгч даруй прокурорт танилцуулж, мөрдөн байцаалт явуулна.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7.Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлгийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхгүй.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

17.2 дугаар зүйл.Хүсэлтийг шийдвэрлэх

1.Прокурор, мөрдөгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрч, мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулж гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлэхээ илэрхийлж, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн бол хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан яллагдагчид Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 6.7 дугаар зүйлд заасныг үндэслэн ял оногдуулах, ялаас чөлөөлөх, ял оногдуулахгүй тэнсэж албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай болон энэ бүлэгт заасан журмаар хэрэг хянан шийдвэрлэх үндэслэл, журмыг танилцуулна.

[/Энэ хэсэг т 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмэл т оруулсан./](#)

[/Энэ хэсэг т 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

2.Прокурор яллагдагчийн хүсэлтийг хүлээн авах, эсхүл татгалзах тухай тогтоол гаргана.

3.Прокурор хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжтой гэж үзсэн бол мөрдөгч 14 хоногийн дотор мөрдөн байцаалт явуулна.

4.Прокурор хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэхээр гаргасан яллагдагчийн хүсэлтийг хүлээн авсан мөрдөгчид дараах мөрдөн шалгах ажиллагаанаас шаардлагатай гэж үзсэн ажиллагааг явуулахыг даалгана:

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

4.1.энэ хуулийн 30.7 дугаар зүйлд заасан мөрдөн шалгах ажиллагаа;

[/Энэ заал т-ыг 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

4.2.энэ хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад мөрдөгчийн бие даан явуулах мөрдөн шалгах ажиллагаа.

[/Энэ заал т-ыг 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.Гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрч, хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан боловч өмгөөлөгч авахаас татгалзсан яллагдагчид өмгөөлөгч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах журмыг Монголын Өмгөөлөгчдийн Холбооны саналыг харгалзан хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

6.Прокурор, мөрдөгч яллагдагчид энэ хуулийн Долдугаар бүлэгт заасан эрх, үүргээс гадна дараах эрхийг тусгайлан танилцуулна:

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

6.1.тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаар мэдээлэл авах;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

6.2.прокурорын санал болгосон эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг хүлээн зөвшөөрөх, эсхүл татгалзах;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

6.3.эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаар өөрийн саналыг илэрхийлэх;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

6.4.шүүх шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө хэргээ хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэхээс татгалзах.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7.Прокурор хохирогчид энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэрийг мэдэгдэж, хохирол нөхөн төлөх талаар яллагдагчийн гаргасан санал болон энэ хуулийн Наймдугаар бүлэгт заасан эрх, үүргийг тусгайлан танилцуулна.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

8.Хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн яллагдагч зарим хэргээ хүлээн зөвшөөрөөгүй бол түүнд холбогдох хэргийг бүхэлд нь ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

9.Нэг, эсхүл хэд хэдэн гэмт хэрэг хамтран үйлдсэн яллагдагч нарын зарим нь гэм буруугаа бүрэн, эсхүл хэсэгчлэн хүлээн зөвшөөрөөгүй бол тухайн яллагдагч нарт холбогдох хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

10.Гэм буруугаа хүлээн зөвшөөрч, гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн хүнд холбогдох хэргийг бусад яллагдагч нарт холбогдох хэргээс тусгаарласан бол түүнд холбогдох хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж болно.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

11.Эрүүгийн хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэсэн нь мөрдөн шалгах ажиллагааны явцад гэм буруугаа хүлээн зөвшөөрч, гэмт хэргийг нотлоход дэмжлэг үзүүлсэн хүнд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлд заасныг журамлан ял оногдуулахад саад болохгүй.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

17.3 дугаар зүйл.Прокурорын хяналт

1.Прокурор хялбаршуулсан журмаар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийн материалтай даруй танилцаж, дараахь нөхцөл байдал тогтоогдсон эсэхийг хянана:

1.1.гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрсөн эсэх;

1.2.Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 5.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 6.7 дугаар зүйлд заасан нөхцөл хангагдсан эсэх;

[/Энэ заалтад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

1.3.гэмт хэрэг үйлдсэн нь нотлох баримтаар тогтоогдсон эсэх.

2.Яллагдагч нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэх хүсэлт гаргасан, эсхүл хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлтээсээ татгалзсан, хэргийн зүйлчлэл, хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар санал зөрсөн, эсхүл энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл байдал тогтоогдоогүй бол хэргийг ердийн журмаар шийдвэрлэхээр прокурор тогтоол гаргана.

3.Прокурор хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх үндэслэлтэй гэж үзвэл хэргийн зүйлчлэл, түүнд оногдуулах ялын төрөл, хэмжээ, эсхүл ялаас чөлөөлөх, эсхүл ял оногдуулахгүй тэнсэж албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай саналыг яллагдагч, түүний өмгөөлөгчид танилцуулж, яллагдагч зөвшөөрвөл гарын үсэг зуруулж, яллах дүгнэлт үйлдэн хэргийг шүүхэд даруй шилжүүлнэ.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан ажиллагааг явуулахад энэ хуулийн Гучин гуравдугаар бүлэгт заасан журмыг баримтлахгүй.

5.Яллагдагчийн хүлээн зөвшөөрсөн прокурорын саналд энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна дараах нөхцөл байдлыг тусгаж, хэрэгт хавсаргана:

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.1.эрүүгийн хариуцлагын талаар прокурорын санал танилцуулсан он, сар, өдөр, газар;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.3.яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн талаарх мэдээлэл;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.4.гэмт хэрэг үйлдсэн он, сар, өдөр, газар, хэргийн товч агуулга;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.5.гэмт хэргийн үндсэн шинж;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.6.гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, хор уршгийн шинж чанар;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.7.яллагдагчийн хохирол нөхөн төлсөн, эсхүл хохирол нөхөн төлөхөө бодитой илэрхийлсэн байдал;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.8.яллагдагчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд харгалзан үзэх хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.9.яллагдагчийн биеийн байцаалт;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.10.яллагдагч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол түүний үйлдэл тус бүрд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.11.Эрүүгийн хуулийн 6.8, 6.9 дүгээр зүйлд заасан журмын дагуу ял нэгтгэснээр яллагдагчийн нийт эдлэх алын төрөл, хэмжээ;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.12.Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасны дагуу хураалгах хөрөнгө, орлого.

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

6.Прокурор яллагдагчийн гэм буруу, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар яллагдагчийн хүлээн зөвшөөрч, гарын үсэг зурж баталгаажуулсан саналыг яллах дүгнэлтийн хавсралтад тусгаж, хэргийг 7 хоногийн дотор шүүхэд шилжүүлнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7.Прокурорын яллах дүгнэлтийн хавсралтад дараах зүйлийг тусгана:

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7.1.яллагдагчтай хийсэн тохиролцооны агуулга;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7.2.яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээ;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7.3.гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг яллагдагч нөхөн төлсөн, эсхүл нөхөн төлөхөө илэрхийлсэн байдал;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7.4.мөрдөн шалгах ажиллагаанд гарсан зардлын тооцоо;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7.5.хэрэгт хураагдсан, битүүмжлэгдсэн хөрөнгө, эд мөрийн баримт, тэдгээрийн байгаа газар;

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7.6.прокурорын яллагдагчтай хийсэн тохиролцоог батлах хүсэлт.

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

8.Прокурор яллах дүгнэлтийн хувийг яллагдагчид гардуулж, хавтаст хэргийг харьяалах шүүхэд шилжүүлсэн тухай яллагдагч, хохирогч, эсхүл тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

9.Прокуророос эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлсний дараа оролцогч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой санал, хүсэлтээ харьяалах шүүхэд гаргана.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

17.4 дүгээр зүйл.Шүүх хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам

1.Шүүх хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад энэ хуульд заасан ердийн журмаас гадна энэ бүлэгт заасан тусгай журмыг баримтална.

2.Шүүх тухайн хэргийг шууд хянан шийдвэрлэх боломжтой гэж үзвэл хүлээн авсан даруй, эсхүл 7 хоногийн дотор эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлэлцэх шүүх хуралдаан зарлан явуулж болно.

[/Энэ хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

3.Шүүх хуралдаанд прокурор, шүүгдэгч, түүний өмгөөлөгч, эсхүл хууль ёсны төлөөлөгч оролцоно. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч оролцох хүсэлт гаргасан бол оролцуулна.

4.Шүүх хуралдаанаар дараахь нөхцөл байдлыг хянана:

4.1.шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлох баримтаар нотлогдсон эсэх;

4.2.гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрсөн эсэх;

4.3.прокурорын сонгосон ял, албадлагын арга хэмжээг хүлээн зөвшөөрсөн эсэх;

[/Энэ заалт ад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

4.4.хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг зөвшөөрсөн эсэх;

[/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

4.5.гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршгийг нөхөн төлсөн, нөхөн төлөхөө илэрхийлсэн эсэх;

[/Энэ заалт ад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

4.6.гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа хүлээн зөвшөөрсний улмаас үүсэх хууль зүйн үр дагаврыг ойлгосон эсэх.

5.Шүүх хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэх үндэслэл тогтоогдвол шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 5.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 6.7 дугаар зүйлд заасныг баримтлан прокурорын саналын хүрээнд шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай шийдвэр гаргана.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

6.Шүүгдэгч хүсэлтээсээ татгалзсан, эсхүл энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан нөхцөл байдлын аль нэг нь хангагдаагүй гэж үзэх үндэслэл байвал шүүх хэргийг прокурорт буцаах, эсхүл буцаахгүйгээр ердийн журмаар шийдвэрлэнэ. Энэ шийдвэрт прокурор, оролцогч гомдол, эсэргүүцэл гаргахгүй.

[/Энэ хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

7.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу гаргасан шүүхийн шийдвэрт прокурор, оролцогч гагцхүү энэ хуулийг ноцтой зөрчсөн үндэслэлээр давж заалдах журмаар гомдол, эсэргүүцэл гаргаж болно.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

8.Энэ зүйлийн 7 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд гомдол, эсэргүүцэл гаргахгүй.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

9.Хялбаршуулсан журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдааны дэг болон шүүхийн шийдвэрийг боловсруулах аргачлал, журмыг Улсын дээд шүүх батална.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

17.5 дугаар зүйл.Зарим гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх журам

[/Энэ зүйлийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

17.6 дугаар зүйл.Шүүх хуралдаанд хохирогч, шүүгдэгч, прокурор, өмгөөлөгч хүрэлцэн ирээгүйн холбогдол

1.Энэ бүлэгт заасан шүүх хуралдаанд шүүгдэгч, прокурор, өмгөөлөгч, шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргасан хохирогч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно.

2.Өмгөөлөгч, прокурор хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд шүүх хуралдаанд оролцоно.

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ ӨСВӨР НАСНЫ СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧ, ШҮҮГДЭГЧИД ХОЛБОГДОХ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

18.1 дүгээр зүйл.Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэрэг хянан шийдвэрлэх журам

1.Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа энэ хуульд заасан ердийн журмаас гадна энэ бүлэгт заасан тусгай журмыг удирдлага болгоно.

2.Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийг оролцуулахаас гадна шаардлагатай гэж үзвэл сурган хүмүүжүүлэгч, эсхүл хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг байлцуулж болно.

3.Хууль ёсны төлөөлөгчийг өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй гэж шүүх, прокурор, мөрдөгч үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахгүй.

4.Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч энэ хуулийн 5.2 дугаар зүйлд заасны дагуу өмгөөлөгч

18.2 дугаар зүйл.Өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах нийтлэг шаардлага

- 1.Шүүх өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, шийдвэр гаргахдаа түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангана.
- 2.Өсвөр насны шүүгдэгчтэй харьцахдаа түүний нэр төрийг хүндэтгэн харьцаж, насны онцлогийг харгалзан хүмүүжих, алдаагаа засах боломж олгохыг анхаарч ажиллана.
- 3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулж, шийдвэрийг олон нийтэд мэдээлэхдээ өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, түүнд учирч болох бусад хор уршгийг тусгайлан харгалзана.
- 4.Өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасан ердийн журмаар явагдах ажиллагаанаас шуурхай, богино хугацаанд явуулах нөхцөлийг шүүх хангаж ажиллана.

18.3 дугаар зүйл.Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдлыг тогтоох

- 1.Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийн хувийн байдалтай нь холбоотой дараахь мэдээллийг тогтоосон байна:
 - 1.1.төрсөн он, сар, өдөр, нас;
 - 1.2.амьдралын нөхцөл байдал ба хүмүүжилтэй холбоотой мэдээлэл;
 - 1.3.гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл;
 - 1.4.гэмт хэрэг хамтран үйлдэгч байсан эсэх;
 - 1.5.сэтгэцийн өвчинтэй холбогдолгүй боловч ухаан санаа нь гүйцэд хөгжөөгүйн улмаас өөрийнхөө үйлдлийн холбогдлыг бүрэн ойлгож байгаа эсэхэд эргэлзээ төрвөл шинжээч томилж, дүгнэлт гаргуулах.
- 2.Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийн насыг хуулийн дагуу авсан иргэний бүртгэлийн бичиг баримтаар тодорхойлно.
- 3.Дараахь тохиолдолд өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийн насыг тогтоох зорилгоор шинжээч томилно:
 - 3.1.энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бичиг баримт нь хуурамч гэж үзэх үндэслэл байвал;
 - 3.2.энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бичиг баримт байхгүй бол;
 - 3.3.өөр улсад бүртгэлтэй, энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан бичиг баримтыг олж авах боломжгүй бол.
- 4.Өсвөр насны яллагдагч, шүүгдэгчийн насыг энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас өөр аргаар тогтоосон нотлох баримтыг шүүхээр шинжлэн судлах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.
- 5.Шүүх өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх явцад дараахь мэдээллийг гаргаж өгөхийг прокуророос шаардаж болно:
 - 5.1.тухайн шүүгдэгч гэмт хэрэг үйлдэхийн өмнө болон дараа биеэ хэрхэн авч явж байсан зан байдал, араншин;
 - 5.2.тухайн шүүгдэгч гэмт хэрэг үйлдэх үедээ ямар нөхцөл байдалд байсан.
- 6.Шүүх ял эдэлж байгаа өсвөр насны хүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэхэд энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан мэдээлэл гаргаж өгөхийг прокуророос шаардаж болно.

18.4 дүгээр зүйл.Өсвөр насны яллагдагчийн үйлдсэн хэргийг тусгаарлах

- 1.Эрүүгийн хэргээс өсвөр насны яллагдагчид холбогдох хэргийг мөрдөн байцаалтын шатанд тусгаарлаж шалгана.
- 2.Өсвөр насны яллагдагчийн хэргийг тусгаарлах нь хэргийг бүх талаас нь бүрэн бодитой тогтооход саад учруулахаар байвал тусгаарлахгүй байж болно.

18.5 дугаар зүйл.Мөрдөн байцаалтад хууль ёсны төлөөлөгч оролцох

- 1.Прокурор, мөрдөгч өсвөр насны сэжигтэн, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгчийг тогтоож, түүнд мөрдөн шалгах ажиллагааны явцад ямар эрхтэй оролцохыг тайлбарлана.
- 2.Өсвөр насны сэжигтэн, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч нь дараахь эрхтэй:
 - 2.1.өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг ямар хэрэгт буруутгаж байгааг мэдэх;
 - 2.2.эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахад байлцах;
 - 2.3.өсвөр насны сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авах, яллагдагч, өмгөөлөгчийг байлцуулан хийж байгаа бусад ажиллагаанд мөрдөгч, прокурорын зөвшөөрснөөр оролцох;
 - 2.4.хүсэлт, гомдол гаргах;
 - 2.5.нотлох баримтын ач холбогдол бүхий зүйлийг шалгуулах хүсэлт гаргах.

18.6 дугаар зүйл.Өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг дуудан ирүүлэх, баривчлах

- 1.Баривчлах сэжигтэн нь өсвөр насны хүн бол энэ зүйлд заасан журмыг баримтална.
- 2.Өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг түүний хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчаар дамжуулан дуудна.
- 3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад болох үндэслэл байвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтлахгүй.
- 4.Өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг албадан ирүүлсэн, баривчилсан, цагдан хорьсон тухай түүний гэр бүлийн гишүүн, хууль ёсны төлөөлөгч, эсхүл өмгөөлөгчид нь 6 цагийн дотор мэдэгдэнэ.
- 5.Баривчлагдсан өсвөр насны сэжигтэн, цагдан хоригдсон өсвөр насны яллагдагчийг баривчлагдсан арван найман насанд хүрсэн хүн, цагдан хоригдсон арван найман насанд хүрсэн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээс тусад нь байлгана.

18.7 дугаар зүйл.Өсвөр насны яллагдагчид холбогдох хэргийн шүүхийн хэлэлцүүлэг

- 1.Энэ хуулийн 14.13 дугаар зүйлд заасан журмаар явагдах өсвөр насны яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлэг хаалттай явагдах ба өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчийг оролцуулна.
- 2.Өсвөр насны яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч хүрэлцэн ирээгүй нь шүүхийн хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.

18.8 дугаар зүйл.Цагдан хорих

- 1.Энэ хуулийн 14.13 дугаар зүйлд заасны дагуу өсвөр насны яллагдагчийг цагдан хорих асуудлыг хянан шийдвэрлэх шүүхийн хэлэлцүүлэгт өмгөөлөгч, эсхүл хүсэлт гаргасан хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг оролцуулна.
- 2.Өсвөр насны яллагдагчийг цагдан хорих үндсэн хугацаа 1 сар хүртэл байх ба цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний нийт хугацаа Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид 3 сараас, Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчид 6 сараас хэтэрч болохгүй.

[/Энэ хэсэгт 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

18.9 дүгээр зүйл.Өсвөр насны яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгчийг хавтаст хэргийн материалтай танилцуулах

- 1.Өсвөр насны яллагдагчид хавтаст хэргийн материалыг энэ хуульд заасны дагуу танилцуулахад түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгчийг оролцуулна.
- 2.Өсвөр насны яллагдагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болзошгүй гэж үзвэл мөрдөгч нь өсвөр насны яллагдагчид хавтаст хэргийн материалыг танилцуулахад түүний хууль ёсны төлөөлөгчийг оролцуулахгүй.

18.10 дугаар зүйл.Шүүх хуралдаанд өсвөр насны шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгчийг оролцуулах

- 1.Өсвөр насны шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгч шүүх хуралдаанд нотлох баримт шинжлэн судлахад оролцох, шүүх хуралдаанд оролцогчийг татгалзан гаргах эрхтэй ба шүүх хуралдаан эхлэхэд шүүх хуралдаан даргалагч түүнд энэ эрхийг тайлбарлана.
- 2.Өсвөр насны шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгчөөс гэрчийн мэдүүлэг авах шаардлагатай бол түүний мэдүүлгийг хохирогчоос мэдүүлэг авсны дараа сонсоно.
- 3.Өсвөр насны шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгч шүүх хуралдааны туршид байлцана.
- 4.Шүүх хуралдаанд хууль ёсны төлөөлөгч оролцох нь өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болзошгүй гэж үзвэл түүнийг шүүх хуралдаанд оролцуулахгүй байх, эсхүл шүүх хуралдааны зарим хэсэгт оролцохыг хязгаарлаж болно.
- 5.Өсвөр насны шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгчийг оролцуулах шаардлагатай гэж шүүх үзээгүй бол түүний ирээгүй нь уг хэргийг хянан хэлэлцэх ажиллагааг хойшлуулах шалтгаан болохгүй.

18.11 дүгээр зүйл.Өсвөр насны шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимаас гаргах

- 1.Шүүх хуралдааны явцад өсвөр насны шүүгдэгчид сөргөөр нөлөөлж болох байдал тогтоогдвол талуудын хүсэлтээр шүүх хуралдаан даргалагч түүнийг шүүх хуралдааны танхимаас гаргаж болно.

АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

19.1 дүгээр зүйл.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэл

- 1.Сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй, сэтгэцийн эмгэг, эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай хүн гэмт хэрэг үйлдсэн, эсхүл гэмт хэрэг үйлдсэний дараа сэтгэцийн өвчнөөр өвчилсний улмаас хэрэг хариуцах чадваргүй болсон яллагдагч, шүүгдэгчид эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ энэ хуульд заасан ердийн журмаас гадна энэ бүлэгт заасан тусгай журмыг удирдлага болгоно.
- 2.Гэмт хэрэг үйлдэх үедээ сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй байсан яллагдагчийн сэтгэцийн байдал нь өөртөө, эсхүл бусдад аюул учруулахааргүй бол прокурор эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгоно.

3.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх саналтайгаар хэргийг шүүхэд шилжүүлэх прокурорын шийдвэрт гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон байдал ба эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх үндэслэлийг бичнэ.

19.2 дугаар зүйл.Сэтгэцийн шинжилгээ хийлгэх

/Энэ зүйлийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

1.Сэтгэцийн шинжилгээ хийх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг дараах тохиолдолд авна:

/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

1.1.Шүүх шинжилгээний тухай хуулийн 39.1.6, 39.1.7-д заасан;

1.2.прокурор, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь яллагдагчийн сэтгэцийн эрүүл мэндэд эргэлзэх үндэслэл байвал хэрэг хариуцах чадвартай эсэхийг тогтоолгох.

2.Энэ зүйлийн 1.2-т заасан тохиолдолд прокурор, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь хүсэлтээ шүүхэд гаргах бөгөөд шүүх үндэслэлтэй гэж үзвэл шинжилгээ хийлгэх шийдвэр гаргана.

/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

3.Сэтгэцийн шинжилгээг хийхдээ Шүүх шинжилгээний тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан Сэтгэцийн шинжилгээ хийх журмыг баримтална.

/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

4.Яллагдагчид сэтгэцийн шинжилгээг хийхдээ сэтгэц эмгэг судлалын эмнэлэгт тодорхой хугацаанд хэвтүүлж, эмчийн хяналтад байлгах бөгөөд тухайн эмнэлэгт байрлуулах шийдвэрийг шүүх гаргана.

/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

5.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар эмнэлэгт хэвтүүлж, эмчийн хяналтад байсан хугацааг цагдан хоригдсон хугацаанд оруулж тооцно.

/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

6.Сэжигтэн, яллагдагч сэтгэцийн өвчний улмаас мөрдөн байцаалтын явц, байдлыг ойлгох чадваргүй байгаа бол шүүх сэтгэцийн шинжилгээ хийлгэх тухай шийдвэр, шинжээчийн дүгнэлтийг гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, эсхүл өмгөөлөгчид нь танилцуулна.

/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

19.3 дугаар зүйл.Хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа

1.Гэмт хэрэг үйлдсэн шүүгдэгчийн өвчний шинж байдлыг харгалзан түүнийг шүүх хуралдаанд оролцуулж болно.

2.Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасан тохиолдолд улсын яллагч, өмгөөлөгчийг оролцуулан шүүх хуралдаанаар хэргийг хянан шийдвэрлэнэ.

3.Шүүх хуралдаанаар шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэнийг нотолж байгаа, эсхүл үгүйсгэж байгаа нотлох баримтыг шалгаж, түүний сэтгэцийн өвчний талаар гаргасан шинжээчийн дүгнэлтийг сонсож, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эсэх асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтой бусад байдлыг хянан үзнэ.

4.Шүүх дараахь шийдвэр гаргана:

4.1.шүүгдэгчийг хэрэг хариуцах чадвартай гэж үзвэл ял оногдуулах, эсхүл хэргийг прокурорт буцаах;

4.2.гэмт хэрэг үйлдсэний дараа сэтгэцийн эрүүл мэндийн улмаас хэрэг хариуцах чадваргүй нь тогтоогдсон шүүгдэгчийн сэтгэцийн байдал нь өөртөө, эсхүл бусдад аюул учруулахаар байвал эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, эсхүл сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад эмчлүүлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлэх;

4.3.гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан шүүгдэгчийн сэтгэцийн байдал нь өөртөө, эсхүл бусдад аюул учруулахааргүй бол эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгох;

4.4.шүүгдэгч сэтгэцийн эрүүл мэндийн улмаас хэрэг хариуцах чадваргүй ч эдгэрэх боломжтой гэж үзвэл шүүх хуралдааныг хойшлуулж, энэ зүйлийн 4.2-т заасан шийдвэрийг гаргах.

/Энэ заалт ад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

5.Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй, эсхүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй байдал тогтоогдвол түүний өвчилсөн эсэхийг үл харгалзан эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгоно.

6.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, хугацааг шинжээчийн дүгнэлт, прокурорын саналыг үндэслэн шүүх тогтооно.

7.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад прокурор хяналт тавьж, уг арга хэмжээг зогсоох, хугацааг сунгах, тухайн шүүгдэгч эдгэрсэн нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдвол эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг шүүхээр шийдвэрлүүлнэ.

8.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн хугацааг ял эдэлсэн хугацаанд оруулж тооцно.

ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХОЛБОГДОХ ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

20.1 дүгээр зүйл.Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах

- 1.Хуулийн этгээдийн үйлдсэн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд энэ хуульд заасан ердийн журмаас гадна энэ бүлэгт заасан тусгай журмыг баримтална.
- 2.Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн хуулийн этгээдийг төлөөлөх албан тушаалтны, эсхүл хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдэл хийсэн хүний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамт явагдана.
- 3.Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тухайн гэмт хэрэгт хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж байгаагаас үл хамааран явуулж болно.

20.2 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлөх

- 1.Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд тухайн хуулийн этгээдийг дараахь хүнээр төлөөлүүлж болохгүй:
 - 1.1.хуулийн этгээдийн эсрэг шүүх хуралдаанд гэрчээр оролцож байгаа бол;
 - 1.2.хуулийн этгээдийг төлөөлөх хүн нь тухайн хэргийн яллагдагч бол.
- 2.Яллагдагчаас өөр тухайн хуулийн этгээдийг төлөөлөх хүн байхгүй тохиолдолд энэ зүйлийн 1.2 дахь заалт хамаарахгүй.
- 3.Хуулийн этгээдийг төлөөлөх хүн байхгүй бол тогтоосон хугацааны дотор өөр этгээдийг хууль ёсны төлөөлөгчөөр томилохыг шүүх, прокурор, мөрдөгч хуулийн этгээдэд бичгээр мэдэгдэнэ.
- 4.Тогтоосон хугацаанд хуулийн этгээд хууль ёсны төлөөлөгчөө томилоогүй бол шүүх, прокурор хууль ёсны төлөөлөгчийг томилж болно.
- 5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн хуулийн этгээдийн улсын бүртгэл, зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, тэдгээртэй адилтгах мэдээллийг өөрчлөхгүй байх, улсын бүртгэлээс хасахгүй байхыг шүүх, прокуророос холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

20.3 дугаар зүйл.Хуулийн этгээдийн эрх, үүрэг

- 1.Хуулийн этгээдийн хууль ёсны төлөөлөгч энэ хуульд заасан яллагдагчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

20.4 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн өмгөөлөгч

- 1.Хуулийн этгээд өмгөөлөгчтэй байж болно. Хуулийн этгээдийн өмгөөлөгч энэ хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

20.5 дугаар зүйл.Хуулийн этгээдэд баримт бичиг хүргэх

- 1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэр, бусад баримт бичгийг хуулийн этгээдийн хаягаар хүргүүлж, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгчид гардуулна.
- 2.Шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэр, бусад баримт бичгийг хүргүүлэх, гардуулахдаа энэ хуулийн 11.9 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

20.6 дугаар зүйл.Яллах дүгнэлт, шүүхийн шийдвэр

- 1.Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэргийн яллах дүгнэлт, шүүхийн шийдвэрт дараахь зүйлийг нэмж тусгана:
 - 1.1.хуулийн этгээдийн нэр;
 - 1.2.хуулийн этгээдийн албан ёсны хаяг.

ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ХУРААН АВСАН ХӨРӨНГӨ, ОРЛОГО, ЭД МӨРИЙН БАРИМТЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

21.1 дүгээр зүйл.Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хадгалах

- 1.Шүүх, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын хадгалалт, хамгаалалтыг хариуцна.
- 2.Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгох, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрт гомдол гаргах, давж заалдах хугацаа дуустал хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг тусгай байранд хадгалж, энэ тухай баримтыг хавтаст хэрэгт хавсаргана.
- 3.Хураан авсан үндэсний болон гадаад валютыг тусгай дансанд байршуулна.

4.Хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйлийг хадгалах талаар гаргасан оролцогчийн хүсэлтийг үндэслэн тэдгээрийг хаана хадгалахыг шүүх, прокурорын шийдвэрт тусгайлан зааж болно.

5.Гэмт хэргийн ул мөр агуулсан эд мөрийн баримтаар хураагдсан үндэсний болон гадаад валют нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт хамаарахгүй.

6.Тусгай хадгалалт, хамгаалалт шаардлагатай хөрөнгө, орлого, эд мөрийн баримт, шинжилгээний объектыг шүүх, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, шинжилгээний байгууллагын шинжээчийн саналаар тухайн байгууллагаас өөр байгууллагад хадгалуулж болно.

7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримт, шинжилгээний объектыг хадгалах, хамгаалах, хяналт тавих үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтан тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

21.2 дугаар зүйл.Эд хөрөнгө битүүмжлэх

1.Хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршгийг арилгуулах болон хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээг хангах зорилгоор яллагдагч, шүүгдэгчийн эд хөрөнгийг шүүх, прокурорын шийдвэрээр битүүмжилнэ.

2.Шүүх, прокурорын шийдвэрээр хураан авсан эд мөрийн баримт овор хэмжээ ихтэй, эсхүл бусад шалтгаанаар хадгалах боломжгүй бол мөрдөгч байгаа газарт нь битүүмжилнэ.

3.Эд хөрөнгийг битүүмжлэхдээ эд хөрөнгөө бусдад шилжүүлэх, устгах, өөрчлөх, захиран зарцуулах, хөдөлгөхийг хориглож, өөрт нь, эсхүл бусад боломжтой хүнд хадгалах, хамгаалах үүрэг хүлээлгэнэ.

4.Мөрдөгч энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хадгалах, хамгаалах үүрэг хүлээсэн хүнд эд хөрөнгийг хүлээлгэн өгч, хуульд заасан хариуцлагыг сануулж, гарын үсэг зуруулна.

5.Эд хөрөнгө битүүмжлэхдээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хүний өдөр тутмын зайлшгүй хэрэгцээний эд зүйлийг битүүмжилж болохгүй.

6.Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хураан авах, нэгжлэг хийх ажиллагаатай хамт явуулж болно.

21.3 дугаар зүйл.Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хадгалах хугацаа

1.Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг давж заалдах хугацаа дуустал эд мөрийн баримтыг хадгална.

2.Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын эзэмшлийн талаар гарсан маргааныг иргэний журмаар шийдвэрлэхээр бол тэдгээрийг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болтол хадгална.

21.4 дүгээр зүйл.Хураан авсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хүргүүлэх

1.Хэргийг өөр мөрдөгчид болон шүүхэд шилжүүлэхдээ хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хамт хүргүүлнэ.

2.Хэргийг шилжүүлэхэд овор хэмжээний хувьд болон бусад шалтгаанаар хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хамт хүргүүлэх боломжгүй бол түүнийг шүүхийн шийдвэр гартал журмын дагуу хадгалж, энэ тухай баримтыг хавтаст хэрэгт хавсаргана.

3.Шинжилгээний объектыг хүргэх, тээвэрлэх боломжгүй тохиолдолд шинжээчийг шинжилгээний объект байгаа газар чөлөөтэй нэвтрүүлэх, шинжилгээ хийх нөхцөлөөр хангах үүргийг шинжилгээ хийлгэх шийдвэр гаргасан эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээнэ.

[/Энэ хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

21.5 дугаар зүйл.Хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг шийдвэрлэх

1.Хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, нийтийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх бодит үндэслэл бий болсон, эсхүл түргэн муудах, гэмтэх, устах, эсхүл хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл чанар нь муудах хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг эзэмшигчид нь буцааж өгөх боломжгүй тухай прокурорын саналыг үндэслэлтэй гэж үзвэл шүүх дараахь шийдвэрийн аль нэгийг гаргаж болно:

- 1.1.хэрэгцээний дагуу зохих байгууллагад шилжүүлэх;
- 1.2.хадгалуулахаар зохих байгууллагад шилжүүлэх;
- 1.3.худалдан борлуулж орлогыг тусгай дансанд хадгалах;
- 1.4.устгуулахаар зохих байгууллагад шилжүүлэх.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тухайн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг шилжүүлсэн, хадгалсан, худалдан борлуулсан, устгасан тохиолдолд шүүхийн шийдвэрээр эзэмшигчид нь адил төрөл, чанарын эд зүйлийг олгох, эсхүл үнийг төлнө.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагаанд прокурор, мэргэжилтнийг оролцуулж, тэмдэглэл үйлдэн устгасан, шилжүүлсэн, худалдан борлуулсан хөрөнгө, орлого, эд мөрийн баримтын жагсаалтыг хэрэгт хавсаргана.

4.Шинжилгээнд ирүүлсэн шинж чанараа алдаж шинжилгээнд дахин ашиглах боломжгүй болсон, эсхүл дээжийг нь адилтгал,

мэдээллийн санд авч архивласан биологийн гаралтай эд мөрийн баримт болох цус, үрийн шингэн, шүлс, үс, яс, эд, эс зэрэг бусад зүйлийг шинжилгээ хийж дууссаны дараа Шүүх шинжилгээний тухай хуулийн 13.5-д заасан журмын дагуу устгана.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

5.Шинжээч шинжилгээний объектыг энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу устгасан, устгуулахаар шилжүүлсэн талаар прокурорт мэдээлэл хүргүүлнэ.

6.Хавтаст хэргийн материал, хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх, хууль ёсны эзэмшигчид нь буцаан олгох, улсын орлого болгох болон энэ зүйлийн 1.1, 1.2, 1.3, 1.4-т заасан ажиллагааны журмыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор хамтран батална. Прокурор хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон бол хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, эд мөрийн баримт, гэмт үйлдлийн замаар олсон орлого, түүнтэй адилтган үзэх бусад эд зүйлийг хууль ёсны эзэмшигчид нь олгох, эсхүл улсын орлого болгуулахаар шүүхэд санал гаргаж шийдвэрлүүлнэ.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

V ХЭСЭГ

МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЖУРАМ

ХОРИН ХОЁРДУГААР БҮЛЭГ

МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

22.1 дүгээр зүйл.Мөрдөн шалгах ажиллагаа

1.Мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад энэ хуульд заасны дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулж, нотлох баримт цуглуулж, бэхжүүлнэ.

2.Мөрдөн шалгах ажиллагаа нь прокурорын зөвшөөрлөөр явуулах мөрдөн шалгах ажиллагаа, мөрдөгчийн бие даан явуулах мөрдөн шалгах ажиллагаанаас бүрдэнэ.

3.Мөрдөгч үзлэгийг нууцаар хийх, нэгжлэг хийх, эд зүйл, баримт бичиг хураан авах, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах, хяналт тогтоох, харилцаа холбооны сүлжээнд нэвтэрч, хяналт тогтоох, харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээний хэрэглэгч, эзэмшигч хэн болох, тэдгээрийн байршил, холбогдсон цаг хугацаа, техник хэрэгсэл, төхөөрөмж болон хандалт зэрэг мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгад хамаарахгүй бусад мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах, харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах, хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах, оршуулсан цогцсыг гарган шинжлэх, мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах, хяналттай хүргэлт, хяналтын худалдан авалт, мөрдөн шалгах нууц туршилт, нууц ажиглалт, таньж олуулах ажиллагааг нууцаар хийхийг прокурорын зөвшөөрлөөр явуулна.

4.Мөрдөгч энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад энэ хуульд заасан мөрдөн шалгах ажиллагааг бие даан явуулна.

5.Мөрдөгч энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан ажиллагааг явуулах саналыг прокурорт хүргүүлнэ.

6.Мөрдөгч энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу гаргасан саналыг хэрэгсэхгүй болгосон прокурорын шийдвэрийг хүлээн авснаас хойш 48 цагийн дотор тухайн прокурорын газрын дээд шатны прокурорт санал гаргаж болно.

7.Мөрдөгч мөрдөн шалгах ажиллагаа явуулж эхлэхээс өмнө оролцох хүнд энэ хуульд заасан эрх, үүргийг тайлбарлах, эрхээ эдлэх боломжоор хангах үүрэг хүлээнэ.

8.Энэ зүйлийн 7 дахь хэсэг мөрдөн шалгах ажиллагааг нууцаар хийх тохиолдолд хамаарахгүй.

9.Мөрдөгч, прокурор, шүүх энэ хуульд заасан өмгөөлөгч оролцвол зохих эрүүгийн хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаа хаана, хэзээ явагдах тухай боломжит хугацаанд өмгөөлөгчид урьдчилж мэдэгдэнэ.

10.Мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой журмыг Улсын ерөнхий прокурор батална.

22.2 дугаар зүйл.Прокурорын зөвшөөрөл олгох ерөнхий үндэслэл

1.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах энэ хуульд заасан үндэслэл байвал эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үед мөрдөгч энэ хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан мөрдөн шалгах ажиллагааг явуулах саналыг прокурорт, оролцогч нь энэ хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасан ажиллагаа явуулах хүсэлтийг мөрдөгчид бичгээр гаргана.

2.Мөрдөгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтийг 24 цагийн дотор прокурорт танилцуулна.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлт нь энэ хуульд заасан мөрдөн шалгах нууц ажиллагаанд хамаарахгүй.

22.3 дугаар зүйл.Прокурорын зөвшөөрөл

1.Энэ хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай мөрдөгчийн саналд дараахь зүйлийг тусгана:

1.1.санал гаргасан мөрдөгчийн нэр;

- 1.2.ажиллагааны төрөл;
- 1.3.ажиллагаа явуулах зорилго, үндэслэл;
- 1.4.ажиллагаанд хамрагдах хүн, хуулийн этгээд, байгууллага, объект;
- 1.5.ажиллагаа явуулах газар, нэвтрэх, дамжин орох орон байрны хаяг, эзэмшил газрын байршил;
- 1.6.ажиллагаа явуулах хугацаа;
- 1.7.ажиллагааг шөнийн цагаар явуулах бол энэ тухай үндэслэл бүхий тайлбар.

2.Прокурор энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан саналыг хүлээн авсан даруй мөрдөн шалгах ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох эсэх тухай шийдвэр гаргана.

3.Энэ хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай прокурорын зөвшөөрөлд дараахь зүйлийг тусгана:

- 3.1.ажиллагааны нэр;
- 3.2.ажиллагааны зорилго;
- 3.3.ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан;
- 3.4.ажиллагаа явуулах газар, нэвтрэх, дамжин орох орон байрны хаяг, эзэмшил газрын байршил;
- 3.5.ажиллагаанд хамрагдах хүн, хуулийн этгээд, байгууллага, объект;
- 3.6.ажиллагаа явуулах хугацаа;
- 3.7.ажиллагааны явцад хүний эрхийг хангах арга хэмжээ;
- 3.8.зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа;
- 3.9.зөвшөөрөл олгосон прокурорын нэр, он, сар, өдөр.

4.Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах тухай прокурорын зөвшөөрөлд төрийн нууцыг хамгаалах зорилгоор энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан мэдээллийг хязгаарлаж болно.

5.Мөрдөгч нь прокурорын зөвшөөрлөөр явуулах мөрдөн шалгах ажиллагааг явуулах газар, байршил, үргэлжлэх хугацаа өөрчлөгдвөл хойшлуулшгүй тохиолдлоос бусад үед зөвшөөрөл олгосон прокурорт урьдчилан мэдэгдэнэ.

6.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан прокурорын зөвшөөрөлд тухайн мөрдөн шалгах ажиллагааг шөнийн цагаар явуулж болох эсэх, олон нийтийн хөдөлгөөнийг хязгаарлах эсэх, зөвшөөрлийн хувийг гардуулж өгөх тухай тусгаж болно.

22.4 дүгээр зүйл.Прокурорын зөвшөөрөлгүй мөрдөн шалгах ажиллагаа явуулах

1.Мөрдөгч хойшлуулшгүй тохиолдолд энэ хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан мөрдөн шалгах ажиллагааг прокурорын зөвшөөрөлгүй явуулж болно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагааг явуулахаас өмнө мөрдөгч нь прокурорт даруй мэдэгдэж, ажиллагаа дууссанаас хойш 24 цагийн дотор тухайн ажиллагааг хүчинтэйд тооцуулахаар зөвшөөрөлгүй явуулах болсон үндэслэлийг нотлох баримт, тайлбарыг бичгээр прокурорт хүргүүлнэ.

3.Прокурор энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан баримт, тайлбарыг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор мөрдөн шалгах ажиллагааг хүчинтэйд тооцох эсэхийг шийдвэрлэнэ.

4.Прокурор мөрдөн шалгах ажиллагааг даруй хийхгүй бол нотлох баримт гэмтэх, устгах, зөөвөрлөх, нуун далдлах бодит эрсдэл байсан эсэхийг хянан шийдвэрлэхийн тулд тухайн мөрдөн шалгах ажиллагаанд оролцсон хүнийг дуудаж мэдүүлэг авч, шаардлагатай нэмэлт материалыг мөрдөгчөөс гаргуулан авч болно.

5.Прокурор мөрдөгчөөс ирүүлсэн нотлох баримт, тайлбартай танилцсаны дараа дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

- 5.1.мөрдөн шалгах ажиллагааг хүчинтэйд тооцох;
- 5.2.мөрдөн шалгах ажиллагаа, нотлох баримтыг хүчингүй болгох.

6.Энэ зүйлийн 5.2-т заасан прокурорын шийдвэрт хураан авсан эд зүйл, баримт бичгийг эзэмшигчид нь эргүүлэн олгохыг даалгана.

ХОРИН ГУРАВДУГААР БҮЛЭГ ҮЗЛЭГ, МӨРДӨН ШАЛГАХ ТУРШИЛТ

23.1 дүгээр зүйл.Үзлэг хийх

1.Мөрдөгч гэмт хэрэг гарсан байдал, хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг тогтоох, тодруулах зорилгоор хүний бие, эд зүйл, баримт бичиг, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, мал, амьтан, хэрэг гарсан газарт үзлэг хийнэ.

2.Үзлэг хийхэд байгаа зүйлийг тухайн хүний сайн дурын үндсэн дээр гаргуулан авах, эсхүл гадна талаас нь харах, гараар тэмтрэх, тусгай багаж ашиглах аргаар хийж болно.

3. Үзлэг хийхэд удаан хугацаа шаардагдахаар бол, эсхүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангахын тулд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байгаа байгууллага дээр хийж болно.
4. Үзлэг хийхээр, эсхүл үзлэг хийх явцад саад болохоор байвал эд зүйл, тээврийн хэрэгслийг шилжүүлэн байрлуулж болно.
5. Эд зүйл, баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд эзэмшигчийг байлцуулна. Эзэмшигчийг байлцуулах боломжгүй бол хөндлөнгийн хоёр гэрчийг байлцуулж, эсхүл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ.
6. Үзлэгийг эзэмшигчийн эзгүйд хийсэн бол 3 хоногийн дотор эзэмшигчид, боломжгүй бол эзэмшигчийн оршин суугаа газрын баг, хорооны Засаг даргад мэдэгдэнэ.
7. Үзлэгийн үед хэв загвар, дээж авах, битүүмжлэх, хураан авах ажиллагааг даруй хийх шаардлага гарвал энэ хуулийн 22.4 дүгээр зүйлд заасан журмыг баримтлан явуулна.
8. Тээврийн хэрэгсэл, бусад техник хэрэгсэлд үзлэг хийхэд шаардлагатай бол эд ангийг салгаж болно.
9. Үзлэгийг прокурорын зөвшөөрлөөр нууцаар хийж болно.
10. Үзлэгийг нууцаар хийхэд энэ зүйлийн 5, 6 дахь хэсэг хамаарахгүй.

23.2 дугаар зүйл. Хүний биед үзлэг хийх

1. Хүний биед хэргийн ул мөр, онцлог шинж тэмдэг байгаа, эсхүл хэрэгт ач холбогдол бүхий эд зүйл, баримт бичгийг тухайн хүн биедээ авч яваа гэх үндэслэл бүхий сэжиг байгаа бол түүнийг илрүүлэх зорилгоор хүний биед үзлэг хийнэ.
2. Хүний биед үзлэг хийхэд өмссөн хувцас, биедээ авч яваа эд зүйл, шаардлагатай бол тээврийн хэрэгсэл, уналгыг хамтад нь үзнэ.
3. Нүцгэлж, эсхүл гараар тэмтрэх байдлаар хийх үзлэгийг ижил хүйсийн албан тушаалтан хийнэ. Шаардлагатай бол хүний эмч, сувилагчийг оролцуулж болно.
4. Нүцгэлж хийх үзлэгийг хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, нэр төр, алдар хүнд, хүний эмзэг мэдээллийг хамгаалах шаардлага хангасан, бусдаас тусгаарлагдсан орчинд явуулна.

[/Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

5. Нүцгэлж хийх үзлэгийн үед энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад хүн байлцуулахыг хориглоно.

23.3 дугаар зүйл. Хэргийн газрын үзлэг

1. Мөрдөгч гэмт хэрэг үйлдэгдсэн, үйлдэгдсэн байж болзошгүй гэх бодит үндэслэл байгаа бол хэргийн нотлох баримтыг олж тогтоох, хэрэгт ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор орон байр, бусад газар, нийтийн эзэмшил газрын тодорхой хэсгийг хэргийн газраар тогтоон үзлэг хийнэ.
2. Үзлэгийг хэргийн газраар тогтоосон орон байр, бусад газраас гадна хэргийн газрын хамгаалалтын бүсэд байгаа хүн, эд зүйл, баримт бичиг, тээврийн хэрэгсэл, мал, амьтан, цогцос зэргийг хамруулан хийнэ.
3. Мөрдөгч хэргийн газрын үзлэг хийхэд дараахь арга хэмжээг авна:
 - 3.1. хэргийн газрын хамгаалалтын бүсийг тогтоож хамгаалалтад авах, хамгаалалтыг цуцлах;
 - 3.2. өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангах;
 - 3.3. эзэмшигч, оршин суугч, шаардлагатай бол бусад хүнд хэргийн газрын хамгаалалтын бүсийн талаар мэдэгдэх, эсхүл бусдад ойлгогдохуйц тэмдэг тавих;
 - 3.4. хэргийн газарт байсан, орж ирсэн хүнийг үзлэг дуустал тухайн газраас явах, бусадтай болон бие биетэйгээ харилцахыг хориглох, ажиллагаанд саад учруулахгүй байхыг шаардах;
 - 3.5. хэргийн газрын хамгаалалтын бүсэд хүн, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхгүй байх, эсхүл гарахад хязгаарлалт тогтоох, бүсээс гарахыг шаардах, албадан гаргах;
 - 3.6. хэргийн газар, хамгаалалтын бүсэд байгаа хүний бичиг баримтыг шалгах, хүний бие, эд зүйл, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх;
 - 3.7. хэргийн ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж, цуглуулж бэхжүүлэх, аливаа зүйлийг бүхлээр нь, эсхүл хэсэгчлэн хураан авах, битүүмжлэх, хадгалах;
 - 3.8. хэргийн газарт байгаа хүний бие, эд зүйл, мал, амьтан, цогцосноос хэв загвар, дээж авах;
 - 3.9. хэргийн ул мөр бүхий түгжээтэй зүйлийг нээхийг шаардах, нээх;
 - 3.10. хэргийн газар, түүний дотор байгаа зүйлийн байр байдлыг бэхжүүлэхийн тулд дуу-дүрсний бичлэг хийх, гэрэл зураг авах;
 - 3.11. төрийн болон албаны нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээлэл алдагдах, эд хөрөнгө устгах, үрэгдэхээс хамгаалах.

[/Энэ заалтад 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

4. Шаардлагатай бол хэргийн газарт байгаа хохирогч, бусад хүнд эрүүл мэнд, сэтгэл зүйн анхан шатны тусламж үзүүлэх арга хэмжээ авч, энэ талаар тэмдэглэлд тусгана.

- 5.Мөрдөн шалгах ажиллагааны явцад шаардлагатай гэж мөрдөгч үзвэл мэргэжилтнийг мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулж болно.
- 6.Мөрдөгч энэ зүйлийн 3.6, 3.8-д заасан ажиллагааг үзлэгийн үед даруй хийх шаардлага гарвал энэ хуулийн 22.4 дүгээр зүйлд заасан журмыг баримтлан явуулна.

23.4 дүгээр зүйл.Цогцост үзлэг хийх

- 1.Мөрдөгч үзлэгийг цогцосны гадна хэсэгт, өмссөн хувцас, биед нь байгаа эд зүйл, баримт бичгийг хамруулан хийнэ.
- 2.Цогцост үзлэг хийхэд шинжээчийг, эсхүл хүний эмчийг оролцуулна.
- 3.Цогцсыг зөөх, хувцсыг нь тайлахын өмнө цогцосны ерөнхий байдлыг гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр баримтжуулна.
- 4.Цогцост хийсэн үзлэгийн тэмдэглэлд нас, хүйс, урт, жин, биеийн галбир, эрхтний бүрэн бүтэн байдал, хувцас, мэнгэ, шарх, сорви, бусад содон шинж тэмдэг, илэрсэн гэмтлийн төрөл, хэлбэр, байршил, хэмжээ, өөрчлөлт, нас барсан хугацаа болон анатомын, үйл хөдлөлийн болон нас баралтын шалтгаантай холбоотой шинжийг урьдчилсан байдлаар тусгана.
[/Энэ хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)
- 5.Мөрдөгч цогцсыг оршуулсан газраас нь гаргаж шинжилгээ хийх тохиолдолд прокурорын зөвшөөрөл авах ба уг ажиллагааг гүйцэтгэхэд шүүх эмнэлгийн шинжээчийг байлцуулна.
- 6.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагаанд хөндлөнгийн гэрчийг оролцуулж болно.
- 7.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагааг дуу-дүрсний бичлэг хийж бэхжүүлнэ.
- 8.Цогцсыг оршуулсан газраас нь гаргаж шинжлэх бол энэ зүйлд заасан үзлэгийг урьдчилан хийж, энэ тухай тэмдэглэлд тусгана.

23.5 дугаар зүйл.Мөрдөн шалгах туршилт хийх

- 1.Мөрдөгч хэрэгт ач холбогдолтой тодорхой нөхцөл байдал, үйл явдлыг сэргээн дүрслэх шаардлагатай тохиолдолд мөрдөн шалгах туршилт хийж болно.
- 2.Мөрдөн шалгах туршилт хийхэд хөндлөнгийн хоёр гэрчийг байлцуулах ба яллагдагч, хохирогч, гэрчийг оролцуулж болно. Шаардлагатай бол бусад байгууллага, мэргэжилтний туслалцааг авна.
- 3.Мөрдөн шалгах туршилтад оролцож байгаа хүнд хөтлөх, тулгах асуулт тавихыг хориглоно.
- 4.Мөрдөн шалгах туршилт явуулахад хүний нэр төр, алдар хүндийг гутаах, амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах, бусдыг гэмт хэрэгт хатгахыг хориглоно.
- 5.Прокурорын зөвшөөрлөөр явуулах мөрдөн шалгах нууц туршилтыг мөрдөгч хийж болно.
- 6.Мөрдөн шалгах нууц туршилт явуулахад энэ зүйлийн 2 дахь хэсэг хамаарахгүй.

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ НЭГЖЛЭГ ХИЙХ, ХУРААН АВАХ

24.1 дүгээр зүйл.Нэгжлэг хийх

- 1.Мөрдөгч хэргийн эд мөрийн баримт, бичмэл нотлох баримт, эсхүл эрэн сурвалжилж байгаа хүн, эд зүйл байна гэх хангалттай үндэслэл байвал тэдгээрийг илрүүлэхээр прокурорын зөвшөөрөлд заасан орон байр, бусад газар, хүний биед нэгжлэг хийнэ.
- 2.Нэгжлэг хийхийн өмнө хайж байгаа хүн, эд зүйл, баримт бичгийг сайн дураар заах, гаргаж өгөх боломжийг тухайн хүнд олгоно.
- 3.Нэгжлэг хийхэд энэ хуулийн 23.1 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5, 6, 7, 8 дахь хэсэгт заасан журмыг баримтална.
- 4.Нэгжлэгийг прокурорын зөвшөөрөлд зааснаас бусад зүйлийг илрүүлэх зорилгоор явуулахыг хориглоно. Нэгжлэгээр хайж байгаа зүйлийг илрүүлсэн бол нэгжлэгийг даруй зогсооно.
- 5.Хүн, хуулийн этгээд эзэмших, ашиглах, хадгалах, авч явахыг хуулиар хориглосон зүйлийг нэгжлэгийн явцад илрүүлсэн бол хураан авч, тэмдэглэлд тусгана.

24.2 дугаар зүйл.Хүний биед нэгжлэг хийх

- 1.Мөрдөгч хэрэг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий зүйлийг биедээ нууж байна гэх хангалттай үндэслэл байвал түүнийг илрүүлэх зорилгоор прокурорын зөвшөөрлөөр хүний биед нэгжлэг хийнэ.
- 2.Тусгай багаж, хэрэгсэл ашиглан хүний биед нэгжлэг хийж болно.
- 3.Хүний биед нэгжлэг хийхэд энэ хуулийн 23.2, 24.1 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.
- 4.Дараахь үндэслэл байвал прокурорын зөвшөөрөлгүйгээр хүний биед нэгжлэг хийж болно:
 - 4.1.баривчлах, цагдан хорих арга хэмжээ авахад;
 - 4.2.хураан авах болон нэгжлэг хийж байгаа орон байр, бусад газар байсан хүн хэрэгт холбогдол бүхий эд зүйл, баримт бичгийг биедээ нууж байна гэх хангалттай үндэслэл байвал.

24.3 дугаар зүйл.Орон байр, бусад газарт нэгжлэг хийх

- 1.Мөрдөгч орон байр, бусад газарт прокурорын зөвшөөрлөөр нэгжлэг хийхэд тухайн газарт нэвтрэх, эсхүл түгжээтэй зүйлийг нээх, шаардлагатай бол хана, тааз болон шалыг салгах, задлах зэрэг ажиллагаа явуулж болно.
- 2.Орон байр, бусад газарт нэгжлэг хийхэд энэ хуулийн 23.3 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

24.4 дүгээр зүйл.Эд мөрийн баримт хураан авах

- 1.Мөрдөгч эд мөрийн баримтыг прокурорын зөвшөөрлөөр түр хураан авна.
- 2.Төрийн нууц агуулсан эд мөрийн баримтыг зохих байгууллагын удирдлагад мэдэгдсэний үндсэн дээр хураан авна.
- 3.Мөрдөгч шуудан-цахилгаанаар явуулсан зүйлийг шуудан-цахилгаан харилцааны байгууллагад байх үед нь прокурорын зөвшөөрлөөр хураан авах, эсхүл үзлэг хийж болно.
- 4.Мөрдөгч эд мөрийн баримт хураан авах ажиллагааг эхлэхийн өмнө хураан авах тухай прокурорын шийдвэрийг танилцуулж, хураан авах эд мөрийн баримтыг сайн дураар гаргаж өгөх, зааж өгөх боломжийг тухайн хүнд олгоно.
- 5.Зарим онцлох эд зүйл, үнэт эдлэл, түүх, соёлын дурсгалт зүйлийг хураан авахад мэргэжилтнийг оролцуулж болно.
- 6.Баримт бичгийг эхээр нь, шаардлагатай бол хууль ёсны эзэмшигчид эхийг нь буцаан олгож, хуулбарыг хэрэгт хавсарган тэмдэглэлд тусгана.
- 7.Хураан авсан эд мөрийн баримтын жагсаалт, тэмдэглэлийг эд зүйл, баримт бичгээ хураалгасан болон тухайн ажиллагаанд байлцсан хүнээр гарын үсэг зуруулж, хувийг эд зүйлийн эзэмшигч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид даруй гардуулна.
- 8.Эд мөрийн баримтыг хураан авах ажиллагаанд энэ хуулийн 24.1, 24.2, 24.3 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 9.Хэрэгт ач холбогдолтой цахим баримтыг хуулбарлан авах, эсхүл түүнийг устгах, нэвтрэх боломжийг хязгаарлах боломжгүй бол цахим төхөөрөмжийг хураан авч болно.
- 10.Тэсэрч дэлбэрэх, хордуулах бодисыг хураан авах ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулах, эсхүл мэргэжлийн байгууллагад хандан гүйцэтгүүлж болно.

24.5 дугаар зүйл.Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах

- 1.Мөрдөгч төрийн нууц, хувь хүний эрүүл мэнд, захидал харилцааны нууцтай холбоотой эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авна.
[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)
- 2.Мөрдөгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад мэдээлэл, баримт бичгийг байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргуулан авч болно.
[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)
- 3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан байгууллага, албан тушаалтан, хүн нь прокурорын шийдвэрт заасан хугацаанд мэдээлэл, баримт бичгийг гарган өгч, нууцлалыг хадгална.

ХОРИН ТАВДУГААР БҮЛЭГ МЭДҮҮЛЭГ АВАХ, НҮҮРЭЛДҮҮЛЖ МЭДҮҮЛЭГ АВАХ, МЭДҮҮЛГИЙГ ШАЛГАХ, ТАНЬЖ ОЛУУЛАХ

25.1 дүгээр зүйл.Мэдүүлэг авах

- 1.Гэрч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авахад энэ бүлэгт заасан нийтлэг журмыг баримтална.
- 2.Мөрдөгч мэдүүлгийг мэдүүлэг авах шаардлага хангасан өрөөнд авна. Шаардлагатай бол мэдүүлгийг тухайн хүний байгаа газарт очиж авч болно.
- 3.Мөрдөгч мэдүүлэг өгөх хүнийг болон шинжээчийг энэ хуулийн 12.1, 12.2 дугаар зүйлд заасны дагуу дуудан ирүүлэх, эсхүл энэ хуулийн 12.3 дугаар зүйлд заасны дагуу албадан ирүүлж болно.
- 4.Мэдүүлэг авах хүмүүсийг тус тусад нь байлгаж мэдүүлэг авах ба мөрдөгч нэг хэрэгт мэдүүлэг авах хүмүүсийг өөр хоорондоо харилцахгүй байх арга хэмжээ авна.
- 5.Мөрдөгч мэдүүлгийн эхэнд тухайн хүний хувийн бичиг баримтыг шалгаж, түүнд ямар зорилгоор мэдүүлэг авахаар хэзээ, хэн гэдэг прокурорын шийдвэрээр дуудан ирүүлсэн, түүнчлэн энэ хуульд заасан эрх, үүргийг нь танилцуулсан тухай тэмдэглэлд тусгана.
- 6.Мөрдөгч мэдүүлэг өгөх гэж байгаа хүнд өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэйг нь тайлбарлах ба санаатай худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай сануулна.
- 7.Тухайн хүн мэдүүлэг өгөхдөө эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар мэдэх зүйлээ ярина. Ярьж дууссаны дараа ярьсан зүйлтэй нь холбогдуулан түүнд тодруулах асуулт тавьж болно.

8.Мэдүүлэг өгөх хүн баримт бичиг, бичлэг ашиглаж болно. Мэдүүлэг өгөхөд ашигласан зүйл, тухайн хүний үйлдсэн зураглал, хүснэгт, зургийг бүрэн эхээр нь, эсхүл хуулбарыг нь тэмдэглэлд хавсаргаж болох ба энэ тухай тэмдэглэлд тусгана.

9.Мэдүүлэг авсны дараа дахин мэдүүлэг авах үед өмнөх мэдүүлэгтэй нь холбогдуулан мөрдөгч эд мөрийн баримт, баримт бичиг, бусад нотлох баримтыг мэдүүлэг өгч байгаа хүнд үзүүлж, бусад мэдүүлгийн тэмдэглэлийг танилцуулж болох ба энэ талаар тэмдэглэлд тусгана.

10.Мэдүүлэг авахад орчуулагч, хэлмэрч оролцуулах бол түүнд эрх, үүргийг тайлбарлан, санаатайгаар худал орчуулах, эсхүл хэлмэрчилбэл хүлээлгэх хариуцлагыг урьдчилан сануулж, тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

11.Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүнээс мэдүүлэг авахад хэлмэрчийг оролцуулах боломжгүй бол түүний зөвшөөрснөөр бичгээр асуулт тавьж, мэдүүлэг авч болно.

12.Энэ хуульд заасан хойшлуулшгүй, эсхүл тухайн хүн хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд шөнийн цагаар мэдүүлэг авахыг хориглоно.

13.Мэдүүлэг авах үед хөтөлж, эсхүл тулгаж асуулт тавихыг хориглоно.

14.Мэдүүлэг авах ажиллагааг тэмдэглэл, дууны, эсхүл дүрсний, эсхүл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж болно.

15.Дууны, эсхүл дүрсний, эсхүл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлэх бол мэдүүлэг өгч байгаа хүнд урьдчилан мэдэгдэнэ.

16.Мэдүүлэг өгч байгаа хүн хүсвэл түүнд мэдүүлгээ өөрөө бичих бололцоо олгож, энэ тухай тэмдэглэлд тусгана.

17.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлагыг Улсын ерөнхий прокурор батална.

25.2 дугаар зүйл.Мэдүүлэг авах хугацаа

1.Мэдүүлгийг 4 цагийн хугацаагаар тасралтгүй авч болох ба түүнээс илүү хугацаагаар авах бол 1 цагийн завсарлага авна. Нэг удаагийн мэдүүлэг авах нийт хугацаа 8 цагаас илүүгүй байна.

2.Арван найман насанд хүрээгүй хүнээс авах мэдүүлгийг 2 цагийн хугацаагаар тасралтгүй явуулж болох ба түүнээс илүү хугацаагаар явуулах бол 30 минутын завсарлага авна. Нэг удаагийн мэдүүлэг авах нийт хугацаа 4 цагаас илүүгүй байна.

25.3 дугаар зүйл.Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах

1.Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахын өмнө түүнд хэргийн талаар мэдэх бүх зүйлээ үнэн зөв мэдүүлэхийн чухлыг тайлбарлана. Арван зургаан насанд хүрээгүй гэрч, хохирогчид санаатайгаар худал мэдүүлэг өгвөл хүлээлгэх хариуцлагын талаар урьдчилан сануулахгүй.

2.Арван найман насанд хүрээгүй гэрчээс мэдүүлэг авахад түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл төрөл, садангийн хүн, сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах бөгөөд тэдэнд эрх, үүргийг нь тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд тусгана.

3.Арван найман насанд хүрээгүй хүний эрх ашиг зөрчигдөх бодит үндэслэл байвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүнийг оролцуулахгүй байж болох ба өмгөөлөгчийг оролцуулна.

4.Мэдүүлэг авахад оролцож байгаа хүн арван найман насанд хүрээгүй гэрчид асуулт тавьж болно.

5.Мөрдөгчийн зөвшөөрснөөр хууль ёсны төлөөлөгч, сурган хүмүүжүүлэгч арван найман насанд хүрээгүй хүнээс асуултыг зөв ойлгосон эсэхийг тодруулан асууж, тайлбарлаж болно.

6.Мэдүүлэг авч дуусмагц мэдүүлэг зөв бичигдсэн эсэхийг мэдүүлэг авахад оролцсон хүнд танилцуулж, гарын үсэг зуруулна.

7.Арван найман насанд хүрээгүй хүнээс шөнийн цагаар мэдүүлэг авахыг хориглоно.

25.4 дүгээр зүйл.Нүүрэлдүүлж мэдүүлэг авах

1.Мөрдөгч яллагдагчаас бусад хүний мэдүүлэгт ноцтой зөрөө байвал хоёр хүний хооронд нүүрэлдүүлж мэдүүлэг авч болно.

2.Яллагдагчийн нүүрэлдэж мэдүүлэг өгөх хүсэлтийг гэрч, хохирогч, бусад яллагдагч зөвшөөрсөн бол нүүрэлдүүлж мэдүүлэг авч болно.

3.Нүүрэлдүүлэхийн өмнө гэрч, хохирогчид санаатай худал мэдүүлбэл хүлээлгэх хариуцлагыг урьдчилан сануулж, энэ тухай тэмдэглэлд тусгана.

4.Нүүрэлдүүлж мэдүүлэг авах ажиллагааг эхлэхдээ хүн тус бүрээс бие биеэ таних эсэх, хоорондоо ямар харилцаатай болохыг асууж, дараа нь тодруулах гэж байгаа зүйлийн талаар мэдүүлэг өгч байгаа хүн тус бүрд асуулт тавина.

5.Нүүрэлдэж байгаа хүн мөрдөгчийн зөвшөөрснөөр бие биедээ асуулт тавьж болно.

6.Нүүрэлдүүлэх үед өгсөн мэдүүлэг нь өмнөх мэдүүлгээс зөрөөтэй байвал нүүрэлдүүлэх үеийн мэдүүлгийг тэмдэглэлд бичсэний дараа урьд өгсөн мэдүүлгийг уншиж сонсгон тайлбарлуулж, тэмдэглэлд тусгана.

7.Тэмдэглэлд нүүрэлдүүлж байгаа хүний мэдүүлгийг мэдүүлэг өгсөн дэс дарааллаар бичих ба мэдүүлэг өгсөн хүн тэмдэглэлийн хуудасны нүүр тус бүрд гарын үсэг зурна.

25.5 дугаар зүйл.Мэдүүлэг авах тусгай журам

1.Шүүх хуралдаанд гэрч, хохирогч, дүгнэлт гаргасан шинжээч биечлэн оролцож мэдүүлэг өгөх боломжгүй тухай мөрдөгчийн санал, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл прокурор нь гэрч, хохирогч, шинжээчээс дуу-дүрсний бичлэг ашиглан мэдүүлэг авахыг мөрдөгчид даалгана.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагаа нь хохирогч, гэрч, шинжээчийн шүүх хуралдаанд мэдүүлэг өгөх эрхийг хязгаарлахгүй.

25.6 дугаар зүйл.Мэдүүлгийг газар дээр нь шалгах

1.Илэрсэн нөхцөл байдлыг шалгах, явсан замыг тогтоох, зааж өгсөн газрыг шалгах, урьд өгсөн мэдүүлгийн үнэн зөвийг харьцуулан тогтоох зорилгоор яллагдагчийн зөвшөөрснөөр, эсхүл мөрдөгч өөрийн санаачилгаар мэдүүлгийг газар дээр нь шалгаж болно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагааны үед мэдүүлгээ шалгуулж байгаа хүн хэрэгт ач холбогдол бүхий зарим тухайлсан зүйл, баримт бичиг, ул мөрийг заах, тодорхой үйлдлийг хийж үзүүлэх, шинжлэн судалж байгаа хэргийн нөхцөл байдалд ямар зүйл ямар үүрэгтэй байсан, үйл явдал болсон газрын байдал яаж өөрчлөгдсөн тухай зааж, урьд өгсөн мэдүүлгээ газар дээр нь тодорхой болгон дэлгэрэнгүй тайлбарлана.

3.Мэдүүлэг өгсөн хүн чөлөөтэй ярьж, үйлдлээ үзүүлсний дараа түүнд асуулт тавьж болно.

4.Нэг дор, нэг газарт, хэд хэдэн хүний мэдүүлгийг газар дээр нь нэгэн зэрэг шалгахыг хориглоно.

5.Мэдүүлгийг газар дээр нь шалгаж байхад хөндлөнгөөс оролцох, хөтлөх, сануулах асуулт тавихыг хориглоно.

25.7 дугаар зүйл.Таньж олуулах

1.Мөрдөгч хүн, мал, амьтан, цогцос, эд зүйл, тодорхой газар, орон байрыг гэрч, хохирогч, яллагдагчаар таньж олуулж болно.

2.Гэрч, хохирогч, яллагдагчаас хүн, мал, амьтан, цогцос, эд зүйл, тодорхой газар, орон байрыг ямар шинж тэмдэг, онцлогоор таньж чадахыг урьдчилан асууж, энэ тухай тэмдэглэлд тусгана.

3.Гэрч, хохирогч, яллагдагч нь түүнд харуулсан хүн, мал, амьтан, цогцос, эд зүйл, тодорхой газар, орон байрнаас аль нэгийг мөн гэж таньсан бол ямар шинж тэмдэг, онцлогоор нь таньсан тухай тайлбарлуулж, тэмдэглэлд тусгана.

4.Гэрч, хохирогч, яллагдагчид хөтлөх, тулгах асуулт тавихыг хориглоно.

5.Таньж олуулах ажиллагааны явцыг тэмдэглэл, дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ. Тэмдэглэлд гэрч, хохирогч, яллагдагчийн биеийн байцаалт, таньж олох хүн, мал, амьтан, эд зүйл, тодорхой газар, орон байрны тухай болон бусад бүх ажиллагааг дэс дарааллаар нь үгчлэн бичнэ.

6.Хүнийг хоёроос дээш хүний дундаас таньж олуулна.

7.Таньж олох хүнийг түүнтэй гаднах байдлаараа адил төстэй хоёроос дээш хүний хамтаар таньж олуулах гэж байгаа хүнд харуулна. Таньж олуулахын өмнө таньж олох хүнийг бусад хүний дунд дуртай байрлалаа эзлэхийг хэлж, тэмдэглэлд тусгана.

8.Тусгайлан хүмүүс бэлдэхгүйгээр олон хүн цугларсан газар таньж олох хүн байгаа эсэхийг гэрч, хохирогч, яллагдагчид харуулж таньж олуулж болно.

9.Энэ зүйлийн 7, 8 дахь хэсэгт заасан ажиллагааг явуулах боломжгүй дараахь тохиолдолд гэрэл зураг, эсхүл дууны, эсхүл дүрсний, эсхүл дуу-дүрсний бичлэг ашиглан таньж олуулж болно:

9.1.таньж олох хүн таньж олуулах ажиллагаанд саад учруулж болзошгүй;

9.2.таньж олох хүний дүр төрх эрс өөрчлөгдсөн;

9.3.таньж олох хүнийг биеэр ирүүлэх боломжгүй.

10.Мал, амьтан, эд зүйлийг дангаар нь таньж олуулж болно. Шаардлагатай тохиолдолд хоёроос дээш адил төрлийн, эсхүл төстэй мал, амьтан, эд зүйлээс таньж олуулж болно.

11.Цогцсыг биетээр, дүрс бичлэг, гэрэл зургаар таньж олуулж болно.

12.Гэрч, хохирогч, яллагдагч өөрөө хүсвэл таньж олох хүнд мэдэгдэхгүйгээр таньж олуулах боломж олгоно.

13.Таньж олуулах ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулж болно.

ХОРИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ МӨРДӨН ШАЛГАХ БУСАД АЖИЛЛАГАА

26.1 дүгээр зүйл.Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хянах, хязгаарлах

1.Мөрдөгч гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон байж болох, эсхүл хэрэгт ач холбогдолтой хөрөнгийг нуух, устгах, эрх шилжүүлэх үндэслэл бүхий сэжиг байвал прокурорын зөвшөөрлөөр дараахь ажиллагаа явуулна:

1.1.үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хянах;

/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

1.2.үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахыг зохих байгууллагад даалгах.

[/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.Энэ зүйлийн 1.1-д заасан ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулж болно.

26.2 дугаар зүйл.Харилцаа холбооны сүлжээнд хяналт тогтоох

1.Мөрдөгч хэрэгт ач холбогдол бүхий мэдээ, баримт байна гэх хангалттай үндэслэл байвал прокурорын зөвшөөрлөөр дараахь арга хэмжээг авч болно:

1.1.харилцаа холбооны сүлжээний хэрэглэгч, эзэмшигч хэн болох, тэдгээрийн байршил, холбогдсон цаг хугацаа, техник хэрэгсэл, төхөөрөмж болон хандалт зэрэг мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах;

1.2.харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгад хамаарахгүй бусад мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулан авах;

1.3.харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх боломжийг хязгаарлах талаар холбогдох байгууллагад даалгах.

2.Дараахь ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулж болно:

2.1.харилцаа холбооны сүлжээнд нэвтрэх, хяналт тогтоох;

2.2.харилцаа холбооны сүлжээгээр дамжсан мэдээллийн агуулгыг холбогдох байгууллагаас гаргуулж авах.

26.3 дугаар зүйл.Хяналт тогтоох

1.Мөрдөгч хэрэгт ач холбогдол бүхий мэдээ, баримтыг тогтоох зорилгоор дараахь ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулна:

1.1.орон байранд нэвтрэх, хяналт тогтоох;

1.2.орон байрнаас бусад газарт нэвтрэх, хяналт тогтоох;

1.3.тээврийн хэрэгсэлд нэвтрэх, хяналт тогтоох.

2.Хяналт тогтоох ажиллагааг сэжигтэн, яллагдагч, эсхүл шүүгдэгч оргон зайлсан тохиолдолд түүнийг олж илрүүлэх зорилгоор бусад хүн, объектод явуулна.

26.4 дүгээр зүйл.Ажиглалт явуулах

1.Мөрдөгч эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтоох зорилгоор тодорхой нутаг дэвсгэр, олон нийтийн газарт хүн, объектод ердийн болон нууц ажиглалт явуулна.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нууц ажиглалтыг прокурорын зөвшөөрлөөр явуулна.

26.5 дугаар зүйл.Хяналттай хүргэлт

1.Мөрдөгч гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үйлдэхэд оролцсон хүнийг олж тогтоох зорилгоор хууль бус, сэжигтэй барааг өөрийн улсын хилээр нэвтрүүлэх, эсхүл тодорхой нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхэд хяналт тавих ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулна.

2.Мөрдөгч хяналттай хүргэлтийг хэд хэдэн улсын хилээр нэвтрүүлэх, нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх бол Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтыг үндэслэн хамтран ажиллах хүрээнд прокурорын зөвшөөрлөөр явуулна.

26.6 дугаар зүйл.Хяналтын худалдан авалт

1.Мөрдөгч гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, эд зүйл, мөнгөн тэмдэгт, зэвсэг хэрэгсэл, бодис бэлдмэл, баримт бичгийг худалдан авах, эсхүл худалдан авахаар хэлцэл хийх ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулна.

2.Хяналтын худалдан авалтаар авсан бараа, бүтээгдэхүүн, бусад эд зүйл, баримт бичгийг хадгалж, хамгаалахад энэ хуулийн Хорин нэгдүгээр бүлэгт заасан журмыг баримтална.

26.7 дугаар зүйл.Мөрдөн шалгах нууц ажиллагааны журам

1.Энэ хуулийн 26.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 26.3 дугаар зүйлийн 1.1-д заасан мөрдөн шалгах нууц ажиллагааг хойшлуулшгүй тохиолдолд явуулахыг хориглоно.

2.Зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэг, Эрүүгийн хуулийн 10.1/Хүнийг алах/,12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг/Хүчиндэх/, Арван есдүгээр бүлэг/Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг/, 20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/, 20.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах/, 20.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах/, Хорин

хоёрдугаар бүлэг/Авлигын гэмт хэрэг/, Хорин есдүгээр бүлэг/Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг/-т заасан гэмт хэргийг илрүүлэхээс бусад үндэслэлээр цагдан хорих байранд мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулахыг хориглоно.

[/Энэ хэсэг т 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэг т 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэг т 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

3.Энэ хуулийн 23.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 23.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 25.7 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 26.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 26.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 26.3, 26.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 26.5, 26.6 дугаар зүйлд заасан мөрдөн шалгах нууц ажиллагааг мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага, түүнээс эрх олгосон мөрдөгч гүйцэтгэнэ.

4.Энэ хуулийн 26.5, 26.6 дугаар зүйлд заасан ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжин оролцох шаардлагатай төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийг прокурорын зөвшөөрөлд заана.

6.Энэ хуулийн 23.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 23.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 25.7 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 26.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 26.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 26.3, 26.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 26.5, 26.6 дугаар зүйлд заасан мөрдөн шалгах нууц ажиллагааг явуулах журам, зааврыг Тагнуулын ерөнхий газрын дарга Улсын ерөнхий прокурортой хамтран батална.

26.8 дугаар зүйл.Нууц ажиллагааны магадлагаа

1.Энэ хуулийн 16.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан мөрдөгчийн нууц ажиллагааны магадлагаанд дараахь зүйлийг тусгана:

- 1.1.мөрдөгчийн нэр, албан тушаал;
- 1.2.мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах прокурорын зөвшөөрлийн дугаар, огноо;
- 1.3.мөрдөн шалгах нууц ажиллагааны төрөл;
- 1.4.тухайн мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад илэрсэн баримтат мэдээлэл;
- 1.5.хавсаргасан баримтат мэдээллийн жагсаалт;
- 1.6.магадлагааг баталсан прокурорын нэр, албан тушаал.

26.9 дүгээр зүйл.Мөрдөн шалгах нууц ажиллагаанд тавих прокурорын хяналт

1.Мөрдөн шалгах нууц ажиллагаанд Улсын ерөнхий прокурор, түүний эрх олгосон прокурор хяналт тавина.

2.Прокурор энэ хуулийн 23.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 23.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 25.7 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 26.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 26.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 26.3, 26.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 26.5, 26.6 дугаар зүйлд заасан мөрдөн шалгах нууц ажиллагаанд дараахь хяналт тавина:

- 2.1.мөрдөгчийн ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх;
- 2.2.мөрдөн шалгах нууц ажиллагааны тоо бүртгэл, ашиглагдаж байгаа тусгай техник хэрэгслийн тоо бүртгэлийг зохих журмын дагуу хөтөлж байгаа эсэх;
- 2.3.мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд зөвшөөрөл олгох, зөвшөөрөл олгохоос татгалзах, тухайн ажиллагааны хугацааг сунгах, зогсоох;
- 2.4.мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн, холбогдох материалтай танилцах;
- 2.5.мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн талаархи гомдлыг хянаж, буруутай этгээдэд хариуцлага тооцуулах арга хэмжээ авах.

3.Энэ хуулийн 4.3 дугаар зүйлд заасан ажиллагаа нь энэ зүйлд заасан прокурорын хяналтад хамаарахгүй.

ХОРИН ДОЛДУГААР БҮЛЭГ ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭХ

27.1 дүгээр зүйл.Шинжилгээ хийлгэх журам

1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоохоор, эсхүл тусгай мэдлэг зайлшгүй шаардлагатай бол шүүх, прокурор, мөрдөгч шийдвэр гаргаж шинжилгээ хийлгэнэ.

2.Дараахь тохиолдолд заавал шинжилгээ хийлгэнэ:

- 2.1.гадны нөлөөгөөр, эсхүл сэжигтэй байдлаар хүн нас барсан бол түүний шалтгааныг тогтоох;
- 2.2.хүний эрүүл мэндэд учирсан хохирлын шинж байдлыг тогтоох;
- 2.3.гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэрэгт ач холбогдол бүхий байдлыг бодитой тусгаж, зөв мэдүүлэг өгөх чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл түүний сэтгэцийн байдлыг тодорхойлох;
- 2.4.бүх насаар хорих ял оногдуулж болох гэмт хэргийн яллагдагчийн сэтгэцийн байдлыг тодорхойлох;
- 2.5.сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогчийн насны тухай бичиг баримт байхгүй бөгөөд тэдний насыг тогтоох нь хэрэгт ач холбогдолтой байвал.

3.Шинжилгээ хийлгэх шийдвэрт Шүүх шинжилгээний тухай хуулийн 7.3-т заасан зүйлийг тусгана.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

4.Яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид шинжилгээ хийлгэх шийдвэрийг танилцуулна.

[/Энэ хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

5.Яллагдагч, шүүгдэгч нь сэтгэцийн өвчний улмаас хэргийн байдлыг ойлгох чадваргүй бол шинжилгээ хийлгэх шийдвэрийг түүнд танилцуулахгүй байж болно.

[/Энэ хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

6.Хууль тогтоомж хэрэглэх, түүний зүйл, хэсэг, заалтыг тайлбарлуулахаар шинжилгээ хийлгэхийг хориглоно.

[/Энэ хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

7.Шинжээч нь шүүх, прокурор, мөрдөгчийн шинжилгээ хийх жишиг хугацааг үндэслэн тогтоосон хугацаанд шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

8.Шинжээч нь шинжилгээний цар хүрээ, онцлогоос хамаарч тогтоосон хугацаанд дүгнэлт гаргах боломжгүй бол шинжилгээ хийх хугацааг сунгуулах хүсэлтийг Шүүх шинжилгээний тухай хуулийн 16.3, 16.4, 16.5, 16.6-д заасан журмын дагуу гаргаж, шийдвэрлүүлнэ.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

27.2 дугаар зүйл.Шинжилгээ хийлгэх үед оролцогчийн эрх

1.Шинжилгээ хийлгэх үед оролцогч дараахь эрхтэй:

- 1.1.шинжээчийг татгалзан гаргах хүсэлт гаргах;
- 1.2.шинжээчид нэмэлт асуулт тавих;
- 1.3.шинжээчид нэмэлт баримт бичиг өгөх, тайлбар гаргах;
- 1.4.мөрдөгч, прокурорын зөвшөөрлөөр шинжилгээ хийхэд байлцах;
- 1.5.шинжээчийн дүгнэлттэй танилцах.

2.Энэ зүйлийн 1.1, 1.2, 1.3-т заасан оролцогчийн хүсэлтийг хангах нь үндэслэлтэй гэж үзвэл шүүх, прокурор, мөрдөгч нь шинжээч томилсон шийдвэрийг өөрчилж, нэмэлт оруулж болно.

3.Оролцогчийн хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон бол тэр тухай үндэслэл бүхий шийдвэр гаргаж, шийдвэрийг оролцогчид танилцуулж, гарын үсэг зуруулна.

27.3 дугаар зүйл.Шинжилгээг шүүх шинжилгээний байгууллагаар хийлгэх

[/Энэ зүйлийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

1.Шинжилгээг шүүх шинжилгээний байгууллагаар хийлгэхэд Шүүх шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.Шүүх шинжилгээний байгууллага нь шүүх, прокурор, мөрдөгчийн тогтоолыг хүлээн авмагц шинжээч, эсхүл шинжээчдийн багт шинжилгээ хийлгэхээр хуваарилна.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

27.4 дүгээр зүйл.Шинжилгээг шүүх шинжилгээний байгууллагаас бусад этгээдээр хийлгэх

[/Энэ зүйлийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

1.Шүүх, прокурор, мөрдөгч Шүүх шинжилгээний тухай хуулийн 8.2-т заасан шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдийг урьж, шинжилгээ хийлгэж болно.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.Шинжилгээг шинжилгээний байгууллагаас бусад этгээдээр хийлгэхэд Шүүх шинжилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

27.5 дугаар зүйл.Шинжилгээг шинжээчдийн багаар хийлгэх

1.Шинжилгээ хийлгэхэд хэд хэдэн салбарын тусгай мэдлэг шаардлагатай гэж үзвэл шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэрээр шинжилгээг ижил, эсхүл өөр өөр мэргэжлийн шинжээчдээс бүрдсэн багаар хийлгэж болно.

27.6 дугаар зүйл.Шинжээчийн дүгнэлт

[/Энэ зүйлийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

1.Шинжээчийн дүгнэлтэд Шүүх шинжилгээний тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан зүйлийг тусгасан байна.

27.7 дугаар зүйл.Шинжээчийн дүгнэлт танилцуулах

- 1.Шинжээчийн дүгнэлт, эсхүл дүгнэлт гаргах боломжгүйг мэдэгдсэн түүний тайлбар, шинжээчээс авсан мэдүүлгийн тэмдэглэлийг холбогдох оролцогчид танилцуулна.
- 2.Оролцогч шинжээчийн дүгнэлт, тайлбарыг үл зөвшөөрөх, тайлбар өгөх, шинжээчид асуулт тавих, нэмэлт ба дахин шинжилгээ хийлгэх хүсэлт гаргаж болно.
- 3.Шинжээчийн дүгнэлт, тайлбар, мэдүүлгийг оролцогчид танилцуулсан, энэ үед оролцогчоос тавьсан хүсэлт, асуулт, хариултын талаар тэмдэглэлд тусгана.

27.8 дугаар зүйл.Нэмэлт ба дахин шинжилгээ хийлгэх

[/Энэ зүйлийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

- 1.Шинжээчийн дүгнэлт бүрэн бус, эсхүл шинжилгээ хийлгэж байгаа асуудалтай холбоотой шинэ нөхцөл байдал бий болсон, эсхүл үндэслэлгүй, эсхүл үндэслэлтэй эсэх нь эргэлзээтэй гэж үзвэл шүүх, прокурор, мөрдөгч шинжилгээ хийлгэх шийдвэр гаргаж, Шүүх шинжилгээний тухай хуулийн 27, 28 дугаар зүйлд заасан нэмэлт, эсхүл дахин шинжилгээ хийлгэнэ.

[/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

27.9 дүгээр зүйл.Хэв загвар, дээж авах

- 1.Шинжилгээ хийх зорилгоор хүний бие, цогцос, түүний эд эрхтэн, мал, амьтан, эд зүйл, баримт бичгээс хэв загвар, дээж авч болно.
- 2.Мал, амьтан, тэсэрч дэлбэрэх, хорт бодис, аюул учруулж болзошгүй эд зүйлээс хэв загвар, дээж авахад бусдын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг урьдчилан авна.
- 3.Хэв загвар, дээж авах ажиллагааг мөрдөн шалгах ажиллагааны үед явуулж болно.

27.10 дугаар зүйл.Хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах

- 1.Мөрдөгч хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр шинжээч, эсхүл мэргэжилтний тусламжтайгаар явуулна.
- 2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагаа явуулахыг тухайн хүн сайн дураар зөвшөөрсөн тохиолдолд прокурорын зөвшөөрөл шаардахгүй.
- 3.Хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах ажиллагаанд хүний эрхийг зөрчих, хуурч мэхлэх, айлган сүрдүүлэх, хуулиар хориглосон арга хэрэглэх, хүний биед туршилт хийхийг хориглоно.
- 4.Хүний биеэс шинжилгээнд зориулж авсан биологийн дээжийг мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах зориулалтаар шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн санд авна.

[/Энэ хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

27.11 дүгээр зүйл.Мөрдөгчийн магадлагаа

- 1.Мөрдөгч энэ хуулийн 27.1 дүгээр зүйлд заасан шинжилгээг шинжээч томилж хийлгэх шаардлагагүй, мөрдөн шалгах ажиллагаа явуулж тогтоох боломжтой, эсхүл өөрийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээнд тогтоох боломжтой гэж үзвэл магадлагаа гаргаж болно.
- 2.Мөрдөгч магадлагаа гаргах явцад шинжилгээний объектын шинж чанар өөрчлөгдөх, устах, гэмтэхээр бол шинжээч томилно.
- 3.Мөрдөгчийн магадлагаанд энэ хуулийн 27.6 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.4, 1.5, 1.6-д заасныг тусгана.
- 4.Мөрдөгчийн магадлагааг үндэслэлгүй гэж үзвэл прокурор өөрийн санаачилгаар, эсхүл оролцогчийн хүсэлтийг үндэслэн шинжээч томилж болно.
- 5.Мөрдөгч магадлагааг прокурорт болон энэ хуулийн 27.7 дугаар зүйлд заасны дагуу оролцогчид танилцуулна.
- 6.Мөрдөгч энэ хуулийн 6.2 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасны дагуу магадлагаа гаргах, магадлагааг танилцуулахад энэ бүлэгт заасан журмыг баримтална.

ХОРИН НАЙМДУГААР БҮЛЭГ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ТЭМДЭГЛЭЛ

28.1 дүгээр зүйл.Мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэл үйлдэх

- 1.Мөрдөгч мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэл үйлдэж, түүнд тухайн ажиллагааны явц, дэс дараалал, илэрсэн нөхцөл байдал, авсан арга хэмжээ, үр дүн болон дараахь зүйлийг бичиж тусгана:

1.1.ажиллагааг явуулсан, тэмдэглэл хөтөлсөн албан тушаалтны нэр, албан тушаал;

1.2.ажиллагааг явуулсан газар, эхэлсэн, дууссан он, сар, өдөр, цаг, минут, хэрэгжүүлэх явцад хугацаа тасалдсан бол түүний шалтгаан, үргэлжилсэн хугацаа;

- 1.3.шүүх, прокурорын зөвшөөрлөөр явуулж байгаа бол зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа;
- 1.4.хойшлуулшгүй тохиолдолд явуулж байгаа бол үндэслэл бүхий нөхцөл байдлын талаар;
- 1.5.оролцсон, байлцсан хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг;
- 1.6.ажиллагаанд оролцсон, байлцсан хүний хувийн бичиг баримтын мэдээлэл;
- 1.7.оролцсон хүнд эрх, үүргийг танилцуулсан тухай;
- 1.8.оролцсон, байлцсан хүнээс хүсэлт, гомдол гаргасан эсэх, түүнийг шийдвэрлэсэн талаар.

2.Мэдүүлэг өгсөн болон мөрдөн шалгах ажиллагаанд оролцсон хүний хэлсэн үгийг нэгдүгээр биен дээр тавьсан асуулт, хариултын дагуу үгчлэн бичнэ.

3.Мэдүүлэг өгсөн хүн мэдүүлгээ өөрөө бичиж болох ба энэ талаар тэмдэглэлд тусгана.

4.Мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд баримт бичиг, эд зүйлийн тоо ширхэг, төрөл, хэлбэр, өнгө, сорьц, харагдаж байгаа онцлох шинж тэмдэг, чанар, их, бага, хүнд, хөнгөний хэмжээ зэргийг нэг бүрчлэн, олон тооны эд зүйл, баримт бичгийг жагсаан бичиж, хавтаст хэрэгт хавсаргана.

5.Тэмдэглэлд мэдүүлэг өгч байгаа, мөрдөн шалгах ажиллагаанд оролцож байгаа хүний биеэ хэрхэн авч яваа болон гаргаж байгаа зан авирын талаар тусгаж болно.

6.Ажиллагааны явцад мэдээллийг тусгасан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх, гэрэл зураг авах, гар зураг үйлдэх, хэмжилт хийх, ул мөрнөөс хэв, хээ буулгаж авах зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчимд нийцэх бусад аргыг хэрэглэсэн бол тэдгээрийг тэмдэглэлд тусган хавсаргана.

7.Тэмдэглэлд мөрдөн шалгах ажиллагаанд ашиглаж байгаа техник хэрэгслийн нэр төрөл, үзүүлэлтийг тэмдэглэж, хэдэн минутын бичлэг хийсэн, хэдэн ширхэг гэрэл зураг авсныг тусгана.

8.Тэмдэглэлд ажиллагаа явуулсан, тэмдэглэл хөтөлсөн албан тушаалтан гарын үсэг зурна.

9.Мэдүүлэг өгч байгаа хүний ярьсан зүйлийг болон мэдүүлэг өгч байх явцад гаргаж өгсөн баримтыг тэмдэглэлд тусгаагүй, ярьсан зүйлийн агуулгыг өөрчилж бичсэн мэдүүлгийн тэмдэглэлтэй танилцаад засвар оруулах хүсэлтийг хүлээн аваагүй бол мэдүүлэг өгсөн хүн энэ тухай тэмдэглэлийн төгсгөлд өөрийн гараар, өөрөө бичих боломжгүй бол өөр хүний туслалцаатайгаар бичнэ.

10.Энэ хуулийн 23.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 23.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 25.7 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 26.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 26.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 26.3, 26.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 26.5, 26.6 дугаар зүйлд заасан мөрдөн шалгах нууц ажиллагааны тэмдэглэл үйлдэх журмыг энэ хуулийн 26.7 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан журмаар зохицуулна.

28.2 дугаар зүйл.Дуу-дүрсний бичлэг хийх

1.Мөрдөгч дараахь мөрдөн шалгах ажиллагааг гэрэл зураг, эсхүл дуу- дүрсний бичлэгээр бэхжүүлнэ:

- 1.1.эзэмшигч, оршин суугч нь эзгүй байгаа орон байр, бусад газарт нэвтрэн орж явуулах;
- 1.2.хэргийн газрын үзлэг хийх;
- 1.3.эд зүйлийг түр хураан авах;
- 1.4.эд хөрөнгийг битүүмжлэх;
- 1.5.хөндлөнгийн гэрчтэй хийгдэх мөрдөн шалгах ажиллагаанд хөндлөнгийн гэрч оролцох боломжгүй бол.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад мөрдөн шалгах ажиллагааны явц, үр дүнг дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж болно.

3.Мөрдөгч ажиллагааг эхлэхийн өмнө дуу-дүрсний бичлэг хийх талаар тухайн ажиллагаанд оролцох хүнд мэдэгдэж, бичлэгийг ямар зорилгоор ашиглах талаар танилцуулна.

4.Мөрдөн шалгах ажиллагааны явцад дуу-дүрсний бичлэгийг тасралтгүй хийх нөхцөлийг мөрдөгч хангасан байна. Зайлшгүй шаардлагаар дуу-дүрсний бичлэг тасалдсан тохиолдолд тухайн ажиллагаанд оролцсон хүнд мэдэгдэн мөрдөн шалгах ажиллагааг түр зогсоож, энэ талаар тэмдэглэлд тодорхой тусгана.

5.Дуу-дүрсний бичлэгт тухайн ажиллагааны зорилго, он, сар, өдөр, байршил, эхэлсэн, дууссан цаг, минутыг тусгана.

6.Мөрдөгч, прокурор нь дуу-дүрсний бичлэгийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хариуцна.

28.3 дугаар зүйл.Мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэл танилцуулах

1.Мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлийг тухайн ажиллагаа дуусмагц ажиллагаанд оролцсон, байлцсан хүнд даруй танилцуулж, гарын үсэг зуруулна. Тэмдэглэл хэд хэдэн хуудастай бол ажиллагаанд оролцсон, байлцсан хүн хуудасны нүүр тус бүрд гарын үсэг зурна.

2.Тэмдэглэлийг мөрдөн шалгах ажиллагаанд оролцсон, байлцсан хүнд уншуулж, эсхүл уншиж танилцуулна. Тэмдэглэлийг танилцуулахдаа тухайн мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэл нь хавтаст хэрэгт авагдах тул сайтар нягталж үзэхийг мөрдөгч анхааруулж хэлнэ.

3.Тухайн мөрдөн шалгах ажиллагаанд оролцсон хүн тэмдэглэлтэй танилцахдаа мөрдөн шалгах ажиллагааны явцыг дэс дарааллын

дагуу бичсэн эсэх, мөрдөн шалгах ажиллагааны нөхцөл байдал, авсан арга хэмжээ, ажиллагааны үр дүн зэргийг үнэн зөв, бүрэн тусгасан эсэхийг хянаж үзнэ.

4.Тэмдэглэлд дутуу, буруу, ойлгомжгүй бичсэн зүйлийн талаар засвар оруулах тухай оролцсон, байлцсан хүн санал, хүсэлт гаргасан бол санал, хүсэлтийг хэрхэн хангасан талаар тэмдэглэлд тусгана.

5.Тэмдэглэлийн маягтад мэдүүлэг өгсөн хүний санал, хүсэлтийн тэмдэглэх хэсгийг оруулна.

6.Мөрдөн шалгах ажиллагаанд оролцсон хүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тэмдэглэлд гарын үсэг зурах боломжгүй бол энэ тухай мөрдөгч тайлбар бичиж тэмдэглэлд хавсаргана.

VI ХЭСЭГ

ХЭРЭГ БҮРТГЭЛТ, МӨРДӨН БАЙЦААЛТ

ХОРИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ХЭРЭГ БҮРТГЭЛТ, МӨРДӨН БАЙЦААЛТЫН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

29.1 дүгээр зүйл.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хугацаа сунгах журам

1.Прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах хугацааг сунгахдаа урьд нь хийгдсэн ажиллагаа, хугацаа сунгах үндэслэл, цаашид хийх мөрдөн шалгах ажиллагааг харгалзана.

2.Мөрдөгч хугацааг сунгах тухай үндэслэл бүхий тогтоол үйлдэж, хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө прокурорт хүргүүлнэ.

3.Нэмэлт мөрдөн байцаалт явуулахаар прокуророос буцаасан, түдгэлзүүлсэн, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгосон, хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээсэн бол өмнөх хугацаанаас нь үргэлжлүүлэн тоолж, хугацааг ердийн журмаар сунгана.

29.2 дугаар зүйл.Эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах

1.Хэд хэдэн яллагдагч нэг, эсхүл хэд хэдэн гэмт хэргийг хамтран үйлдсэн, эсхүл нэг яллагдагч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол үйлдэл тус бүрд нь эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, мөрдөн байцаалт явуулна.

2.Хэд хэдэн яллагдагч нэг, эсхүл хэд хэдэн гэмт хэргийг хамтран үйлдсэн, эсхүл нэг яллагдагч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол хэргийг нэгтгэж мөрдөн байцаалт явуулж болно.

3.Хэргийг тал бүрээс нь бүрэн бодитой хянан шийдвэрлэхэд саад болохгүй бол зарим яллагдагчид холбогдох хэргийг тусгаарлаж болно.

4.Хүнд ял оногдуулж болох эрүүгийн хэрэгт хөнгөн ял оногдуулж болох эрүүгийн хэргийг нэгтгэнэ.

5.Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ялын төрөл, хэмжээ ижил эрүүгийн хэргийг нэгтгэх бол эхэлж эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэрэгт нэгтгэнэ.

6.Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан боловч яллагдагчийн холбогдсон зарим эрүүгийн хэрэг нь нотлогдоогүй бол эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолыг хүчингүй болгож, хэргийг тусгаарлан хэрэг бүртгэлтэд буцаана.

7.Прокурор энэ зүйлд заасны дагуу эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.

8.Прокурор нь яллагдагч гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай болохыг мөрдөн байцаалтын явцад хангалттай нотолсон, тухайн хэргийг шүүхээр хянан шийдвэрлүүлэх боломжтой гэж үзвэл яллагдагчид холбогдох зарим хэргийг тусгаарлан шүүхэд шилжүүлж болно.

9.Нэг үйлдэлд хэд хэдэн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн бол хэргийг нэгтгэж хэрэг бүртгэлт явуулна.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

29.3 дугаар зүйл.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нууцлал

1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, албан тушаалтан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын төлөвлөлт, явц, үр дүнгийн нууцлалыг хангаж ажиллана.

2.Мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад олж мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг задруулахгүй байж, холбогдох баримт бичгийг хамгаалах арга хэмжээ авна.

[/Энэ хэсэг т 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

3.Мөрдөгч төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой ажиллагаанд оролцсон, байлцсан хүнд нууцыг задруулахгүй байх үүргийг сануулж, бичгээр баталгаа гаргуулна.

[/Энэ хэсэг т 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

4.Мөрдөн шалгах ажиллагааны явцад төрийн нууцтай холбоотой асуудал гарвал мөрдөгч эрх бүхий байгууллагын удирдлагад мэдэгдэж, нууц хариуцсан албан тушаалтныг байлцуулна.

5.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын материалыг прокурорын зөвшөөрснөөр, прокурорын мэдэгдэх бололцоотой гэж үзсэн

хэмжээгээр нийтэд мэдэгдэж болно.

29.4 дүгээр зүйл.Хамтын ажиллагаа

1.Мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтантай дараахь хэлбэрээр хамтран ажиллаж болно:

- 1.1.мэдээлэл солилцох, гаргуулан авах;
- 1.2.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахад дэмжлэг авах;
- 1.3.эрх бүхий байгууллагын шийдвэрээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг хамтран явуулах.

29.5 дугаар зүйл.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хориглох зүйл

1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад дараахь зүйлийг хориглоно:

- 1.1.хүний нэр төр, алдар хүндийг гутаах, амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах, эрүүдэн шүүх;
- 1.2.мөрдөн шалгах ажиллагааг хойшлуулшгүй тохиолдол, эсхүл нууцаар явуулахаас бусад тохиолдолд шөнийн цагаар явуулах;
- 1.3.бусдыг зөрчил, гэмт хэрэгт хатгах.

29.6 дугаар зүйл.Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ

1.Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тогтоомогц мөрдөгч, прокурор нь зохих хуулийн этгээдэд тэрхүү шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авахуулахаар мэдэгдэл бичиж хуулбарыг хэрэгт нь хавсаргана.

2.Хуулийн этгээд нь мөрдөгч, прокурорын мэдэгдлийн дагуу шаардлагатай арга хэмжээ авч, 1 сарын дотор тэр тухай мөрдөгч, прокурорт хариу мэдэгдэх үүрэгтэй.

ГУЧДУГААР БҮЛЭГ ХЭРЭГ БҮРТГЭЛТ

30.1 дүгээр зүйл.Хэрэг бүртгэлт

1.Мөрдөгч гэмт хэргийг илрүүлэх, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох зорилгоор гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл хүлээн авснаас эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах хүртэл явуулж байгаа энэ хуульд заасан ажиллагааг хэрэг бүртгэлт гэнэ.

30.2 дугаар зүйл.Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл хүлээн авах

1.Мөрдөгч, прокурор дараахь тохиолдолд гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авч шалгана:

- 1.1.хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас гэмт хэргийн талаар гомдол гаргасан, эсхүл мэдээлсэн;
- 1.2.гэмт хэргийн шинжийг өөрөө шууд илрүүлсэн;
- 1.3.гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийгөө илчилж ирсэн.

2.Мөрдөгч, прокурор гэмт хэрэг үйлдсэн, үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай гомдол, мэдээллийг хүлээн авах үүрэгтэй.

3.Мэдээллийг хүлээн авахдаа санаатайгаар худал мэдээлбэл хуульд заасан хариуцлага хүлээлгэхийг мэдээлэл өгөгчид сануулна.

4.Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд тухайн гомдол гаргасан, мэдээлэл өгсөн хүн энэ хуулийн Арван тавдугаар бүлэгт заасан журмын дагуу гомдол гаргаж болно.

30.3 дугаар зүйл.Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэл гаргах

1.Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг иргэн амаар, эсхүл бичгээр гаргаж болно.

2.Биечлэн, эсхүл харилцаа холбооны хэрэгсэл ашиглан гаргасан гомдол, мэдээллийг тэмдэглэл үйлдэж хүлээн авах ба түүнд тэмдэглэл үйлдсэн хүн гарын үсэг зурна.

[Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

3.Бичгээр гаргасан гомдол, мэдээлэлд гомдол гаргагч, эсхүл мэдээлэл өгсөн хүн гарын үсэг зурсан байна.

[Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

4.Санаатайгаар худал мэдээлбэл хүлээлгэх хариуцлагын талаар гомдол гаргагчид тайлбарлан өгч, энэ тухай тэмдэглэлд тусган гомдол, мэдээлэл гаргагчаар гарын үсэг зуруулна.

[Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

30.4 дүгээр зүйл.Хуулийн этгээд, албан тушаалтан гэмт хэргийн талаар мэдээлэл өгөх

1.Хуулийн этгээд, албан тушаалтан гэмт хэргийн талаархи мэдээллийг бичгээр өгөх ба түүнд холбогдох баримт, материалыг хавсаргаж болно.

30.5 дугаар зүйл. Гэмт хэргийн талаархи мэдээллийг төлбөртэй авах

1.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага дараахь мэдээллийг төлбөртэй авахаар нийтэд зарлаж болно:

- 1.1.гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж байгаа, завдсан, эсхүл үйлдсэн тухай;
- 1.2.эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйл, тээврийн хэрэгсэл, баримт бичгийн тухай.

2.Мэдээллийг төлбөртэй авах тухай зарлаагүй боловч хүн, хуулийн этгээдээс хүсэлт гаргасан тохиолдолд мэдээллийг төлбөртэй авах эсэхийг мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын дарга шийдвэрлэнэ.

30.6 дугаар зүйл. Хэргээ илчлэн мэдээлэх

1.Гэмт хэрэг үйлдсэн хүн үйлдсэн хэргээ сайн дураараа илчилсэн мэдээллийг бичгээр, эсхүл амаар гаргаж болно.

30.7 дугаар зүйл. Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг шалгах

1.Мөрдөгч гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хянан үзээд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тогтоох шаардлагатай бол гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор дараахь мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно:

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

- 1.1.үзлэг хийх;
- 1.2.шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрний хэв авах;
- 1.3.хохирогч, гэрч, сэжигтнээс мэдүүлэг авах;

[/Энэ заалт ад 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалт ад 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

- 1.4.хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хурааж авах;
- 1.5.эд хөрөнгийг битүүмжлэх.
- 1.6.шинжилгээ хийлгэх шийдвэр гаргах.

[/Энэ заалт ад 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалт ыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

2.Дараахь эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан мөрдөн шалгах ажиллагааг хойшлуулшгүй тохиолдолд явуулж, прокурорт даруй шилжүүлнэ:

- 2.1.гомдол, мэдээллийг шалгах явцад гэмт хэрэг үйлдэж байгаа болон үйлдсэн тухай үндэслэлтэй сэжиг байгаа тохиолдолд мөрдөгч, тагнуул, цагдаа, авлигатай тэмцэх байгууллагын алба хаагч;
- 2.2.Монгол Улсын хилийн гадна байгаа тус улсын усан онгоц, агаарын хөлөг аялж яваа үед гарсан гэмт хэрэгт усан онгоцны ахмад, агаарын хөлгийн багийн дарга;
- 2.3.Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутагт гарсан гэмт хэрэгт тухайн Дипломат төлөөлөгчийн газрын консулын асуудал эрхэлсэн ажилтан;
- 2.4.хорих ангийн харьяа нутаг дэвсгэрт хоригдлын үйлдсэн гэмт хэрэгт хорих байгууллагын эрх бүхий албан тушаалтан;
- 2.5.зэвсэгт хүчний анги, байгууллагын нутаг дэвсгэрт цэргийн алба хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт тухайн зэвсэгт хүчний анги, байгууллагын захирагч;
- 2.6.хилийн зурваст гарсан гэмт хэрэгт улсын хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтан;
- 2.7.цэргийн алба хаагч энхийг дэмжих, олон улсын бусад ажиллагаанд оролцох явцад тэдний хооронд үйлдсэн гэмт хэрэгт тухайн цэргийн багийн эрх бүхий албан тушаалтан;
- 2.8.гаалийн хяналт, шалгалтын явцад илэрсэн гэмт хэрэгт гаалийн улсын байцаагч.

3.Шаардлагатай тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг нэг удаа 14 хүртэл хоногоор сунгаж болно.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

30.8 дугаар зүйл. Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хянан үзээд гаргах шийдвэр

1.Мөрдөгч гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авч хянаж үзсэн даруй, эсхүл энэ хуулийн 30.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулж дараахь шийдвэрийн аль нэгийг гаргасан даруй энэ тухай гомдол, мэдээлэл гаргагчид мэдэгдэнэ:

- 1.1.хэрэг бүртгэлтийн хэрэг нээх;
- 1.2.хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг прокурорт гаргах;
- 1.3.харьяаллын дагуу шилжүүлэх саналыг прокурорт гаргах.

2.Эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 30.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулж, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэр гаргуулахаар харьяаллын дагуу прокурорт саналаа даруй хүргүүлнэ.

3.Мөрдөгч энэ зүйлийн 1.2-т заасан саналыг прокурорт 72 цагийн дотор хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

30.9 дүгээр зүйл.Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх

- 1.Мөрдөгч хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн бол прокурорт даруй мэдэгдэн, прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, тогтоолыг 72 цагийн дотор прокурорт танилцуулна.
- 2.Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн нь энэ хуульд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл болно.
- 3.Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх тухай мөрдөгчийн тогтоолд хэргийн бүртгэлийн дугаар, ямар гэмт хэрэг хэзээ, хаана үйлдэгдсэн, уг хэрэгт хэрэг бүртгэлт явуулах үндэслэлийг тусгана. Тогтоолд хүн, хуулийн этгээдийн нэрийг холбогдуулан бичихийг хориглоно.
- 4.Мөрдөгч хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн нь үндэслэлгүй гэж үзвэл прокурор мөрдөгчийн тогтоолыг хүчингүй болгоно.

30.10 дугаар зүйл.Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах

1.Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээх үндэслэл байхгүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй нөхцөл байдал тогтоогдсон бол прокурор хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзана.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

2.Прокурорын хяналтын явцад, эсхүл энэ хуулийн 30.8 дугаар зүйлийн 1.2-т заасан саналыг үндэслэж прокурор хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах тухай тогтоол гаргана.

3.Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан тухай гомдол, мэдээлэл гаргагчид мэдэгдэх ба энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан прокурорын шийдвэрийг гомдол, мэдээлэл гаргагч эс зөвшөөрвөл шийдвэр хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор дээд шатны прокурорт гомдол гаргаж болно.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

4.Мөрдөгчийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг прокурор хянаж, 7 хоногийн дотор шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

5.Прокурор энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацаанд мөрдөгчийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг хянаад үндэслэлгүй гэж үзвэл дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

- 5.1.гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг дахин шалгуулахаар буцаах;
- 5.2.хэрэг бүртгэлтийн хэрэг нээх;
- 5.3.эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах.

30.11 дүгээр зүйл.Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх

1.Гэмт хэргийн талаархи гомдол, мэдээлэлд дурдсан асуудал нь тухайн мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын харьяаллын бус болох нь тогтоогдвол мөрдөгч харьяаллын дагуу шилжүүлэх саналыг прокурорт даруй хүргүүлнэ.

2.Гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх тохиолдолд мөрдөгч гэмт хэргийг таслан зогсоох, гэмт хэргийн ул мөрийг хамгаалах, бэхжүүлэх арга хэмжээ авна.

3.Прокурор өөрийн санаачилгаар, эсхүл мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл хэргийг 24 цагийн дотор харьяаллын дагуу шилжүүлэх шийдвэр гаргаж, эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

30.12 дугаар зүйл.Хэрэг бүртгэлтийн хугацаа

- 1.Хэрэг бүртгэлтийн үндсэн хугацаа нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээснээс хойш 1 сар байна.
- 2.Хэрэг бүртгэлтийн нийт хугацаа нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацаагаар хязгаарлагдана.
- 3.Хэрэг бүртгэлтийн хугацааг прокурор тухай бүр 3 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.
- 4.Энэ хуулийн 30.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг хэрэг бүртгэлтийн хугацаанд оруулж тооцно.

30.13 дугаар зүйл.Хэрэг бүртгэлтийг дуусгах

1.Мөрдөгч хэрэг бүртгэлтийг дуусгаж, дараах саналын аль нэгийг гаргаж хэргийн хамт ажлын 3 өдрийн дотор прокурорт хүргүүлнэ:

[/Энэ хэсэг т 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

1.1.хэрэг бүртгэлтийн хэргийг хаах;

1.2.эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах.

30.14 дүгээр зүйл.Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах

1.Хэрэг бүртгэлтийн явцад гэмт хэрэг үйлдэгдээгүй, эсхүл тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь зөрчлийн шинжтэй болох нь тогтоогдвол мөрдөгч хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналаа прокурорт хүргүүлнэ.

2.Прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл хэрэг бүртгэлтийн хэргийг хааж, зөрчлийн шинжтэй болох нь тогтоогдсон тохиолдолд зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэхийг мөрдөгчид даалгана.

3.Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах тухай мөрдөгчийн саналыг үндэслэлгүй гэж үзвэл прокурор нэмэлт хэрэг бүртгэлт явуулахаар хэргийг буцаах, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоол гаргана.

4.Энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл тогтоогдвол прокурор өөрийн санаачилгаар, эсхүл мөрдөгчийн саналаар хэрэг бүртгэлтийн хэргийг хаах шийдвэр гаргаж, энэ тухай хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.

5.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан шийдвэрийг хохирогч эс зөвшөөрвөл шийдвэр хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор дээд шатны прокурорт гомдол гаргаж болно.

6.Хэрэг бүртгэлтийн хэргийг үндэслэлгүйгээр хаасан гэж үзвэл дээд шатны прокурор уг тогтоолыг хүчингүй болгож, хэрэг бүртгэлт, эсхүл мөрдөн байцаалт явуулахаар харьяаллын дагуу шилжүүлж болно.

7.Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах шийдвэр гарсны дараа хохирогч, түүний өмгөөлөгч хүсэлт гаргавал хэрэг бүртгэлтийн хэрэгтэй танилцуулна.

8.Хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай прокурорт шилжүүлсэн хэргийн материалыг прокурор 14 хоногийн дотор хянах ба зайлшгүй тохиолдолд дээд шатны прокурор энэ хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болно.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

30.15 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах санал хүргүүлэх

1.Хэрэг бүртгэлтийн явцад энэ хуулийн 1.5 дугаар зүйлд заасан тохиолдол үүсээгүй, тухайн хүн, хуулийн этгээд гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх нөхцөл байдал тогтоогдсон, яллагдагчаар татах хүн, хуулийн этгээд хаана байгаа нь тодорхой бол мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналыг прокурорт хүргүүлнэ.

2.Прокурор энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор үндэслэл бүхий дараахь шийдвэр гаргана:

[/Энэ хэсэг т 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

2.1.нэмэлт хэрэг бүртгэлт явуулахаар хэргийг буцаах;

2.2.эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдэх;

2.3.хэрэг бүртгэлтийн хэргийг хаах.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэр гаргах хугацааг хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан дээд шатны прокурор 14 хүртэл хоногоор сунгаж болно.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

30.16 дугаар зүйл.Нэмэлт хэрэг бүртгэлт явуулахаар хэргийг буцаах

1.Прокурор яллагдагчаар татагдах хүн, хуулийн этгээд гэмт хэрэг үйлдсэн гэх нөхцөл байдал бүрэн тогтоогдоогүй гэж үзвэл нэмэлт хэрэг бүртгэлт явуулахаар хэргийг мөрдөгчид буцаана.

30.17 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдэх

1.Прокурор энэ хуулийн 30.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоол үйлдэж, прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.

2.Энэ хуулийн 30.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тохиолдолд яллагдагчаар татах хүн, хуулийн этгээд хаана байгаа нь тодорхой, хэрэг бүртгэлт явуулах шаардлагагүй гэж үзвэл прокурор өөрийн санаачилгаар, эсхүл мөрдөгчийн саналаар эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоол үйлдэж, прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.

3.Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолын тогтоох хэсэгт тогтоол үйлдсэн прокурорын нэр, албан тушаал, ямар гэмт хэрэг хэзээ, хаана үйлдэгдсэн, сэжигтний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэг, заалтад заасан гэмт хэрэгт буруутгаж байгаа тухай заана. Хуулийн этгээдийг яллагдагчаар татаж байгаа бол хуулийн этгээдийн нэрийг заана.

4.Прокурор тогтоолын тодорхойлох хэсэгт тухайн хүнийг гэмт хэрэг үйлдсэн болохыг нотлох баримтын жагсаалт, нотлох баримт тус

ГУЧИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ МӨРДӨН БАЙЦААЛТ

31.1 дүгээр зүйл.Мөрдөн байцаалт

1.Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэнээс хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл хэргийн талаар нотлогдвол зохих байдлыг тогтоох зорилгоор явуулж байгаа энэ хуульд заасан ажиллагааг мөрдөн байцаалт гэнэ.

31.2 дугаар зүйл.Сэжигтнийг дуудан ирүүлэх ажиллагаа

/Энэ зүйлийн гарчиг т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./

1.Энэ хуульд заасны дагуу баривчлагдсан, эсхүл гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл тогтоогдсон, эсхүл гэрчийн мэдүүлэг авах үед гэмт хэрэгт сэжиглэх үндэслэл илэрсэн, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар мэдэгдэх хуудсаар дуудагдсан хүнийг сэжигтэн гэнэ.

/Энэ хэсэг т 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэл т оруулсан./

/Энэ хэсэг т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмэл т оруулсан./

2.Прокурор эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэний дараа сэжигтнийг мэдэгдэх хуудсаар дуудан ирүүлж, уг тогтоолыг танилцуулахыг мөрдөгчид даалгана.

3.Тогтоол танилцуулахаар сэжигтнийг дуудан ирүүлэхдээ энэ хуулийн 12.1 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

4.Хүндэтгэн үзэх шалтгаанаар ирэх боломжгүй тухайгаа мэдэгдэх хуудас хүлээн авсан сэжигтэн мөрдөгчид даруй мэдэгдэж, энэ тухай баримтаа ирүүлсэн бол яллагдагчаар татах тогтоол танилцуулах хугацааг прокурор 24 цаг хүртэл хугацаагаар хойшлуулж болно.

5.Мэдэгдэх хуудсыг гардуулан өгөхдөө хүлээн авсан огноо, цаг, минутыг тэмдэглэн хүлээн авсан хүнээр гарын үсэг зуруулна.

6.Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудсан сэжигтэн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй, мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзсан нь түүнийг шүүхийн зөвшөөрлөөр баривчлах үндэслэл болно.

7.Шөнийн цагт тогтоол танилцуулахаар сэжигтнийг дуудан ирүүлэхийг хориглоно.

8.Энэ зүйлд заасан тогтоол танилцуулахаар сэжигтнийг дуудан ирүүлэх ажиллагаа нь энэ хуулийн 12.1 дүгээр зүйлд заасан оролцогчид хамаарахгүй.

31.3 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулах, гардуулан өгөх

/Энэ зүйлийн гарчиг т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./

1.Мөрдөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг прокуророос хүлээн авсан даруй дуудан ирүүлсэн сэжигтэнд танилцуулж, хувийг гардуулан өгнө. Төрийн нууцад хамаарах хэргийн яллагдагчаар татах тогтоолыг яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид гардуулахгүйгээр танилцуулна.

/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

2.Сэжигтэн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцахаас татгалзвал түүнд тогтоолыг уншиж энэ талаар тэмдэглэл хөтөлж, шаардлагатай бол дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ.

3.Сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулсны дараа энэ хуулийн Долдугаар бүлэгт заасан яллагдагчийн эрхийг тайлбарлан өгч, тэр тухай тэмдэглэлд тусгаж, гарын үсэг зуруулна.

4.Мөрдөгч сэжигтний хувийн байдлыг тогтоох, яллагдагчаар мэдүүлэг авах ажиллагааг 12 цагийн дотор явуулна.

/Энэ хэсэг т 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./

5.Сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол танилцуулсны дараа шаардлагатай гэж үзвэл таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

6.Сэжигтэн эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцах, гарын үсэг зурах, гардан авахаас татгалзсан нь мөрдөн шалгах ажиллагаа явуулахад саад болохгүй.

/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./

31.4 дүгээр зүйл.Сэжигтнийг баривчлах

1.Дараахь үндэслэл байгаа бол прокурор сэжигтнийг баривчлах тухай мөрдөгчийн саналыг хүлээн авснаас хойш уг саналыг шүүхэд даруй хүргүүлнэ:

1.1.энэ хуулийн 31.2 дугаар зүйлд заасны дагуу сэжигтнийг дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй, эсхүл мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзсан бол;

- 1.2.оргон зайлсан, эсхүл мэдэгдэх хуудсаар дуудахад оргон зайлах үндэслэл байгаа бол;
- 1.3.мөрдөгч, прокурор, шүүгч, хохирогч, гэрч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнийг дарамтлах, сүрдүүлэх, амь нас, эрүүл мэндэд нь халдах үндэслэл байгаа бол;
- 1.4.гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай үндэслэл байгаа, түүнчлэн дахин гэмт хэрэг үйлдэх, гэмт хэргээ төгсгөх үндэслэл байгаа бол;
- 1.5.нотлох баримтаа устгах, өөрчлөх, хуурамчаар үйлдэх, эсхүл гэрч, хохирогч, хамтран гэмт хэрэг үйлдсэн хүнд хууль бусаар нөлөөлөх үндэслэл илэрсэн бол.

2.Сэжигтнийг баривчлах тухай прокурорын саналд дараахь зүйлийг тусгана:

- 2.1.санал гаргасан прокурорын нэр, албан тушаал, гарын үсэг, он, сар, өдөр;
- 2.2.сэжигтний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг;
- 2.3.энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл, түүнийг нотлох баримт.

3.Шүүх нь прокурорын саналыг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор сэжигтнийг баривчлах эсэхийг шийдвэрлэнэ.

4.Сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгох тухай шүүхийн шийдвэрт дараахь зүйлийг тусгана:

- 4.1.сэжигтний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
- 4.2.энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баривчлах үндэслэл;
- 4.3.баривчлах ажиллагаа явуулах зөвшөөрлийг хэрэгжүүлэх байгууллага;
- 4.4.зөвшөөрөл олгосон он, сар, өдөр, цаг;
- 4.5.шийдвэр хүчинтэй байх хугацаа;
- 4.6.шүүгчийн гарын үсэг, тэмдэг.

5.Шүүхийн зөвшөөрлөөр баривчилж саатуулах хугацаа 48 цагаас хэтэрч болохгүй.

31.5 дугаар зүйл.Сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах

/Энэ зүйлийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

1.Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт холбогдуулан сэжигтнийг дараах үндэслэлээр хойшлуулшгүйгээр баривчилж болно:

/Энэ зүйлийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

- 1.1.гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь, эсхүл гэмт хэрэг үйлдсэн газраас зугтах үед барьсан;

/Энэ заал туг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

- 1.2.гэмт хэрэг үйлдсэн даруй гэрч, хохирогч шууд заасан;

/Энэ заал туг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

- 1.3.хэргийн газарт болон тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд ул мөр илэрсэн.

/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

2.Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт холбогдуулан сэжигтнийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас гадна дараах үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол хойшлуулшгүйгээр баривчилж болно:

/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

- 2.1.хэн болох нь тогтоогдоогүй;

/Энэ заал туг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

- 2.2.Монгол Улсад оршин суух газрын хаяг тодорхойгүй, эрхэлсэн ажилгүйн улмаас түүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй;

/Энэ заал туг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

- 2.3.Монгол Улсад байнга оршин суудаггүй.

/Энэ заал туг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

3.Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүнд гэмт хэрэг үйлдэгдсэн даруй энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад үндэслэл бүхий сэжиг тогтоогдвол сэжигтнийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан аль нэг үндэслэлээр хойшлуулшгүйгээр баривчилж болно.

/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

4.Мөрдөгч сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчилсан даруй прокурорт мэдэгдэж, прокурор баривчлах ажиллагаа хуульд нийцсэн эсэхийг хянаж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

- 4.1.мөрдөгчийн шийдвэрийг баталж, шүүхэд даруй хүргүүлэх;

/Энэ заал туг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

- 4.2.мөрдөгчийн шийдвэрийг үндэслэлгүй, эсхүл үргэлжлүүлэн баривчлах шаардлагагүй гэж үзвэл батлахаас татгалзаж,

тэмдэглэл үйлдэх.

[/Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

5.Үндэслэлгүйгээр баривчлагдсан сэжигтнийг прокурор даруй суллана.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

6.Мөрдөгч энэ хуулийн 30.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлтэй бол хойшлуулшгүйгээр баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналаа сэжигтнийг баривчилснаас хойш прокурорт даруй хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

7.Прокурор мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл саналыг хүлээн авснаас хойш 6 цагийн дотор баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах эсэхийг шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

8.Прокурор сэжигтнийг баривчилсан шийдвэрийг хүчинтэйд тооцуулах, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай саналаа баривчлах хугацаа дуусахаас 24 цагийн өмнө шүүхэд хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

9.Шүүх энэ зүйлийн 8 дахь хэсэгт заасан прокурорын саналыг хүлээн авснаас хойш даруй, эсхүл 24 цагийн дотор шүүхийн хэлэлцүүлгийг товлон явуулж, прокурорын саналыг үндэслэн баривчлах ажиллагааг хүчинтэйд тооцох, яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээ авах эсэхийг хянан шийдвэрлэнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

10.Прокурор, эсхүл баривчлах байрны даргын шийдвэрээр суллагдсан сэжигтэн, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч уг хэрэг гарсан газрын харьяалах шүүхэд баривчлах ажиллагааны талаар сэжигтнийг суллагдсанаас хойш 10 хоногийн дотор гомдол гаргаж болно. Прокурор гомдолд холбогдох материалыг харьяалах шүүхэд даруй хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

11.Шүүх энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасан гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор энэ хуульд заасан нийтлэг журмын дагуу шүүхийн хэлэлцүүлгийг товлон явуулж, баривчлах ажиллагааг хүчинтэйд тооцох эсэхийг хянан шийдвэрлэнэ. Энэ шийдвэрт гомдол гаргахгүй.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

12.Энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасны дагуу суллагдсан хүн гомдол гаргаагүй бол холбогдох шийдвэрийг 30 хоногийн дотор харьяалах шүүхэд хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

31.6 дугаар зүйл.Баривчилсны дараа хийгдэх ажиллагаа

1.Мөрдөгч сэжигтнийг баривчлах үед түүнийг ямар хэрэгт холбогдуулан баривчилж байгаа талаар мэдэгдэж, энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан эрхийг сануулна.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.Шүүхийн зөвшөөрлөөр баривчлах тохиолдолд мөрдөгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагаа явуулсны дараа сэжигтэнд баривчлах тухай шүүхийн зөвшөөрөл, үндэслэлийг танилцуулна.

3.Мөрдөгч сэжигтнийг баривчлах үед, эсхүл баривчилсны дараа сэжигтний биед үзлэг хийж, дараахь эд зүйлийг хураан авна:

3.1.хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах эд зүйл;

3.2.оргон зайлахад ашиглаж болох эд зүйл, баримт бичиг;

3.3.гэмт хэрэг үйлдэж олж авсан, эсхүл гэмт хэрэг үйлдэхэд ашигласан байж болзошгүй эд зүйл, баримт бичиг;

3.4.хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой эд зүйл, баримт бичиг;

3.5.хүн, хуулийн этгээд эзэмших, ашиглах, хадгалах, авч явахыг хуулиар хориглосон эд зүйл, баримт бичиг.

4.Мөрдөгч сэжигтнийг баривчилснаас хойш 6 цагийн дотор түүний хувийн байдлыг тогтоох, мэдүүлэг авах ажиллагааг явуулна.

5.Мөрдөгч сэжигтнийг баривчилснаас хойш 6 цагийн дотор тухайн сэжигтнийг баривчилсан талаар түүний гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгч, гадаад улсын иргэн бол тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ.

6.Мөрдөгч баривчлах ажиллагааны үед холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадлага хэрэглэж болно.

31.7 дугаар зүйл.Тэмдэглэл үйлдэх

1.Мөрдөгч сэжигтнийг баривчлахдаа тэмдэглэл үйлдэж бэхжүүлнэ. Тэмдэглэлийг баривчлах ажиллагааны үед үйлдэх боломжгүй байсан бол тухайн ажиллагааг дууссанаас хойш даруй нөхөн үйлдэнэ.

2.Тэмдэглэлд баривчлах ажиллагааны үйл явцаас гадна дараахь зүйлийг тусгана:

2.1.баривчилсан мөрдөгчийн овог, нэр, албан тушаал;

2.2.баривчлах ажиллагаа эхэлсэн огноо, газар;

2.3.баривчлагдаж байгаа сэжигтэнд эрхийг нь танилцуулсан цаг, минут;

2.4.баривчлах газарт хүргэсэн цаг, минут;

2.5.баривчлагдсан сэжигтний гаргасан санал хүсэлт, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн;

2.6.энэ хуулийн 31.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу сэжигтнийг баривчилсныг хаана, хэнд мэдэгдсэн тухай болон мэдэгдсэн цаг, минут.

3.Баривчлагдаж байгаа сэжигтэнд эрхийг нь танилцуулсан цаг, минутыг тэмдэглэж, гарын үсэг зуруулна. Гарын үсэг зурах боломжгүй, эсхүл гарын үсэг зураагүй бол энэ тухай тэмдэглэлд тусгана.

31.8 дугаар зүйл.Сэжигтний эрх

[/Энэ зүйлийн гарчигт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

1.Сэжигтэн дараахь эрхтэй:

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

1.1.баривчилсан үндэслэлтэй танилцах;

1.2.хойшлуулшгүйгээр баривчилснаас бусад тохиолдолд баривчлах тухай шүүхийн зөвшөөрөлтэй хуульд заасан хугацаанд танилцах, хуулбарыг авах;

[/Энэ заалтад 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

1.3.өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, өмгөөлөгч, гэр бүлийн гишүүнтэй холбогдох боломжоор хангагдах;

1.4.баривчлах шийдвэр, ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах;

1.5.өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх;

1.6.эмнэлгийн тусламж авах;

1.7.хууль бусаар баривчилсны улмаас учирсан хохирлоо арилгуулахаар гомдол гаргах;

1.8.хууль зөрчсөн эрх бүхий албан тушаалтан, мөрдөгч, прокурорын үйл ажиллагаанд гомдол гаргах.

2.Сэжигтэн түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцаж, хуулбарлаж авах, баривчилсан үндэслэлийн талаар мөрдөгчөөр тайлбарлуулах эрхтэй.

[/Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

31.9 дүгээр зүйл.Баривчлах хугацааг тоолох

1.Сэжигтэнд баривчлах тухай шүүхийн шийдвэрийг танилцуулсан, эсхүл хойшлуулшгүйгээр баривчилсан тохиолдолд энэ хуулийн 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг танилцуулсан үеэс баривчилсан хугацааг тоолох бөгөөд сэжигтнийг мөрдөн шалгах байгууллагад хүргэх, зайлшгүй эмнэлгийн туслалцаа үзүүлэх, эрүүлжүүлэх, өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзахад зарцуулсан хугацааг энэ хуулийн 31.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан хугацаанд оруулан тооцохгүй. Өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзах хугацаа 1 цагаас илүүгүй байна.

[/Энэ хэсгийг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.Мөрдөгч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг тэмдэглэлд тусгана.

31.10 дугаар зүйл.Хувийн байдлыг тогтоох

1.Мөрдөгч энэ хуулийн 31.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 31.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан хувийн байдлыг тогтоох зорилгоор дараахь ажиллагааг явуулна:

1.1.хувийн бичиг баримтыг шалгах, шаардлагатай тохиолдолд хувийн байдлын талаар нэмэлт мэдээлэл авах;

1.2.гэрэл зураг, эсхүл дүрсний, эсхүл дуу-дүрсний бичлэгээр нүүр царай, биеийн төрх байдлыг бэхжүүлэх;

1.3.хуруу, алганы хээ, эсхүл бусад хэв загварыг бэхжүүлэх;

1.4.шаардлагатай бол шинжилгээнд зориулж биеэс нь биологийн дээж авах;

1.5.биед үзлэг хийх;

1.6.харьцуулсан шинжилгээ хийх.

2.Хувийн байдлыг нь тогтооход саад учруулбал мөрдөгч холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадлага хэрэглэнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувийн байдлыг тогтоосон мэдээллийг хавтаст хэрэгт тусгана.

31.11 дүгээр зүйл.Сэжигтнээс мэдүүлэг авах

1.Мөрдөгч сэжигтнээс мэдүүлэг авахын өмнө түүнд ямар хэрэгт холбогдуулан мэдүүлэг авч байгаа талаар танилцуулж, дараахь эрхийг

тайлбарлана:

[/Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

- 1.1.өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх;
- 1.2.өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч сонгон авах;
- 1.3.өмгөөлөгчтэйганцаарчлан уулзах, өмгөөлөгч байлцуулан мэдүүлэг өгөх;
- 1.4.эх хэлээрээ, эсхүл өөрийн сайн мэдэх хэлээр мэдүүлэг өгөх;
- 1.5.орчуулагч, хэлмэрчийн туслалцааг авах;
- 1.6.мэдүүлэг өгөхөөс татгалзах;
- 1.7.мөрдөгч, прокурор, орчуулагч, хэлмэрчээс татгалзах;
- 1.8.энэ хуулийн Долдугаар бүлэгт заасан бусад эрх.

2.Сэжигтнээс мэдүүлэг авахад энэ хуулийн 25.1, 25.2, 25.3 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

3.Сэжигтний сонгон авсан өмгөөлөгч 2 цагийн дотор хүрэлцэн ирээгүй, эсхүл өмгөөлөгч авахаас татгалзсан бол энэ хуулийн 5.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу өмгөөлөгч оролцуулна.

4.Өсвөр насны сэжигтнээс мэдүүлэг авахад энэ хуулийн 25.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 25.3 дугаар зүйл, энэ зүйлд заасан журмыг баримтална.

[/Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

31.12 дугаар зүйл.Баривчлагдсан сэжигтнийг суллах

1.Хойшлуулшгүйгээр баривчлагдсан сэжигтнийг дараахь тохиолдолд шүүгч суллах шийдвэр гаргана:

[/Энэ хэсэгт 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

- 1.1.гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай баримт байхгүй;
- 1.2.энэ хуулийн 31.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчиж баривчилсан.

2.Баривчилснаас хойш 48 цаг дуусч, сэжиглэгдэж байгаа хүнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах прокурорын шийдвэр, цагдан хорих шүүхийн шийдвэр ирээгүй бол баривчлах байрны дарга мөрдөгч, прокурор, шүүгчид мэдэгдэж, түүнийг суллана.

3.Сэжигтнийг суллахдаа түүнийг ямар үндэслэлээр, хэзээ, хаана, хэний шийдвэрээр баривчилсан, хэзээ, хэний шийдвэрээр сулласан тухай магадлагаа олгоно.

4.Сэжигтнийг суллахдаа түүнээс хураан авсан эд зүйлээс хуулиар биедээ авч явахыг хориглосноос бусдыг нь буцаан олгоно.

5.Баривчлагдсан өсвөр насны сэжигтнийг суллахдаа түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчийн аль нэгэнд хүлээлгэн өгнө.

6.Мөрдөгч сэжигтнийг сулласан тухай тэмдэглэл, баривчлах ажиллагаатай холбоотой материалыг 24 цагийн дотор прокурорт хүргүүлнэ.

7.Мөрдөгч, прокурор, шүүх хууль бусаар баривчлагдсан болох нь тогтоогдсон сэжигтнийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу суллахдаа түүнд энэ хуульд заасны дагуу хууль бусаар баривчилснаас болж учирсан хохирлоо арилгуулахаар гомдол гаргах эрхтэй болохыг тайлбарлана.

8.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр суллагдсан сэжигтэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой ямар ч үүрэг хүлээхгүй.

31.13 дугаар зүйл.Мөрдөн байцаалтын хугацаа

1.Гэмт хэрэг үйлдсэнээс хойш Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тухайн хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хугацаа өнгөрсөн бол мөрдөн байцаалтын хугацааг сунгаж болохгүй. Энэ хуулийн 31.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн, эсхүл хэргийг прокурорт шилжүүлсэн бол мөрдөн байцаалтын хугацааг зогсооно. Түдгэлзүүлсэн хэргийг сэргээсэн, эсхүл хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр прокуророос мөрдөгчид хэргийг буцааснаас эхлэн мөрдөн байцаалтын хугацааг үргэлжлүүлэн тоолно.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.Энэ хуульд заасан журмын дагуу хэргийг түдгэлзүүлсэн хугацаа нь мөрдөн байцаалтын хугацаанд тооцогдохгүй.

3.Эрүүгийн хуульд заасан хөнгөн гэмт хэргийн мөрдөн байцаалтыг 14 хоног, хүнд гэмт хэргийн мөрдөн байцаалтыг 1 сарын дотор явуулж дуусган хавтаст хэргийн материалыг оролцогчид танилцуулна.

4.Тухайн хэргийн ээдрээ төвөгтэй байдал, эсхүл ажиллагаа ихтэй, олон яллагдагчтай, эсхүл олон үйлдэлтэй зэрэг нөхцөл байдлыг харгалзан шаардлагатай тохиолдолд мөрдөн байцаалт явуулах хугацааг дараахь байдлаар сунгаж болно:

- 4.1.сум буюу сум дундын прокурорын газрын хяналтад байгаа хэрэгт сум буюу сум дундын ерөнхий прокурор 5 сар хүртэл, аймгийн ерөнхий прокурор 7 сар хүртэл;

4.2.аймгийн прокурорын, дагнасан прокурорын газрын хяналтад байгаа хэрэгт аймгийн, дагнасан прокурорын газрын ерөнхий прокурор 16 сар хүртэл;

4.3.дүүргийн прокурорын газрын хяналтад байгаа хэрэгт дүүргийн ерөнхий прокурор 5 сар хүртэл, нийслэлийн ерөнхий прокурор 7 сар хүртэл;

4.4.нийслэлийн прокурорын газрын хяналтад байгаа хэрэгт нийслэлийн ерөнхий прокурор 16 сар хүртэл.

5.Мөрдөн байцаалтын хугацааг цаашид сунгах асуудлыг Улсын ерөнхий прокурор шийдвэрлэнэ.

6.Яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч мөрдөн байцаалтын хугацааг сунгасан хугацаанд мөрдөн шалгах ажиллагаа хийгээгүй тухай гомдлыг дээд шатны прокурорт гаргана.

31.14 дүгээр зүйл.Мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх, сэргээх

1.Прокурор нь мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл дараахь тохиолдолд мөрдөн байцаалтыг түдгэлзүүлнэ:

1.1.сэтгэцийн, эсхүл хүнд өвчнөөр өвчилсний улмаас хүрэлцэн ирж чадахгүй болох нь шинжээчийн дүгнэлт, эмнэлгийн байгууллагын тодорхойлолтоор нотлогдсон бол;

1.2.яллагдагч оргон зайлсан бол;

1.3.яллагдагчийн гадаад улсын болон олон улсын байгууллагын дипломат дархан эрхийг хязгаарлаагүй, эсхүл яллагдагчийн хуульд заасан халдашгүй байдлыг түдгэлзүүлээгүй бол.

1.4.гадаад улсад эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлт хүргүүлсэн бол.

[/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

2.Мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэхийн өмнө мөрдөгч нь яллагдагчийг байхгүйд гүйцэтгэж болох бүх ажиллагааг явуулах, гэмт хэрэг үйлдсэн болон оргон зайлсан этгээдийг олж илрүүлэх бүх арга хэмжээг авах үүрэгтэй.

3.Хоёр болон хэд хэдэн яллагдагчид холбогдох хэргийн мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх үндэслэл нь бүх яллагдагчид хамаарахгүй байвал зарим яллагдагчид хамаарах хэргийг тусгаарлан түдгэлзүүлж болно.

4.Мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх тухай тогтоолд дараахь зүйлийг тусгана:

4.1.прокурорын нэр, албан тушаал;

4.2.түдгэлзүүлсэн он, сар, өдөр;

4.3.хэргийн дугаар, хэргийн утга;

4.4.яллагдагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

4.5.мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх үндэслэл;

4.6.таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх эсэх.

5.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл арилсан, эсхүл нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлагатай бол мөрдөн байцаалтыг сэргээх тухай прокурор тогтоол гаргана.

6.Мөрдөн байцаалтыг сэргээх тухай тогтоолд дараахь зүйлийг тусгана:

6.1.мөрдөн байцаалтыг сэргээсэн прокурорын нэр, албан тушаал;

6.2.мөрдөн байцаалтыг сэргээсэн үндэслэл;

6.3.мөрдөн байцаалт явуулах хугацаа.

ГУЧИН ХОЁРДУГААР БҮЛЭГ МӨРДӨН БАЙЦААЛТЫГ ДУУСГАХ

32.1 дүгээр зүйл.Хавтаст хэргийн материал танилцуулах

1.Мөрдөгч мөрдөн шалгах бүх ажиллагааг хийж дууссан, хэргийн бодит байдлыг бүрэн нотолж тогтоосон гэж үзвэл яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид хавтаст хэргийн материалтай танилцахыг мэдэгдэнэ.

2.Мөрдөн шалгах ажиллагаа дууссаныг мэдэгдсэний дараа яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид хавтаст хэргийн материалыг эх хувиар нь танилцуулах ба энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогчид хялбаршуулсан журмаар шийдвэрлэх хавтаст хэргийн материал танилцуулах хугацаа 7 хүртэл хоногт, бусад хэргийн материалтай ажлын 3-аас доошгүй өдрийн хугацаанд танилцах боломж, нөхцөлөөр хангана. Хавтаст хэргийн материал танилцуулах үндсэн хугацаа 14 хүртэл хоног байх бөгөөд хэргийн ээдрээ төвөгтэй

байдлыг харгалзан тус хугацааг мөрдөгч 14 хүртэл хоногоор сунгаж болно.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

4.Хавтаст хэрэгт тусгагдсан эд мөрийн баримт, мөрдөн шалгах ажиллагааны тэмдэглэлд тусгагдсан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгтэй танилцах тухай оролцогчийн хүсэлтийг мөрдөгч хангах арга хэмжээ авна.

5.Оролцогч хүсэлт гаргавал хавтаст хэргийн материалаас шүүхээр хэлэлцүүлэх төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах боломжоор хангана. Талууд хуулбарлан авсан нотлох баримтыг шүүхэд шинжлэн судлахаас өөр зорилгоор ашигласан бол хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.Оролцогч хавтаст хэргийн материалтай танилцсан тухай тэмдэглэлд дараахь зүйлийг тусгана:

6.1.мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой хүсэлт, гомдол;

6.2.хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлт;

6.3.шүүх хуралдаанд дуудаж оролцуулах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын жагсаалт.

7.Хэргийн материалтай танилцах үед энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан оролцогчоос гаргасан хүсэлт, гомдлыг мөрдөгч хүлээн авч хангах, эсхүл хэрэгсэхгүй болгож энэ тухай шийдвэр гаргана.

8.Хавтаст хэргийн материалтай танилцаад тэмдэглэлд тусгасан оролцогчийн хүсэлт, гомдлыг мөрдөгч хэрэгсэхгүй болгосон бол оролцогч прокурорт гомдол гаргаж болно.

9.Нэмэлт мөрдөн байцаалт явуулсан бол нэмж хийсэн ажиллагааны материалыг энэ зүйлд заасан журмын дагуу оролцогчид танилцуулна.

[/Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

10.Энэ хуульд заасны дагуу оролцогчид танилцуулаагүй, хавтаст хэрэгт хавсаргаагүй нотлох баримтыг шүүх хуралдаанаар хэлэлцэхгүй.

[/Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

11.Энэ зүйлд заасныг зөрчиж, хавтаст хэргийн материалтай танилцах хугацаа, боломж, нөхцөлөөр хангаагүй мөрдөгчийн үйл ажиллагааны талаар прокурорт гомдол гаргаж болно.

12.Энэ хуулийн 16.8 дугаар зүйлд заасан баримт бичиг, төрийн нууцад хамаарагдах баримт бичигт энэ зүйлийн 4 дэх хэсэг хамаарахгүй.

32.2 дугаар зүйл.Хэргийг прокурорт шилжүүлэх

1.Энэ хуулийн 32.1 дүгээр зүйлд заасан ажиллагаа бүрэн хийгдэж дууссаны дараа мөрдөгч холбогдох саналыг хавтаст хэргийн хамт 3 хоногийн дотор прокурорт шилжүүлнэ.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

32.3 дугаар зүйл.Мөрдөн байцаалт явуулсан хэргийн талаар прокуророос хянавал зохих асуудлууд

1.Мөрдөгчөөс шилжүүлсэн хэргийн талаар прокурор доор дурдсан асуудлыг хянах үүрэгтэй:

1.1.оролцогчийг хавтаст хэргийн материалтай танилцах боломжоор хангасан эсэх, хавтаст хэргийн материалтай танилцаад оролцогчоос гаргасан хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн эсэх;

1.2.гэмт хэргийн шинжийг бүрэн нотолсон эсэх;

1.3.хэргийг хэрэгсэхгүй болгох, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тогтоолыг хүчингүй болгох үндэслэл байгаа эсэх;

1.4.энэ хуулийн 16.2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх;

1.5.Эрүүгийн хууль болон энэ хуулийн зүйл, хэсэг, заалтыг зөв хэрэглэсэн эсэх;

1.6.таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэхдээ хууль зөрчсөн эсэх;

1.7.гэмт хэрэг үйлдсэн бүх этгээдийг яллагдагчаар татсан эсэх;

1.8.гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр хөрөнгө хамгаалах арга хэмжээ авсан эсэх;

1.9.гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тодруулж чадсан эсэх, түүнийг арилгах талаар арга хэмжээ авсан эсэх;

1.10.яллагдагч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг бүрэн нотолсон эсэх.

32.4 дүгээр зүйл.Мөрдөн байцаалт явуулсан хэргийн талаар прокуророос гаргах шийдвэр

1.Мөрдөн байцаалт явуулж дууссан хэргийн материалыг прокурор 14 хоногийн дотор хянах ба зайлшгүй тохиолдолд зохих дээд шатны прокурор энэ хугацааг тухай бүр 14 хүртэл хоногоор нэмж сунгаж болно.

2.Прокурор хэргийг хянаж үзээд дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

- 2.1.мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх;
- 2.2.эрүүгийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх;
- 2.3.эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах;
- 2.4.эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэг бүртгэлтэд буцаах;
- 2.5.хэргийг хэрэгсэхгүй болгох;
- 2.6.нэмэлт ажиллагаа хийлгэхээр мөрдөн байцаалтад буцаах;
- 2.7.эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх.

32.5 дугаар зүйл.Хэргийг хэрэгсэхгүй болгох, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгох

1.Прокурор дараахь үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгоно:

- 1.1.гэмт хэргийн шинжгүй;
- 1.2.тухайн үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон;
- 1.3.тухайн гэмт хэргийг өмнө нь хянан шийдвэрлэсэн шүүх, прокурорын шийдвэр хүчин төгөлдөр байгаа;
- 1.4.сэжигтэн, яллагдагч нас барсан;
- 1.5.гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан;
- 1.6.гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон боловч ял оногдуулах насанд хүрээгүй.

2.Мөрдөн шалгах ажиллагааг явуулсан боловч яллагдагчийн гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдохгүй бол эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгож, хавтаст хэргийн материалыг хэрэг бүртгэлтэд буцаана.

3.Хэд хэдэн хүн яллагдагчаар татагдсан тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгох, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоол хүчингүй болгох үндэслэл нь нийт яллагдагчид хамаарахгүй байвал тухайн яллагдагч, эсхүл яллагдагчид холбогдох зарим үйлдлийг хэрэгсэхгүй болгох, эсхүл тогтоолын холбогдох хэсгийг хүчингүй болгоно.

4.Нэгтгэн шалгаж байгаа хэд хэдэн гэмт хэргийн аль нэг нь нотлогдохгүй байвал прокурор эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тухайн тогтоолыг хүчингүй болгож, хэргийг тусгаарлан хавтаст хэргийн материалыг хэрэг бүртгэлтэд буцаана.

5.Энэ зүйлийн 1.1 дэх заалт, 2, 3, 4 дэх хэсэгт заасан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгох тухай тогтоолд яллагдагч энэ хуульд заасны дагуу хохирлоо арилгуулахаар гомдол гаргах эрхтэй болохыг тусгана.

6.Энэ зүйлийн 1.6-д заасан гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон боловч ял оногдуулах насанд хүрээгүй үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосныг хохирогч, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрч гомдол гаргасан бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулна.

32.6 дугаар зүйл.Хэргийг хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолыг хүчингүй болгосон прокурорын тогтоолыг танилцуулах

1.Хэргийг хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгосон прокурорын шийдвэрийг яллагдагч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид 7 хоногийн дотор гардуулна.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан прокурорын шийдвэрт гомдол гаргах журмыг заана.

3.Төрийн нууцтай холбоотой хэргийг хэрэгсэхгүй болгосон бол яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид тогтоолыг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гардуулахгүйгээр танилцуулж болно.

4.Прокурорын шийдвэрийг авах хүсэлт гаргасан энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад оролцогчид тухайн шийдвэрийг 7 хоногийн дотор ирж гардан авахыг прокурор мэдэгдэнэ.

5.Энэ зүйлийн 1, 4 дэх хэсэгт заасан хугацаанд прокурорын шийдвэрийг гардаж аваагүй бол энэ хуулийн 11.9 дүгээр зүйлд заасны дагуу хүргүүлнэ.

32.7 дугаар зүйл.Хэргийг хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолыг хүчингүй болгосон тогтоолд гомдол гаргах

1.Оролцогч хэргийг хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгосон прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл тогтоолыг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор дээд шатны прокурорт гомдол гаргах эрхтэй.

2.Яллагдагч өөрийн гэм буруугүйг шүүхээр тогтоолгон цагаатгах шүүхийн шийдвэр гаргуулахаар хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээлгэж шалгуулахаар дээд шатны прокурорт гомдол гаргаж болно.

32.8 дугаар зүйл.Хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээх

1.Энэ хуулийн 41.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл тогтоогдсон бол хэргийг хэрэгсэхгүй болгосон, эрүүгийн хэрэг үүсгэж

яллагдагчаар татах тухай тогтоолыг хүчингүй болгосон прокурорын шийдвэрийг дээд шатны прокурор хүчингүй болгож, хэргийг мөрдөн байцаалтад шилжүүлнэ.

2.Энэ хуулийн 32.4 дүгээр зүйлийн 2.4-т заасан тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэж өөр хүнийг яллагдагчаар татсан бол энэ зүйлийн 1 дэх хэсэг хамаарахгүй.

32.9 дүгээр зүйл.Прокурор яллагдагчаар татах тогтоолд өөрчлөлт оруулах

/Энэ зүйлийн гарчиг т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

1.Прокурор яллагдагчийг буруутгаж байгаа Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалтыг өөрчлөх, нэмэлт оруулах бол яллагдагчаар татах тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж, яллагдагчаар татах тогтоолд оруулсан өөрчлөлтийг яллагдагчид танилцуулахыг мөрдөгчид даалгана.

/Энэ хэсэг т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

2.Яллагдагчаар татах тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэн өөрчилсөн бол яллагдагчаас дахин мэдүүлэг авна.

/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./

3.Яллагдагчаар татах тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулсан тогтоолыг яллагдагчид танилцуулж, хувийг гардуулна.

/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./

32.10 дугаар зүйл.Яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлэх

1.Прокурор хэргийг шүүхэд шилжүүлэх үндэслэлтэй гэж үзвэл яллах дүгнэлт үйлдэн харьяалах шүүхэд хүргүүлнэ.

2.Яллах дүгнэлт нь тэмдэглэх, тогтоох хэсэг, хавсралтаас бүрдэнэ.

3.Яллах дүгнэлтийн тэмдэглэх хэсэгт дараахь зүйлийг тусгана:

3.1.яллагдагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, биеийн байцаалттай холбоотой бусад мэдээлэл;

3.2.яллаж байгаа гэмт хэргийн товч агуулга, гэмт хэрэг үйлдсэн газар, цаг хугацаа, учруулсан хохирол, зайлшгүй шаардлагатай нотлох баримт.

4.Яллах дүгнэлтийн тогтоох хэсэгт дараахь зүйлийг тусгана:

4.1.яллагдагчийн үйлдсэн гэмт хэргийн шинж нь Эрүүгийн хуульд заасан ямар зүйл, хэсэг, заалтаар зүйлчлэгдэх;

4.2.эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал;

4.3.яллах дүгнэлт үйлдсэн прокурорын нэр, албан тушаал, он, сар, өдөр.

5.Яллах дүгнэлтийн хавсралтад дараахь зүйлийг тусгана:

5.1.шүүх хуралдаанд шинжлэн судлах нотлох баримтын жагсаалт, мэдүүлэг авахаар дуудах бусад оролцогчийн нэр;

5.2.таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан эсэх, түүний хугацаа;

5.3.хохирол, хор уршгийн талаархи мэдээлэл;

5.4.эд мөрийн баримт, хураасан, битүүмжилсэн эд хөрөнгө.

6.Прокурор яллах дүгнэлтийн хувийг яллагдагчид гардуулж, хавтаст хэргийн материалыг ажлын 3 өдрийн дараа харьяалах шүүхэд шилжүүлэх тухай яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.

/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

7.Яллагдагч яллах дүгнэлтийг гардаж авахаас татгалзвал энэ тухай тэмдэглэл үйлдэж, шаардлагатай бол дуу-дүрсний бичлэгээр баримтжуулж хэргийг шүүхэд шилжүүлнэ.

/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./

8.Өмгөөлөгч хэргийг шүүхэд шилжүүлэхээс өмнө энэ хуулийн 32.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан яллагдагчийг шүүхэд шилжүүлэхтэй холбоотой санал, хүсэлтийг бичгээр гаргаж, хэрэгт хавсаргаж болно.

/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./

9.Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан яллах дүгнэлтийг яллагдагчид бүрэн танилцуулан, төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж, гардуулан өгнө.

/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./

VII ХЭСЭГ

АНХАН ШАТНЫ ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

ГУЧИН ГУРАВДУГААР БҮЛЭГ ЯЛЛАГДАГЧИЙГ ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЭХ, ШҮҮХ ХУРАЛДААНЫ БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖИЛЛАГАА

33.1 дүгээр зүйл. Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх

1. Прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийг шүүгч хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор тухайн хэргийн талаар дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

- 1.1. яллагдагчийг шүүхэд шилжүүлэх;
- 1.2. хэргийг прокурорт буцаах;
- 1.3. хэргийг түдгэлзүүлэх;
- 1.4. хэргийг харьяалах шүүхэд шилжүүлэх.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх боломжгүй бол тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болно.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрт дараахь зүйлийг тусгана:

- 3.1. шийдвэрийг хэзээ, хаана гаргасан;
- 3.2. шийдвэр гаргасан шүүгчийн нэр;
- 3.3. шийдвэрийн үндэслэл.

4. Талууд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах хүсэлт гаргаагүй бол шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг явуулахгүй байж болно.

5. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг энэ хуульд заасан үндэслэлээр хаалттай явуулж болно.

6. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр яллах дүгнэлтэд заасан гэмт хэргийн хүрээнд талуудын гаргасан хүсэлт, гомдлоор, эсхүл шүүгч өөрийн санаачилгаар дараахь асуудлыг хянан хэлэлцэж шийдвэр гаргана:

- 6.1. өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой хүсэлт;
- 6.2. хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг томилох, өөрчлөх талаархи санал, хүсэлт;
- 6.3. эрүүгийн хэргийг түдгэлзүүлэх, эсхүл энэ хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5-д заасан нөхцөл байдал бий болсонтой холбоотой хүсэлт;
- 6.4. прокурорын яллах дүгнэлтэд гарсан үг, үсэг, тоо, тооцооны зэрэг техникийн шинжтэй алдааг засуулах хүсэлт;
- 6.5. яллагдагч гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлбөрийг төлөх тухай хүсэлт;
- 6.6. шүүх хуралдааныг хялбаршуулж явуулах тухай хүсэлт;
[/Энэ заалтыг 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)
- 6.7. яллагдагч, хохирогч нар сайн дураараа эвлэрэх тухай хүсэлт;
- 6.8. яллах дүгнэлт албан ёсоор гардуулаагүй тухай гомдол;
- 6.9. шүүх хуралдааны товын талаархи санал, хүсэлт;
- 6.10. шүүх хуралдаанд дуудах хохирогч, гэрч, шинжээч, шинжлэн судлуулах нотлох баримтын талаархи прокурор, оролцогчийн санал, хүсэлт;
- 6.11. шүүх хуралдааныг хаалттай явуулах хүсэлт;
- 6.12. таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой санал, хүсэлт;
- 6.13. нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар энэ хуульд заасан журам зөрчигдсөн талаар гаргасан гомдол;
- 6.14. хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, хууль бусаар хязгаарласан тухай гомдол;
- 6.15. мөрдөн шалгах ажиллагаа нэмж хийлгэх хүсэлт;
- 6.16. хөрөнгө хураан авах ажиллагаатай холбоотой санал, хүсэлт;
- 6.17. эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан тогтоол албан ёсоор танилцуулаагүй болон уг тогтоол ойлгомжгүй тухай гомдол.

7. Энэ зүйлийн 6.5, 6.6, 6.7-д заасан хүсэлтийг шүүх хүлээн авах үндэслэлтэй байвал эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлэлцэх шүүх хуралдааныг даруй үргэлжлүүлэн явуулж болно.

[/Энэ хэсэгт 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

8.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт оролцох хүсэлт гаргасан тохиолдолд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг оролцуулж болно. Хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.

9.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн товыг прокурор, өмгөөлөгчийн саналыг харгалзан шүүх тогтоож, урьдчилсан хэлэлцүүлэг явуулахаас 3-аас доошгүй хоногийн өмнө оролцогчид мэдэгдэнэ. Прокурор, оролцогч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг хойшлуулах үндэслэл болохгүй.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

10.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүгч дангаар удирдан явуулж, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга энэ хуулийн 11.7, 11.8 дугаар зүйлд заасны дагуу тэмдэглэл үйлдэж, прокурор, оролцогчид танилцуулна.

11.Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр яллагдагчийн гэм буруу, эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой асуудлыг хэлэлцэхгүй.

12.Шүүхийн шатнаас урьдчилсан хэлэлцүүлэг рүү хэрэг буцаахгүй.

[/Энэ хэсгийг 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

33.2 дугаар зүйл.Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх

1.Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх тухай шийдвэрт дараахь асуудлыг тусгана:

- 1.1.шүүх хуралдааныг хэзээ, хаана хийх;
- 1.2.шүүх хэргийг дангаар, эсхүл шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэх эсэх;
- 1.3.шүүх хуралдаанд дуудан ирүүлэх хүний нэр;
- 1.4.шүүх хуралдааныг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь хаалттай явуулах эсэх;
- 1.5.яллагдагчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэн шийдвэрлэх;
- 1.6.зарим хэргийг тусгаарлах, нэгтгэх эсэх;
- 1.7.энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай;
- 1.8.шүүх хуралдааны бэлтгэлийг хэн, хэрхэн хангах тухай.

2.Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх ба шүүх хуралдааны товыг 3-аас доошгүй хоногийн өмнө талуудад мэдэгдэнэ.

33.3 дугаар зүйл.Хэргийг прокурорт буцаах

1.Урьдчилсан хэлэлцүүлгийн үед дараахь үндэслэлээр шүүх өөрийн санаачилгаар, эсхүл хэргийг буцаах тухай прокурорын санал, яллагдагч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан хэргийг прокурорт буцаахаар шийдвэрлэнэ:

- 1.1.хэргийг буруу тусгаарласан бол;
- 1.2.шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй мөрдөн шалгах ажиллагааг хийлгэх бол;
- 1.3.мөрдөн шалгах ажиллагаа явуулахад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн бол.

2.Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор, яллагдагч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрхтэй.

[/Энэ хэсэгт 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

[/Энэ хэсгийн "Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрхтэй." гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 7 дугаар дүгнэлтээр 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлнэ. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 80 дугаар тогтоолоор хүлээн зөвшөөрсөн./](#)

33.4 дүгээр зүйл.Хэргийг түдгэлзүүлэх

1.Шүүгч дараахь нөхцөлд хэргийг түдгэлзүүлнэ:

- 1.1.яллагдагчийн хаана байгаа нь мэдэгдэхгүй байгаа бол;
- 1.2.яллагдагч сэтгэцийн болон бусад хүнд өвчний улмаас хүрэлцэн ирж чадахгүй болох нь шинжээчийн дүгнэлт, эсхүл эмнэлгийн байгууллагын тодорхойлолтоор нотлогдсон бол;
- 1.3.тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаархи гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол;

[/Энэ заалтын "тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаархи гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол;" гэснийг Үндсэн](#)

[хуулийн цэцийн 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 4 дүгээр дүгнэлтээр 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсэн./](#)
[/Монгол Улсын Их Хурлын 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 42 дугаар тогтоолоор хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн./](#)
[/Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 4 дүгээр дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 03 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./](#)

1.4.тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчиж байгаа эсэхийг тогтоолгохоор тухайн шүүхээс Улсын дээд шүүхэд хандсан бол;

1.5.тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчиж байгаа эсэхийг тогтоолгохоор Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд хандсан бол.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нөхцөл арилсан бол шүүгч захирамж гарган хэргийг сэргээнэ.

ГУЧИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ШҮҮХ ХУРАЛДААНЫ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

34.1 дүгээр зүйл.Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаан

1.Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанаар шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг тогтоосны дараа гэм буруутай бол Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх, гэм буруугүй бол цагаатгах асуудлыг хянан шийдвэрлэнэ.

2.Шүүх гэм буруугийн талаар маргасан шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон шийдвэрийнхээ үндэслэлийг танилцуулсны дараа түүнд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлэлцэх шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулна.

3.Шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх талаар гаргасан шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн санал, хүсэлтийг үндэслэн шүүх хуралдааныг завсарлуулж болно.

4.Шүүх хуралдааныг завсарлуулах тухай шийдвэрт завсарлах хугацааг зааж, шүүх хуралдаан хэзээ үргэлжлэн явагдахыг талууд, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгчид мэдэгдэнэ.

5.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан үндэслэлээр шүүх хуралдаан завсарлах тохиолдолд завсарлах хугацаа ажлын 5 өдрөөс хэтэрч болохгүй.

34.2 дугаар зүйл.Шүүх хуралдааны танхим

1.Шүүх хуралдааныг Монгол Улсын төрийн сүлд, далбаа байрлуулсан танхимд явуулна.

34.3 дугаар зүйл.Шүүх хуралдааныг тасралтгүй явуулах

1.Шүүх хуралдааныг өдрийн цагаар явуулах ба амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна.

34.4 дүгээр зүйл.Шүүх хуралдааныг нээлттэй явуулах

1.Төрийн нууцад хамаарах хэрэг хянан шийдвэрлэх, энэ хуульд тусгайлан зааснаас бусад шүүх хуралдааныг нээлттэй явуулна.

[/Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.Шүүх хуралдааныг дараах тохиолдолд бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нээлттэй, эсхүл хаалттай явуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ:

[/Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.1.хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хохирогч, гэрч, өсвөр насны яллагдагч, өсвөр насны шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол;

[/Энэ заалт 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

[/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.2.хамгаалалтад байгаа гэрчийн мэдүүлгийг уншиж сонсох, эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад олж авсан нотлох баримтыг шинжлэн судлах.

[/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

3.Хаалттай явуулах шүүх хуралдаанд оролцуулах, байлцуулах хүнийг шүүх шийдвэрлэнэ.

4.Шүүх хуралдаанд мөрдөн шалгах ажиллагааг нууцаар явуулахтай холбоотой ил болгохыг хориглосон мэдээллийг танилцуулахдаа холбогдох хуулийг баримтална.

5.Шүүх эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсоно.

6.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасан албаны нууцыг задруулахгүй байх баталгааны

зохицуулалт шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааныг нээлттэй явуулахад хамаарахгүй.

[/Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

34.5 дугаар зүйл.Шүүх хуралдаан даргалагчийн эрх хэмжээ

- 1.Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааныг тухайн хэрэгт холбогдолтой асуудлыг хянан шийдвэрлэхэд чиглүүлж, хэргийг бүх талаас нь бүрэн шинжлэн судалж, бодит байдлыг тогтоохын тулд хуульд заасан арга хэмжээг авна.
- 2.Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааны дэгийг сахиулах арга хэмжээ авч оролцогчид эрх, үүргийг нь тайлбарлана.
- 3.Шүүх хуралдаан даргалагч нь шүүхийн хэлэлцүүлгийг яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

34.6 дугаар зүйл.Шүүх хуралдааны явцад шүүх бүрэлдэхүүн өөрчлөгдөхгүй байх

- 1.Хэргийг шүүхийн нэг бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэнэ.
- 2.Шүүгч хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд үргэлжлэн оролцох боломжгүй болсон бол өөр шүүгч томилж, шүүх хуралдааныг эхнээс нь явуулна.

34.7 дугаар зүйл.Прокурор шүүх хуралдаанд оролцох

- 1.Прокурор шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцож, нотлох баримтыг шинжлэн судлах, шүүх хуралдааны явцад гарсан асуудлын талаар санал гаргах, шүүгдэгчид ял оногдуулахад баримтлах Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалт, эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ, хорих байгууллагын нөхцөл, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, тэнсэх, албадлагын арга хэмжээ хэрэглэх болон бусад асуудлын талаархи дүгнэлтээ шүүхэд гаргана.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

- 2.Улсын яллагч хуулийн үндэслэл, хэргийн бодит байдал, нотлох баримтад тулгуурлан өөрийн дотоод итгэлийг удирдлага болгон яллана.
 - 3.Улсын яллагч шүүгдэгчийг яллах, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэхтэй холбогдуулан гаргасан хохирогч түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн саналыг яллах үйл ажиллагаандаа харгалзана.
 - 4.Шүүх хуралдаанд хэд хэдэн улсын яллагч оролцож байгаа бол шүүх хуралдаанд тодорхой асуудлаар мэтгэлцэхэд нэг улсын яллагч нь бусдыгаа төлөөлнө.
 - 5.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу бусдыгаа төлөөлж байгаа улсын яллагч бусад улсын яллагчтай зөвлөлдөх зорилгоор шүүхээс шүүх хуралдааныг завсарлуулахыг хүсч болно.
 - 6.Улсын яллагч доор дурдсан тохиолдолд шүүгдэгчийг яллахаас татгалзаж, саналаа бичгээр гаргана:
 - 6.1.шүүгдэгчийг гэм буруугүй гэж үзсэн;
 - 6.2.хэргийг прокурор буцаах шаардлагатай гэж үзсэн.
- [/Энэ заалтыг 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
- 7.Шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орохоос өмнө улсын яллагч яллахаас татгалзаж болно.
 - 8.Төр, нийтийн эрх ашгийг хамгаалах шаардлагатай гэж үзвэл прокурор иргэний нэхэмжлэл гаргах, гарсан нэхэмжлэлийг дэмжих эрхтэй.

34.8 дугаар зүйл.Хохирогч шүүх хуралдаанд оролцох

- 1.Хохирогч бичгээр хүсэлт гаргасан, эсхүл улсын яллагч, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд хохирогчийг оролцуулна.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

- 2.Хохирогч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.
- 3.Хохирогч шүүх хуралдааны хэвийн үйл ажиллагаанд саад болохгүйгээр өмгөөлөгчтэйгөө, шаардлагатай тохиолдолд улсын яллагчтай чөлөөтэй харилцах боломжоор хангагдана.
- 4.Хохирогч нь шүүгдэгчийг яллах, хариуцлагыг хүндрүүлэхтэй холбоотой санал хүсэлтийг шүүх хуралдааны аль ч үед гаргаж болно.

34.9 дүгээр зүйл.Шүүгдэгч шүүх хуралдаанд оролцох

- 1.Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд шүүгдэгчийг оролцуулна. Шүүгдэгч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болно.
- 2.Шүүгдэгч шүүх хуралдааны хэвийн үйл ажиллагаанд саад болохгүйгээр өмгөөлөгчтэйгөө чөлөөтэй харилцах, ганцаарчлан уулзах боломжоор хангагдана.

3.Шүүх хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй шүүгдэгчийг албадан ирүүлэх, түүнд энэ хуульд заасан таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх шийдвэр гаргаж болно.

4.Шүүх хуралдаанаар эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эсэхийг хэлэлцэхэд шүүгдэгчийн өвчний шинж байдлыг харгалзан түүнийг оролцуулахгүйгээр хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг оролцуулан хэргийг хянан шийдвэрлэж болно.

34.10 дугаар зүйл.Өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцох

1.Шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцож нотлох баримт шинжлэн судлах, шүүх хуралдааны явцад гарсан асуудлаар хүсэлт гаргах, шүүгдэгчийг цагаатгах, түүний хариуцлагыг хөнгөрүүлэх байдлын талаар дүгнэлт гаргана.

2.Шүүгдэгчийг хэд хэдэн өмгөөлөгч өмгөөлж байгаа бол шүүх хуралдаанд тодорхой асуудлаар мэтгэлцэхэд нэг өмгөөлөгч бусдыгаа төлөөлж болно.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу бусдыгаа төлөөлж байгаа өмгөөлөгч бусад өмгөөлөгчтэй зөвлөлдөх зорилгоор шүүхээс шүүх хуралдааныг завсарлуулахыг хүсч болно.

4.Энэ хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх хүсэлтийг бичгээр гаргасан бол хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж болно.

5.Хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн өмгөөлөгчид энэ бүлэгт заасан шүүгдэгчийн өмгөөлөгчийн эрх, үүрэг нэгэн адил хамаарна.

34.11 дүгээр зүйл.Иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч шүүх хуралдаанд оролцох

1.Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч оролцох тухай бичгээр хүсэлт гаргасан тохиолдолд оролцуулж болно.

2.Иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

34.12 дугаар зүйл.Шүүх хуралдаанд улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч хүрэлцэн ирээгүйн холбогдол

1.Улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол энэ тухай шүүхэд урьдчилан бичгээр мэдэгдэнэ. Улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд ирээгүй тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулна.

2.Улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд цаашид үргэлжлүүлэн оролцох боломжгүй бол тэдгээрийг сольж болно. Энэ тохиолдолд анхан шатны шүүх хуралдааныг эхнээс нь явуулах ба тэдгээрт хавтаст хэргийн материал танилцуулна. Хавтаст хэргийн материалтай танилцах хугацааг тэдний хүсэлтийг харгалзан шүүх тогтооно.

3.Улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй нь хариуцлага хүлээлгэх үндэслэл болох ба энэ талаарх мэдээллийг харьяалах прокурорын байгууллага, Монголын Өмгөөлөгчдийн Холбоонд даруй хүргүүлнэ.

[/Энэ хэсэг т 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

4.Шүүгдэгч өөрийгөө өмгөөлж байгаа бол өмгөөлөгчтэй холбоотой энэ зүйлийн 1 дэх хэсэг хамаарахгүй.

34.13 дугаар зүйл.Шүүх хуралдаанд хохирогч, гэрч, шинжээч хүрэлцэн ирээгүйн холбогдол

1.Шүүх хуралдаанд хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, түүний хууль ёсны төлөөлөгч, гэрч, шинжээч хүрэлцэн ирээгүй бол шүүх хуралдаан даргалагч түүнийг оролцуулахгүйгээр хэрэг хэлэлцэж болох эсэхийг улсын яллагч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс асууж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх, эсхүл хойшлуулах тухай асуудлыг шийдвэрлэнэ.

34.14 дүгээр зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэмжээ хязгаар

1.Анхан шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн шүүгдэгчийн хувьд прокуророос шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэргийн хүрээнд явагдана.

2.Шүүх нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэн өөрчилж болно.

34.15 дугаар зүйл.Шүүх хуралдаан завсарлах

1.Шүүх дараахь үндэслэлээр шүүх хуралдааныг тодорхой хугацаагаар завсарлуулж болно:

1.1.ажлын цаг дууссан;

1.2.төлөөлөн мэтгэлцэж байгаа улсын яллагч бусад улсын яллагчтай, өмгөөлөгч бусад өмгөөлөгчтэй зөвлөлдөх тухай хүсэлт гаргасан;

1.3.энэ хуулийн 34.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу санал, хүсэлт гаргасан;

1.4.бусад хүндэтгэн үзэх шалтгаан байгаа бол.

34.16 дугаар зүйл.Шүүх хуралдааныг хойшлуулах

1.Шүүх дараахь үндэслэлээр шүүх хуралдааныг хойшлуулж болно:

- 1.1.шүүх хуралдаанд оролцвол зохих тал, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, гэрч, шинжээч ирээгүй;
- 1.2.шүүх хуралдаанд нэмэлт шинжилгээ хийлгэх, туршилт хийх, газар, орон байранд үзлэг хийхийг талууд харилцан зөвшөөрсөн;
- 1.3.улсын яллагч, өмгөөлөгч солигдож, эсхүл нэмэгдэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох болсон;
- 1.4.шүүх хуралдааныг хойшлуулах хүндэтгэн үзэх бусад шалтгаан бий болсон.

2.Шүүх хуралдааныг хойшлуулахад талуудын санал, хүсэлтийг харгалзан дараагийн шүүх хуралдааны товыг тогтоож, хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээг авна. Шүүх хуралдааныг хойшлуулахад хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд энэ хуулийн 33.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтална.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатай саад учруулах нөхцөл болж байвал шүүх хуралдааныг хойшлуулахгүй байж болно.

[/Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

4.Шүүгдэгч шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэмт хэрэг дахин үйлдсэн, эсхүл урьд нь үйлдсэн өөр гэмт хэрэг илэрсэн нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

5.Шүүх хуралдааны явцад нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол, эсхүл энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-т заасан гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүх хэргийг хянан хэлэлцэхийг нэг удаа 60 хүртэл хоногоор хойшлуулна.

[/Энэ хэсгийг 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

6.Шүүх энэ зүйлийн 5-д заасан үндэслэлээр шүүх хуралдааныг хойшлуулах бол энэ хуулийн 33.1 дүгээр зүйлийн 6.13, 6.14-т заасан гомдолд тусгасан асуудлыг шийдвэрлэх, шүүгдэгчид зүйлчлэлийг өөрчлөн сонсгох, мэдүүлэг өгөх эрхийг хангах, яллах дүгнэлтийг гаргуулах ажиллагаа явуулахыг прокурорт даалгах ба прокурор шүүхээс тогтоосон хугацаанд эдгээр ажиллагааг явуулж, шүүх хуралдаанаар хэлэлцүүлнэ.

[/Энэ хэсгийг 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

7.Энэ зүйлд заасан үндэслэлээр шүүх хуралдаан хойшлогдсон тохиолдолд шүүх хуралдааныг энэ хуульд заасан журмаар эхнээс нь явуулна. Энэ зүйлд заасны дагуу шүүх хуралдааныг хойшлуулсан шийдвэрт гомдол гаргахгүй.

[/Энэ хэсгийг 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

34.17 дугаар зүйл.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх

1.Шүүх дараахь шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, тухайн хэрэгт холбоотой бусад шүүгдэгчийн хувьд шүүх хуралдааныг үргэлжлүүлнэ:

- 1.1.шүүгдэгч оргон зайлсан бол түүнийг олж ирүүлэх хүртэл;
- 1.2.шүүгдэгч сэтгэцийн, эсхүл өөр хүнд өвчний улмаас шүүхэд ирэх бололцоогүй нь шинжээчийн дүгнэлт, эсхүл эмнэлгийн байгууллагын тодорхойлолтоор нотлогдож байгаа бол түүний өвчнийг эдгэрэх хүртэл.

2.Шүүхээс оргон зайлсан шүүгдэгчийг эрэн сурвалжлах ажиллагааг шүүхийн шийдвэрээр эрх бүхий байгууллагад гүйцэтгүүлэхээр даалгана.

3.Оргон зайлсан, хүндээр өвчилсөн шүүгдэгчид холбогдох хэргийг тусгаарлан бусад шүүгдэгчид холбогдох хэргийг хэлэлцэх нь хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулахаар бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.

4.Шүүх хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх маргаан Үндсэн хуулийн цэцэд үүссэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.

[/Энэ хэсгийн "Шүүх хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх маргаан Үндсэн хуулийн цэцэд үүссэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ." гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 4 дүгээр дүгнэлтээр 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсэн./](#)

[/Монгол Улсын Их Хурлын 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 42 дугаар тогтоолоор хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн./](#)

[/Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 4 дүгээр дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 03 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./](#)

5.Шүүх хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, энэ тухай саналаа Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

6.Энэ зүйлд заасан түдгэлзүүлэх нөхцөл арилсан бол шүүх хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээнэ.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

34.18 дугаар зүйл.Хэргийг тусгаарлаж хэлэлцэх

1.Шүүх дараахь тохиолдолд эрүүгийн хэргийг тусгаарлах тухай улсын яллагчийн санал, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн эрүүгийн хэргийг тусгаарлаж, шүүх хуралдааныг үргэлжлүүлж хэргийг эцэслэн шийдвэрлэнэ:

- 1.1.яллах дүгнэлтэд заасан шүүгдэгчийн холбогдох зарим гэмт хэргийг тухайн шүүгдэгч үйлдсэн нь нотлогдоогүй бол;
- 1.2.зарим шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон ба түүнд холбогдох хэргийг тусгаарлаж, хэргийг хянан шийдвэрлэх нь хэргийн байдлыг бүрэн бодитойгоор тогтооход нөлөөлөхөөргүй байвал.

34.19 дүгээр зүйл.Хэргийг хэрэгсэхгүй болгох

1.Шүүх дараахь үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгоно:

- 1.1.гэмт хэргийн шинжгүй;
- 1.2.гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан;
- 1.3.шүүгдэгч нас барсан;
- 1.4.тухайн хэргийг өмнө нь хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр байгаа;
- 1.5.тухайн үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон;
- 1.6.шүүгдэгч Эрүүгийн хуульд заасан ял оногдуулах насанд хүрээгүй;
- 1.7.шүүгдэгч гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй болох нь тогтоогдсон;
- 1.8.гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал тогтоогдсон.
- 1.9.нэмэлт нотлох баримтыг цуглуулах бүхий л ажиллагааг хийсэн боловч шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлогдоогүй.

[/Энэ заалтыг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

~~2.Энэ зүйлийн 1.1-д заасны дагуу шүүх хэрэгсэхгүй болгосон хэргийг хэрэг бүртгэлтэд буцаана-~~

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

3.Энэ зүйлийн 1.9-д заасны дагуу шүүх хэрэгсэхгүй болгосон хэргийг хэрэг бүртгэлтэд буцаана.

[/Энэ хэсгийг 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

34.20 дугаар зүйл.Шүүх хуралдааны дэг

- 1.Шүүгч, шүүх бүрэлдэхүүн танхимд орж ирэх, шүүхийн шийдвэр уншиж сонсгох үед шүүх хуралдааны танхимд байгаа хүмүүс бүгд босч шүүхэд хүндэтгэл үзүүлнэ.
- 2.Шүүх хуралдаанд оролцогч шүүхэд хандаж үг хэлэх, мэдүүлэг өгөхдөө суудлаасаа босно.
- 3.Шүүх хуралдаанд оролцогч хүндэтгэн үзэх шалтгаантай бол шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр суугаагаар мэдүүлэг өгч, үг хэлж болно.
- 4.Улсын яллагч, оролцогч шүүхийн шийдвэр уншиж сонсгоход байлцана.
- 5.Шүүх хуралдаанд оролцогч, шүүх хуралдааны танхимд байгаа бусад хүн шүүх хуралдаан даргалагчийн хуралдааны дэг сахиулах шийдвэрт захирагдана.

34.21 дүгээр зүйл.Шүүх хуралдааны дэг зөрчсөн хүнд хариуцлага хүлээлгэх

- 1.Шүүх хуралдааны дэг зөрчсөн, шүүх хуралдаан даргалагчийн шийдвэр, дэг сахиулагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимаас гаргах тухай сануулж, дахин зөрчил гаргавал шүүх хуралдааны танхимаас гаргаж, шүүхийн шийдвэрийг уншиж сонсгоход шүүх хуралдааны танхимд байлцуулна.
- 2.Шүүгдэгчид энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээлгэсэн бол түүнийг шүүх хуралдааны явцтай танилцах, мэдүүлэг өгөх бололцоотой тусгай тоноглогдсон өрөөнд тусгаарлаж болно.
- 3.Улсын яллагч, өмгөөлөгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч шүүх хуралдааны дэг зөрчсөн, эсхүл шүүх хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдаагүй бол тэдэнд сануулга өгч, дахин зөрчил гаргавал Зөрчлийн тухай хуулийн 15.5 дугаар зүйлд заасан шийтгэл оногдуулна.
- 4.Шүүх хуралдааны танхимд байгаа бусад хүн энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил гаргавал шүүгчийн шийдвэрээр түүнийг шүүх хуралдааны танхимаас гаргаж, Зөрчлийн тухай хуулийн 15.5 дугаар зүйлд заасан шийтгэл оногдуулна.
- 5.Энэ зүйлд заасан шүүхийн шийдвэрт гомдол гаргаж болно.

ГУЧИН ТАВДУГААР БҮЛЭГ
ШҮҮХЭД ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

35.1 дүгээр зүйл.Шүүх хуралдааныг нээх

- 1.Шүүх хуралдаан даргалагч нь хэргийг хянан шийдвэрлэхээр товлосон цагт шүүх хуралдааныг нээж, хэнд холбогдох, ямар хэргийг хянан хэлэлцэж шийдвэрлэх гэж байгааг зарлана.
- 2.Талууд болон шүүхэд дуудагдсан оролцогч, бусад оролцогч хүрэлцэн ирсэн эсэхийг шүүх хуралдааны нарийн бичгийн дарга илтгэж, ирээгүй оролцогчийн шалтгааныг мэдэгдэнэ.
- 3.Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдаанд улсын яллагч, оролцогч, бусад оролцогч ирээгүй бол шалтгааныг тодруулж, шүүх хуралдааныг хойшлуулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

35.2 дугаар зүйл.Орчуулагч, хэлмэрчид түүний үүргийг тайлбарлах

- 1.Орчуулагч, хэлмэрч нь хуралдаанд оролцож байгаа монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний мэдүүлэг, хүсэлтийг шүүх хуралдаан дээр гарсан мэдүүлэг, хүсэлт, уншсан баримт бичиг, түүнчлэн шүүх хуралдаан даргалагчийн болон шүүхийн шийдвэрийг орчуулуулж, эсхүл хэлмэрчлүүлж байгаа хүнд орчуулж, хэлмэрчилж өгөх үүрэгтэй болохыг шүүх хуралдаан даргалагч түүнд тайлбарлаж өгнө.
- 2.Санаатайгаар худал орчуулах, эсхүл хэлмэрчилбэл хуульд заасан хариуцлага хүлээлгэхийг орчуулагч, хэлмэрчид урьдчилан сануулж, шүүх хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

35.3 дугаар зүйл.Гэрчийг шүүх хуралдааны танхимаас гаргах

- 1.Гэрчийн мэдүүлгийг сонсох хүртэл түүнийг шүүх хуралдааны танхимаас гаргана.
- 2.Шүүх хуралдаан даргалагч нь шүүх хуралдаанд мэдүүлэг өгсөн гэрчийг мэдүүлэг өгөөгүй гэрчтэй уулзуулахгүй байлгах арга хэмжээ авна.

35.4 дүгээр зүйл.Шүүгдэгчид яллагдагчаар татсан тогтоолыг танилцуулсан, яллах дүгнэлтийн хуулбарыг өгсөн эсэхийг шалгах

- 1.Шүүх хуралдаан даргалагч нь шүүгдэгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн газар, он, сар, өдөр, иргэний харьяалал, оршин суугаа газар, эрхэлсэн ажил, боловсрол, мэргэжил, гэр бүлийн байдлыг тодруулж, яллагдагчаар татсан тогтоолтой хэзээ танилцсан, яллах дүгнэлтийн хуулбарыг хэзээ авсныг асууна.

35.5 дугаар зүйл.Шүүх бүрэлдэхүүнийг зарлах, татгалзан гаргах эрхтэй болохыг тайлбарлах

- 1.Шүүх хуралдаан даргалагч шүүх бүрэлдэхүүнийг зарлаж, улсын яллагч, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч, түүнчлэн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, орчуулагч, хэлмэрчээр хэн, хэн оролцож байгааг мэдэгдэж, шүүгдэгч, татгалзан гаргах хүсэлт гаргах эрх бүхий бусад оролцогчид энэ хуульд заасны дагуу хүсэлт гаргах эрхтэй болохыг тайлбарлана.
- 2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүх хуралдаанд оролцогч татгалзан гаргах хүсэлт гаргавал түүнийг энэ хуулийн Аравдугаар бүлэгт заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

35.6 дугаар зүйл.Шүүх хуралдаанд оролцогчид түүний эрх, үүргийг тайлбарлах

- 1.Шүүх хуралдаан даргалагч нь шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, шинжээч, бусад оролцогчид энэ хуульд заасан тэдний эрх, үүргийг тайлбарлана.
- 2.Шүүгдэгч, хохирогчийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрх хангагдсан эсэхийг тодруулна.
- 3.Шүүх хуралдаанд оролцогчдын хэн нэг нь ирээгүй бол шүүх хуралдааны ажиллагааг үргэлжлүүлэх эсэхийг энэ хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

35.7 дугаар зүйл.Шүүхийн хэлэлцүүлэг явуулах дараалал тогтоох

- 1.Шүүх хуралдаан даргалагч талуудаас шинжлэн судлуулах хүсэлт гаргасан нотлох баримтын хүрээнд хэрэг хэлэлцэх дарааллыг тогтоож, заасан хугацаанд бэлэн байхыг гэрч, хохирогч, шинжээчид мэдэгдэнэ.
- 2.Талууд шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судлуулахаар шүүхэд танилцуулсан нотлох баримтыг шүүх хуралдаанд хэлэлцүүлэхгүй байх, нотлох баримтаас хасуулах, эсхүл нотлох баримтыг шинжлэн судлах дараалалд өөрчлөлт оруулах талаар санал, хүсэлт гаргах эрхтэй.
- 3.Шүүх хэд хэдэн шүүгдэгчид холбогдох хэрэгт энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шүүхийн хэлэлцүүлэг явуулах дарааллыг тогтоохдоо өөрийнх нь хууль ёсны ашиг, сонирхол хөндөгдөхгүй шүүхийн хэлэлцүүлэг явагдах үед шүүх хуралдааны танхимд байлцахгүй байх талаар оролцогчийн гаргасан хүсэлтийг талуудын саналыг харгалзан шийдвэрлэж болно. Шүүх хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн бол энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаж, шүүх хуралдаанд үргэлжлүүлэн оролцох товыг оролцогчид мэдэгдэнэ.

/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./

35.8 дугаар зүйл.Шүүхийн хэлэлцүүлэг

- 1.Шүүхийн хэлэлцүүлэг нь яллах, өмгөөлөх талын эрх тэгш мэтгэлцээний үндсэн дээр явагдана.
- 2.Шүүхийн хэлэлцүүлэгт эхлээд яллах, дараа нь цагаатгах нотлох баримтыг шинжлэн судална.
- 3.Улсын яллагч яллах дүгнэлтийг уншиж сонсгосноор шүүхийн хэлэлцүүлэг эхэлнэ.
- 4.Шүүх хуралдаан даргалагч шүүгдэгч бүрээс улсын яллагчийн яллах дүгнэлтийн агуулга, түүнд оногдуулж болох эрүүгийн хариуцлагын талаар ойлгосон эсэхийг тодруулж, шүүгдэгчийн хүсэлтээр тайлбарлахыг улсын яллагчид даалгаж болно.
- 5.Улсын яллагч яллах дүгнэлт уншиж сонсгосны дараа шүүх хуралдаан даргалагч шүүгдэгчээс мэдүүлэг өгөх эсэхийг асууж, хэрэв зөвшөөрвөл түүний мэдүүлгийг сонсоно.
- 6.Улсын яллагчийн яллах дүгнэлттэй холбогдуулан шүүгдэгчийн өмгөөлөгч үг хэлж болно.
- 7.Шүүгдэгч, гэрч, шинжээчээс мэдүүлэг авах, нотлох баримт шинжлэн судлах хүсэлт гаргасан тал эхэлж асуулт тавьж, шинжлэн судална.
- 8.Шүүгдэгч, гэрчид тавьсан асуулт нь өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг хариулт өгөхөөр бол өмгөөлөгч, улсын яллагч нь шүүгдэгч, гэрчийг тухайн асуултад хариулахгүй байх хүсэлтийг шүүхэд гаргаж болно.
- 9.Талуудаас шүүгдэгч, гэрч, шинжээчээс нэг зүйл дахин давтан асуусан, эсхүл хэрэгт холбогдолгүй асуултад хариулахгүй байх тухай талуудын эсэргүүцэл үндэслэлтэй гэж үзвэл шүүх хуралдаан даргалагч асуултад хариулахыг зогсоож болно.
- 10.Улсын яллагч, өмгөөлөгч нь шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэг өгсөн шүүгдэгч, хохирогч, гэрч, шинжээчид дахин асуулт тавих, шинжлэн судалсан нотлох баримтыг дахин судлуулахаар шүүхэд санал, хүсэлт гаргаж болно.
- 11.Нотлох баримтыг дахин шинжлэн судлах, шүүгдэгч, хохирогч, гэрч, шинжээчээс дахин мэдүүлэг авахад энэ хуульд заасан журмыг баримтална.
- 12.Шүүгч, иргэдийн төлөөлөгч нотлох баримтыг шинжлэн судлахад оролцож, аль ч үед тодруулах асуулт тавих эрхтэй.
- 13.Шүүгдэгч, гэрч, хохирогч, шинжээчээс мэдүүлэг авах, нотлох баримт шинжлэн судлах ажиллагааг явуулж дуусмагц шүүх хуралдаан даргалагч шүүхийн хэлэлцүүлэг дууссаныг мэдэгдэнэ.

35.9 дүгээр зүйл.Шүүгдэгчийн мэдүүлгийг сонсох

- 1.Улсын яллагч яллах дүгнэлт сонсгосны дараа шүүх хуралдаан даргалагч шүүгдэгчээс хэргийн талаар мэдүүлэг өгөх эсэхийг асууж, зөвшөөрвөл түүнээс мэдүүлэг авна.
- 2.Шүүгдэгч мэдүүлэг өгсний дараа түүнд эхэлж улсын яллагч, дараа нь өмгөөлөгч асуулт тавьж болно.
- 3.Талууд шүүх хуралдаан даргалагчийн тогтоосон дарааллын дагуу шүүгдэгчид асуулт тавьж болно.
- 4.Талуудын хүсэлтээр хэргийн бодит байдлыг тогтооход ач холбогдолтой гэж үзвэл бусад шүүгдэгчийг байлцуулахгүйгээр шүүгдэгчийн мэдүүлгийг сонсож болно.
- 5.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу мэдүүлгийг сонссон бол мэдүүлэг сонсох үед байгаагүй шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимд орж ирсний дараа шүүх хуралдаан даргалагч түүний эзгүйд гаргасан мэдүүлгийн утгыг танилцуулж, өөрийг нь байхгүйд мэдүүлэг өгсөн шүүгдэгчид асуулт тавих бололцоог түүнд олгоно.
- 6.Шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр шүүгдэгч шүүхийн хэлэлцүүлгийн аль ч үед нэмж мэдүүлэг өгч болно.
- 7.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан журам нь өсвөр насны шүүгдэгчээс мэдүүлэг авахад нэгэн адил хамаарна.

35.10 дугаар зүйл.Хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн мэдүүлгийг сонсох

- 1.Шүүгдэгчийн мэдүүлгийг сонсч дууссаны дараа энэ хуулийн 35.14, 35.15 дугаар зүйлд заасан журмын дагуу хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн мэдүүлгийг сонсоно.
- 2.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед гаргасан мэдүүлэг нь шүүхэд гаргасан мэдүүлгээс ноцтой зөрсөн, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч шүүх хуралдаанд ирээгүй бол хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед түүний гаргасан мэдүүлгийг уншиж сонсоно.

35.11 дүгээр зүйл.Гэрчид хууль сануулах

- 1.Шүүх хуралдаан даргалагч гэрчээс мэдүүлэг авахын өмнө түүний биеийн байцаалт, шүүгдэгч, хохирогчтой ямар харилцаатай болохыг тодруулж, хэргийн талаар мэдэх зүйлээ үнэн зөв мэдүүлэх үүрэгтэйг тайлбарлан, мэдүүлэг өгөхөөс татгалзах, зайлсхийх, санаатайгаар худал мэдүүлбэл хүлээлгэх хариуцлагын талаар сануулж, шүүх хуралдааны тэмдэглэлд гарын үсэг зуруулна.
- 2.Шүүх хуралдаан даргалагч арван зургаан насанд хүрээгүй гэрчид хэргийн талаар мэдэх зүйлээ үнэн зөв мэдүүлэхийн ач холбогдлыг тайлбарлан өгөх ба санаатайгаар худал мэдүүлбэл хүлээлгэх хариуцлагын тухай сануулж болохгүй.

35.12 дугаар зүйл.Гэрч мэдүүлэг өгөхөд байлцах хүн

1.Гэрч сэтгэл санаа, хувийн байдал, бусад шалтгааны улмаас шүүх хуралдааны үед тавгүй байдалд орно гэж үзэж улсын яллагч, өмгөөлөгчийн гаргасан санал, хүсэлтийг харгалзан шүүх дараахь гэрчийн гэр бүлийн гишүүн, эсхүл ойр дотны хүнийг байлцуулж болно:

1.1.сэтгэцийн өвчинтэй холбогдолгүй боловч ухаан санаа нь гүйцэд хөгжөөгүй хүн;

1.2.гэмт хэргийн улмаас бие махбодын болон сэтгэл санааны хувьд хохирсон хүн.

2.Шүүх хуралдаан даргалагч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гэрчийн хажууд байлцаж байгаа хүнд гэрчийг мэдүүлэг өгөх үед хөндлөнгөөс оролцох, гэрчийн мэдүүлэгт нөлөөлж болохгүйг урьдчилан сануулж, зөрчвөл шүүх хуралдааны танхимаас гаргана.

35.13 дугаар зүйл.Хамгаалалтад байгаа гэрчийн биеийн байцаалтыг шалгах

1.Энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан хамгаалалтын арга хэмжээ авсан гэрчээс мэдүүлэг авахаар бол шүүх хуралдаан даргалагч тухайн гэрчийн биеийн байцаалт болон шүүгдэгч, хохирогчтой ямар харилцаатай болохыг урьдчилан шалгана.

2.Гэрчид өөрийн хаягийн өөрчлөлтийн талаар шүүхэд тухай бүр урьдчилан мэдэгдэж байхыг сануулна.

35.14 дүгээр зүйл.Гэрчийн мэдүүлгийг сонсох

1.Талуудын хүсэлтээр шүүх хуралдаанд оролцуулахаар шийдвэрлэсэн гэрчийг дуудан ирүүлж, шүүх хуралдаанд биечлэн оролцуулж мэдүүлэг авна.

2.Гэрчээс мэдүүлэг авахуулахаар санал, хүсэлт гаргасан талын, эсхүл санал, хүсэлт гаргаагүй бол яллах талын гэрчээс эхэлж мэдүүлэг авч, асуулт тавина.

3.Талууд шүүх хуралдаан даргалагчийн тогтоосон дарааллын дагуу гэрчээс мэдүүлэг авахад энэ хуулийн 35.8 дугаар зүйлийн 6, 7, 8, 9, 10, 11, 12 дахь хэсэгт заасан журмыг баримтална.

4.Бусад гэрчээс мэдүүлэг авах үед шүүх хуралдааны танхимд байсан гэсэн үндэслэлээр тухайн гэрчээс мэдүүлэг авахаас татгалзаж болохгүй.

5.Гэрчээс мэдүүлэг авч дууссаны дараа түүнийг танхимд суулгаж болох ба шаардлагатай гэж үзвэл түүнээс дахин мэдүүлэг авч болно.

35.15 дугаар зүйл.Арван найман насанд хүрээгүй гэрчийн мэдүүлгийг сонсох

1.Шүүх хуралдаанд арван найман насанд хүрээгүй гэрчээс мэдүүлэг авахад түүний оюун санааны байдал, учирч болох сөрөг нөлөөнөөс сэргийлэх нөхцөл байдлыг улсын яллагч, өмгөөлөгч нь шалгана.

2.Шүүх улсын яллагч, өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу арван найман насанд хүрээгүй гэрчийн мэдүүлгийг сонсох үед түүний хууль ёсны төлөөлөгч, сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйчийг оролцуулж болно.

3.Шүүх хуралдаан даргалагч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хамт оролцож байгаа хүнд арван найман насанд хүрээгүй гэрч мэдүүлэг өгөхөд хөндлөнгөөс оролцож, гэрчийн мэдүүлэгт нөлөөлж болохгүйг урьдчилан сануулж, зөрчсөн тохиолдолд энэ хуулийн 34.21 дүгээр зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

35.16 дугаар зүйл.Гэрчийн мэдүүлэг, баримттай танилцах

1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед гэрчийн гаргасан мэдүүлэг нь шүүхэд гаргасан мэдүүлгээс зөрсөн тохиолдолд хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой шинжлэн тогтоохын тулд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны үед гэрчийн өгсөн мэдүүлгийг шүүх хуралдаанд уншин сонсож болно.

2.Гэрч шүүх хуралдаанд мэдүүлэг өгөхдөө тэмдэглэл ашиглаж болно.

3.Өөрийн мэдүүлэгтэй холбогдох баримт бичгийг уншихыг гэрчид зөвшөөрөх бөгөөд гэрч уг баримт бичгээ шүүхэд өгнө.

4.Гэрчээс мэдүүлэг авах явцад улсын яллагч, өмгөөлөгч шаардлагатай нотлох баримтыг танилцуулж, үзүүлж болно.

35.17 дугаар зүйл.Мэдүүлэг уншиж сонсох

1.Гэрчийн урьд өгсөн мэдүүлгийн тэмдэглэлийг уншиж, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг талуудын хүсэлтээр шүүх хуралдаанд сонсож, үзүүлж болно.

2.Шүүх нь талууд, оролцогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасны дагуу хамгаалагдсан гэрчийг, эсхүл сэтгэл санааны дарамт, нөлөөллөөс хамгаалах зорилгоор гэрчийг шүүхэд ирүүлэхгүйгээр дуу-дүрсний төхөөрөмж ашиглан шүүх хуралдаанд оролцуулж, мэдүүлэг авч, асуулт тавьж, хариулт авч болно.

3.Шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах зорилгоор талууд, оролцогчийн санал, хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл, эсхүл шүүх өөрийн санаачилгаар шүүх хуралдаан явуулахад зориулан тусгайлан тоноглогсон өрөөнөөс дуу-дүрсний дамжуулах хэрэгсэл ашиглан шүүх хуралдааны танхимд гэрчийн мэдүүлэг сонсож, асуулт тавьж, хариулт авч болно.

4.Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан ажиллагаа явуулахад тухайн гэрчийн биеийн байцаалтыг шалган тодруулж, хууль сануулна.

5.Гэрч нас барсан, эсхүл биечлэн мэдүүлэг өгөх чадваргүй болсон нь шинжээчийн дүгнэлт, эсхүл эмнэлгийн байгууллагын тодорхойлолтоор нотлогдсон бол гэрчийн яриаг тусгасан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг сонсож, түүний гар бичмэлийг шинжлэн судална.

35.18 дугаар зүйл.Гэрч, хохирогчийг хамгаалах

- 1.Шүүх хуралдааны турш энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авахад гэрч, хохирогчийн хувийн байдал, тухайн гэмт хэргийн нөхцөл байдал, ялгаварлан гадуурхах, бэлгийн халдашгүй байдлын эсрэг, хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн зэргийг харгалзана.
- 2.Энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасны дагуу нэрийг нь нууцалсан гэрч, хохирогчоос шүүх хуралдаанд мэдүүлэг авахын өмнө тухайн гэрч, хохирогчийг ил болгоно.
- 3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэрч, хохирогч оролцох шүүх хуралдааныг хаалттай явуулах эсэхийг энэ хуулийн 33.1 дүгээр зүйлд заасан шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлэнэ.
- 4.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан мэдүүлэг өгсөн гэрч, хохирогчийг хамгаалах үндэслэл бүхий нөхцөл байдал арилаагүй, эсхүл шинээр үүсвэл энэ хуулийн Арван гуравдугаар бүлэгт заасны дагуу хамгаалалтын арга хэмжээ авна.

35.19 дүгээр зүйл.Эд мөрийн баримт, бичмэл нотлох баримтыг шинжлэн судлах

- 1.Нотлох баримтыг шинжлэн судлахад талууд хэрэгт авагдсан эд мөрийн баримт, бичмэл нотлох баримтыг шүүх, шүүгдэгч, гэрч, шинжээчид танилцуулна.
- 2.Эд мөрийн баримт, бичмэл нотлох баримттай танилцсан оролцогч, шүүгдэгч, гэрч, шинжээч холбогдох зарим асуудлыг тодруулах хүсэлт шүүхэд гаргаж болно.
- 3.Шүүх хуралдаанд ирүүлэх боломжгүй эд мөрийн баримтад үзлэг хийх шаардлагатай бол энэ тухай тэмдэглэлд тусгаж, эд мөрийн баримт байгаа газарт шүүх бүрэлдэхүүн талуудыг байлцуулан үзлэг хийж болно.
- 4.Шүүх хуралдаанд оролцогчийн хүсэлтээр хэрэгт авагдсан бичмэл нотлох баримтыг шалгаж, түүнийг уншин сонсгож болно.
- 5.Шүүхэд гаргасан талуудын хүсэлтээр эд мөрийн баримт, бичмэл нотлох баримтыг шинжлэн судлахад шинжээч, мэргэжилтэн, бусад гэрчийг оролцуулж болно.
- 6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан оролцогчоос мэдүүлэг авахад энэ хуулийн 35.11, 35.12, 35.13, 35.14, 35.15, 35.16, 35.17 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

35.20 дугаар зүйл.Мөрдөн шалгах ажиллагааны дүнг шинжлэн судлах

- 1.Энэ хуульд заасан мөрдөн шалгах ажиллагааны дүнг тухайн ажиллагааны тэмдэглэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгтэй танилцах, оролцсон гэрч, шинжээчийг дуудаж мэдүүлэг авах байдлаар шинжлэн судална.
- 2.Мөрдөн шалгах ажиллагааны дүнг шинжлэн судлах ажил нь хийгдсэн ажиллагааны тэмдэглэл, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгт тусгагдсан мэдээллээр хязгаарлагдана.
- 3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан оролцогчоос мэдүүлэг авахад энэ хуулийн 35.11, 35.12, 35.13, 35.14, 35.15, 35.16, 35.17 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 4.Энэ хуулийн 26.8 дугаар зүйлд заасан магадлагааг мөрдөгч танилцуулсны дараа түүнийг тайлбарлуулах, тодруулах зорилгоор талууд мөрдөгчид асуулт тавьж болно.

35.21 дүгээр зүйл.Шинжээчийн дүгнэлтийг шинжлэн судлах, шинжээчээс мэдүүлэг авах, нэмэлт шинжилгээ хийлгэх

- 1.Мөрдөгчийн магадлагаа, хэд хэдэн шинжээчийн дүгнэлтийг шинжлэн судлах дарааллыг талуудын саналыг харгалзан шүүх тогтооно.
- 2.Шинжээч гаргасан дүгнэлтээ уншиж сонсгосны дараа түүнийг тайлбарлуулах, тодруулах зорилгоор талууд шинжээчид асуулт тавьж, нэмэлт шинжилгээ хийлгэх тухай хүсэлт шүүхэд гаргаж болно.
- 3.Шинжээчээс мэдүүлэг авахад энэ хуулийн 35.11, 35.12, 35.13, 35.14, 35.15, 35.16, 35.17 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

35.22 дугаар зүйл.Газар, орон байранд үзлэг хийх

- 1.Хэргийн бодит байдлыг өөрөөр тогтоож шинжлэн судлах боломжгүй бол шүүх талуудын хүсэлтээр хэрэг гарсан газар, орон байранд талууд, гэрч, шинжээч, оролцогчийг байлцуулан үзлэг хийж болно.
- 2.Үзлэг хийх газар ирмэгц шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдаан үргэлжилж байгааг зарлах ба талууд үзлэгт оролцож байгаа шүүгдэгч, хохирогч, гэрч, шинжээч, мэргэжилтэнд үзлэг хийхтэй холбогдсон асуулт тавьж болно.
- 3.Үзлэгт оролцогч хэргийн байдлыг тодруулахад ач холбогдолтой гэж үзсэн бүх зүйлийг шүүхэд хандан тайлбарлаж болно.
- 4.Үзлэг хийхэд энэ хуульд заасан журмыг баримтална.

35.23 дугаар зүйл.Туршилт хийх

- 1.Хэрэгт авагдсан нотлох баримтыг шинжлэн судлахын тулд ямар нэг үйл явдал, үйлдэл, бусад байдлыг сэргээн дүрслэх шаардлагатай байвал шүүх талуудын хүсэлтээр туршилт хийж болно.
- 2.Туршилтыг талууд, гэрч, шинжээч, бусад оролцогчийг байлцуулан хийнэ.

3.Туршилтыг энэ хуульд заасан журмаар явуулна.

35.24 дүгээр зүйл.Улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт танилцуулах

- 1.Шүүх хуралдаан даргалагч шүүхийн хэлэлцүүлэг дууссаныг зарласны дараа улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт гаргана. Дүгнэлтээ шүүхэд бичгээр өгч болно.
- 2.Улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт хэлэхийн өмнө шүүхэд хандан завсарлага авч болно. Завсарлах хугацааг шүүх тогтооно.
- 3.Улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт хэлж дууссаны дараа дүгнэлтэд заасан зүйлийн талаар харилцан тус бүр нэг удаа тайлбар хэлж болно.
- 4.Дүгнэлтэд шүүх хуралдаанаар хэлэлцэгдээгүй шинэ нотлох баримтыг ашиглахгүй.
- 5.Шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн улсын яллагч, өмгөөлөгчийн дүгнэлт тэдгээрийн тайлбар гаргах хугацааг талуудын санал, хүсэлтийг харгалзан урьдчилан тогтооно.
- 6.Шүүгдэгч өөрийгөө өмгөөлж байгаа бол энэ зүйлд заасан дүгнэлт, тайлбар хэлэх эрхтэй.
- 7.Улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт, тайлбар хэлсний дараа шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааны дүгнэлт танилцуулах ажиллагаа дууссаныг зарлана.

35.25 дугаар зүйл.Шүүгдэгчийн эцсийн үг

- 1.Улсын яллагч дүгнэлт, өмгөөлөгч санал, тэдгээрийг тайлбар хэлж дууссаны дараа эцсийн үг хэлэхийг шүүх хуралдаан даргалагч шүүгдэгчид зөвшөөрөх ба шүүгдэгч эцсийн үг хэлж байхад түүнд асуулт тавьж болохгүй.
- 2.Шүүгдэгчээс хэлэх эцсийн үгийг цагаар хязгаарлаж болохгүй.

35.26 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчийн санал сонсох

- 1.Иргэдийн төлөөлөгч энэ хуулийн 35.25 дугаар зүйлд заасан ажиллагаа явагдаж дууссаны дараа шүүгдэгчийн гэм буруугийн талаар бичгээр гаргасан саналаа уншиж сонсогж болно.

35.27 дугаар зүйл.Тогтоол гаргахаар шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орох

- 1.Шүүгдэгчийн эцсийн үгийг сонссоны дараа шүүх шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орох ба шүүх хуралдаан даргалагч энэ тухай зарлан мэдэгдэнэ.

ГУЧИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ ШҮҮХИЙН ШИЙДВЭР

36.1 дүгээр зүйл.Шийдвэр гаргахаар зөвлөлдөх

- 1.Шүүх шийдвэрээ зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэж гаргана. Шүүх хуралдаан даргалагч зөвлөлдөх тасалгаанд санал хураах, шийдвэр гаргах ажиллагааг удирдан явуулж, олонхийн саналаар шийдвэр гаргана.
- 2.Зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэх асуудлын талаар шүүгч бүр санал гаргах тэгш эрх, үүрэгтэйгээр оролцож, өөрийн санал, байр сууриа чөлөөтэй илэрхийлж, тайлбарлана.
- 3.Зөвлөлдөх тасалгаанд хэлэлцсэн асуудлаар цөөнх болсон шүүгч үндэслэлээ тайлбарлаж дахин санал хураалгах эрхтэй.
- 4.Зөвлөлдөх тасалгаанд шийдвэрлэсэн асуудлаар цөөнх болсон шүүгч тусгай саналаа бичиж шүүхийн шийдвэрт хавсаргах ба түүнийг тогтоол уншиж сонсоход зарлахгүй.
- 5.Шүүх шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг шийдвэрлэхдээ зөвлөлдөх тасалгаанд дараахь асуудал тус бүрийг хэлэлцэнэ:
 - 5.1.шүүх хуралдаанаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдал нь гэмт хэрэг мөн эсэх;
 - 5.2.тухайн гэмт хэрэгт шүүгдэгч гэм буруутай эсэх;
 - 5.3.шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэг, заалтад заасны дагуу зүйлчлэгдэх;
 - 5.4.гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн хэмжээг тогтоох, шүүгдэгч тус бүрээс ямар хэмжээгээр гаргуулах.
- 6.Шүүх шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон шийдвэрийг шүүх хуралдааны танхимд танилцуулж, тэмдэглэлд тусгуулсны дараа түүнд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлэлцэх шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулж болно.
- 7.Энэ хуулийн 34.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу шүүх хуралдааныг тодорхой хугацаагаар завсарлуулсны дараа эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлэлцэх шүүх хуралдааныг явуулах шийдвэр гаргасан тохиолдолд уг шүүх хуралдааныг явуулахад энэ хуулийн Гучин дөрөвдүгээр бүлэгт заасан шүүх хуралдааны ерөнхий нөхцөл нэгэн адил хамаарна.
- 8.Шүүх шүүгдэгчид Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэхээр зөвлөлдөх тасалгаанд дараахь асуудал тус бүрээр хэлэлцэнэ:

- 8.1.Эрүүгийн хуулийн 6.5, 6.6 дугаар зүйлд заасан ял хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал байгаа эсэх;
 - 8.2.шүүгдэгчид оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ, ялыг биечлэн эдлүүлэх эсэх;
 - 8.3.шүүгдэгчид хорих ял оногдуулах бол хорих байгууллагын дэглэм;
 - 8.4.шүүгдэгчийг баривчилсан хугацаа, түүнд авсан таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг ял оногдуулахад хэрхэн тооцох;
 - 8.5.эд мөрийн баримтыг хэрхэн шийдэх;
 - 8.6.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг хэрхэн тооцох;
 - 8.7.шүүгдэгчид авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох эсэх;
 - 8.8.хураагдсан, битүүмжлэгдсэн эд хөрөнгийг хэрхэн шийдэх.
- 9.Шүүгчид зөвлөлдөж байгаа үед зөвлөлдөх тасалгаанд тухайн хэргийг хэлэлцсэн шүүх бүрэлдэхүүнээс өөр хүн байж болохгүй.
- 10.Шүүгчдийн зөвлөлдөх тасалгаанд хэлэлцсэн асуудлыг задруулж болохгүй.

36.2 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийн хэлбэр, бүтэц

- 1.Монгол Улсын нэрийн өмнөөс гаргах шүүхийн шийдвэр нь шийтгэх, эсхүл цагаатгах хэлбэртэй байна.
- 2.Шүүхийн шийдвэр нь удиртгал, тодорхойлох, тогтоох хэсгээс бүрдэнэ.
- 3.Шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байна.
- 4.Шүүх хуралдааны үед шүүгдэгч гэм буруутай болох нь нотлогдсон бол шүүх шийтгэх тогтоол гаргана.
- 5.Шүүгдэгчийн холбогдсон үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжгүй, эсхүл шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй бол шүүх цагаатгах тогтоол гаргана.
- 6.Шүүхийн цагаатгах тогтоолд шүүгдэгч энэ хуульд заасны дагуу хохирлоо арилгуулахаар гомдол гаргах эрхтэй болохыг тусгана.

36.3 дугаар зүйл.Шүүх тогтоол гаргах үед иргэний нэхэмжлэлийг шийдвэрлэх

- 1.Шүүх шийтгэх тогтоол гаргахдаа иргэний нэхэмжлэлийг түүний үндэслэл, хэмжээний нотлогдсон байдлыг харгалзан бүгдийг, эсхүл хэсэгчлэн хангах, эсхүл хэрэгсэхгүй болгоно.
- 2.Шүүх цагаатгах тогтоол гаргахдаа дараахь зүйлийг шийдвэрлэнэ:
 - 2.1.гэмт хэрэг гарсан нь тогтоогдоогүй, эсхүл шүүгдэгч гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нь нотлогдоогүй бол иргэний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох;
 - 2.2.шүүгдэгчийн үйлдэл гэмт хэргийн шинжгүйгээс түүнийг цагаатгасан бол нэхэмжлэлийг хэлэлцэхгүй орхих.
- 3.Хэрэг хэлэлцэх ажиллагааг хойшлуулахгүйгээр иргэний нэхэмжлэлийн тодорхой тооцоо гаргах бололцоогүй тохиолдолд шүүх иргэний нэхэмжлэгч нь нэхэмжлэлээ хангуулах эрхтэй болохыг зааж, түүний хэмжээний тухай асуудлыг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар шийдвэрлүүлэхээр шилжүүлж болно.

36.4 дүгээр зүйл.Иргэний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон, эсхүл хэлэлцээгүй орхисны холбогдол

- 1.Хэрэг хэлэлцэх үед иргэний нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон бол нэхэмжлэгч иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэлийг дахин гаргах эрхээ алдана.
- 2.Иргэний нэхэмжлэлийг хэлэлцээгүй орхисон бол нэхэмжлэгч түүнийг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар дахин гаргах эрхтэй.

36.5 дугаар зүйл.Иргэний нэхэмжлэлийг хангах

- 1.Иргэний нэхэмжлэлийг хангасан ба түүнийг хангах талаар урьд нь арга хэмжээ аваагүй бол шүүх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл нэхэмжлэлийг хангах арга хэмжээ авч болно.
- 2.Иргэний нэхэмжлэл гараагүй боловч гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол учирсан гэж үзвэл шүүх шийтгэх тогтоол гаргахдаа цаашид иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмаар нэхэмжлэлээ хангуулах эрхтэй болохыг заана.

36.6 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийн удиртгал хэсэг

- 1.Шүүхийн шийдвэрийн удиртгал хэсэгт дараахь зүйлийг тусгана:
 - 1.1.Монгол Улсын нэрийн өмнөөс шийдвэр гаргасан;
 - 1.2.шийдвэрийг хэзээ, хаана гаргасан;
 - 1.3.шийдвэр гаргасан шүүхийн нэр, шүүх бүрэлдэхүүн, иргэдийн төлөөлөгч, шүүхийн нарийн бичгийн дарга, талууд, оролцогч;
 - 1.4.хэргийн дугаар;

1.5.шүүгдэгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн газар, он, сар, өдөр, түүний оршин суугаа газар болон ажлын газар, эрхэлсэн ажил, албан тушаал, боловсрол, мэргэжил, гэр бүлийн байдал, хэрэгт ач холбогдол бүхий биеийн байцаалтын талаархи бусад мэдээлэл;

1.6.шүүгдэгчийн холбогдсон хэрэг Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэг, заалтад хамаарах.

36.7 дугаар зүйл.Шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэг

1.Шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэг нь шүүгдэгчийг гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

2.Шүүгдэгчийг гэм буруутайд тооцох хэсэгт дараахь зүйлийг тусгана:

2.1.гэмт хэрэг үйлдэгдсэн газар, цаг, хугацаа, арга, гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл, гэм буруугийн хэлбэр, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэр хэмжээ, шинжийг тогтоосон хэргийн талаархи нөхцөл байдал;

2.2.шүүх хэд хэдэн шүүгдэгчид холбогдох хэргийг шийдвэрлэж байгаа бол шүүгдэгч тус бүрийн үйлдэл, оролцоо, гэмт хэрэгт хамтран оролцсон хэлбэр;

2.3.шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутайд тооцсон шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтын агуулга, шүүх тухайн нотлох баримтыг хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, хууль ёсны гэж үзсэн улсын яллагчийн дүгнэлт, өмгөөлөгчийн саналын үндэслэл болгосон баримт, иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийг няцаан үгүйсгэсэн үндэслэл;

2.4.шүүх хуралдаанаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдалд хийсэн хууль зүйн дүгнэлт;

2.5.хэд хэдэн шүүгдэгчээс заримыг нь цагаатгасан, эсхүл шүүгдэгчийг яллаж байгаа зарим хэргийг хэрэгсэхгүй болгосон бол яллах нотлох баримтыг үгүйсгэсэн үндэслэл, тэдгээрийг нотлох баримтын агуулга.

3.Шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэсэгт дараахь зүйлийг тусгана:

3.1.шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтын агуулга, хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал, эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний үндэслэл;

3.2.шүүгдэгчид хорих ял оногдуулсан бол уг ялыг эдлүүлэх хорих байгууллагын дэглэмийг заасан үндэслэл;

3.3.урьд сонгосон ялыг шүүхээс хөнгөрүүлж өөрчилсөн бол түүний үндэслэл, тэдгээрийг нотлох баримтын агуулга;

3.4.шүүгдэгчийг ял эдлэхээс чөлөөлсөн болон Эрүүгийн хуулийн 7.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан албадлагын арга хэмжээ хэрэглэсэн үндэслэл;

3.5.гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршигтай холбоотой нэхэмжлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хангах тухай, эсхүл хэрэгсэхгүй болгох, эсхүл хэлэлцэхгүй орхих тухай үндэслэл;

3.6.гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналга, галт зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг хураах үндэслэл.

36.8 дугаар зүйл.Шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсэг

1.Шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт дараахь зүйлийг тусгана:

1.1.шүүгдэгч Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэг, заалтад заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болох;

1.2.шүүгдэгчид хэрэглэсэн албадлагын арга хэмжээ, оногдуулсан ялын төрөл, хэмжээ, Эрүүгийн хуулийн 6.1 дүгээр зүйлд заасны дагуу тодорхойлсон эдэлбэл зохих ялын хэмжээ;

1.3.хорих ял оногдуулсан хүний ял эдлэх хорих байгууллагын дэглэм;

1.4.шүүгдэгч нь шүүхийн шийтгэх тогтоол гарахын өмнө баривчлагдсан, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хугацааг ял оногдуулахдаа хэрхэн тооцсон;

1.5.шүүхийн шийтгэх тогтоолыг хуулийн хүчин төгөлдөр болтол шүүгдэгчид таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх эсэх тухай;

1.6.гэмт хэрэг үйлдсэн этгээдэд торгох ял оногдуулах, эсхүл хохирогчид хохирол, хор уршгийг нөхөн төлж барагдуулах бол мөнгөн төлбөр, хохирол барагдуулах ажиллагааг ямар хугацаанд, ямар хэмжээгээр хийх;

1.7.гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршигтай холбоотой нэхэмжлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хангах тухай, эсхүл хэлэлцэхгүй орхих үндэслэл;

1.8.хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд мөрийн баримтыг хэрхэн шийдвэрлэх тухай;

1.9.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг хуваарилсан тухай.

2.Шүүгдэгч Эрүүгийн хуулийн хэд хэдэн зүйл, хэсэг, заалтад заасан гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан бол цагаатгагдсан, эсхүл ял шийтгүүлсэн зүйл, хэсэг, заалтыг шийтгэх тогтоолд нэг бүрчлэн заана.

3.Шүүгдэгч ялаас чөлөөлөгдсөн бол энэ тухай заана.

4.Шүүхийн шийтгэх тогтоолыг улсын яллагч, шүүгдэгч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч өөрөө гардан авснаас

хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхтэй болохыг тусгана.

5.Шүүхийн шийтгэх тогтоолд шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурна.

36.9 дүгээр зүйл.Шүүхийн цагаатгах тогтоол

1.Шүүхийн цагаатгах тогтоолын тодорхойлох хэсэгт дараахь зүйлийг тусгана:

1.1.шүүхээс хэргийн талаар тогтоосон байдал, түүнийг нотолж байгаа нотлох баримтын агуулга;

1.2.шүүгдэгчийг цагаатгах үндэслэл болсон нотлох баримтын агуулга, шүүх тухайн нотлох баримтыг хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, хууль ёсны гэж үзсэн, эсхүл улсын яллагчийн дүгнэлт, өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгчийн саналыг няцаан үгүйсгэсэн үндэслэл.

2.Шүүхийн цагаатгах тогтоолын тогтоох хэсэгт дараахь зүйлийг тусгана:

2.1.шүүгдэгчийг цагаатгасан үндэслэл;

2.2.таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан бол түүнийг хүчингүй болгосон тухай;

2.3.иргэний нэхэмжлэл, эд хөрөнгө хурааж болзошгүй байдлыг хангах зорилгоор арга хэмжээ авагдсан бол түүнийг хүчингүй болгосон тухай;

2.4.хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжлэл гаргах эрх, шүүхэд хандах хугацаа болон шүүхийн харьяаллын талаар;

2.5.эд мөрийн баримтыг хэрхэн шийдвэрлэх тухай;

2.6.тогтоолд давж заалдах, эсэргүүцэл бичих журмын тухай.

3.Шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн талаар шүүхээс гаргасан шийдвэрийн үндэслэлийг заана.

4.Шүүгдэгч тухайн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй гэх үндэслэлээр цагаатгах тогтоол гарсан бол холбогдох шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг прокурорт буцаана.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

5.Цагаатгах тогтоолыг улсын яллагч, шүүгдэгч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч өөрөө гардан авснаас хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхтэй болохыг тусгана.

36.10 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийг уншиж сонсгох

1.Шүүх хуралдааныг нээлттэй явуулсан бол шүүх хуралдаан даргалагч энэ хуулийн 36.1 дүгээр зүйлийн 5.1, 5.2, 5.3, 5.4-т заасан асуудал тус бүрээр шүүхийн шийдвэрийг уншиж сонсоно.

2.Шүүх хуралдаан даргалагч шүүхийн шийдвэрийн агуулга, тогтоох хэсгийг уншиж сонсгох ба шаардлагатай бусад асуудлыг тайлбарлаж дууссаны дараа шүүх хуралдааныг хаана.

3.Шүүх хуралдааны танхимд байгаа шүүгдэгч, бусад хүн шүүхийн шийдвэрийг босч сонсоно.

4.Шүүхийн шийдвэр уншиж сонсгосноор хүчинтэй болно.

5.Шүүгдэгч монгол хэл мэдэхгүй бол шүүхийн тогтоолыг танилцуулсны дараа орчуулагч, хэлмэрч шүүгдэгчийн эх хэл, эсхүл түүний мэдэх хэлээр орчуулж, эсхүл хэлмэрчилж өгнө.

6.Шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулсан бол шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтэд уншиж сонсоно.

36.11 дүгээр зүйл.Цагдан хоригдож байгаа шүүгдэгчийг суллах

1.Шүүгдэгчийг цагаатгасан, ял эдлэхээс чөлөөлсөн, ял оногдуулахгүйгээр тэнссэн, эсхүл түүнд хорихоос өөр төрлийн ял оногдуулсан, хэргийг хэрэгсэхгүй болгосон бол цагдан хоригдож байгаа шүүгдэгчийг суллана.

36.12 дугаар зүйл.Таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх

1.Шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болохыг тогтоосон шүүхийн шийдвэр гарсан бол улсын яллагчийн санал, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн санал, хүсэлтийг үндэслэн шүүх түүнд авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж болно.

36.13 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гардуулан өгөх

1.Шүүхийн шийдвэрийг уншиж сонсгосноос хойш 15 хоногийн дотор шүүхийн цагаатгах, шийтгэх тогтоолыг бүрэн эхээр, бичгээр үйлдэж улсын яллагч, шүүгдэгч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, өмгөөлөгчид гардуулан өгнө.

2.Шүүхийн шийдвэрийг авах тухай хүсэлт гаргасан энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад оролцогчид шүүхийн шийдвэрийг үйлдсэнээс хойш 7 хоногийн дотор ирж гардан авахыг шүүх мэдэгдэнэ.

3.Монгол хэл мэдэхгүй шүүгдэгчид шүүхийн шийдвэрийг түүний эх хэлээр, эсхүл мэдэх хэлээр орчуулсан хувийг монгол хэлээрх эх хувьтай нь хамт энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд гардуулан өгнө.

4.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан хугацаанд шүүхийн шийдвэрийг гардаж аваагүй бол энэ хуулийн 11.9 дүгээр зүйлд заасны дагуу хүргүүлнэ.

5.Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийг прокурор, оролцогчид бүрэн танилцуулан, төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж, гардуулан өгнө.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

36.14 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэрийг залруулах

1.Шүүхийн шийдвэрт үг, үсэг, тоо, тооцооны зэрэг техникийн шинжтэй гарсан алдааг залруулах талаар улсын яллагчийн санал, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт шүүхэд гаргаж, эсхүл шүүх өөрийн санаачилгаар залруулж болно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан алдааг шүүх даруй хянан хэлэлцэж, шийдвэрийг залруулна.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хянан хэлэлцэх ажиллагаанд оролцогч, улсын яллагчийг оролцуулж болно.

4.Шүүхийн шийдвэрийг залруулсан бол энэ хуулийн 36.13 дугаар зүйлд заасны дагуу гардуулан өгнө.

5.Шүүхийн шийдвэрийг залруулсан тухай шийдвэрт ямар алдааг хэрхэн залруулсныг тусгаж, шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурна.

ГУЧИН ДОЛДУГААР БҮЛЭГ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ

37.1 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох

1.Анхан шатны шүүхийн шийдвэр дараахь тохиолдолд хуулийн хүчин төгөлдөр болно:

1.1.талууд, оролцогч энэ хуулийн 38.2 дугаар зүйлд заасан хугацаанд давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргаагүй бол гомдол, эсэргүүцэл бичих хугацаа дуусмагц;

1.2.давж заалдах шатны шүүх гомдол, эсэргүүцлийг хянаад анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн, эсхүл өөрчлөлт оруулсан.

2.Анхан шатны шүүхийн шийдвэрт гомдол, эсэргүүцэл гаргасан бол шүүхийн шийдвэрийн биелэлт түдгэлзэнэ.

37.2 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх

1.Энэ хуульд заасан хугацаанд давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргаагүй бол уг хугацаа дуусмагц шүүхийн шийдвэрийг гүйцэтгэнэ.

2.Давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргасан бол давж заалдах шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэнэ.

37.3 дугаар зүйл.Шүүхийн шийдвэрийг биелүүлэх

1.Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээд биелүүлнэ.

37.4 дүгээр зүйл.Хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг хүргүүлэх

1.Энэ хуульд заасны дагуу хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажлын 5 өдрийн дотор хүргүүлнэ.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан энэ тухай прокурорт даруй мэдэгдэнэ.

37.5 дугаар зүйл.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах

[/Энэ зүйлийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

1.Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг 2 жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Энэ хугацаанд ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина.

2.Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно.

3.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, эсхүл тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

4.Ялтан хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

5.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг үйлдвэл шүүх Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.

6.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээд шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.

37.6 дугаар зүйл.Хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох

- 1.Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлд заасны дагуу хорих ялаас хугацаанаас өмнө суллах тухай асуудлыг хорих байгууллагын тодорхойлолтыг үндэслэн гаргасан прокурорын дүгнэлтийн дагуу хорих байгууллагын оршин байгаа газрын шүүх шийдвэрлэнэ.
- 2.Хорих ялаас хугацаанаас өмнө суллахдаа ялтны эдлээгүй үлдсэн ялын хугацаатай тэнцүү хяналтын хугацаа тогтооно.
- 3.Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүнд хяналтын хугацаанд үүрэг хүлээлгэж болох ба үүрэг хүлээлгэсэн тохиолдолд хүлээлгэсэн үүргийг зөрчсөн бол прокурорын дүгнэлтээр шүүх хяналт тогтоосон шийдвэрийг хүчингүй болгож, эдлээгүй үлдсэн ялыг эдлүүлэхээр тогтооно.
- 4.Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүн хяналтын хугацаанд санаатай гэмт хэрэг үйлдсэн бол шүүх эдлээгүй үлдсэн ял дээр шинээр үйлдсэн гэмт хэрэгт оногдуулсан ялыг Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйлд заасан журмаар нэмж нэгтгэнэ.
- 5.Хорих ялаас хугацаанаас өмнө суллагдсан хүн хяналтын хугацаанд болгоомжгүй гэмт хэрэг үйлдсэн бол Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйлд заасан журмаар ял оногдуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ.
- 6.Хорих ялаас хугацаанаас өмнө суллах тухай шийдвэр гарсан бол уг ялтныг даруй суллаж, суллагдсан хүний оршин суугаа газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад мэдэгдэж, хувийн хэргийг хүргүүлнэ.
- 7.Хорих ялаас хугацаанаас өмнө суллах тухай шийдвэрт өмгөөлөгч гомдол, прокурор эсэргүүцэл бичиж болно.

37.7 дугаар зүйл.Хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөх

- 1.Эрүүгийн хуулийн 6.13 дугаар зүйлд заасан ял эдлүүлэх боломжгүй байдал үүсвэл прокурор нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын саналыг үндэслэн энэ хуулийн Хорин долдугаар бүлэгт заасан журмын дагуу шинжээчийн дүгнэлт гаргуулна.
- 2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шинжээчийн дүгнэлт, байгууллагын саналд тулгуурласан прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүгч ялтанд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж, сэтгэцийн эмгэг судлалын тусгай, эсхүл бусад эмнэлэгт байлгах, эсхүл түүнийг цаашид ял эдлэхээс чөлөөлөх тухай шийдвэр гаргана.
- 3.Ялаас өвчний учир чөлөөлөх тухай шүүхийн шийдвэр гарсан бол тухайн ялтныг даруй суллана.
- 4.Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасны дагуу прокурорын дүгнэлтийг үндэслэн ял эдлүүлэх асуудлыг шүүх хянан шийдвэрлэнэ.

37.8 дугаар зүйл.Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, ялыг хөнгөрүүлэх

- 1.Хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээг багасгасан, гэмт хэрэгт тооцохгүй болсон бол шүүх ялтныг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, эсхүл ялыг хөнгөрүүлнэ.

37.9 дүгээр зүйл.Бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээдийг суллах

- 1.Бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээд 25 жил хоригдсоны дараа шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, ял шийтгүүлсэн этгээдийн хувийн байдлыг харгалзан суллах эсэхийг шийдвэрлэнэ.
- 2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан журмаар ялтныг суллаагүй бол 2 жил тутам энэ талаар дахин хэлэлцэнэ.
- 3.Хорих байгууллага бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээдийг суллуулах саналыг Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан хугацаанаас 1 сарын өмнө прокурорт хүргүүлнэ.
- 4.Прокурор энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан саналыг хүлээн авч судлан дараахь дүгнэлтийг шүүхэд хүргүүлнэ:
 - 4.1.хорих ялаас суллах;
 - 4.2.хорих ялаас суллахаас татгалзах.
- 5.Шүүх бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээдийг суллах шийдвэр гаргахдаа энэ хуулийн 37.6 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

37.10 дугаар зүйл.Хорих байгууллагад ял эдлүүлэх дэглэмийг солих

- 1.Ял шийтгүүлсэн этгээдийг Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлд заасан нээлттэй хорих байгууллагаас хаалттай хорих байгууллагад ял эдлүүлэхээр, эсхүл хаалттай хорих байгууллагаас нээлттэй хорих байгууллагад ял эдлүүлэхээр солих тухай прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.
- 2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг тогтоол биелүүлж байгаа газрын шүүх шийдвэрлэнэ.

37.11 дүгээр зүйл.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэх үндэслэл

- 1.Торгох, нийтэд тустай ажил хийлгэх ялыг хорих ялаар солих, түүнчлэн тогтоол биелүүлэх үед гарсан ямар нэг тодорхой биш зүйлийг тодруулах асуудлыг уг тогтоол гаргасан шүүх тухайн асуудлыг мэдэгдсэнээс хойш 15 хоногийн дотор шийдвэрлэнэ.

2.Шүүхийн шийтгэх тогтоол нь түүнийг гаргасан шүүхийн нутаг дэвсгэрийн харьяалалд үл хамаарах өөр орон нутагт биелэгдэж байгаа бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан асуудлыг тогтоол биелүүлж байгаа газрын адил эрхтэй шүүх, хэрэв тийм шүүх байхгүй бол дээд шатны шүүх шийдвэрлэж, шийдвэр гаргасан шүүхэд даруй хүргүүлнэ.

3.Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солих, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох, хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөх асуудлыг уг тогтоолыг ямар шүүх гаргасныг харгалзахгүйгээр тогтоол биелүүлж байгаа газрын шүүх шийдвэрлэнэ.

37.12 дугаар зүйл.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг шийдвэрлэх журам

1.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан асуудлыг уг тогтоол гаргасан шүүх тухайн асуудлыг мэдэгдсэнээс хойш 15 хоногийн дотор шийдвэрлэнэ. Ялтан, түүний өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргавал оролцуулна.

2.Шүүхийн шийдвэрийн хохирол, хор уршиг нөхөн төлүүлэхтэй холбоотой хэсэгт гарсан тодорхой биш асуудлыг шийдвэрлэх шүүх хуралдаанд хохирогчийг оролцуулж болно.

3.Шүүх ялтанг хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөх, эмнэлгийн байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ энэ хуулийн Хорин долдугаар бүлэгт заасан журмын дагуу дүгнэлт гаргасан шинжээчийг байлцуулж болно.

4.Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солих, хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох тухай асуудлыг шийдвэрлэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төлөөлөгчийг оролцуулна.

5.Хэрэг хэлэлцэх ажиллагааг шүүгчийн мэдээллээр эхлэх бөгөөд шүүх хуралдаанд ирсэн хүмүүсийн хүсэлт, прокурорын дүгнэлтийг сонссоны дараа шүүх шийдвэр гаргана.

6.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдож гарсан шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл ялтан, түүний өмгөөлөгч давж заалдах гомдол, прокурор эсэргүүцэл бичиж болно.

VIII ХЭСЭГ

ДАВЖ ЗААЛДАХ, ХЯНАЛТЫН ЖУРМААР ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

ГУЧИН НАЙМДУГААР БҮЛЭГ ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ДАВЖ ЗААЛДАХ

38.1 дүгээр зүйл.Давж заалдах журмаар гомдол, эсэргүүцэл гаргах эрх

1.Шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, тэдгээрийн өмгөөлөгч шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй.

2.Өмгөөлөгч давж заалдах гомдлыг шүүхэд хүргүүлэхээс өмнө өмгөөлж байгаа хүндээ давж заалдах гомдлыг урьдчилан танилцуулсан байна.

3.Прокурор, дээд шатны прокурор, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, тэдгээрийн өмгөөлөгч нь давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргаж байгаа үндэслэлээ тодорхой бичсэн байна.

4.Цагаатгагдсан этгээд шүүхийн шийдвэрийн цагаатгасан шалтгаан, үндэслэлд давж заалдах гомдол гаргах эрхтэй.

5.Иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч, өмгөөлөгч шүүхийн тогтоолын зөвхөн иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах гомдол гаргах эрхтэй.

38.2 дугаар зүйл.Давж заалдах журмаар гомдол, эсэргүүцэл гаргах

1.Прокурор, дээд шатны прокурор, оролцогч анхан шатны шүүхийн шийдвэрийг гардан авснаас хойш, эсхүл энэ хуулийн 11.9 дүгээр зүйлд заасны дагуу хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол, эсэргүүцлээ шийдвэр гаргасан анхан шатны шүүхэд бичгээр гаргана.

2.Цагдан хоригдож байгаа ял шийтгүүлсэн этгээд давж заалдах гомдол гаргасан бол цагдан хорих байгууллагын захиргаа уг гомдлыг баталгаажуулж, дараагийн ажлын өдөрт багтаан харьяалах шүүхэд хүргүүлнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаа хэтрүүлж гаргасан гомдлыг шүүх хүлээж авахгүй.

4.Давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд хүндэтгэн үзэх шалтгаанаар давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих хугацааг хэтрүүлсэн бол хэтэрсэн хугацааг сэргээлгэх хүсэлтээ шийдвэр гаргасан шүүхэд гаргана.

5.Хугацаа сэргээлгэх хүсэлтийг шүүх хянан шийдвэрлэхдээ хүсэлт гаргасан хүнийг дуудаж тайлбар авч болно. Хугацааг хэтрүүлсэн нь хүндэтгэн үзэх шалтгаантай болохыг хүсэлт гаргасан хүн өөрөө нотолно.

6.Хугацаа хэтрүүлсэн нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол шүүх хугацааг сэргээх шийдвэр гаргана.

7.Гомдол, эсэргүүцэл гаргах хугацаа сэргээлгэх хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.

8.Давж заалдах шатны шүүх гомдол, эсэргүүцэл гаргах хугацааг сэргээсэн тохиолдолд гомдол, эсэргүүцлийн дагуу хэргийг хянан шийдвэрлэх, эсхүл энэ хуулийн 38.3 дугаар зүйлд заасан ажиллагааг хийлгэхээр тухайн шийдвэр гаргасан шүүхэд хүргүүлнэ.

38.3 дугаар зүйл.Давж заалдах журмаар гомдол, эсэргүүцэл гаргасан тухай мэдэгдэх

1.Давж заалдах журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийг хүлээн авсан шүүх дараагийн ажлын өдөрт багтаан гомдол, эсэргүүцлийн хуулбарыг прокурор, оролцогчид хүргүүлнэ.

2.Цагдан хоригдож байгаа шүүгдэгчид давж заалдах гомдол, эсэргүүцлийн хуулбарыг хүргүүлнэ.

3.Прокурор, оролцогч давж заалдах журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийн хуулбарыг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хариу тайлбар гаргаж болно.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хариу тайлбар нь гомдол, эсэргүүцлийн хүрээнд байна.

5.Хариу тайлбар гаргасан тухай шүүх давж заалдах журмаар гомдол, эсэргүүцэл гаргагчид дараагийн ажлын өдөрт багтаан мэдэгдэнэ.

38.4 дүгээр зүйл.Давж заалдах шатны шүүхэд хэрэг хүргүүлэх

1.Анхан шатны шүүх давж заалдах журмаар гаргасан гомдол, эсэргүүцэлд хариу тайлбар гаргах хугацаа дуусмагц хавтаст хэрэгт гомдол, эсэргүүцэл, хариу тайлбарыг хавсаргаж, харьяалах давж заалдах шатны шүүхэд хүргүүлнэ.

2.Давж заалдах шатны шүүхэд ирсэн хэргийг шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмын дагуу шүүгчид хуваарилна.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

38.5 дугаар зүйл.Давж заалдах журмаар гаргасан гомдол, эсэргүүцлээс татгалзах

1.Прокурор, дээд шатны прокурор, оролцогч нь шүүгч хэргийн талаар илтгэхээс өмнө давж заалдах журмаар гаргасан гомдол, эсэргүүцлээсээ татгалзаж болно.

2.Өмгөөлөгч давж заалдах журмаар гаргасан гомдлоосоо өмгөөлж байгаа хүнийхээ зөвшөөрөлгүйгээр татгалзаж болохгүй.

3.Шүүх давж заалдах журмаар гаргасан гомдол, эсэргүүцлээс татгалзсан тухай талуудад дараагийн ажлын өдөрт багтаан мэдэгдэнэ.

ГУЧИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН АЖИЛЛАГАА

39.1 дүгээр зүйл.Давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээ

1.Давж заалдах шатны шүүх гомдол, эсэргүүцлийг хянан шийдвэрлэхдээ тухайн хэргийн бүх ажиллагаа, шийдвэрийг бүхэлд нь хянаана.

2.Давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхээр хэлэлцээгүй, тогтоогдоогүй нөхцөл байдал, шинжлэн судлаагүй нотлох баримтыг шийдвэрийн үндэслэл болгохгүй.

3.Шүүх давж заалдсан гомдол, эсэргүүцэлд заасан асуудлаар хязгаарлахгүй ба бусад ял шийтгүүлсэн, цагаатгагдсан этгээд давж заалдах гомдол, эсэргүүцэл бичигдсэн эсэхийг харгалзахгүйгээр хэргийг бүхэлд нь хянаж үзнэ.

4.Давж заалдах шатны шүүх шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг өөрчлөн ялыг хөнгөрүүлж, эсхүл шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж болно.

[/Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтээр "...хүндрүүлж..." гэсэн нь Үндсэн хууль зөрчсөн байна гэснийг Монгол Улсын Их Хурлын 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор хүлээн зөвшөөрсөн./](#)

[/Энэ хэсэгт 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой гарсан давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг анхан шатны шүүх, прокурор, мөрдөгч биелүүлнэ.

6.Шүүх давж заалдах гомдол, эсэргүүцлийг хянаж үзээд хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх үндэслэлтэй гэж үзвэл шүүх хуралдааны товыг тогтооно.

7.Шүүх дараахь үндэслэл тогтоогдвол хэргийг давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхгүй тухай шийдвэр гаргана:

7.1.гомдол, эсэргүүцэл гаргагч нь давж заалдах шатны шүүхэд гомдол, эсэргүүцэл гаргах эрх бүхий хүн, хуулийн этгээд биш;

7.2.гомдол, эсэргүүцэл гаргах хугацаа хэтэрсэн;

7.3.давж заалдах шатны шүүхийн харьяалан шийдвэрлэх асуудал биш;

7.4. тухайн хэргийг урьд нь давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн шийдвэр хүчинтэй байгаа;

7.5. гомдол, эсэргүүцэл гаргагч нь гомдол, эсэргүүцлээсээ татгалзсан.

8. Энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл прокурор, оролцогч энэ хуулийн 15.8 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасан журмаар гомдол гаргаж болно.

9. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл нь иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийн гаргасан давж заалдах гомдлыг хянан шийдвэрлэхэд хамаарахгүй.

[/Энэ хэсгийг 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

39.2 дугаар зүйл. Давж заалдах шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх хугацаа

1. Давж заалдах шатны шүүх нь анхан шатны шүүхээс хавтаст хэргийн материал хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хэргийг хянан шийдвэрлэнэ.

2. Ерөнхий шүүгч хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болно.

3. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх хуралдаан болох газар, товыг 3-аас доошгүй хоногийн өмнө хүсэлт гаргасан прокурор, оролцогчид мэдэгдэнэ.

39.3 дугаар зүйл. Давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох

1. Давж заалдах шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд прокурор, оролцогч оролцох тухай хүсэлтээ бичгээр гаргасан бол оролцуулна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд давж заалдах шатны шүүх хуралдаанд прокурор, оролцогч ирээгүй нь хэрэг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

3. Шүүх хуралдаанд энэ хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээд оролцож байгаа бол түүнийг шүүх хуралдаанд өмгөөлөгчтэй оролцуулна.

4. Энэ хуулийн 34.16 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3, 1.4-т заасан үндэслэлээр шүүх хуралдааныг хойшлуулсан бол энэ тухай прокурор, оролцогчид даруй мэдэгдэнэ.

5. Энэ хуулийн 34.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр давж заалдах шатны шүүхээр хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулах шийдвэр гаргаж болно.

39.4 дүгээр зүйл. Давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэрэг хэлэлцэх

1. Давж заалдах шатны шүүх хуралдаан эхлэх ажиллагааг энэ хуулийн 35.1, 35.2, 35.5 дугаар зүйлд заасныг удирдлага болгон явуулна.

2. Шүүх хуралдаан даргалагч талуудын санал, хүсэлтийг харгалзан давж заалдах шатны шүүх хуралдааны хэлэлцүүлэг явуулах дарааллыг тогтооно.

3. Илтгэгч шүүгч тухайн хэргийг илтгэж, шүүхийн шийдвэрийн агуулга, давж заалдах журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийн үндэслэлийг өөрийн урьдчилсан дүгнэлтгүйгээр танилцуулна.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

4. Шүүх хуралдаан даргалагчийн тогтоосон дарааллын дагуу давж заалдах гомдол, эсхүл эсэргүүцэл гаргасан тал гомдол, эсэргүүцлийн үндэслэлийг тайлбарлах, нотлох баримтыг шинжлэн судлах, шүүх хуралдаанд оролцогчийн тайлбар, прокурорын дүгнэлт, шүүгдэгчийн тайлбар, түүний өмгөөлөгчийн саналыг сонсоно.

5. Талууд дүгнэлт, санал хэлэхдээ анхан шатны шүүхийн тэмдэглэл, дуу-дүрсний бичлэг, хэрэгт авагдсан нотлох баримт ашиглахаас гадна, ял шийтгүүлсэн этгээдийн хувийн байдал, ялыг хөнгөрүүлэхтэй холбоотой баримт гаргаж өгч болно.

6. Шүүх талуудын гаргасан гомдол, эсэргүүцэл, тайлбартай холбогдуулж асуулт тавьж болно.

7. Шүүх хуралдаан даргалагч хэрэг хэлэлцэх ажиллагаа дууссаныг мэдэгдэж, шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орно.

8. Шүүх хуралдааны дэгийг зөрчигчид хариуцлага хүлээлгэхдээ энэ хуулийн 34.21 дүгээр зүйлд заасныг баримтална.

9. Давж заалдах шатны шүүх хуралдааны тэмдэглэлийг энэ хуулийн 11.7 дугаар зүйлд заасны дагуу хөтөлнө.

39.5 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх үндэслэл

1. Дараахь үндэслэлийн аль нэг нь байвал давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн тогтоолыг хүчингүй болгох, эсхүл өөрчилнө:

1.1. шүүхийн тогтоолд заасан үндэслэл нь хэргийн бодит байдалтай нийцээгүй;

1.2. Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн;

1.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ноцтой зөрчсөн.

39.6 дугаар зүйл.Шүүхийн тогтоолд заасан дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцээгүй байх

1.Дараахь нөхцөл байдлын аль нэг нь тогтоогдвол анхан шатны шүүхийн тогтоолд заасан дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцээгүй гэж үзнэ:

- 1.1.дүгнэлт нь шүүх хуралдаанаар хэлэлцсэн нотлох баримтаар нотлогдохгүй байвал;
- 1.2.дүгнэлтэд ноцтойгоор нөлөөлж болох нөхцөл байдлыг шүүх анхаарч үзэлгүй орхигдуулсан бол;
- 1.3.дүгнэлтэд онцгой ач холбогдол бүхий нотлох баримт харилцан зөрүүтэй байхад аль нэгийг нь авахдаа бусдыг нь үгүйсгэсэн тухай үндэслэлийг заагаагүй бол;
- 1.4.дүгнэлт нь шүүгдэгчийн гэм буруугийн асуудлыг шийдвэрлэх, Эрүүгийн хуулийг зөв хэрэглэх, ял оногдуулахад нөлөөлсөн, эсхүл нөлөөлж болох ноцтой зөрүүтэй байвал.

39.7 дугаар зүйл.Эрүүгийн хуулийг буруу хэрэглэх

1.Дараахь нөхцөл байдлын аль нэг нь тогтоогдвол Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзнэ:

- 1.1.шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй;
- 1.2.хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн;
- 1.3.хуулийн зүйл, хэсэг, заалтыг буруу тайлбарлаж хэрэглэсэн.

39.8 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ноцтой зөрчих

1.Дараахь нөхцөл байдлын аль нэг нь тогтоогдвол шүүх шийдвэр гаргахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ноцтой зөрчсөн гэж үзнэ:

- 1.1.шүүх хууль бус бүрэлдэхүүнээр тогтоол гаргасан;
- 1.2.хуульд заасан үндэслэлээр гаргасан шүүхийн харьяалалтай холбоотой хүсэлтийг хэлэлцэхгүйгээр шийдвэрлэсэн;
- 1.3.энэ хуулийн 10.1, 10.2 дугаар зүйлд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон;
- 1.4.энэ хуулийн 35.14, 35.15 дугаар зүйлд заасныг зөрчсөн;
- 1.5.шүүх шийдвэр гаргахдаа энэ хуулийн 16.3 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 16.11, 16.12 дугаар зүйлд заасан нотлох баримтыг ашигласан;
- 1.6.шүүхийн шийдвэр нь энэ хуулийн 36.2, 36.6, 36.7, 36.8, 36.9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй;
- 1.7.хэрэгт шүүх хуралдааны тэмдэглэл, түүнд хавсаргасан нотлох баримт байгаагүй;
- 1.8.шүүх хуралдаанд уншиж сонгосон шийдвэрийн тогтоох хэсэг гардуулсан шийдвэрийн тогтоох хэсгээс зөрүүтэй бол;
- 1.9.анхан шатны шүүх хуралдааны тэмдэглэл, дуу-дүрсний бичлэг зөрүүтэй бол;
- 1.10.илт үндэслэлгүйгээр хэргийг хэрэгсэхгүй болгосон.

39.9 дүгээр зүйл.Давж заалдах шатны шүүхийн шийдвэр

1.Давж заалдах шатны шүүх дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

- 1.1.гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх;
- 1.2.анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох;
- 1.3.энэ хуулийн 33.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 34.7 дугаар зүйлийн 6.2-т заасан үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг прокурорт, эсхүл дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаах;
[/Энэ заалтыг 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)
[/Энэ заалтыг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)
- 1.4.хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэхгүйгээр анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;
[/Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтээр "... эсхүл хүндрүүлж ..." гэсэн нь Үндсэн хууль зөрчсөн байна гэснийг Монгол Улсын Их Хурлын 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор хүлээн зөвшөөрсөн./](#)
[/Энэ заалтыг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)
- 1.5.энэ хуулийн 36.8 дугаар зүйлийн 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9-д заасан шийдвэрт өөрчлөлт оруулах.
[/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

2.Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт дараахь зүйлийг тусгана:

- 2.1. давж заалдах гомдол, эсэргүүцлийг хэзээ, хаана, хэн гаргасан;
- 2.2. давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүний нэр, прокурор, өмгөөлөгчийн нэр;
- 2.3. анхан шатны шүүхийн нэр, шийдвэр гарсан он, сар, өдөр, дугаар;
- 2.4. анхан шатны шүүхийн шийдвэрийн товч агуулга;
- 2.5. давж заалдах гомдол, эсэргүүцлийн үндэслэл;
- 2.6. давж заалдах гомдол, эсэргүүцэлд гаргасан хариу тайлбарын агуулга;
- 2.7. давж заалдах шатны шүүхийн дүгнэлт, түүний үндэслэл;
- 2.8. шүүх бүрэлдэхүүний гарын үсэг.

39.10 дугаар зүйл. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг уншиж сонсгох

1. Давж заалдах шатны шүүх хуралдаан даргалагч шүүхийн шийдвэрийг уншиж сонсгоно.
2. Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, оногдуулсан ялыг хүчингүй болгосон, өөрчилсөн үндэслэлийг шүүх хуралдаан даргалагч тайлбарлана.
3. Шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээсэн, эсхүл өөрчилсөн тохиолдолд ял шийтгүүлсэн этгээдэд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг ял эдлэх хугацаанд оруулж тооцно.
4. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг уншиж сонсгосноос хойш 15 хоногийн дотор шийдвэрийг бичгээр үйлдэж энэ хуулийн 36.13 дугаар зүйлд заасны дагуу прокурор, оролцогчид гардуулна.

39.11 дүгээр зүйл. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг биелүүлэх

1. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг уншиж сонсгосон даруй хуулийн хүчин төгөлдөр болно.

39.12 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг залруулах

1. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт үг, үсэг, тоо, тооцооны зэрэг техникийн шинжтэй гарсан алдааг залруулах талаар прокурор, оролцогч шүүхэд хүсэлт гаргаж, эсхүл шүүх өөрийн санаачилгаар энэ хуулийн 36.14 дүгээр зүйлд заасан журмаар залруулна.

ДӨЧДҮГЭЭР БҮЛЭГ ХЯНАЛТЫН ЖУРМААР ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

40.1 дүгээр зүйл. Хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргах

1. Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт дараах үндэслэлээр оролцогч хяналтын журмаар гомдол, прокурор, дээд шатны прокурор эсэргүүцэл гаргаж болно:

- 1.1. шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах;

[/Энэ заалтыг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

/Энэ заалтын “анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг зөрүүтэй хэрэглэсэн;” гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 02 дугаар дүгнэлтээр 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсэн./

/Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор хүлээн зөвшөөрсөн./

- 1.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн;

[/Энэ заалтыг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

- 1.3. хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн;

[/Энэ заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ заалтыг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

/Энэ заалтын “шүүх хуулийг Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбараас өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн.” гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 02 дугаар дүгнэлтээр 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсэн./

/Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор хүлээн зөвшөөрсөн./

- 1.4. эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой.

[/Энэ заалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

2. Энэ хуулийн 39.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг гардуулсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргаж болно.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

3.Хяналтын журмаар дараахь үндэслэлээр гомдол, эсэргүүцэл гаргана:

3.1.шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн;

3.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн, эсхүл нөлөөлж болохуйц нөхцөл байдал тогтоогдсон.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

4.Гомдол, эсэргүүцэл гаргагч нь хяналтын шатны шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцэж эхлэхээс өмнө гомдол, эсэргүүцлээсээ татгалзаж болно.

5.Хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргасан нь давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.

6.Хяналтын шатны шүүхэд гаргах гомдол, эсэргүүцэлд дараахь зүйлийг тусгана:

6.1.гомдол, эсэргүүцлийг хянан шийдвэрлэх шүүхийн нэр;

6.2.гомдол гаргасан хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар;

6.3.эсэргүүцэл гаргасан хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал;

6.4.өмгөөлөгчөөр оролцох хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, бусад шаардлагатай мэдээлэл;

6.5.аль шүүхийн ямар шийдвэрт гомдол, эсэргүүцэл гаргаж байгаа;

6.6.анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт заасан хэргийн товч утга;

6.7.гомдол, эсэргүүцлийн хууль зүйн үндэслэл, нотолгоо;

6.8.гомдол, эсэргүүцэл гаргагчийн санал, хүсэлт;

6.9.хавсаргасан баримт бичиг, тэдгээрийн жагсаалт.

7.Хяналтын журмаар гомдол, эсэргүүцэл гаргах хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацааг сэргээлгэх хүсэлтийг энэ хуулийн 38.2 дугаар зүйлийн 5, 6, 7, 8 дахь хэсэгт заасан журмаар хянан шийдвэрлэнэ.

8.Улсын ерөнхий прокурор, түүний томилсон прокурор хяналтын журмаар эсэргүүцэл бичих зорилгоор хавтаст хэргийн материалтай танилцах эрхтэй.

9.Өмгөөлөгч хяналтын журмаар гаргасан гомдлыг шүүхэд хүргүүлэхээс өмнө өмгөөлж байгаа хүндээ урьдчилан танилцуулсан байна.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

10.Өмгөөлөгч хяналтын журмаар гаргасан гомдлоосоо өмгөөлж байгаа хүнийхээ зөвшөөрөлгүйгээр татгалзаж болохгүй.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

40.2 дугаар зүйл.Хяналтын журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийг хүлээн авах

1.Хяналтын журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүх хүлээн авах бөгөөд энэ хуулийн 38.3 дугаар зүйлд заасан ажиллагааг гүйцэтгэнэ.

2.Гомдол, эсэргүүцэл хүлээн авсан шүүх хэргийг гомдол, эсэргүүцэл, тайлбарын хамт Улсын дээд шүүхэд хүргүүлнэ.

3.Хяналтын шатны шүүх гомдол, эсэргүүцлийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж дөрөв, түүнээс дээш шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх талаар санал гаргавал энэ тухай тогтоол гаргана.

[/Энэ хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу гомдол, эсэргүүцлийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргаагүй бол татгалзсанд тооцож, энэ тухай тогтоол гаргана.

[/Энэ хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

5.Энэ зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасан тогтоолд шүүгчид гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Тогтоол эцсийн шийдвэр байх ба гомдол гаргахгүй.

[/Энэ хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

6.Гомдол, эсэргүүцлийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэхэд оролцогч, прокурор оролцохгүй.

[/Энэ хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

40.3 дугаар зүйл.Хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэх хугацаа

1.Шүүх хэргийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хяналтын журмаар хянан шийдвэрлэх ба хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг

харгалзан энэ хугацааг Танхимын зөвлөгөөнөөс шүүгчийн саналыг харгалзан нэг удаа сунгаж болно.

[/Энэ заалт ад 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

40.4 дүгээр зүйл.Шүүх хуралдааны тов

1.Хяналтын шатны шүүх хуралдааны товыг прокурор, гомдол гаргасан болон шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргасан оролцогчид энэ хуулийн 11.9 дүгээр зүйлд заасан журмаар мэдэгдэнэ.

2.Прокуророос бусад оролцогч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

40.5 дугаар зүйл.Хяналтын шатны шүүхийн эрх хэмжээ

1.Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэж байгаа шүүх нь анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрээр тогтоогдоогүй, эсхүл үгүйсгэгдсэн нөхцөл байдлыг тогтоох, түүнийг нотлогдсон гэж үзэх, ямар нэг нотлох баримтыг нөгөөгөөс нь ач холбогдолтойд тооцох, анхан шатны болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэг, заалтыг хэрэглэх, ямар ял оногдуулах тухай асуудлыг урьдчилан шийдвэрлэх эрхгүй.

2.Хяналтын шатны шүүх нь шүүхийн Эрүүгийн хуулийн хэрэглээний зөрүү байгаа эсэх, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн эсэх, шүүх хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн эсэхийг хянана.

[/Энэ хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

[/Энэ хэсгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

/Энэ хэсгийн "... зөрүүтэй хэрэглэсэн эсэх, ..." гэснийг Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 02 дугаар дүгнэлтээр 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсэн./

/Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор хүлээн зөвшөөрсөн./

3.Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн гэдгийг энэ хуулийн 39.7, 39.8 дугаар зүйлд заасны дагуу ойлгоно.

4.Хяналтын шатны шүүх энэ хуулийн 40.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад үндэслэлээр хэрэг хянахгүй.

5.Шүүх хяналтын журмаар хэргийг хянан хэлэлцэхдээ анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрийг бүрэн хянаж үзнэ.

40.6 дугаар зүйл.Хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэх

1.Хяналтын журмаар хэргийг Улсын дээд шүүхийн таван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан хэлэлцэх ба шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг тогтоосон журмын дагуу томилно.

[/Энэ хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааныг нээж хэнд холбогдох, ямар хэрэг хэлэлцэхийг зарлаж, шүүх бүрэлдэхүүн бусад оролцогчийг татгалзан гаргах талаар болон хэргийн талаар өөр санал, хүсэлт байгаа эсэхийг прокурор, оролцогчоос тодруулна.

3.Илтгэгч шүүгч тухайн хэргийг илтгэж, шүүхийн шийдвэр болон хяналтын журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийн агуулгыг өөрийн урьдчилсан дүгнэлтгүйгээр танилцуулна.

[/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

4.Хяналтын шатны шүүхэд гомдол, эсэргүүцэл гаргасан прокурор, өмгөөлөгч гомдол, эсэргүүцлийнхээ үндэслэлийг танилцуулна.

5.Шүүх бүрэлдэхүүн нь шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр талуудад асуулт тавьж, хариулт авна.

6.Прокурор хууль зүйн дүгнэлт, өмгөөлөгч саналаа танилцуулсны дараа шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орж шийдвэр гаргана.

40.7 дугаар зүйл.Шийдвэр гаргахаар зөвлөлдөх

1.Шүүх шийдвэрээ зөвлөлдөх тасалгаанд хаалттай хэлэлцэж гаргана. Шүүх хуралдаан даргалагч зөвлөлдөх тасалгаанд санал хураах, шийдвэр гаргах ажиллагааг удирдан явуулж асуудал бүрийг олонхийн саналаар шийдвэрлэнэ.

2.Зөвлөлдөх тасалгаанд шийдэх гэж байгаа асуудлын талаар шүүгч бүр санал гаргах тэгш эрхтэйгээр оролцож, өөрийн санал, байр сууриа чөлөөтэй илэрхийлж, тайлбарлана.

3.Зөвлөлдөх тасалгаанд хэлэлцсэн асуудлаар цөөнх болсон шүүгч үндэслэлээ тайлбарлаж дахин санал хураалгах эрхтэй.

40.8 дугаар зүйл.Хяналтын шатны шүүхийн шийдвэр

1.Хяналтын шатны шүүх дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

1.1.гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх;

[/Энэ заалтыг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

1.2.анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгох, хэргийг хэрэгсэхгүй

болгох;

[/Энэ заалтыг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

1.3.энэ хуулийн 33.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 34.7 дугаар зүйлийн 6.2 т заасан үндэслэлээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг прокурорт, эсхүл дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцааж;

[/Энэ заалтыг 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

[/Энэ заалтыг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

1.4.хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэхгүйгээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;

[/Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтээр "... эсхүл хүндрүүлж ..." гэсэн нь Үндсэн хууль зөрчсөн байна гэснийг Монгол Улсын Их Хурлын 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор хүлээн зөвшөөрсөн./](#)

[/Энэ заалтыг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

1.5.энэ хуулийн 40.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан үндэслэлээр гомдол, эсэргүүцлийг хэлэлцэхгүй орхих;

1.6.шүүх хэрэглэсэн, эсхүл хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргуулах тухай саналыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанд шилжүүлэх;

1.7.энэ хуулийн 36.8 дугаар зүйлийн 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9-д заасан шийдвэрт өөрчлөлт оруулах.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

2.Хяналтын шатны шүүх хуралдаан даргалагч гомдол, эсэргүүцлийг хангасан эсэхийг сонсоно. Шийдвэрийг шүүх хуралдаан дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргах ба хугацааг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нэг удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

[/Энэ хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

3.Хяналтын шатны шүүхийн тогтоолд шүүх бүрэлдэхүүн гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Хяналтын шатны шүүхийн тогтоолд анхан болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалын тогтоох хэсгийн агуулга, гомдол, эсэргүүцэл болон гаргаж байгаа тогтоолын үндэслэлийг тусгана.

[/Энэ хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

4.Хяналтын шатны шүүхийн тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх ба уг тогтоолд гомдол гаргахгүй.

[/Энэ хэсгийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

5.Хяналтын шатны шүүхийн шийдвэрийг шүүгчийн тусгай саналын хамт хэрэгт хавсаргаж, шийдвэрийн хувийг энэ хуулийн 36.13 дугаар зүйлд заасны дагуу гомдол, эсэргүүцэл гаргагчид гардуулна.

40.9 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэрийг залруулах

1.Хяналтын шатны шүүхийн шийдвэрт үг, үсэг, тоо, тооцооны зэрэг техникийн шинжтэй гарсан алдааг залруулах талаар прокурор, орлогч шүүхэд хүсэлт гаргаж, эсхүл шүүх өөрийн санаачилгаар энэ хуулийн 36.14 дүгээр зүйлд заасан журмаар залруулна.

40.10 дугаар зүйл.Хяналтын шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргах

[/Энэ зүйлийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

[/Энэ зүйлийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

1.Хяналтын шатны шүүхийн шийдвэр хууль зөрчсөн гэж үзвэл энэ хуулийн 40.1 дүгээр зүйлд заасан этгээд уг шийдвэрийг гардан авснаас хойш 30 хоногийн дотор Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж болно.

2.Хяналтын шатны шүүхийн шийдвэрт гаргасан гомдлыг уг хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн шүүхээр дамжуулан Улсын дээд шүүхэд хүргүүлж болно.

3.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл 30 хоногийн дотор Улсын дээд шүүхийн хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр дүгнэлт гаргана. Ерөнхий шүүгчийн дүгнэлтэд хэрэг шийдвэрлэсэн байдал, хууль зөрчсөн үндэслэлийг тусгаасан байна.

4.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч гомдлыг Улсын дээд шүүхийн хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх үндэслэлгүй гэж үзвэл 30 хоногийн дотор энэ хуулийн 11.9 дүгээр зүйлд заасны дагуу гомдол, эсэргүүцэл гаргагчид бичгээр хариу өгнө.

40.11 дүгээр зүйл.Улсын дээд шүүхийн хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаан

[/Энэ зүйлийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./](#)

1.Хяналтын шатны шүүхийн шийдвэр гаргахад өрөлцсөн шүүх бүрэлдэхүүний хоёр шүүгч тусгай санал гаргасан, эсхүл Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч дүгнэлт гаргасан, Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичсэн бол хэргийг 30 хоногийн дотор Улсын дээд шүүхийн хяналтын шатны Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаан /цаашид "Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаан" гэх/ аар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тохиолдолд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаан явуулах тухай шийдвэр гаргаж, хуралдааны төвыг тогтооно.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хуралдааныг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч даргална.

4.Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаан нь Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс гадна Эрүүгийн хэргийн танхимын нийт шүүгчийн дөрөвний гурваас доошгүй нь өрөлцсөнөөр хүчинтэйд тооцогдоно.

40.12 дугаар зүйл. Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдааны шийдвэр

/Энэ зүйлийг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

1.Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хяналтын шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх эсэх асуудлыг өлөнхийн саналаар шийдвэрлэнэ.

/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

2.Шийдвэр гаргахаар зөвлөлдөхдөө энэ хуулийн 36.1 дүгээр зүйлийг удирдлага болгоно.

3.Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанд өрөлцсөн шүүгчид санал тэнцвэл хяналтын шатны шүүхийн шийдвэр хэвээр үлдэнэ.

4.Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаан энэ хуулийн 40.3, 40.4, 40.5, 40.6 дугаар зүйлд заасан журмаар явагдаж энэ хуулийн 40.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шийдвэр гаргана.

5.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг уншиж сонсгоосон даруй хуулийн хүчин төгөлдөр болно.

6.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн өрөлцсөн Эрүүгийн хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдааны шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байна.

IX ХЭСЭГ

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ОНЦГОЙ ЖУРАМ

ДӨЧИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ШИНЭЭР ИЛЭРСЭН НӨХЦӨЛ БАЙДЛЫН УЛМААС ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ХЯНАХ

41.1 дүгээр зүйл. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянах үндэслэл

1.Дараахь нөхцөл байдал тогтоогдвол шинээр илэрсэн нөхцөл байдал гэж үзэж, урьд гарсан хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг сэргээн шалгаж болно:

1.1.гэрч, шинжээчийн санаатай гаргасан худал мэдүүлэг, дүгнэлт, орчуулагч, хэлмэрчийн санаатай худал орчуулга, хуурамч нотлох баримт, тэмдэглэл, баримт бичгийг үндэслэж шийдвэр гарсан нь тогтоогдсон;

1.2.шүүгч, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан нь эрх хэмжээгээ урвуулан ашигласан нь хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр тогтоогдсон;

1.3.цагаатгагдсан хүн, хуулийн этгээд гэм буруутай болохыг нотлох, эсхүл гэм буруугүй хүн, хуулийн этгээдэд ял оногдуулахад хүргэсэн, шүүх шийдвэр гаргах үед мэдэгдээгүй байсан ба оногдуулснаас хөнгөн, эсхүл хүнд ялтай зүйл, хэсэг, заалт хэрэглэх үндэслэл болох нөхцөл байдал илэрсэн;

1.4.хуулийг илт буруу хэрэглэсэн шүүхийн шийдвэрийн улмаас хүний эрх ноцтой зөрчигдсөн бол.

2.Хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн, Өршөөл үзүүлэх тухай хууль гарсан, уучлал үзүүлсэн, яллагдагч нас барснаас шүүхийн тогтоол гаргах бололцоогүй болсон бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шинээр илэрсэн нөхцөл байдлыг энэ хуульд заасан журмаар тогтооно.

41.2 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлт

1.Шинээр илэрсэн нөхцөл байдлын тухай гомдол, хүсэлтийг прокурор хүлээн авч энэ хуулийн 41.1 дүгээр зүйлд заасан үндэслэлийн аль нэг нь байвал прокурор шинэ нөхцөл байдал илэрсэн гэж үзэж, хэрэг үүсгэх тухай тогтоол гаргаж, энэ тухай хэргийн оролцогчид мэдэгдэх, уг байдлыг хянан шалгах, эсхүл энэ талаар мөрдөгчид даалгавар өгнө.

2.Шинээр илэрсэн нөхцөл байдлыг шалгахад мөрдөгч энэ хуульд заасан журмыг баримтлан шаардлагатай мөрдөн шалгах ажиллагааг явуулна.

3.Прокурор шинээр илэрсэн нөхцөл байдлын талаар хэрэг үүсгэх үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай үндэслэл бүхий тогтоол гаргаж, гомдол, хүсэлтийг хүлээн авахаас татгалзах шийдвэр гаргах ба түүнийг эс зөвшөөрвөл дээд шатны прокурорт гомдол гаргаж болно.

4.Шинээр илэрсэн нөхцөл байдлыг мөрдөн шалгах ажиллагаа эхэлмэгц хэргийн хугацааг шинээр тогтоож, хугацаа сунгахад энэ хуулийн 31.13 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

41.3 дугаар зүйл.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг сэргээх хугацаа

- 1.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас цагаатгасан шүүхийн шийдвэрийг хянан үзэх, түүнчлэн ялтанд хүндрүүлсэн ялтай хуулийг хэрэглэх шаардлагатай болсон бол Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан хөөн хэлэлцэх хугацааны дотор шинэ нөхцөл байдал илэрснээс хойш 1 жил өнгөрөөгүй бол гүйцэтгэж болно.
- 2.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийтгэх тогтоолыг хянан үзэх явдал нь ял шийтгүүлсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлэхээр байвал хугацаагаар хязгаарлахгүй.
- 3.Ял шийтгүүлсэн хүнийг цагаатгахын тулд хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдал илэрсэн үндэслэлээр сэргээхэд уг хүн нас барсан нь саад болохгүй.

41.4 дүгээр зүйл.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээх хүсэлтийг шийдвэрлэх

- 1.Прокурор энэ хуулийн 41.1 дүгээр зүйлд заасан үндэслэл байгаа эсэхийг шалгаж, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг сэргээх тухай дүгнэлтээ дараахь шүүхэд бичгээр гаргана:
 - 1.1.анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүхэд;
 - 1.2.давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэрийг хяналтын шатны шүүхэд.
- 2.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах тухай дүгнэлтийг хүлээн авсан шүүх хянан хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэр гаргана.
- 3.Шүүх дүгнэлтийг хүлээн авахаас татгалзах шийдвэр гаргасан бол энэ талаар хүсэлт гаргагчид мэдэгдэнэ.
- 4.Шүүх дүгнэлтийг хүлээн авах үндэслэлтэй гэж үзвэл шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дараахь шийдвэр гаргана:
 - 4.1.тухайн хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тогтоож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаах;
 - 4.2.хэргийг прокурорт буцаах.
- 5.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан шийдвэрийн хуулбарыг энэ хуулийн 11.9 дүгээр зүйлд заасны дагуу прокурор, оролцогчид хүргүүлнэ.

41.5 дугаар зүйл.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа

- 1.Энэ хуулийн 41.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан үндэслэлээр шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээсний дараа явагдах эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасан ердийн журмыг баримтлан явуулна.
- 2.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хүчингүй болгосон бол анхан шатны шүүх уг хэргийг дахин шийдвэрлэхдээ өмнөх шүүхийн шийдвэрийн заалтыг удирдлага болгохгүй.

ДӨЧИН ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ АЖИЛЛАГАА

42.1 дүгээр зүйл.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлт гаргах

- 1.Гадаад улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг, нэгжлэг, туршилт хийх, эд хөрөнгө хураан авах болон энэ хуульд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагатай бол уг асуудлыг эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ.
- 2.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлтийг олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан байгууллагаар дамжуулан явуулна.
- 3.Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол хүсэлтийг хүлээн авах улсын хэлээр үйлдэнэ.

42.2 дугаар зүйл.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлтийн агуулга

- 1.Мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах тухай хүсэлтийг бичгээр үйлдэж, түүнд дараахь зүйлийг тусгана:
 - 1.1.хүсэлт гаргаж байгаа байгууллагын нэр, хаяг;
 - 1.2.хүсэлт хүлээн авах байгууллагын нэр, хаяг;
 - 1.3.хүсэлтийн утга;
 - 1.4.хэргийн агуулга, мөрдөн шалгах ажиллагаагаар тогтоогдсон нөхцөл байдал, эрх зүйн туслалцаа авах зорилго;
 - 1.5.эрх зүйн туслалцаа үзүүлэх үндэслэл;
 - 1.6.хүсэлтэд заасан хүний иргэний харьяалал, эрхэлдэг ажил, оршин суугаа газрын, эсхүл байрлаж байгаа газрын талаархи мэдээлэл, хуулийн этгээдийн хувьд түүний нэр, хаяг;
 - 1.7.эд мөрийн ба бусад нотлох баримт;

1.8.зүйлчлэлийн тухай мэдээлэл, шаардлагатай бол учирсан хохирлын хэмжээ;

1.9.тухайн улсын нутаг дэвсгэрт хийгдэх мөрдөн шалгах тодорхой ажиллагаа.

2.Хүсэлтэд хавсаргаж байгаа баримт бичиг, нотлох баримтыг хүлээн авах улсын албан ёсны хэлээр орчуулж, холбогдох албан тушаалтан гарын үсэг зурж, шаардлагатай бол тэмдэг дарна.

42.3 дугаар зүйл.Гэрч, хохирогч, шинжээч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийг дуудах, мэдүүлэг авах

1.Олон улсын гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол гадаад улсад байнга, эсхүл түр хугацаагаар оршин сууж байгаа Монгол Улсын харьяат гэрч, хохирогч, шинжээч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийг тухайн улс дахь Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан дуудаж болно.

2.Олон улсын гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол гадаад улсын харьяат гэрч, хохирогч, шинжээч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагчийг гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон тухайн улсын эрх бүхий байгууллагаар дамжуулан дуудна.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэрч, хохирогч болон бусад оролцогчид дараахь хариуцлага, албадлагын арга хэмжээ хэрэглэхгүй:

3.1.албадан ирүүлэх;

3.2.мэдүүлэг өгөхөөс татгалзах, эсхүл зайлсхийсэн үйлдэлд шийтгэл оногдуулах;

3.3.худал мэдүүлэх, худал дүгнэлт гаргахад эрүүгийн хариуцлага хүлээлгэх.

42.4 дүгээр зүйл.Мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг биелүүлэх

1.Шүүх, прокурор, мөрдөгч нь гадаад улсын холбогдох байгууллага, албан тушаалтны мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай хүсэлтийг энэ хуульд заасан нийтлэг журмын дагуу биелүүлнэ.

2.Хүсэлтийг биелүүлэхэд тухайн улстай байгуулсан олон улсын гэрээнд заасан бол гадаад улсын мөрдөн шалгах ажиллагааны хэм хэмжээг хэрэглэж болно.

3.Олон улсын гэрээнд заасан бол мөрдөн шалгах ажиллагаа явуулахад гадаад улсын холбогдох байгууллагын төлөөлөгч байлцаж болно.

4.Хүсэлтийг биелүүлэх боломжгүй дараахь тохиолдолд олон улсын гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Улсын ерөнхий прокурорын газраар дамжуулан хүсэлт явуулсан гадаад улсын байгууллагад биелүүлээгүй шалтгааныг зааж, хүлээн авсан баримт бичгийг буцаана:

4.1.энэ хууль болон тухайн асуудалтай холбогдох олон улсын гэрээнд заасан шаардлагыг хангаагүй;

4.2.Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд харшлах;

4.3.Монгол Улсын хуулийг зөрчиж байвал.

42.5 дугаар зүйл.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг үргэлжлүүлэхээр хавтаст хэргийн материалыг хүргүүлэх

1.Гадаадын иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа Монгол Улсаас гарч явсан нь тогтоогдвол уг хэргийг шалгах явцад цугларсан баримт, материалыг хууль, олон улсын гэрээнд заасан журмын дагуу гадаад улсын холбогдох байгууллагад хүргүүлнэ.

42.6 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хүсэлтийг биелүүлэх

1.Монгол Улсын иргэн гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа Монгол Улсад буцаж ирсэн бөгөөд гадаад улсын эрх бүхий байгууллага уг хэргийг үргэлжлүүлэн шалгуулах хүсэлт ирүүлсэн бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд заасан журмын дагуу явуулна.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээдийн хэргийг гадаад улсын эрх бүхий байгууллага шалгасан материалыг хууль, олон улсын гэрээнд заасан журмын дагуу шилжүүлж авах ба энэ хуульд заасан шаардлагыг хангасан нөхцөлд нотлох баримтаар тооцох эсэхийг шүүх шийдвэрлэнэ.

ДӨЧИН ГУРАВДУГААР БҮЛЭГ ТОГТООЛ БИЕЛҮҮЛЭХ ЗОРИЛГООР ХҮНИЙГ ШИЛЖҮҮЛЭН АВАХ, ШИЛЖҮҮЛЭН ӨГӨХ

43.1 дүгээр зүйл.Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авах тухай хүсэлт гаргах

1.Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэнийхээ дараа гадаад улсад гарсан Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авах тухай хүсэлтийг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан журмын дагуу гадаад улсын эрх бүхий байгууллагад тавина.

2.Хүсэлтэд дараахь зүйлийг тусгана:

2.1.шилжүүлэн авах хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, түүнийг гэрчлэх баримт;

- 2.2.иргэний харьяалал, гадаад төрх байдлын тодорхойлолт, гэрэл зураг;
- 2.3.тухайн хүний үйлдсэн хэргийн товч агуулга, хэрэглэх хуулийн заалт, шийтгүүлсэн бол шүүхээс оногдуулсан ял;
- 2.4.шүүхийн шийтгэх тогтоол, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоол гаргасан он, сар, өдөр;
- 2.5.хүсэлтэд хавсаргасан баримт бичгийн баталгаат хуулбар.

43.2 дугаар зүйл.Гадаад улсын иргэнийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг биелүүлэх

- 1.Гадаад улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн, эсхүл ял шийтгүүлсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг шилжүүлэн өгөх тухай гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу шийдвэрлэнэ.
- 2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шилжүүлбэл зохих хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт хорих ял эдэлж байгаа бол ял эдэлж дуустал, эсхүл ялаас чөлөөлөх хүртэл шилжүүлэн өгөхийг хойшлуулж болно.
- 3.Шилжүүлэн өгөхийг хойшлуулбал хөөн хэлэлцэх хугацаа дуусах, эсхүл гэмт хэргийг мөрдөхөд саад учруулахаар бол уг хүнийг шилжүүлэн өгч болно.

43.3 дугаар зүйл.Шилжүүлэн өгөхөөс татгалзах

- 1.Дараахь тохиолдолд шилжүүлэн өгөхгүй:
 - 1.1.Монгол Улсын иргэн;
 - 1.2.уг хүнд Монгол Улсад орогнох эрх олгосон;
 - 1.3.уг хүний холбогдсон үйлдэл, эс үйлдэхүй нь Монгол Улсад гэмт хэрэгт тооцогддоггүй бол;
 - 1.4.шилжүүлбэл зохих хүн тухайн үйлдэлд урьд нь ял шийтгүүлж эдэлсэн, эсхүл уг хэргийг өмнө нь хэрэгсэхгүй болгосон бол;
 - 1.5.Монгол Улсын хуулиар тухайн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, эсхүл бусад үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, ял шийтгэж болохгүй нөхцөл байдал байгаа бол;
 - 1.6.уг хүнийг шилжүүлэн өгснөөр түүнийг эрүүдэн шүүх бодит аюул тулгарахаар бол;
 - 1.7.уг хүний үйлдсэн гэмт хэрэгт шилжүүлэн авах хүсэлт гаргасан улсын хуулиар цаазаар авах ял оногдуулахаар бол.

43.4 дүгээр зүйл.Давхар харьяалалтай ба харьяалалгүй хүнийг шилжүүлэн өгөх

- 1.Давхар харьяалалтай ба харьяалалгүй хүнийг шилжүүлэн өгөх асуудлыг энэ хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрт заасны дагуу шийдвэрлэнэ.

43.5 дугаар зүйл.Шилжүүлэн өгөх зорилгоор цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх

- 1.Гадаад улсын эрх бүхий байгууллагын хүсэлтийг хангаж шилжүүлэн өгөх хууль зүйн үндэслэл байвал түүнийг баривчлан шилжүүлж өгөх хүртэл цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах тухай прокурорын саналыг шүүх хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 2.Шилжүүлэн өгөх цаг, хугацаа, газрыг хүсэлт гаргасан гадаад улсын эрх бүхий байгууллагад прокурор мэдэгдэнэ.
- 3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу цагдан хоригдсон этгээдийг 30 хоногийн дотор шилжүүлж аваагүй бол шүүхийн шийдвэрээр суллана.
- 4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу сулласан хүнийг шинээр хүсэлт гаргасан тохиолдолд дахин цагдан хорьж болно.

43.6 дугаар зүйл.Эд зүйл, бусад нотлох баримтыг шилжүүлэх

- 1.Энэ хуульд заасан журмын дагуу гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнийг гадаад улсад шилжүүлэн өгөхдөө түүний гэмт хэрэг үйлдэхэд ашигласан зэвсэг болон бусад зүйл, түүнчлэн гэмт хэргийн ул мөр бүхий, эсхүл гэмт үйлдлийн замаар олж авсан эд зүйл, шаардлагатай бусад нотлох баримтыг шилжүүлнэ.
- 2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан нотлох баримтыг эрүүгийн өөр хэрэг шийдвэрлэхэд ашиглах шаардлагатай бол түүнийг шилжүүлэн өгөхөөс татгалзаж болно.
- 3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлага байгаа боловч гадаад улсын холбогдох байгууллага хэргийг шийдвэрлэж дуусмагц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд зүйлийг буцааж өгөх тухай баталгаа гаргасан үед шилжүүлнэ.

ДӨЧИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХОРИХ ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН ХҮНИЙГ ХАРЬАТ УЛСАД НЬ ЯЛ ЭДЛҮҮЛЭХЭЭР ШИЛЖҮҮЛЭХ, МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙГ ШИЛЖҮҮЛЭН АВАХ

44.1 дүгээр зүйл.Хорих ял шийтгүүлсэн хүнийг харьяат улсад нь ял эдлүүлэхээр шилжүүлэх үндэслэл

- 1.Монгол Улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн хүнийг харьяат улсад нь шилжүүлэн өгөх, түүнчлэн гадаад улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн Монгол Улсын иргэнийг шилжүүлэн авах асуудлыг тухайн улстай байгуулсан хоёр талт болон Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу гүйцэтгэнэ.

2.Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн хүнийг харьяат улсад нь шилжүүлэн өгөх шийдвэрийг Улсын ерөнхий прокурор гаргаж, түүнийг шийдвэр гаргасан шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад мэдэгдэнэ.

44.2 дугаар зүйл.Хорих ял шийтгүүлсэн хүнийг харьяат улсад нь шилжүүлэн өгөхөөс татгалзах

1.Дараахь тохиолдолд Монгол Улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн хүнийг харьяат улсад нь шилжүүлэн өгөхөөс татгалзаж болно:

- 1.1.уг хүнд ял оногдуулсан аль ч үйлдэл ял шийтгүүлсэн хүнийг харьяалах улсын хуулиар гэмт хэрэгт тооцогддоггүй бол;
- 1.2.ял шийтгүүлсэн хүнийг харьяалах улсын хуулиар хөөн хэлэлцэх хугацаа дууссан, бусад үндэслэлээр ялыг харьяалах улсад нь эдлүүлэх боломжгүй бол;
- 1.3.ял шийтгүүлсэн хүн, эсхүл шилжүүлэн авах хүсэлт гаргасан улс шүүхийн шийтгэх тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбоотой заалтыг биелүүлээгүй, тийм баталгаа өгөөгүй бол;
- 1.4.олон улсын гэрээнд заасан нөхцөлөөр ял шийтгүүлсэн хүнийг шилжүүлэн өгөх зөвшилцөлд хүрээгүй бол;
- 1.5.ял шийтгүүлсэн хүн Монгол Улсад байнга оршин суугч байсан бол;
- 1.6.ял шийтгүүлсэн хүний холбогдсон гэмт хэрэгт шилжүүлэн өгөх улсын хуулиар цаазаар авах ял оногдуулж болох бол.

44.3 дугаар зүйл.Ял эдлүүлэх зорилгоор Монгол Улсын иргэнийг шилжүүлж авах тухай хүсэлтийг хянан шийдвэрлэх

1.Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсын шүүхээр хорих ял шийтгүүлсэн Монгол Улсын иргэнийг шилжүүлж авах тухай хүсэлтийг тухайн ял шийтгүүлсэн хүн, түүний хууль ёсны төлөөлөгч, төрөл, садангийн хүн, түүнчлэн ял шийтгүүлсэн хүний зөвшөөрснөөр тухайн улсад суугаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар, эсхүл тухайн улсын эрх бүхий байгууллага Улсын ерөнхий прокурорт уламжилна.

2.Улсын ерөнхий прокурор хүсэлтийг хянаж, түүнийг хангах боломжтой гэж үзсэн тохиолдолд түүний саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн тогтоосон харьяаллын дагуу сум буюу сум дундын, дүүргийн шүүх шийдвэр гаргана.

3.Шүүхийн шийдвэрт дараахь зүйлийг заасан байна:

- 3.1.гадаад улсын шүүхийн нэр, шийдвэр гаргасан газар, он, сар, өдөр;
- 3.2.Монгол Улсад хамгийн сүүлд байнга оршин сууж байсан болон ажиллаж байсан газар;
- 3.3.ял шийтгүүлсэн хүний үйлдсэн гэмт хэрэг, гадаад улсын шүүхээс түүнд хэрэглэсэн хуулийн зүйл, хэсэг, заалт;
- 3.4.ял шийтгүүлсэн хүний үйлдэлд хэрэглэх Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалт;
- 3.5.гадаад улсын шүүхээс ял шийтгүүлсэн хүнд оногдуулсан ялын хугацаа, хорих ангийн дэглэм, Монгол Улсад эдэлбэл зохих ялын хугацаа, хорих ангийн дэглэм, хохирол нөхөн төлөх журам.

4.Гадаад улсын шүүхээс оногдуулсан хорих ялын хугацаа нь Эрүүгийн хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулж болох ялын дээд хэмжээнээс их байвал Монгол Улсад ял эдлэх хугацааг Эрүүгийн хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулж болох хорих ялын дээд хэмжээгээр тогтооно.

5.Гадаад улсын шүүх хорих ял оногдуулсан боловч Монгол Улсын хуулиар уг хэрэгт хорих ял оногдуулж болохооргүй байвал шүүх уг хүнд гадаад улсын шүүхээс оногдуулсан ялтай дүйцэхүйц төрөл, хугацааны өөр төрлийн ял эдлүүлэхээр шийдвэрлэнэ.

6.Гадаад улсын шүүх хэд хэдэн хэрэг үйлдсэн гэж үзэж ялтанд ял оногдуулсан боловч тэдгээр нь Монгол Улсын хуулиар гэмт хэрэгт тооцогддоггүй бол шүүх хэрэгсэхгүй болгож, ял шийтгүүлсэн хүнийг ялаас чөлөөлнө.

7.Шүүхийн шийдвэр нь гарсан хугацаанаас хүчин төгөлдөр болох бөгөөд түүнд прокурор эсэргүүцэл бичиж болно.

8.Шүүхийн шийдвэрийг Монгол Улсын ерөнхий прокурор тухайн улсын эрх бүхий байгууллагад хүргүүлж, ял шийтгүүлсэн хүнийг тухайн улстай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу шилжүүлж авна.

9.Гадаад улсаас шилжин ирж энэ зүйлд заасны дагуу Монгол Улсад ял эдлэхээр болсон ял шийтгүүлсэн хүнийг хорих ялаас хугацааны өмнө суллах, ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих, өршөөл, уучлал үзүүлэх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой асуудлыг Монгол Улсын хуулиар зохицуулна.

10.Гадаад улсад өршөөлийн хууль гарсан бол тэнд шийтгүүлээд шилжиж ирсэн этгээдийг уг өршөөлд хамруулах ба энэ тухай шийдвэрийг ял эдлүүлж байгаа газрыг харьяалах анхан шатны шүүхийн шүүгч гаргана.

44.4 дүгээр зүйл.Хууль, олон улсын гэрээг хэрэглэх хэмжээ хязгаар

1.Ял эдлүүлэх зорилгоор Монгол Улсын иргэнийг шилжүүлж авах тухай хүсэлтийг хянан шийдвэрлэхдээ тухайн хүний эрх зүйн байдлыг дордуулсан хууль, олон улсын гэрээний заалтыг хэрэглэхгүй.

УЧИРСАН ХОХИРЛЫГ АРИЛГАХ

[/Энэ бүлгийн гарчиг т 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

45.1 дүгээр зүйл.Хохирол арилгуулах эрх

1.Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэндийн хохирол, сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн төлүүлэх болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй.

[/Энэ хэсэг т 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

[/Энэ хэсэг т 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөл т оруулсан./](#)

45.2 дугаар зүйл.Хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэл

1.Хүнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсэн, эрүүдэн шүүсний улмаас учирсан хохирлыг мөрдөгч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгана.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

2.Хохирол нөхөн төлүүлэх эрх дараах тохиолдолд үүснэ:

- 2.1.хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн нь тогтоогдсон;
- 2.2.тухайн хүнийг цагаатгасан шүүхийн шийдвэр гарсан;
- 2.3.тухайн хэрэг нь гэмт хэргийн шинжгүй, эсхүл тухайн хүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон;
- 2.4.эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн хууль бус шийдвэрийг хүчингүй болгосон;
- 2.5.яллагдагчийг эрүүдэн шүүсэн болох нь нотлогдсон.

[/Энэ хэсгийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

3.Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу ялаас чөлөөлсөн, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон, уучлал үзүүлсэн, хөөн хэлэлцэх хугацаа дууссан, эрүүгийн хариуцлага хүлээлгэх насанд хүрээгүй, эсхүл тухайн гэмт хэргийг гэмт хэрэгт тооцохгүй болсон, ял, албадлагын арга хэмжээг хөнгөрүүлсэн хууль батлагдсанаар хүчингүй болсон, өөрчлөгдсөн тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсэг хамаарахгүй.

4.Хүнийг хууль бусаар хохироосон мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчид хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан албан тушаалтан хүнийг хууль бусаар хохироосон үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжтэй болох нь тогтоогдвол эд хөрөнгийн хохирлыг гэм буруутай хүнээр нөхөн төлүүлнэ.

45.3 дугаар зүйл.Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх

1.Дараахь эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлнө:

- 1.1.хууль бус ажиллагааны улмаас хүний аваагүй цалин хөлс болон амьжиргааны үндсэн эх үүсвэр болж байсан хөдөлмөрийн бусад орлого;
- 1.2.хуулийн этгээдийн орлого;
- 1.3.хууль бусаар хорих ял шийтгүүлсний улмаас зогсоосон тэтгэвэр, тэтгэмж;
- 1.4.шүүхийн шийдвэрээр хураасан, улсын орлого болгосон болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагын гаргуулсан эд хөрөнгө, орлого, эд зүйл;
- 1.5.шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлж гаргуулсан мөнгөн төлбөр, хүн, хуулийн этгээдээр төлүүлсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон бусад зардал;
- 1.6.хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлс.

2.Энэ зүйлийн 1.1, 1.2, 1.5, 1.6-д заасан хохирлыг хуульд заасан эх үүсвэрээс нөхөн олгоно.

3.Нөхөн төлөх эд хөрөнгийн хохирлын хэмжээг тогтоохдоо тухайн хүн ял эдэлж байхдаа авсан цалин хөлс, эсхүл ажил, албан тушаалаас халагдсанаас хойшхи хугацаанд өөр ажил, албан тушаал эрхэлж авсан цалин хөлсийг хасаж тооцно.

4.Ял шийтгүүлсний улмаас зогсоосон тэтгэвэр, тэтгэмжийг нийгмийн даатгалын болон холбогдох бусад байгууллага нөхөн олгоно.

5.Энэ зүйлийн 1.4-т заасан эд хөрөнгийг холбогдох хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага болон прокурор, шүүхийн байгууллага биет байдлаар нь буцааж олгох ба тийм боломжгүй бол анхны үнэлгээгээр тооцож хуульд заасан эх үүсвэрээс олгоно.

6.Эд хөрөнгийн үнийг түүнийг нөхөн төлүүлэх шийдвэр гарах үеийн үнэлгээгээр тодорхойлно.

7.Эд хөрөнгө гэмтсэн тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлнө.

45.4 дүгээр зүйл.Сэтгэгцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлбөр олгох

/Энэ зүйлийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

1.Сэтгэгцэд учирсан хор уршгийг арилгуулах, нөхөн төлүүлэх эрхтэй этгээд нь эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэтгэгцэд учирсан хор уршгийг арилгуулах, нөхөн төлүүлэх талаар иргэний нэхэмжлэл гаргаагүй, эсхүл хэрэг хэлэлцэх ажиллагааг хойшлуулахгүйгээр иргэний нэхэмжлэлийн тодорхой тооцоо гаргах бололцоогүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нэхэмжлэл гаргаж, шийдвэрлүүлэх эрхтэй.

/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

2.Шүүхээс сэтгэгцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийг тогтоохдоо харгалзан үзэх нөхөн төлбөрийн жишиг хэмжээг Иргэний хууль, шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Улсын дээд шүүх батална.

/Энэ хэсгийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

45.5 дугаар зүйл.Хуулийн этгээдэд хохирлыг нөхөн төлөх

1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага болон прокурор, шүүхийн байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагааны улмаас хуулийн этгээдэд учирсан хохирлыг энэ бүлэгт заасан журмын дагуу төр хариуцна.

45.6 дугаар зүйл.Хууль зөрчсөн ажиллагааны тухай лавлагаа өгөх

/Энэ зүйлийн гарчигт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

1.Цагаатгах тогтоол гарсан, гэмт хэрэг гараагүй, гэмт хэргийн шинжгүй, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон бол шүүх, прокурор нь хүн, хуулийн этгээдэд зөрчигдсөн эрхээ сэргээх болон бусад хохирлыг нөхөн төлүүлэх журмыг тайлбарлаж, хүн, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу өөрийн гаргасан шийдвэрийн талаар тухайн хүн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авсан даруй түүний ажиллаж байгаа байгууллагад бичгээр лавлагаа өгнө.

/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

2.Хүнийг ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авсан, эмнэлгийн байгууллагад байлгасан тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсний дараа уг ажиллагаа хууль бус болох нь нотлогдвол холбогдох хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, прокурор, шүүх олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хийсэн мэдээлэлдээ залруулга хийж, шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан./

45.7 дугаар зүйл.Хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг тайлбарлах

1.Цагаатгах тогтоол гарсан, бусад хууль бус шийдвэрийг хүчингүй болгосон, өөрчилсөн тухай тогтоолын хуулбарыг эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж байгаа хүнд гардуулан өгөх, эсхүл энэ хуулийн 11.9 дүгээр зүйлд заасны дагуу шуудангаар илгээнэ.

/Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тогтоолтой хамт хохирлоо нөхөн төлүүлэх журмыг тайлбарласан хуудас хүргүүлэх бөгөөд түүнд хууль зөрчсөн ажиллагааны талаар нэхэмжлэл гаргах эрх, шүүхэд хандах хугацаа болон шүүхийн харьяаллын талаар тодорхой заана.

45.8 дугаар зүйл.Хохирол арилгуулах тухай нэхэмжлэл гаргах

1.Хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай нэхэмжлэлийг хүн, хуулийн этгээд өөрөө, түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл тухайн хүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч гаргаж болно.

2.Өсвөр насны хүнийг цагаатгасан тохиолдолд хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч гаргана.

3.Эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг цагаатгах тогтоол, яллахаас татгалзсан шийдвэрийг хүлээн авснаас хойш 10 жилийн дотор гаргана.

4.Бусад эрхийг сэргээлгэх тухай нэхэмжлэлийг тухайн хүн эрхийг нь тайлбарласан хуудсыг хүлээн авснаас хойш 10 жилийн дотор гаргаж болно.

5.Энэ зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол сонирхогч этгээдийн хүсэлтээр хэтэрсэн хугацааг шүүх сэргээж болно.

6.Хохирогч нэхэмжлэлийг оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ шүүхэд гаргана.

7.Тухайн хүн нас барсан тохиолдолд эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх эрх нь түүний өв залгамжлагчид, зогсоосон тэтгэвэр, тэтгэмж нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх бүхий гэр бүлийн гишүүнд тогтоосон журмын дагуу шилжинэ.

8.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага болон прокурор, шүүхийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас улсад учирсан эд хөрөнгийн хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг прокурор Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар шүүхэд гаргана.

9.Энэ бүлэгт заасан хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл гаргагч шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөгдөнө.

45.9 дүгээр зүйл.Хохирол арилгуулах нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх

/Энэ зүйлийг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./

1.Хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ.

ДӨЧИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

46.1 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

1.Энэ хуулийг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ц.НЯМДОРЖ